

Урианханы хөх чоно Дамцганы  
ЖАМБЯН



**ЧИНГИС ХААНЫ**  
**МЭНГЭ**  
роман

Чингис хааны мэнгэ  
Зохиолч: Д. Жамъян  
Редактор:  
Эрхлэн гаргасан:  
Орчуулсан:

ISBN: 926-122005-33-25

© Энэхүү бүтээлийн эрх нь Монгол Улсын Зохиогчийн Эрхийн тухай хуулиар хамгаалагдсан болно. Бүтээлийг цахим хэлбэрээр түгээх эрхийг bookstore.mn цахим хуудас эзэмших бөгөөд зөвшөөрөлгүйгээр бүтнээр нь буюу хэсэгчлэн хувилах болон бусад ямар нэгэн хэлбэрээр олшруулах, ашиглахыг хориглоно.

[www.bookstore.mn](http://www.bookstore.mn)

## Нэгдүгээр бөлөг



*Бөртэ чоно баатар Гоо Марал гэргийгээ дагуулан манай он тооллын долоон зуун жаран зургаадугаар онд Бурхан халдун уулнаа нутаглажээ*



**"Хөх өвсний эгшиглэн" найман боть зохиолыг танилцуулж байна.**

Манай эриний он тооллын долоон зуун жаран зургаадугаар (766) он болой. Жүд мод навчлах өдөр хөх чонын сүрэг хөх сүүдрээ дагуулан цувж ирээд цугларч буув гэдэг нь Бөртэ чоно хаан, гэргий Гоо Маралын хамт гучин гурван хөндий хоолойг туулж, ерөн есөн гол, горхийг гаталж Бурхан халдун уулыг нар зөв тойрч Тэргүүн өндөрлөгийн өвөрт нутаглаж Батцагаан нэрт нэгэн хөвүүн төрүүлсэнийг өгүүлэв бөлгөө.

Жүд модны мянган навч газар бүтээхэд мод нүцгэрч арван үе мултарч өнгөрөөд Бутанцар мунхаг хэмээх бутач хөвүүн Бөртэ чонын удмаас үлджээ. Бурхан халдун уулын энгэрт Жүд модон өмхөрч, Ялгуун мод навчлах зуур Бодончар мунхаг төрж үхэв.

Бодончар мунхагийн дараа Хабич баатар, Мэнэн Түдүн, Хачи хөлөг, Хайду, Бай-Шонхор догшин, Тумбунай сэцэн, Хабул хаан, Бартанбаатар, Есүхэй баатар төрж үхэхэд Ялгуун модны

мөчир арван үеэрээ хугарч унав. Чингис хааны үед лууны ургамал, гүндбалын ургамалтай могой судсаараа холбогдож хөх, ногоон шүүсээр морьдын туурайг будав.

Бөртэ чонын дээд язгуур үргэлжилсээр Чингис хааны үед газар, тэнгэрт суу нь тархаж мөнх тэнгэр тэтгэснийг мэдтүгэй.

\* \* \*

Монголын тал нутагт хавар болж Сэлэнгийн Шар тохой нэлдээ ногоорон өвсний үндэс хөөсөн цагаар Чингис хааны морьдын туурайд газрын нойтон хөрс хэгз гишгэгдэв.

Мэргидийн цус тэнгэрт үсрэв. Орхон, Сэлэнгийн уужуу бэлчир малын сэг, зэм, хүний хүүрээр дүүрч, шатсан гэр майхны үнс чандруу хийсч, хаа нэгтээгээс үхлийн үнэрт соронздуулсан тас, ёл, хонхэрээ, сар мэтийн махчин шувууд тэнгэр харлуулан цугларчээ. Мэргидүүд цэрэг, ардгүй хүйс тэмтрүүлсэн нь чухам юунаас эхтэйг үргэлжийн дайн тулаанд туйлдсан хүмүүс өш хонзон хэмээн гадарлах бөлгөө. Монголчуудын хоорондын дайн тулаан учир битүүлэг хэвээр үргэлжилнэ.

Хүн малын зоо тэнийх цагаар хамаг монголын их цэрэг хучин буужээ. Намгийн ногоон мэлхий, чийгийн улаан өг хүртэл шаварт хутгалдав. Мэргидийн хэлтэй болгон өршөөл гуйн хашгирч, хөлтэй бүхэн дутаав. Ой шугуйгаар хөхөмдөг будан татаж, яргуйны бор гөрөөс өвөлжөө, хаваржааны хөл бараадаж, цөхөрсөн ууль шөнө турш эмэгчинээ дуудна. Ёроолгүй там гэгч мэргидийн хот хүрээнд нүүрлэв.

Үхэр хулгана ичээндээ шургав.

Их дэлтэй хөө хар морьтон салхи татуулан давхисаар цэргийн хээрийн цацрынхаа өмнө жолоо татсан нь Чингис хаан болой. Түүний нүдний харц догширч, уруул омголтож, үхээрийн дайн дажны цөхрөл гутралд илт автагдсан аж. Хөлс дуслуулан дагжиж буй хөө хар мориноосоо хаан дэвхрэн бууж цулбуураа шадар цэрэгт шидэж өгөв. Цэргийн царайд хөлс нэвчиж завьж нь халтартаж, богино сэлэмд нь цус, үс наалдсан ажгуу.

Энэ үе бол монголын гуравдугаар жарны билгийн тооллын хар нохой жилийн хар нохой өдөр юмсанж. Чингис хааны зүүн гарын баатар Мухулай мөрөө жадлуулж шархандаа үл ялиг түүртэх боловч хааны дуугаа хураасныг ажаад "Дайр-Үсүний зайран бөөг барив. Танд айлтгал буй гэнэ. Далны яс мэт содон дүрстэй, гажууд төрхтэй юм" гэв. Цацрын үүдэнд хаан цааш харж зогсоно.

Түүний занг мэдэх Мухулай өөр юм өгүүлэхээ түтгэлзэв. Мухулайн дээл цоорч цоорхойгоор цус нөжирч наалджээ. Хаан түүн рүү толгойгоо аажим эргүүлэв. Жанжин Мухулайн нүүр нэлдээ шаргалтаж, шанааны судас гүрийн томроод ядрангуй боловч хааны нууцлаг харалтад хариу барихаар шийдэв.

Хөө хар морины тохотноос хөлс дусна. Ийм ганган бөгөөд шандаст хүлэг боржигоны дайчдад олон буй. Адууны хөл дороос үл мэдэг чийг дэгдэж тааварлахын аргагүй зөөлөн агаар самсай өөд цутгана. Чингис хаан хоёр гараа алдлан сунгаснаа "нэхүүл ирсэн үү" хэмээн

Мухулайд хандав. Тал, тал тийш нэхүүл илгээж, зугадаж дугаасан мэргидийг журамлаж байгаа билээ. Зөвхөн нэхүүлүүдийн тухайд бус Чингис хаан дайны байдлыг бүхэлд нь мэдэхийг хүсчээ. Удуйд мэргидийн толгойлогч Тогтоа бэхи мөргүй арилсан гэдгийг хаан сонсоод "ширэнгэн дотор нуугдсан байж магад, нохой тавь" гэж Мухулайд сануулав.

Хаан өндөрлөгийн намссан тал руу бууц явахдаа "манай хохирол хэд хүрэв" гэж Мухулайгаас асуухад "цэрэг дал, агт хорь..." хэмээн товч тодорхойлов. Тэд ярилцаж явсаар голын зэгст тохойд тулжээ. Зэгсний ёроол тас харлаж, замаг, шавар, ялмаг нийлж овоорчээ.

Чингис хаан баруун гарын алгаар ус хутгаж магнайгаа шавшиж норгосноо "хүнд өдөр өнгөрлөө" гэж хэлээд эрэг сандайлж суув. Энэ зуур зэгсний завсраар гараа шургуулж, өрвийсөн нугас базаж тийчигнүүлэн хаан өөд сарвайгаад,

- Нугасны цус амттай шүү. Хаан та болгоо. Биенд тэжээл өгнө гэхэд Чингис хаан агзасхийн "чи өөрөө сорчих" гэвэл цэргийн жанжин ер тоосон шинжгүй "надад зөндөө буй" хэмээгээд нугасны сул толгойг тасдаж хоолойг нь чимхсээр түүний аманд үмхүүлэв. Нугасны цусыг хаан тун амтархан шалчийтэл сорлоо. Мухулай нугасыг бургасны мөчирт тээгэлдүүлж шидээд зэгс рүү гараа шургуулж бас нэг нугас гаргаад түрүүчийн адил дадамгай сорж тамшаалсанаа элгээрээ хэвтэж голын цэнгэг ус залгилав. Хаан мөн хэвтэж ус залгилаад хормойдоо наалдсан өвсийг гөвж "дотор онгойв" гэлээ.

Орхон, Сэлэнгийн бэлчир нийлж, их усны шуугиан тэртээд бөглүү дуулдана. Хааны өлмий тушаа бургасны мөчир, хөх өвс сүлжиж хонхойсон үүрэнд гурван өндөг хэвтэнэ. Тэрбээр хөлөө огцомхон цочмог татсанаа өндөгнөөс цэрвэн холдоход Мухулай тачирхал цагаан шүд яралзуулж инээв.

-Шархаа сэдрээв гэж Чингис цаашлуулна.

-Гурван мэргидийг мартахааргүй болов гэж Мухулай өөрийгөө дамшиглаад шархаа хөндүүлэхэд ярвайв. "Мухулай шархдав. Маргааш анд нарын минь нэг үхэхийн дохио болов. Биеийн шарх эдгэнэ. Сэтгэлийн шарх дахин сэдрэх нь өр өвчих юм" гэж Чингис хаан тавгүйтэн бодоод "Дайр-Үсүний туршуул иржээ. Тэр мэргид чинь Чилэдү баатар, Чилгэр бөх хоёрын эцгийн дүү юм гэнэ лээ. Дайр-Үсүн үг дайж явуулсан болов уу" хэмээн бодолхийлнэ.

Мухулай шархтай мөр рүүгээ гилжийжээ.

Хааны цацар бүхий толгойн оройгоор шадар цэргүүд сүүтэгнэнэ. Ойролцоох бургасны чөлөөгөөр утаа уугина. Сэлэнгийн хөндий нэлдээ нам гүм болжээ. Бүдэг хөх саарал тэнгэрт хар шувуу заарцаглаж байв. Сэлэнгийн үерт бор ус тэртээх шаантагласан тохой тушаа нарны сүүлчийн гэрлийг ойлгох аж. Холын уулс бүдэг бараан, хар бараан, хөхөлбий өнгөт гурвалжин, өндөр нам хэрчлээс, тэмээний бөх, нохойн чих мэт босоо дэлбэн дүрстэй харагдана.

-Дайр-Үсүн ч намайг шархлуулсан хүн мөн гэж Чингис сэтгэлээ нээв. Мухулай "Дайр-Үсүн хааны зуултанд байгаа юм байна" гэж сэтгээд,

-Дайр- Үсүний зайран бөө далны яс шиг дүрстэй юм. Ямар нэгэн амьтны сүүдэр байхаас зайлахгүй. Танд айлтгалтай гэсэн шүү гэж ердийн байдлаар өчив.

Чийг даасан дулаахан үдэш боллоо.

-Олзны хүрээ хаана буй хэмээн хаан хянамхай няхуур асуухад цэргийн жанжин,

-Тэр хүрээн дотороос огтоно гарахгүй гэвэл

Чингис хаан бага зэрэг зэмлэх аястай,

-Тогтоа бэхи, Дайр-Үсүн хоёрын дальтрахыг харахсан гээд хөмхий зуув.

Жанжины дууны өнгө сааралтаж,

-Олзны нэг хүрээ Гүр хар уулын өвөрт, нөгөө хүрээ Сэлэнгийн халцгайд буй гэж баруун, зүүн тийш чиглүүлэн заалаа.

Хамаг монгол аймгийн хохирол мэргидүүдтэй зүйрлэх аргагүй бага байв. Мэргидийн үхдэл дундуур нэг хүн тэнүүчилж явжээ. Мэргидийн хуйхлагдсан хонхорт яваа тэнүүлч эрийг барьж авчирахад гоёмсог дээлтэй, унжуу урт хамартай, шувтан эрүү нь үзүүртээ тэгш дөрвөлжин толгойны хэсэг хоёр тийшээ шаантган хэлбэртэй ерөнхий төрхөөрөө нүүрний хэв байдал далны ясыг санагдуулсан догшин жижиг нүдтэй эр байв. Дээлээ сугалдаргалж ханцуйгаа нарийхан сураар томж сүлжсэн бүсэндээ хавчуулсан этгээд нэгэн байв. Толгойдоо хараацайн үүр шиг эсгий углажээ. Үхдэл дунд тэрхүү эр шөвөг атгаж явав. Мэргидийн гавлыг нүхэлж байв. Үхдэлийн дийлэнх мэргид аж. Гавлын нүхээр мөлхөө ургамал сүвлэж зангилагдана. Мөлхөө ургамал дараагийн гавалд мөн зангилагдаж нэгэн өдөр үхсэн мэргидийн гавлын яс овоо болох гэнэ. Тэрхүү овоо гай түйтгэр, өш хонзонг байнга сануулж байх нигууртай ажгуу.

Мэргид эрийн өвөрт шатаасан дал байснаас сэжиг төржээ. Хүүр үхээр дотор айж цочихгүй явааг бодоход тэр хүн зайран бөөгийн удамтан бөлгөө. Сэлэм далайхад догшин жижиг нүдээ цавчлав. Боржигоны цэргүүд түүнийг тойрч "чи хүн мөн үү, сүнс сүүдэр юмуу" хэмээн бархиралдан хөхрөлдөхөд маш тэвчээртэй дуугай царайлав.

-Наадхиа ташуурд....

-Бугуйлдаад багалзууры нь боож ал!

-Болохгүй ээ, хаантанд тушааж учрыг олъё...

Мухулай жанжин мэргид эрээс айхтар цочиж "хачин дүрстэй эр вэ?" хэмээн бодоод

-Үхсэн хүний жодгорт хүлээд хорьж бай гэж тушаажээ. Лавлаж мэдвэл Дайр- Үсүн толгойлогчийн зайран бөө гэнэ. Далч мэргийн хүн гэнэ. Хаанд үг дуулгах учир буй гэнэ. Адууны мах цадтал идэж, хүйтэн ус уугаад тэрбээр хурхирчээ. Түүний гар, хөлийн хүлээсийг жодгорын гаднах модны хожуулаас уяж харуул гаргав.

Мэргид эр Чингис хааны өмнө хичээнгүйлэн сөгдөж морины шавар, хөвдтэй сагагийг гөлрөв. Хаан урьд өмнө огт үзээгүй дүрсийг харж "шувууных шиг нүдтэй юм" хэмээн цээр гаргах мэт тургиад,

-Чи хэн буй гэж асуув.

-Миний нэр Төгсжин билээ. Би Дайр-Үсүний албат иргэн. Багаасаа бөө хэмээгдсэн.

Төгсжингийн байр байдал Чингис хаанд огтоос үл ойлгогдох аж. Өүлэн эхийг Чилэдү баатар эхнэр буулгахад Төгсжин хамт явсансан. Тэгэхэд Есүхэй баатрын мэргэн харваачийн суманд гарынхаа булчинг сэтлүүлжээ. Тэмүжингийн цуу дуулианыг эртнээс сонсож боржигоны хот айлаар малын эрэлчин болж Төгсжин зайран очиж байжээ. Төгсжингийн түлсэн далны мэргэ түүний нүднээ тодрон үзэгдэнэ.

Далны зураас, хагалбар, цуурдас, сэтэрхий болгоныг Төгсжин анзаарах бөлгөө. Хэдийбээр зарим талаар бэрх авч таамаглал, төсөөлөл тархинд оршиж, бодит дүр зураг нь үзэх нүднээ илт болой. Тэрхүү нууцлаг төлгийг төгсжин зөвхөн унших төдий. Түүнийг бүрэн гүйцэд тайлах түлхүүрийг ах дүү зайран бөө Цагаанбух, Халзанбух хоёр монгол туургатан дотроо эзэмшсэн байж. Одоо ах дүү зайран тэнгэрт хальжээ. Далны хуудас дээрхи бичгийг Чингис хаан уншихыг Төгсжинд тушаагаагүй боловч хэрэв толгойтойгоо үлдэе гэвэл унших ёстой байв.

"Хаан таны алганы хээ далны зураг дээр гарчээ. Та мичид, маралын завсар орших Зургаадай одонд төрсөн тул дал хүртэл насална. Сүр жавхлантай, цог тегэлдер тул эхнэрүүдийг хураамуй. Баатар дайчин, дайсныг номхотгоход билиг их, насан багадаа муу атлаа эцэс сүүлдээ амьдрал тань гайхам сайн бөлгөө. Таны сэтгэл найдангуй, өгөөмөр, бясалган үйлдэгч бөгөөд ганцаардан орогногч мөн"

Үүнийг дуудаж байхдаа Төгсжин ээрч мунгинан цахилдагийн хөх цэцэгт бутнаас базлан зуурч байв. Түүний цахилдаг атгасан хурууны хумс урт махир, хамар хянга унжуу, нүүр шувтан дээрээ уртсаж, хацрын гонзгой яс хонхойж, бөөрөнхий нүдээр Чингис рүү цоо ширтэнэ.

Шатаасан далыг Чингис хаан эргүүлж тойруулж үзсэнээ гав ганцаар бургасан ширэнгэ рүү шургав. Боорчи, Мухулай хоёр хааны хойноос ажиглаж байснаа бие биерүүгээ хяламхийв. Бургасны навч найлзуур шүргэлцэн чичирхийлэх тэр ширэнгэний оройг хэсүүчлэн харж хааны хаахна явааг мэдэж байлаа. Усны харгиа сонсдож, моддын мөчир салхинд ганхах нь хааны яваа газрын чигийг алдагдуулав. Чухамдаа Чингис хааны араас зориглож явах хэн ч байсангүй. Нэгэнт дайны утаа шингэрч, зэлүүд хээрийн төрх буй болсон тул дутаан зугатагсад цөөрчээ.

Нэлээд хугацааны хойно Чингис хааны нүд очтой гялалзсаар хүрч ирэв. Мэргидийн зайран бөө Төгсжин өвс ногоог шалчийтэл өвдөглөж, хөх шүүс нь түүний өвдгөнд өнгөр оруулж байгааг умартаж,

-Хаантан өршөө. Миний толгой одоо таны мэдэлд байна. Би бол боол. Та бол хаан. Хаан бол

боолын толгойг цавчиж болно. Хаантан өршөөвөл Сайн-Ерөөлтийн долоодох үеийн лус савдагтай нөхцсөн зайран бөө би хүчээ өгч зүтгэе. Би Бай-Шонхорын цусан удмын удганаас төржээ. Удганы нутаг Зуун голын бэлчир билээ. Би тэндэхийн иргэн. Хаан таны цусан төрөлтөн. Яс ургаж үлддэг бол цус урсаж алга болдог. Тэгэвч борвийг минь бүү тасла! гэж Төгсжин өчиглөн гуйв.

Чингис хаан түлэнхий далыг баруун гартаа бяц атгахад шавьж хорхойн хальс мэт шаржигнаж үйрлээ. Далны үйрмэгүүд хааны гарт дахин бяцлагдан шажигнаж бүдэг хөх, хар цайвар үнс бутран унахдаа борогны зай завсраар хийсэн орж ноднин жилийн нойтовтор шар навчийг онов. Шатаасан далыг Чингис хаан юу ч үлдээлгүй нунтаглаж атгасаар байхад Төгсжин "миний тархи толгой, гэдэс дотор, зүрх уушиг бас үйрлээ. Хаан миний гадна, дотор хоёр талыг хайр найргүй хэмхчиж хаяв. Сэтгэлийг минь хаан бас дарангуйлж бяц атгав" гэж шалчийж сөгдөнө.

Харин Чингисийн нүд харгис бус дөлгөөн, Боорчи, Мухулай хоёрыг сонжих байдалтай харна. Хааны гар үнс болжээ. Үнсний зэвхий өнгө Төгсжингийн гонсойж гутарсан царайтай төстэй аж.

-Зайран бөө чи шатаасан далаа харж байна уу хэмээн Чингис хааныг шалгаахад,

-Ортас мартсан гэж Төгсжин үнэнээ хэлэв. -Зайран чиний бодол санааг би имэрч хаяв. Хэрэв эргэж санах ахул үхдэл бологтун. Өршөөл хүссэн тул өршөөв. Танай мэргидүүд намайг элдвээр ярьдаг биз.

-Дайр-Үсүн толгойлогч танаас айдаг. Их айдаг. Хаан танд толгойгоо тушаахаар ирнэ. Тэр Дайр-Үсүн намайг явуулсан билээ.

-Чи олон юмны гэрч байна. Өүлэн эхийг бэр буулгахад чи явсан бусуу. Бөртэ хатныг мэргидийн хүрээнд аваачихад тэнд байсан бус уу. Хожим намайг бас гэрчлэх үү.

-Хаан таны атганд би оржээ. Мэргидийг мэргид гэлгүй монгол гэж бодвол таарна. Мэргидийн бөх баг хүрээ сэт үсэрч, тамтаггүй алаан хядаан болжээ. Та мэргидэд өршөөлгүй юм.

-Өр дээр хэн хутга тавив. Тэр надад тэрсэлмүү.

Тэрслүү авираа татаж надад дагаар орохыг хорин жил шаардсаар байтал заавал тэнгэрийн гэсгээл үзэх гэж танай мэргид ёрлов. Харин одоо л...

Чингис хаан Сэлэнгэ мөрний догшин урсгалыг чагнаархан Төгсжинд ойртоод алганыхаа үнсийг түүний хонхор шувган хацарт нялж "Бай-Шонхор догшин төрөөгүйсэн бол ертөнц дээр би хэн бэ, чи хэн бэ. Тэр үндэс биднийг учруулав. Зайран бөөг Боорчи ав" хэмээн Төгсжинг цаазаас хэлтрүүлжээ. Сэлэнгийн урсгал Чингисийн үгийг тээж одов. Сэлэнгэ мөрөн цаг хугацааг тээж, бас арчиж урсадаг билээ. Сэлэнгийн урсгал догшин, түргэн боловч ай савдаа хоормоглон багтаж алсаас харахад дөлгөөн болдог. Сэлэнгэ мөрөн урсаж, урсаж цагийг элээгээд асар том эргүүлэг үүсгэж түүн дотроо он жилүүдийн үйл явдлыг хэлхэж



үлдээдэг жамтай билээ. Сэлэнгэ мөрний их усанд Чингис хааны дуу хоолой, Төгсжин зайрангийн дүрс зураг шингэж, давалгаанаас давалгаанд бүүвэйлэгдэн одов.

Энэ үед тэнгэрийн баруун хаяаг үүл бүрхжээ. Самарч байгаа сүү шиг үүлс хөөс мэт сэвсийж төдөлгүй хүн дүрсэд хувилав. Чингисийн харсаар атал үүлэн дүрс түүний эцэг Есүхэй баатар болов. Өргөн мөр, янхир шанаа, жартгар хурц нүд эцгийн төрхийг санагдуулахад Чингис босоо ороолон мэт харагдах Төгсжингийн Боорчийг таширлан зогсох биеийг халыт харав. "Эцгийн сүнсийг хэн дуудав" хэмээн тэрбээр өөрөөсөө асуув.

Чингист аль болохоор харагдахгүйг хичээн Боорчийн тушаа сүүдэгнэх тэр зайран бөө бол сүнс дуудагч байж болно. Угаас эцгийн сүнснээс хүч сэлбэх, ухаан ургах явдал Чингист олонтаа таарсан тул байнга холбоотой байсаар хаан болжээ. Энэ удаа тэрбээр "Эцэг минь мэргид иргэд дуулгаваргүй тул дайлав. Тэр иргэдийг номхотгох цаг бага байна. Бутарсан олноо хурааж дуусаад эв найрыг хичээж амьдрах минь" гэж өгүүлэв. Эцэг нь ширүүн төрхөө гээж "Монголчууд жалга бүрт нутаглана. Овог аймгаар талцаж байлдана. Биенээ мохоосоор монголчуудын хүч сульдах боллоо. Зам отож охид хүүхнээ булаалдаж овог хоорондоо дайтах нь хэрээс хэтэрлээ.

Одоо сүрэглэн нэгдэх хэрэгтэй. Чоно хүртэл сүрэглэдэг бус уу. Сүрэг чоно хүчтэй, сүр бараатай байдгийг санагтун. Хөх чонын бутарсан хөх сүргийг нэг сүүдэр үлдээлгүй хумиж хураахгун" гэв. Эцгийн дуу хоолой гаслантай ажгуу. Есүхэй баатрын төрх өөрчлөгдөн зүүн тийш тэлхэн сунаснаа дүрсээ хувилган араатны зогдор лугаа салаалж нүүдэллэв. Чингис хааны тэгш хэмт цайвар царай нь улангассан барсын төрхийг агуулж түүний тархины дундуур "чоно сүрэглэхээрээ хүчтэй бус уу" хэмээх тэнэмэл хатуу үг нэвчиж оров. Мэргидийг сөнөөх тулалдааны нэгэн үдэш Сэлэнгэ мөрний булан, тохойд энд тэнд түүдэг асч, гуринхалсан араатан, махчин шувуу цусны үнэрт татагдан бургас, зэгсний цоорхойг нэгжиж шөнөдөө цадаж залхуутай хонодог болжээ.

\* \* \*

Дайн байлдааны сүүлчийн үдэш завсарлаж, гурван мэргидийн үлдэгдэл бут цохигдож, Орхон, Сэлэнгийн цутгалан шөнөжингөө Төгсжин зайрангийн чих рүү шаагив. Мөрөн голын урсгал ийм их чимээтэй урсдагийг тэр шөнө Төгсжин чихээрээ бус зүрхээрээ мэдэрчээ. Ямагт үертэй байдаг мөрөнгүүд эрэг дэнж дээрээ уухайлан хашгиралдаж, жад, сэлэм, нум сумаар биенээ хенеөх монголчуудын хоорондын зэрлэг байлдаанд цөхөрч туйлдсан хэрнээ хором тедий зогсолгүй шаагин урсана.

Шатсан дал хааны гарт бяцлагдан үнс болоход Төгсжин "мэргид төгсөв" гэж бодов. Мэргидийн үлдэгдэл тайгаар тархжээ. Тэдний толгойлогч нар зүг буруулжээ.

Шархны халуунтай мэргид цэрэг үүр цайхад хараатай хэвээр талийв. Төгсжин үхсэн цэргийн жодгорт нойр муутай үүрийн гэгээнээр гадаалав.

Яг жодгорын дээгүүр шархадсан цэргийн өлөн гэдсээр хонхэрээ хэц татсаныг бөө харлаа. Хонхэрээ бол муу ёрын жигүүртэн. Үхсэн мал, адгуусны зөвхөн нүдийг тоншиж, ухархайг мөлжиж иднэ. Хэрэв хонхэрээ айсуй бол нүдээ аньж үл болно. Нүдээ аних зуур хонхэрээний

эвэр хушуу бүлж ороод хүүхэн харааг сорж ходоодоо мялаадаг учраас шархадсан мэргид эр хараатай хэвээр талийсан байна. Мэргидийн өлөн гэдэс нойтон бөгөөд чийгний өтний ягаан өнгийг санагдуулна. "Амьд үлдсэн минь гай болов" хэмээн Төгсжин зайран өөртөө шивэгнэв. Бургасны үзүүрт зангидсан өлөн гэдсийг зайран өгөр мөчрөөр өлгөж шидэв. Тэр шөнө мөрөн голын усны чимээ Төгсжинг тайван хонуулсангүй юу гэтэл шархтай мэргид эр зайрангийн хоносон майхан руу мөлхсөөр байгаад ойртож очих үедээ үхжээ. Махчин хонхэрээ шөнө турш тэр цэргийг сахиж үүрийн гэгээнээр бүлтийсэн нүднээс нь зэвүүрхэн гэдсийг хөвжээ. Энэхүү там, шаналал зайранг зовоосон ажээ.

Зайранд Чингис хааны дэндүү хүчтэй, далд аймшигтай, маш нууцлаг араншин бодогдсоор байлаа. Өглөө адууны нойтон хомоолоос уур савсана. Үхсэн мэргидийн хүйтэн зовхийг зайран доош дарж буулгахдаа "нүдээ хайрладаг энэ цэрэг надтай хүйн холбоотой байж" хэмээн санаж "яагаад над руу мөлхөв" гэж хар буухад хэн нэгэн харах вий гэх шиг хялалзав.

Мөнх тэнгэрийн дуудлага зайран бөөд адармаатай санагдана.

\* \* \*

Хөх ногоо ургаж, мал цадаагүй цаг тул Сэлэнгэ мөрөнг эмжин хөвөөлөх Гүр харын уулнаас гөрөөс авлахаар Хамаг монголын хаан баатар эрсийн хамт зэхжээ. Хааны хөө хар моринд нарийн ширмэл хээтэй өргөн тохом бүхий зандан бүүрэгтэй, алтан хяртай эмээл тохжээ. Баатрууд нум, сум агсаж өвдөг, тохой, гар хөлийн шуугаа арьсан хамгаалалтаар даруулан баглав. Үргээлгэнд гарах цэргүүд зөвхөн урт жадаар зэвсэглэв.

Сэлэнгийн Шар тохой дугуй, дугуй мөргөцөгтэй. Дугуй тойрог усаа дагах бөгөөд нэлмийсэн бургасан шугуйтай. Сэлэнгэ мөрөн тохойрон урсахдаа заримдаа цэнхэртэн задгайрч заримдаа битүү шугуйд шургаж далд орно. Хэчнээн тохой залгалдан таах аргагүй нийлсэн аж. Гүр харын уул хэдэн өртөө дамжин Сэлэнгэ мөрөнг хашиж сунайх ажээ.

Өргөн Сэлэнгийг шахаж тогтсон ардаа модтой, урдаа сахлаг өвс ургасан гүн сайр жалга, хад чулуутай Гүр харын уулнаас гөрөөс авлаж хүнс бэлтгэхээр Чингис хаан шийдэж отог бүрт зар тараав.

Гөрөөс агнахаар морин цэргүүд газрын хэвгий рүү хүрээгээ хумин хумисаар багалзуурдан шахаж ирэв. Адууны хөлс ханхлан, туурайн төвөргөөн газар дэлдэхэд цэргүүд аль болохоор агсам морьдын амыг хөөс цахартал татаж явна. Цэрэг эрсийн гөрмөл суран ташуур агаарт могой мэт эрчлэн тасхийх бүрт морьдын чих хулмалзан самсай сарталзан урагшаа ухасхийх бөлгөө.

Гэнэт олон анчдын хашгараан гүвээ, гүвээ дамнан цуурайтаж тэрхүү дуу чимээнд сайр, жалганы гөрөөс дэгдэн дүүлэн зугадна. Жалганы ирмэг хаа байгаа нь мэдэгдэхгүй тэгш атал үе үе огцом өндөр эрэг, гүн мөргөцөг таарч, ав хоморгонд яваа эрс, агт морьдыг багагүй сандаргана.

Ноднин жилийн шивээн толгой цайрч тэрхүү цагаан өвс морьдын туурайн аясыг даган сагагтай орооцолдон намилзах авай.

Нэгэн бяцхан хулгана газар доорхи нүх ичээнээсээ толгойгоо цухуйлган нүдээ бүлтэгнүүлэн байснаа маш болгоомжтой мярайн гэтэж чагнаархана. Морьдын төвөргөөн газар бөмбөрдөхийг сонсуут хулгана өвсний дундуурхи нарийн жимээсээ хазайн сахлаг боргонд түүртэн бөндөгнөж гүйлээ. Хулганыг барьж идэхээр өлөн нүдээрээ ажиглан суусан махчин сар шувуу дайчин эрсийн зэрлэг хашгираан, морьдын бахардан амьсгаадаж хар хүчээр эвхрэн хурдалж яваа туурайн төвөргөөнийг сонсоод далавчаа дэвэн ууртайгаар дээшээ хөөрлөө. Газар, тэнгэрийн хоёр амьтан мөрөө хөөж нөгөө бор хулгана нь шувууны эвэр хошуунд тархиа бяц тоншуулахаас аврагдав. Хэрэв армаг хүлэг морьд хуйлран орж ирвэл хулганын арьс үс өвс ногооны шүүстэй хутгалдах байлаа.

Энэ удаагийн ав хоморгын даамал Мухулай архирсан бүдүүн хоолойгоор,

-Баруун тийш шах! Эрэг рүү эргүүлж хумицгаа хэмээн хүнгэнүүлэн хашгирлаа.

Мухулай толгойн орой дээр зогсох хөө хар морьтоны зүг эргэж харав. Тэр лагс биетэй бадриун чийрэг эр байв. Түүний нүүр царай үл хувирах ажээ. Асгат энгэрээс нижигнэн бууж буй гөрөөсний бужигнааныг маш анхааралтай харна. Хөө хар морьтой Чингисийн баатрууд анчдыг талархан харж байв. Уулын бор гөрөөс олныг авласны дараа Мухулай хааны зүг дахин хараа чилээхэд Чингис баруун мутраа өндөрт өргөв. Ав хоморгыг зогсоох дохио байлаа.

Өндөр газрын харууц дээрээс гурвантаа сум тавьж сүрэг гөрөөсний цээжинд зоож гөрөөс эвхрэн унахыг Чингис ажна. Чингис хаан дөрвөн зүг рүү ажиглана.

Тээр дор агсам морьтой нэгэн эр гартаа нум сумаа барин давхиж айсуу. Түүний дэргэд дун цагаан морьтой бүсгүй зэрэгцэн явна.

Тэд хааны зогсож буй өндөрлөгийг чиглэн давхих нь тэмүүлэл дүүрэн ажгуу.

Чингис төдхөнөө догдлон хөөрч ямар хэргээр хэн ирж буйг мэдэхийг хүсэв. Ав хоморгын дайчид бор гөрөөсний түүхий элэг үмхлэн завьжаараа улаан хөөс цахруулж, хуу татсан арьсаа хадан дээгүүр дэлгэж байв. Зарим нь махыг мөчлөн төхөөрч хүнсэнд нийлүүлэхээр богцолж эмээл дээрээ тохоцгооно. Гүр хар уулын гүн жалгат дэвсэг энгэрт боржигоны цэргүүд зав зайгүй язганан агнасан гөрөөсөө төхөөрнө.

Дун цагаан морьтоныг дагуулан яваа тэр хүнийг хаан танилаа. Өчигдөрийн үл ойлгогдох зайран бөө угсаат мэргид эр байлаа. Харин дагуулж яваа бүсгүй нь хэн бол. Тэдний араас нэгэн морьтон салхи татуулан нэхэж буй харагдлаа. Чингисийн нүдний харц хүйтэрчээ. Намхандуу хамартай босоо зууван нүүртэй, шалмаг хөдөлгөөнтэй Зэлмэ нум, сумаа авахад хаан боль гэх шиг огцом харав.

Урианханы Зэлмэ бага залуугаасаа хааны араншинг мэдэх тул зүүн гартаа атгасан нумаа огцом доошлуулав. Нэхүүл морьтон тэдний урдуур хэрэн зогсоход мөнөөх хурц догшин нүдэт Төгсжин бөө бүсгүйн эцэгт,

-Хааны таалалд нийцэхгүй аваас би эхнэрээ болгоно гэв. Мэргидийн нэгэн отгийн толгойлогч Дайр -Үсүн хэмээх баатар эр дөнгөж арван зургаан настай охин Хулангаа Чингист

хүргэж өгөхөөр ирээд Төгсжинтэй таарч "зайран минь манай охиныг хаан тоох болов уу. Мэргид бидний хар толгой илдний доор үй олноороо хэрчигдлээ. Чамайг тэгээд кэн өршөөв" хэмээн асуухад Төгсжин,

-Чингис хаан өршөөв. Миний толгой мөрөн дээрээ байна. Хаан өршөөхгүй бол шууд хяргаж орхино гэж хээвнэг гүвтнэв. Дайр-Үсүн бодолхийлж Бөртийг хорин жилийн өмнө хэрхэн доромжилсоноо эргэн санав.

-Тэмүжинд наадхи хүүхнээ аваачиж өгөгтүн- Үл тоох аваас цаашхийг чи мэдтүгэй гэж цөхөрсөн Дайр-Үсүн омогдов.

Хулан эцэг өөдөө ширүүхэн харав. Түүний сормослог том нүд нь зөрүүд ааштай, зоргоороо зантай болохыг илчилнэ. Хулан бол хөвч тайгын зэрлэг согоо шиг бүсгүй байлаа. Тэр бүсгүйн биед хээрийн салхи, харзын тунгалаг ус, өвс ногооноос өөр наалдсан зүйл үгүй байлаа. Охиноо Чингист өгч байж Дайр-Үсүн амьд үлдэх салаа замын уулзварт тулжээ. Ер нь мэргидийн хувь заяа туйлын ээдрээтэй байжээ. Тэмүжиний эх Өүлэн, хатан Бөртэ хоёулаа мэргидтэй хувь заяа, лай ланчигаар холбогдож тэрхүү хэн ч үл мэдэх холбоосыг үүрд тасар татаж хаяхыг Чингис хаан хүсч байлаа. Хүснэ гэвэл хясна гэгчээр Дайр-Үсүний танхил охин ойрхон ирж явлаа.

Цус урссан дайнаар үл шийдэх явдал, суудал хүмүүний амьдралд өчнөөн байдаг билээ. Удахгүй монголын тал нутаг, цаст уулсыг нэг гарт оруулж чадах эсэхээ Орхон, Сэлэнгийн бэлчир газарт шийдэхээр Чингис хаан сэтгэл шулуудаж байна. Мэргидийг дарж сөнөөв. Мэргидийн толгойлогч баатрын нэг Дайр-Үсүн охиноо Тэмүжинд бэлэглэхээр авчрах замдаа отгийн зайран Төгсжинтэй таарч аятайхан хөтөчтэй болсон нь энэ бөлгөө.

Бүсгүйн дэндүү сониуч зан Төгсжинийг нэвт ширтэж байвч хааны зогсож буй өндөрлөгт дөхөж очлоо. Дун цагаан морьтой, шийдмэг бүсгүй хааны нүдийг булаав.

Хааны нүднээс хуурай хүйтэн байдал арилж элэгсэг зөөлөн болов. Хулан бүсгүй хөө хар морины нуруун дээр хөндлөн сууж, ташаа тулсан Чингисийн харцнаас дальдирч байв. Өндөрлөгийн цаана хөв хөх тэнгэр Чингисийг улам омголон сүрлэг болгож дэвсгэрлэнэ. Тэр хүн тэнгэрээс морилж ирсэн гийчин мэт Хуланд санагдав.

Чингис хаантай нүүр тулж уулзах торгон агшин улам ойртсоор байлаа. Тэнгэр, газар эзгүйрсэн мэт цэрэг эрс чимээгүй дүнсийж, нам гүм болжээ. Хааны мөр дээгүүр ясан үзүүрт цагаан сум шивээлж түүний идэрмэг чийрэг бие хүлэгдсэн мэт хөдөлгөөнгүй бөгөөд морины алхаа нэг нэгээр дөхөж амьдрал эргэж байснаа гэв гэнэт зогссон мэт болжээ. Дун цагаан морьтой бүсгүйн ар талд Дайр-Үсүн, Төгсжин хоёр мориныхоо амыг татаж зогсчээ.

\* \* \*

Нэгэн жаалхүү насандаа ахадсан том чулуу тэвэрч уул өөд мацна. Мацах тусам уул улам өгсүүр болж чулуу хүнддэнэ. Жаалхүү уулын орой ойртох тусам амьсгаадан тэвчээр заан мацсаар байлаа.

Тэрбээр түр зогсох зуураа эргэж харав. Уудам хээр тал нэлмийн, тэр талыг сүлжиж хээлсэн гол горхи сул орхисон мөнгөн утас лугаа мушгарна.

Тэртээ хол үхэр тэрэгтэй хөсөг гол хөвөөлөн явах ажээ. Бас нэгэн хөвүүн чулуу үүрч мацна. Тэр хоёр хөвүүн чулуугаар хаан суудал өрж байв. Хаан суудал өрж дуусаад уулын бэлээс уралдаж суухаар хөвгүүд тохирсон нь өнийн явдал юмсанжээ.

## Хоёрдугаар бөлөг



*Гурван мэргидийг дайлж дагуулав. Тэдний цус тэнгэрт үсрэв. Чингис хааныг тэнгэр ивээжээ*



Чингис хааны хараанд дун цагаан морьтон өртсөн цагаас зүрхний догдлол ихсэж, сөл татарсан цагаан шаргал борог өвсний дороос нялх ногоо хэнзэлж хөхөмдөг униар татсан Гүр хар уулын бэл хормой уужимсаж түүний зогсож буй өндөрлөгийг Сэлэнгэ мөрөн тойрон эргэлдэх мэт болжээ. Сэлэнгийн бургас цэл ногоорчээ.

Бөөн ногоон бургасны завсраар Сэлэнгийн эргүүлэг цэнхэртэж, цэнхэр усны дээгүүр зурвас цагаан шугам татаж тэгээд эрчлэгдэн хугарч, хөх, хар хөх долгион эрэг мөргөнө. Усны гадаргуу дээр бургасны саравгар мөчир гарын сарвуу мэт гэрэлтэнэ. Мөрөн голын эрэг дагуух зэгс, сахлаг ногоо, шар, шар тохой, өндөр өндөр нарс усны бөглүү чимээнд бүүвэйлэгдэж ганхана. Тарианы шан харлана.

Чингис хаан бүсгүйг харж байна. Бүсгүйн унасан дун цагаан морины самсай сарталзан, молор толгой нь шувууных адил шунхайж, тунгалаг хялман нүдээрээ зэр зэвсэг агссан баатар эрс, хүлэг морьдыг хачирхаж, хаа, цээж, өвчүүний нь булчин гүрэлзэн зүтгэнэ. Хөө хар морины чих харацайн далавч мэт босч солбилзон байв. Сайхан хилэн хар дэл, шанх нь

цацаглан нэлмийн унжжээ.

-Хаантан өршөө!

Морины омруун дороос ийм үг дуулдахад Чингис хаан зовхио доошлуулж харвал цагаан дээлт, шувтан нүүрт Төгсжин зайран, шодон гээгтэй, алтан тоног бүхий бүстэй, шингэн сахалтай, угсаа сайт эрийн хамт сөгджээ. Толгойтныг бөхийлгэж, тойгтоныг сөгдүүлж буй Хамаг монголын хаан тоомжиргүй царайлна.

\* \* \*

Сэлэнгэ мөрөн, Орхон мөрөн, олон гол зэрэгцэж урсаад дундаа Талхун хэмээх бэдэрт арлыг үүсгээд бие биетэйгээ янагшин нийлж холыг зорьдог билээ. Талхун аралд хааны хээрийн асар дэрвэн босов. Чингис хааны нүүр царайны байдал жирийнхээс тэс өмнөө бодолд дарагдсан байлаа. Увас мэргидийн толгойлогч Дайр-Үсүнээс Чингис хаан,

-Чи охиноо авчрав. Хэн сэдэв хэмээн чандлан шалгаахад,

-Миний охин балчир боловч таныг зүүдэндээ үздэг гэнэ. Намайг амар байлгахыг болив. Тэр охин юу сэтгэснийг өөрөө мэднэ хэмээн өчив. Хааны сэтгэл ханамжгүй тул

-Эм хүнийг би үл итгэнэ. Тиймийн тул босгоны боол болгох ажаамуу гээд асар өөд харлаа.

Увас мэргидийн толгойлогчийн царай ов тов цоохортож айж хулчийснаасаа биеийнхээ бүх цусыг нүүрэндээ шахжээ. Түүний нүүр улам хүрэнтэж "энэ охин намайг өштөний өлмийд хаяв. Мэргидийн цус тэнгэрт үсэрчээ. Тоотой нас тегссөн бол охин үрийн гай биз" хэмээн хааны өмнө бөхийж зогслоо. Хааны хүдэр чийрэг хөл доор Бурхан халдун уулнаас үндэслэн монголын хээр тал нутаг, өндөр уулс дундуур салаалж салбарласан гүндбал, лууны ургамлын судас лугшиж байв. Хааны бие гүндбалын ургамалтай нийлсэн аж.

Дайр-Үсүнийг цацарт аваачиж хооллохыг хаан Боорчид тушаав. Дайр-Үсүнд тусгай цацар бэлджээ. Талхун арлын бэлчир бол тариа тарьдаг, загас барьдаг, завь хийдэг хүн, мал олноор бөөгнөрсөн үржил шимтэй, хусан ойтой нутаг билээ. Намуухан үдэш болохын үес Талхун арлын дээгүүр үүл бүрхэж, хэд хоногийн байлдааны утаа униар дарагджээ.

Үүл зузаарсаар байлаа. Үүл хүндэрч өнгө нь бараантах тусам ургамал, агаарын чийг анхилж Чингис хаан хүнд бодлоосоо аажмаар хагацаж асарт байгаа танхил бүсгүйг бодлоо. Тэнгэрээс бороо ганц нэгээр дусална. Бороо Талхун арлын баруун бөөрийг битүү хучсан үхрийн нүд жимсний хүрэн бор бутыг угаахад хавтгай дугуй навчис сэржигнэнэ. Тэртээх зүүн толгодын наана үхэр меернө. Бороон хөшигний дунд толгод хөх өнгөтэй харагдана. Бороо цайрахад холын уулс улам намсаж, өнө эртний мөрөөдөл мэт цахлай хашгичан эмэгчинээ дуудаж байна.

Асарт ойртох нь Чингист чухам яагаад төвөгтэй байгааг ухаж бодохыг хичээвч мэргид охины гурвалжин царай, гурвалжин хамар, гурвалжин чих, том нүд саад болно. Өндөрлөг дээр хаан тэр танхил бүсгүйтэй үгийн солиогүй Боорчи руу харвал багын андын санааг ойлгох тул шууд

цулбуурдан давхижээ. Одоо Боорчи гав ганцаар хааны хажууд зөөлөн шүхэрлэх бороонд норж зогсоно. Бороо хааны дуулга малгай дээр бус зүрхийг норгож байв. Хаан Чингис рүү шууд давхиж ирсэн анхны бүсгүй асарт хүлээнэ. "Намайг зүүдэлдэг гэж эцэг нь хэлэв. Бөртэ надтай сарны туяагаар холбогдож байсан. Хадаан надад гунигийн дуу аялж зүрхэнд минь хайр юүлж өгсөн. Гэтэл энэ буурал хорвоо яасан уужим билээ. Мэргид охин хэний элч бэ. Тэнгэр илгээсэн бол хайрын элч мөн. Эцэг Дайр-Үсүн нь явуулсан аваас хорлол мөн. Ямарч атугай намайг зорьж иржээ" хэмээн бодох Чингисийн харц Боорчийн цохон дээр онов.

-Боорчи-оо мэргид охин...

-Надад мөнгөн загас шиг санагдав.

-Яагаад тэр билээ

-Дэндүү том нүдтэй юм. Дээд, доод зовхиндоо хар зураас мэт өтгөн сормуустай, уян налархай биетэй, загас мэт гурвалжин төрхтэй илбийн бүсгүй байна. Би гоёмсог мөнгөн загас харав. Хаантан хэрхэн болгоов.

-Үзэх нүдэнд гүнж загас адил. Дотор санаа нь хэн буй. Би ийм содон төрхийг гайхна.

Боорчи хааны санааг тааж ядав. Дулаахан бороо шивэрсээр ахуйд Боорчи аялгуут хөгжим сонссон мэт тайван дөлгөөн байж "мэргидийн асгарсан цус угаагдаж байна" хэмээн санана. Талхун арал, хааны асар, тариан талбай дээгүүр бүдэг цайвар манан хөшиглөж, өвс ногоо дуншиж яргана.

- Борооших нь ээ гээд Боорчи шүүрс алдав.

- Уйтгартай бороо байна гэж Чингис сэтгэлээ тайтгаруулав. Бут, бут дамжих хөх бөднө часхийн дуугарч хааны үгийг дэмжиж далавч юугаа сэвнэ. Гүр харын ууланд авласан гөрөөсний мах бүх цэргийн тогоонд пор пор буцалж амар амгалан үдэш налайлаа.

Чингис хаан асартаа ойртохыг яарахгүй байлаа. Хөх асрын оройгоор нарийвтар улаан, шар туяа татаж буй бөгөөд тэр нь задгай галын гэрэл юм. Тэнгэр намссан мэт байвч энгүй уужим хэвээр зах хязгааргүй орон зайг ноёлон оршимуй. Хаантаны асрын гадуур гурван хүрээ буй. Их, дунд, бага хүрээний төвд хааны асар байна. Асрыг найман зүгээс шадар цэргүүдийн нүд ширтэж, нүдний хараа огтлолцон биенээ онох ажээ.

Зэр зэвсэг агссан Боорчид хуяг дуулгаа хөнгөлөх санаа байвч хааны дэргэдээс холдох сэтгэл төрөхгүй байв. Зүсэрсэн бороонд жимсний төглийн нуугдмал навчис хүртэл өртөж хярсан бүжингийн чихийг халхална. Амрагийн адбиш цэнгэлийг амсаж ханасан хааны сэтгэлийн гүнд огт сонсоогүй салхин аялгуу гэгэлзэн байлаа. Тэр аялгуу түгээмэл биш гагцхүү Чингис хаанд зориулагдсан болохоор Боорчи үл сонсоно. Үнэндээ хаан лүгээ өөрийн биеэр зоригтойхон давхиж ирсэн анхны тэр охиныг Боорчи гайхаж билээ. Мэргид охиныг Хасар, Мухулай, Зэлмэ, Бэлгүгэй цөмөөр гайхан баясан харж, ихэд шохоорхон таашааж, гурвалжин нүүр, том нүд нь үхдэл болохоос огт айхгүй шийдмэг болохыг анзаарч, тэгсэн мөртөө ташаа тулан ханхайх эрчүүд тэнгэрийн охины зургийг үзээгүй юм шиг царйлж байлаа. Охины



морийг Боорчи цулбуурдан давхихад дун цагаан адгуус баатар цэргүүдийг хуйлруулан тэдний зүрхэн дээр туурайн тамга үлдээжээ. Тэд сэржээ. Олзны мэргид эмс Дайр-Үсүний охинтой эгнэх аргагүй санагдана.

"Мэргидийн толгойлогч охиноо надад өгч хар толгойгоо аврах гэв үү. Эсвэл энэ хүүхэн надад тэнгэр заяат уу. Би зүүд нойрондоо нэг удаа ийм мөнгөн загас мэт хүүхэн үзсэн билүү" хэмээн Чингис бодолхийлэв.

Талхун арал бүхэлдээ борооны шиврэх аялгуунд умбажээ. Хааны хардах нь урьд өмнөхөөс багасаж байлаа. Мөдхөн хааны өмнө бүсгүйн цээж нүцгэрч, ягаан товчтой цагаан хөх сэрийж байхад баруун гараа түүнд хүргэлээ. Хөх лугшиж, хүүхний амьсгал түргэсэж давхацлаа. Хөхөн дээр хүрсэн хурууны өндөг хүүхний биеийн анхны хээ байв. Хурууны хээ хүүхний бие дээр тодоос тод гарахад Чингис хаан дотогш амьсгаа түрлээ.

-Хулан чи намайг хэзээ зүүдлэв гэхэд Хулангийн нүд ормолзон "таны нэрийг дуулсан цагаасаа..." гэв.

-Чи онгон танхи юм. Айхгүй байна уу гэхэд Хулан цочисхийн толгой сэгсрэв. Түүний сэргэр хөхнөөс Чингис хаан гараа бас цочсон мэт татан авч,

-Тэрлэгээ өмс гэж тушаав.

Хулангийн зузаавтар хэрнээ тод зурагтай уруул өмөлзөн чичирч, хааны өмнө давчдан дагжиж байсан бие дээгүүрээ тэрлэгээ гулсуулан нөмөрлөө. Мэргид бүсгүйн биений донсолгоон хаанд нөлөөлж хааны таван хурууны өндөг халуу шатав. Хааны нүдэнд гал асчээ. Чингис хааны шанханд унасан мөнгөн сор галд хуйхлагдах мэт болов. Хааны гурвалжин хэлбэрт босоо хөмсөг орооцолдох адил мушгирсанаа буруу харж,

Чи эцгийнхээ толгойг төлөөлж над руу иржээ гэвэл Хулан дургүйцэн,

-Бүх мэргидийн толгойг... гэж залруулав.

-Үхэл чамайг дуудаж... гэж хааныг хэлтэл,

-Тэнгэр намайг дуудаж... хэмээн Хулан нөмгөн чигтээ өгүүлэв.

\* \* \*

Хулан бол гуравдугаар жарны улаан морин жил төрсөн Чингис хааны гутгаар хөвүүн Өгөөдэйн цацуутан байлаа. Сүүлийн хоёр жилд Хулан нүд нээж амрагийн явдлыг харжээ. Мэргидийн хот айл нутаг сэлгэж холбоо гурван цөөрмийн дунд буужээ. Тэр үдэш хот айлынхаа эгчмэд бүсгүй Нэрсийг дагаж цөөрөм рүү очив. Нэрс бүсгүй Хуланг бутны дэргэд орхиод "одоохон ирнэ" хэмээн одов. Үдшийн сарны гэгээнд нуур цөөрөм, ой шугуй, жимсний бут хөхөлбий өнгөөр дүнсийв. Хэзээ ч ийм дүнсгэр хөх шөнийг Хулан мэдэхгүй болохоор Нэрс хэдийд ирэхийг хүлээж суув. Цөөрмийн тэртээд нугас нургиж хааяа далавчаараа ус үсчүүлнэ. Гэнэт Хулан охин бачим амьсгаа, гиншин тачаадахыг сонсов. Шөнийн бүдэг хөх

гэгээ, анир гүмийг эвдэж янагийн шивнээн, амраглах долгионд Хулан авгаж бяцхан зүрх нь баяр баясалтай юм шиг догдолно. Нэрс бүсгүй буцаж ирэхдээ хаана, юу хийснээ хэлээгүй боловч Хулангийн гарыг чийг даасан алгаараа илж "Мэргидийн агтчин Цоохортой уулзав" хэмээн ичингүйрэн хэлжээ. Цоохор бол домбо шиг ойлон толгойтой шалмаг залуу билээ.

Нэг удаа Цоохор овоолоостой гишүүний цаана Хулангаар Нэрсийг дуудуулж уулзсаныг саналаа.

Зуны сүүлчээр мэргидийн хот хүрээг нозоорсон халуун өдрүүд төөнөв. Нэрс бүсгүй жимс, мөөгөнд явах бүрийдээ Хулан охинг дагуулах бөгөөд буг сөөг, моддын хооронд хавтгай хөвд дунд Цоохортойгоо уулзаж, гар гараасаа атгалцаж, духаа нийлүүлж, хувцсаа тайчиж цэнгэнэ. Олон арван навчны цоорхойгоор Хулан тэднийг хэрхэн аяглахыг хөхөн харна. Цоохорын шодон гээг савчин хөдөлж эхлэх үесэд Нэрс дуу алдан ичингүйрлээ гэж "Хүүхэд харчихвал яана" гэж гиншинэ. Агтчин Цоохор самсайгаа сэтэртэл амьсгаадахад, хушны оройгоор үсчин буй хэрэм зогтусаж чагнаархана.

Хулан чихэнд сонсголонтой, тагнайд амттай тэр мөчийг өнгөртөл харж Нэрстэй цуг санаа алдаж, эр, эм хоёр могой мэт орооцолдож болдгийг гайхна.

Хойтон жил нь Нэрс бүсгүй амрагийн явдал цэнгэлийг Хуланд ойлгуулан ярьж, аав. ээждээ хэлэхгүй байхыг захижээ. Тэр ч бүү хэл "чамайг харж байгаа гэж санахаар улам сайхан болдог" хэмээн өгүүлэхэд амрагийн явдалд долиггоршсон бүсгүйн үг гэдгийг Хулан ухаж ойлголгүй өнгөрсөн ажээ. Тэр цагаас хойш мэргидийн хот хүрээний хаяа, цөөрмийн зах, малын бэлчээрт өт хорхойны сэрэл хөдөлгөсөн ийм явдал болдгийг Хулан сайтар мэдэж, нүдээр үзсэн юмсанж.

Хулан нөмгөн зогсоно. Асар дээр борооны дусал шивэрч, тасралтгүй үргэлжлэх хөгжмийн аялгуу мэт нэгэн хэмээр зөөлөн уянгална. Асрын үүдийг буулгажээ. Морьд тургих, амгай шаргих, цэргүүдийн өвө" хоорондоо хүүрнэх яриа татарч, үүлс битүүрч, зөвхөн хааны асар газраас ургасан мэт чийгэнд умбажээ.

Чингис хааны нүдний харц, гарын хөдөлгөөн ноцтой амьсгал Хуланд айдас хүйдэс төрүүлэхгүй байлаа. Тэрлэгнийхээ товчийг товчилж, хааны учир битүүлэг тушаалыг дагасан Хуланг хөөж туусанч явахааргүй эрс шийдмэг зогсоно. Цэцэг хагдарч сөл татарсан хойно туяхан ишин дээрээ ганхаж үлдсэн ганц ширхэг согоо суман цэцгийг Хулан санагдуулна. Түүний хөх чимчигнэн, хааны хурууны хээ шүргэсэн учраас нүгэлтэй халуун шатна. Хэдийчинээ хугацаа өнгөрч ямар орон зайд тэр хоёр байгаагаа эргэн санах аргагүй болжээ. Хаан босов.

Хуланд тэрбээр тулж ирээд түүний том нүдийг цоо ширтлээ. Хулан том нүдтэй дээрээ цагаан нь дэндүү тунгалаг тул ид шидийг агуулжээ. Хаан тэрлэгний товчийг имэрч тайлахад Хулангийн биенээс дээл нь мултарч уналаа. Дараа нь цамц хийгээд бусад хувцсыг хаан өөрийнхөө гараар тайлж Хуланг нүцгэлэв. Бүсгүйн хүзүү, цээж, хэвлий, бөгс, ташаа, шилбэ нь хааны өмнө тодорхой болов.

Тэр шөнө Чингис хаан, Хулан хоёрын хэвлийгээр Сэлэнгэ мөрөн илж таалан должилж, өвс

ургамлын үндсийг нэг нэгээр чичрүүлэн урсаж хонов. Зөөлөн тунгалаг бороо Талхун арлын агаарын орон зайг эзэгнэн шивэрлээ. Ой модны хожуул нэвт норж, тарианы соёо бүлт өсөж, жимсний бутнаас нахиа задарсан байжээ.

\* \* \*

Увас мэргидийн язгууртан Дайр-Үсүн өчигдөрхөн охиндоо өширхөж байснаа умартаж "мэргидийг аврав" хэмээн бодсоноо цацрын үүдэнд суугаа Төгсжин зайран руу ойртов. Чингис хааны асрын дэргэд хоёр загал морь эмээллэж сойсон байв. Хоёр загалын дэл, сүүлнээс шонхор шувууны өд сөд зүүж ижилсүүлжээ.

Зайрангийн загасан нүд нь далны яс шиг төрхөндөө огт зохиогүй санагдсаар байдгийг Дайр-Үсүн тэрхэн зуур мартсан юм шиг байснаа төдөлгүй сэхээрч "энэ зайран Чингис хааныг нохой шиг дагана" хэмээн зэвүүрхэв.

Төгсжин зайран Дайр-Үсүний баяслыг мэдэрч "хэрэв Бөртийн толгой руу алтан үрэл асгаж байсныг Чингис хаанд дуулгавал Дайр-Үсүний амь таслагдана" гэж тоомжиргүй бодлоо.

-Мэргидийн толгой өндийх үү гэж Дайр-Үсүн асуув.

-Хамаг монголчууд нийлсэн гэж Төгсжин өчлөө.

-Хаан миний охиныг таалжээ.

-Хулан биднээс илүү ухаалаг юм.

-Зайран бөөгийн шатаасан далыг хаан яагаад бяц атгаж, үнс чандруу болгосныг би бодоод байна.

-Хааны алганы хээ далны хуудсанд буусан хэрэг.

-Хааны төөрөг ямар бэ. Хааны алганы хээг шинжив үү.

-Хоёулаа толгой мэнд үлдэе, толгойлогч минь. Чингис хааныг одоо хэнч дийлэхгүй...

Дайр- Үсүний нүдэнд үерийн ус шиг их цэргийн цуваа харагдана. Ийм их усыг хэн сөрөх билээ. Сэлэнгэ мөрөн мянган гол усыг нийлүүлж Сэлэнгэ мөрөн хэмээх их усан болсон бус уу. Сэлэнгэ мөрний их урсгалыг зогсоох хүчин бий юү. Сэлэнгэ мөрөн Талхун арлыг үлдээж урсчээ. Усны урсгалын хүчит чимээн Чингисийн их цэргийн морин төвөргөөнийг дэмжиж шуугих авай.

\* \* \*

Талхун арлын зөөлөрч дэвтсэн хөрснөөс манан хөөрч, төдхөнөө нарны хурц туяанд замхарч, урьд шөнөжин бороо шивэрч, ногоо ургаж хоносныг мартуулав. Хааны гоёмсог асар байсан тэрхүү өвс ногоон дунд Чингис хаан, Хулан хатантайгаа хоёр загал морьтойгоо зэрэгцэнэ. Дайр-Үсүний цацар эмээлийн ганзагалаанд эвхэгджээ. Цэргийн цуваа хөдлөхөд хэдийнэ

бэлэн болжээ. Олзныхоны хуаранг цэгцэлж тараажээ. Олзлогдсон эмс хүүхнүүд боржигоны олон цэргийг дагаж явна.

Дайр-Үсүний эрхэмсэг шар сахлыг хичээнгүйлэн харсан Чингис хаан,

-Миний их цэрэгт гөлмөө давирч явсу хэмээн тушаав. Мэргидийн толгойлогчийн сахал дундуур ямар нэгэн юм жирвэлзэн орооцолдоо нь гарах мэт хөдлөтөл хаан хэлэв.

-Би чамаас гурван гэм тулгаж ял асуух байсан. Тэнгэр үүнийг гэрчилнэ. Гурван мэргид хуйвалдаж Өүлэн эхийн булаагдсаны өшөөг нэхэж Бөртэ хатанг булаасан нэгэн гэм буй. Тэмүжиний хатанг булаасны дараа тэнэг аймхай Чилгэрт асруулж, Хуагчинг ятгаж Бөртийг өөртөө авах гэсэн нэгэн гэм буй. Бөртэ хатан дээр алтаар бороо оруулах гэхэд Дайр-Үсүн чиний өмнө сөгдөөгүй билээ. Намайг алгандаа нөж атгаж төрсөнийг сонсоод аймшигтайгаар хашгирч "Есүхэй баатрын хөвүүний баруун гарыг тасдаж хая" хэмээн хэн хэллээ. Энэ бол Дайр-Үсүний хүнд гэм билээ. Намайг багад хорхой идсэн баавгайгаар гишгүүлэх санааг гурван мэргид сэдсэнийг тэнгэр гэрчилнэ.

Хааны омголон хурц үг Дайр-Үсүний цээжийг нэвглэн зүрхэнд сум шиг зоогдов.

Эцгээ Төгсжин зайранг дагуулан их цэргийн цуваа РУУ УУсан одоход Хулан бүсгүй тэдний хойноос дагуулан харсаар байлаа. Дайр-Үсүн угаас тавьгиргүй тул эцсийн эцэст цэргийн тоосон дунд явах болжээ. Хулан бүсгүйн төрх байдал Чингис хаанд элгэмсүү атлаа сэтгэлдээ гунигтай байв. Хулан тэнгэр заяат хаанд өөрийгөө тушааснаар овог аймгаа аварсан төдийгүй гэм нүглийн цээрийг гаргажээ.

\* \* \*

Хамаг монголын хэрэйд, мэргид, боржигон, татаар, урианхан, жүрхэн олон овгоос бүрдсэн цэргийн цувааны түрүүч нар ургасан тэнгэр рүү дамналдан хөвөрч ахуйд сүүлийн цэрэг Талхун арлаас мориндоо дөрөөлж байв. Нар, тэнгэр, газар гурав ээнэгшин нийлжээ. Тэнгэр, газрын зах хязгааргүй савслага шаргал, хөхөмдөг, ногоовтор туяагаар Чингис хааны цэргийг уусгаж байлаа.

Энэ их цэрэг монголын хээр тал нутаг, өндөр уулс, өргөн гол усыг хэрэн хэжиж, хиур сүлдээ намируулан он жилийг өртөөлөн одох эхлэл нь Талхун арал бөлгөө. Төгсгөл нь орон дэлхийн хаана байхыг хүмүүн төрөлхтөн мэдсэн гэж үү.

Дайн байлдааны хүнд хүчрийг гурвалжин нүүртэй, том нүдтэй, алиахан Хулан даван туулахаар Чингис хааныг дагасан үлгэрийн төгсгөл мэт өдөр үргэлж баяраар дүүрэн бус байхыг бүсгүй төсөөлсөн гэж үү. Цэргийн цуваа галын дөл шиг цоролзож өндөлзөн буй өвсөн дундуур цэл ногоон шүүсээр өвдөг, гутлаа будан байгалийн гүн шимийг хүртэж одов оо. Хөх, шар, улаан нүүртэй, жартгар нүдтэй шалмаг цэргүүд гөлөм юугаа давирч уулын орой, сугаар тэнгэр өөд явж байлаа.

Чингис хааны Хулан хатанг Хэрлэнгийн хөдөө аралд нутаглаж буй Өүлэн эх нь хүлээж байв. Өүлэн эхийн сэтгэлд Чингисийг саранд дурламтгай байсан үеийг эргэж санахад хүргэжээ.

Монголын их цэргийн цуваа бороон дундуур хөвөрч явна.

## Гуравдугаар бөлөг



*Мэргидийн толгойлогч Дайр-Үсүн Бөртийн толгой дээр алтан үрэл цацаж "миний зхнэр бол" хэмээн гуйжээ.*



Хаврын өглөө шар усны уруй уулын гуу, жалга бүрээс цутган бууж гол бор хоормог болж үерлэнэ. Ногооны үндэс хөөсөн байлаа. Тэрэгний дугуй чихарч чийгтэй хөрсийг гүнзгий мөр гарган зүсч байна. Тэрэгний ачаа хүнд тул газрын зөөлөн хөрснөө дугуй нь шигдэж чангаажээ. Чингэлэгт хөнгөн сүйхэнд мэргид Чилэдү саяхан Ольхон нутгаас буулгаж авсан залуу хатан Өүлэний хамт явна. Өүлэний царай тунгалаг, цээж хөх түлхүү ер бусын жавхаалаг атлаа бодолд дарагдан явна. Сүйх тэрэг болоод морьдын эмээл хэрэглэл алтан тоноглол бүхий ажээ.

Чилэдү хэмээх мэргид овгийн ясан шанаатай, омголон зантай баатар эр Өүлэн бүсгүйд,

-Миний арван үеийнхэн хөх тэнгэрт магтаал ергөсөн юм. Тэр нэн эртний үед бидний мэргид ирээдүйгээ зөгнөн төлөг буулгаж ирсэн. Сайн төлөг буусны хүчээр би чамтай учрав гэж бахархан өгүүлнэ.

Өүлэн түүний бардам яриаг сонсож ямар нэгэн хариу хэлэхээс зүрхшээн байв. Сүйхний

алтадмал цагираг морины явдалд гялалзан гялталзан тал тал тийш найгалзахын тоолонгоор өнгө нь тодорч бүдгэрч хөдөлнө. Хонхот тэрэгний дэргэд яваа цагаан дээл өмссөн хурц бөөрөнхий нүдтэй Төгсжин тэргэнд яваа Чилэдүгийн яриаг тодхон сонсож байсан тул,

-Төлөгч нар тэгээд таны ирээдүйг чухам ямраар зөгнөв дөө. Та тэдэнд итгэсэн үү хэмээн дотночлон асуулаа.

-Тэд зөгнөсөн, би сонссон. Чи юунд санаа зовоов. Тэдний зөгнөлийг биелээсэй гэж итгэж явбал чамд өлзийтэй бус уу. Чи өөрийнхөө заяа төөргийг надад эхлээд хэлэгтүн.

-Миний хувь тавиланг хэн урьдаар хэлж өгөх вэ. Би бол зайран гэвч эгэл борчуулын нэг билээ. Дал шатаахаас цаашгүй хүн шүүдээ.

-Эхнэрийн хувьд та нар санаа зовох юун. Бэл бэнчингийнхээ хэмжээнд таарсан эхнэртэйгээ ханилах учиртай бус уу. Тэнгэрийн зөнгөөр та нар юу хийнэ. Эхнэр хүүхэд тэжээхээс гадна цэрэгт явж, аян дайны хөлд амь үрэгдэж мэдэх учраас болгоомжтой байхад илүүдэхгүй.

-Мэдээж удам угсаа сайтай айл барлаг боол, зайран бөөд охиноо өгнө гэж үү. Чилэдү та зөв айлдлаа. Бид бол үхэхийн тулд амьд яваа юм.

-Төгсжин чи сонс! Өүлэн хатан болбол ялагдашгүй баатрыг төрүүлнэ гэж төлөгч бөө айлдав. Чамд ямар совин буй бол зөн совингоо надад нэг хэлээрэй. Хол газар үүрэглэж явсанаас хуучилж явбал зугаатай бусуу. Чамайг зайран бөө болгож миний ах Дайр-Үсүн өргөмжилсөн учраас надад үг зөөж бай.

Сүйх тэрэгний үүд сөхөгдлөө. Өүлэн үзэсгэлэн төгс ажээ. Чилэдү хүүхний үзэсгэлэнд автаж түрүүчийн ярианд сэтгэл ханасан авч гонсгор байна. Харин Өүлэн бүсгүйн хосгүй тунгалаг нүүр царайд хүлцэнгүй ноомой бус тэсч ядсан бардам янз илэрхий. Орхон, Сэлэнгийн уулзварт бөөн, бөөн бургас багсайтал гөлөглөж, шар өвсний дундаас хавар цагийн ногоо орон зайгаа булаалдаж түрэмгийгээр орооцолдон ургажээ. Өдөржингөө тэрэгний явдалд бүүвэйлэгдсэн Өүлэн хоёр их мөрний нижигнэн урсах түрлэгийг сонсоод баясаж байлаа ч нүдний харц сэтгэлийн зөн нь нэг юм эрнэ. Түүнд Чилэдү баатар ирэх цагийн аугаа баатар эрийн эцэг болж чадах хүн мөн үү гэж бодоход сэтгэлд хур буухгүй байжээ.

Өүлэн зүг, зүг тийш хараачлаж гэнэт түүний нүд баяр хөөрөөр гялсхийх бөгөөд гүн шугуй руу шунамхай ширтэж эрэлхийлнэ. Шар усны үерт автсан шугуй, нуга дээгүүр нүүдлийн шувууд наадна. Ангир шувуу газарт хоногшихоор гунганан ганганаж, моддын мөчир бүрт болжмор дүүжлээстэй найгалзан жиргэж шувууд найрал хөгжим мэтдуугаа авалцан өрсөлдөнө.

Сүйх тэргийг дагалдан яваа морьтон цэргүүд гол уруудан талийжээ. Тэд гарам хайн оджээ. Чилэдүгийн шанаа гүрэлзэн, магнай нь таагүй үрчийн Өүлэнг дагана.

-Энэ хавьд нэг гарам байсан юмсан. Би шувуу агнаж яваад олсон юмсан хэмээн амандаа үглэн газрын баримжаа ажиглаж байв. Энэ зуур Өүлэн хатан голын эргээр алхана. Түүний еэтэн гоёмсог гутал шаварлаг элсэнд шигдэн тод мөр үлдээнэ. Тэр мөр шувууны өндөг тавьсан мэт зууван хэлбэртэй байв. Өүлэн моддын дунд зогсож, эргэн тойрноо нэгжин нэг

зүйлийг эрэх аж. Ойрхон хэн нэгэн байгааг ёрлоод байв. Шувууд жигүүрээр ус цацлуулан дэгдэж улмаар сүрэглэн Орхон, Сэлэнгэ мөрний дээгүүр цуцтал эргэлдэн зугаацаж уралдан бууж байлаа. Зэгсэн имжээртэй багил шугуй дундаас шувууд үргэж тэнд ямар нэгэн амьтан явааг илтгэнэ. Сум исгэрэн нисч өвгөн модны голд ханхийн зоогдов. Түүний цаана бас нэг сум сахлаг өвсөнд мөн зоогдоод эрч нь хариагүй тул өдний аясаар ганхаж байна.

Өүлэний чих сонор тул ийш тийш харав. Гэтэл сумны гоёмсог өдөн чичрийн өмнө сийлсэн цагаан шонхор шувууны дүрс тодорч бүсгүйн анхаарлыг татлаа. Тэрхүү сумыг зоогдсон модноос суга татан авч эргүүлж тойруулан үзэхдээ шонхор шувууны гайхамшигтай дүрсийг Өүлэн ажиглаад "энэ хэний сум буй" хэмээн зүрхнээсээ асуув. Зүрх нь хариу хэлэхийн оронд хариу нэхэх мэт оволзоно. Намайг хэн дагаж явна вэ. Тэр шонхор шувуу ямар овгийн тэмдэг билээ. Голын хөвөөний битүү зэгс намилзана.

Тэнд яваа амьтны хөлөөр газрын хөрсний ус шал палхийв. Өүлэн модны араар нуугдав. Зэгс баруун зүүн тийш налж ярагдан явган хүний аясаар бөхөлзөн долгилох ажээ. Тэндээс нэгэн идэр эр эрэг рүү бууж харагдав. Тэрбээр өндөр түрүүтэй мөртөө элдүүр нь ханасан бугын арьсан гутал өмсчээ. Мөрөндөө саадаг өлгөсөн нь өнгө өнгийн өдөөр чимсэн дүүрэн сумтай байв. Түүний цаана морьд тургилян, галуу нугас агнах чимээ гарч байгааг Өүлэн сонсов. Баг цэрэгтэй явааг бодоход цагаан шонхор овгийн толгойлогч мөн гэж Өүлэнд бодогдоно. Өүлэнийг бүсэлжээ.

Алтан чимэг, тоног бүхий бүснээс зүүсэн сэлэмний хуй нь нарны гэрэлд солонгорох нь эрдэнийн чулуун шигтгээтэй ажээ. Идэр эр тас хар үсээ илсээр сумаа хайн эргэлдэж моддын чөлөөг гярхай ажна. Өтгөн өвс дотор зоогдсон сумаа суга татаж цайвар ясан хошууг нь авч өвөртлөөд ишийг эргүүлж зоов. Модны ард нуугдсан Өүлэн дуу алдах дөхсөнөө амаа барив. Идэр эрийн нүд хүрэн бөгөөд усны цээлд гялалзах тунгалаг чулуу шиг үзэгдэнэ. Тэрбээр гараа алдалж,

Тараад ир. Би чиний гишгэсэн мөрийг харж байна шүү гээд нумаа авав. Яах ийхийн завдалгүй нэгэн сум исгэрэн нисч Өүлэний өмнөх модонд шунхийн зоогдлоо. Өүлэн гартаа түрүүчийн сумыг барьсаар модны цаанаас царай зүсээ харуулав. Өүлэний турьхан бие бэлхүүсээрээ гунхалзан ойр ойрхон гашгэх хөл бяд муутай хэрнээ танхил болохыг гэрчилнэ.

-Яг үлгэрт гардаг шиг гэнэт уулзлаа даа. Миний сум намайг залж явдаг юм. Тэнгэрийн ерөөл бус уу гэж залуу эр өгүүлэв. Өүлэн бүсгүй,

-Та хэн буй. Шонхор шувууны дүрс ямар овгийнхоны бэлгэдэл бэ гэж асуув.

-Би Бодончар мунхагийн гол удам билээ. Намайг Амбагай хааны ач гэнэ. Намайг Бартанбаатарын хөвүүн хэмээнэ. Есүхэй баатар би биеэрээ өмнө тань зогсож байна.

-Та нар улаан зам отоож байжээ. Тийм үү. Надад хачин санагдаад явсан юм.

Есүхэй болгоомжтой алхам ойртсоноо,

-Өүлэн чамайг аль эрт анзаарч зам турш дагаж явсан болохыг мэдэхтүн. Манай туршуул



танайхны хоногдосон газар чамайг олж харсан билээ. Хаан хөвүүн төрүүлэх алтан хэвлийтэй гэдгийг тань хүртэл мэдсэн гээд би ямагт өндөр зэгсэн дунд зогсож алсаас харж байсан хэмээн нэмж хэлэв. Өүлэн бүсгүй үл мэдэг инээмсэглэн сайшаагаад,

~Та намайг мэргэн сумаараа золтой хөнөөчихсөнгүй гээд сумыг Есүхэйн гарт нь бариулан эргэж одлоо. Өүлэний гарын илч Есүхэйн гарт бүлээнээрээ шингэв.

Есүхэй нүүгэлтэн буй шувуун задыг үргэтэл "Байз" хэмээн дуу алдаад,

-Чиний үзэсгэлэн төгсийг би гайхна. Чи надад итгэ гэв. Өүлэн эргэж харсан чигтээ,

-Би Чилэдүйн эхнэр. Та миний салаа гэзгийг харахгүй байна уу. Миний эр нөхөр мэргидийн баатар Чилэдү энүүхэн мөргөцөгийн цаана намайг хүлээж буй гэсэнд Есүхэй,

-Чамайг би зүүд зөндөө олонтаа харсан юм. Худал гэвэл тэнгэр мэднэ. Өүлэн чамтай тэнгэрийн ивээлээр учирлаа. Орхон, Сэлэнгэ мөрний уулзварт миний сум соёлон ургаасай гэж хүснэ гэв. Өүлэн баахан тэвдэж,

-Боржигоны Есүхэй баатар та мөн гэж үү. Залуугаараа баатар болсон танд хатан хаанаас ч олдох буй за. Хатан болох бүсгүй танд байгаа биз дээ. Намайг орхи. Төвөг чирэгдэл болоогүй дээрээ би өөрийн эр дээр очихуудаа хэмээн тээнэгэлзэнгүй өгүүлбэл Есүхэй цааш лавшруулан,

-Хаврын байлдааны дараа Амбагай хаан надад баатар цол хүртээсэн билээ. Хатны хувьд гэвэл ээж, бэргэд одоохондоо хэлэлцэж буй. Тайчуудын нэг бүсгүй буй боловч би түүнтэй ёсолж дэр нэгтээгүй нь үнэн. Тэр бүсгүйн нэр Сочихэл гэв.

-Бусдын эхнэр чамд хань болно гэж үү

-Бүр зүүд нойрондоо би чамайг сонгож, чамайг үзэж байсан билээ.

Өүлэн тэнгэрийн хаяа руу тархинд эргэлдэх үй түмэн бодлоосоо хагацахын тулд шимтэнгүй харсанч явчихаж үл төвдөнө. Хэрэв хашгирч дохио өгвөл Чилэдү баатар сэлмээ сугалж дайран ирнэ. Мэргидийн отог овогт очоогүй байтлаа эр нөхрөө бусдын сумны бай болгох гэж үү. Яагаад Есүхэй баатар зам хөндөлдөнө вэ. Чухамдаа боржигоны Есүхэй баатрын суу дуулиан монгол туургатаны дунд тархаад байсан үе билээ. Дайн байлдаанд овжин эрэлхгээрээ гайхагдсан Есүхэй бол намирсан хар үстэй, шанаа туушин урттай, догшиндуу нүдтэй, Амбагай өвгөөрөө ихэд бахархдаг нэгэн ажээ. Алтан улсад Амбагай хааныг цовдолж алсан өшөөг авахыг чармайж байдгаараа монголчуудын чихийг дэлдийлгэсэн баатар Есүхэй Өүлэн бүсгүйн яг өмнө очиж,

-Нэр, нэрээ мэдэж, нүүр зүсээ харав. Чамайг мэргидийн Чилэдү надаас урьдаж авчээ. Эхнэр бол хувцасны өнгө солихтой адил юм. Би чамайг мэргидээс булааж авна гэвэл Өүлэнгийн царай хувьсхийн нүд нь гунигтай дүрлийж,

-Хувь төөргийг таахад бэрх ажээ. Охин заяа төрхөмдөө үнэгүй хойно... эмс бид эрчүүдийн

зугаа төдий юм хэмээн аргагүйдсэн юм шиг хариулжээ. Есүхэй баатар өөрийнхөө санааг улам хүчтэй тулгаж,

-Өүлэн чамайг би ургамлын үндэс тоолж, уулын сархиаг, гуу жалга бүрийг нэгжиж, усны урсгалыг самнаж байгаад олохдоо нэг олно. Ямар овог, аймагт очно, тэндээс авч чадна. Эсвэл илдний ир, хүлгийн хурдыг шалгаж булаах болно гэхэд Өүлэн дуугарсангүй. Нэг бодоход Есүхэй баатар арга эвэнд гаргуун, ил цагаан үгтэй санагдана. Нөгөө талаар холч мэргэн санаатай бодогдоно. Мэргидийн Чилэдү баатарт дутуу бүхэн Есүхэйд цогцолсон тул зам зуурын тохиолдолыг Өүлэн хүлээн зөвшөөрөвч, тэгэхдээ Чилэдү баатрыг золигт гаргахыг үл хүснэ.

Есүхэй баатрын харц Өүлэн үжинг олзлон түүний бие дээгүүр хэсүүчлэн тэнүүчилж, өлөн араатны шуналыг агуулна. Өүлэн бэлхүүс нарийн хөх том, өгзөг хондлой бөөрөнхий болоод гуниг тогтоогүй цайвар царай, тогтуун дулаан харц тэргүүтэн яруу зохицолтой тул Есүхэй хэт тэмүүлэлдээ авгаж улангасан ээрч билээ. Өүлэн үжин үнэ хүндээ алдахгүйн тулд сэтгэлийн гүнд буй догдлолоо тас нуув.

\* \* \*

Хурим найрын алтадмал сүйх тэргийг довтолгон явааг Есүхэй баатрын баг цэргийн нэгэн хижээл бөө Цагаанбух үзээд түүнийг мөрдөн мөшгиж Сэлэнгэ мөрөнг өгсөв. Сэлэнгийн эрэг дагуух зам харгуй хэжлүүр ихтэй, дов сондуултай, намаг шалбаагтай ажээ. Чингэлэгт сүйх нь бараа ачсан бололтой гүн ховил үлдээн морины хар хүчийг шавхаж явсанаа гэнэт зогсож мэргидүүд түр буудаллав.

Яг энэ үеэр туршуулд явсан Цагаанбух зайран морио нарсан төгөлд чөдөрлөж орхиод бут сөөг дамжин, цоор ихтэй зэгсний араар тойрч сүйх тэрэгнээс буусан үзэсгэлэнт бүсгүйг отлоо. Шар усны үер дөнгөж татраад уруйд идэгдсэн газрын хаван ихэссэн байлаа. Ус урссан ховилд бор навчис, үндэстэйгээ ховхорсон хөх өвс бөөгнөж бутанд наалджээ.

Сум арзайтал шигтэсэн мэт сэрийх цооргонын бутны ард Цагаанбух нуугдав. Мэргидийн багийг дагаж яваа ноход боорлож, бүсгүйн хойно өмнө орон наалинхайтаж хуцна. Сүйх тэрэгний хөтөч бололтой махлаг эр ташуурын сурыг агаарт эргэлдүүлэн исгэрүүлж жов, жов хэмээн нохдыг омогдоход сүүлээ хавчин буцацгаалаа.

Мэргидийн нохдоос баахан эмээж асан зайран бөө өндөр босоо цооргонын дунд суугаад хотгор руу орж сөөгний ард үзэсгэлэнт бүсгүйг суухад "энэ бүсгүй" боржигонд ерөөлтэй юм байна даа" гэж бодсон билээ. Нэгэнтээ хэд хоног дагаж өдгөө түүний гоо төрхийг сэрэмжлэн харахуйд тэнгэрийн бүтээл гэж Цагаанбух зайрангийн тархинд буужээ. Зайран бөө бол хүнийг танихдаа долиггоршиж, тэнгэрийн дуудлагыг таван мэдрэхүйгээр нэвт сонсох учраас цоргоноос ус дуслах эгэлгүй чимээг сонсов. Есүхэй баатар зайранг ихэд тоож дандаа дэргэдээ байлгах дуртай билээ. Зайран Цагаанбухд Есүхэй итгэдэг байлаа. Энэ удаа зайран бөө Есүхэйн зараалаар цооргонын бутанд хэвтэнэ.

Ачир дээрээ Есүхэйд эхнэр олохын тулд юм. Мэргидийн хөллөсөн морьд, сүйх тэрэг цөм алтан тоноглол, чимэгтэй нь даржин бус угсаатай хүмүүс явааг анхнаасаа гадарлаж учир

начрыг олохоор омголон морьдын хурдаар нэхэж, нуугдаж яваа бүлгээ. Охидын өнгө зүсээр баатар эрс хоорондоо гайхуулж, язгуурлаг амьдрахыг хүсэх нь эртнээс монголчуудын өрсөлдөөн юм. Бутны цаана бүсгүй удаан нуугдаж босов. Түүний нүд сэргэлэн, царай цайвар, нуруу гоолиг тэгш ажээ.

Бүсгүйн явдал эрвээхэй мэт хөнгөхөн, гишгэрэл бүтэн дүүрэн, гар, хөлийн хөдөлгөөн уян байв. Тэрбээр явж байхдаа маш сэргэг, зочимтгой, ажигч гярхай болохыг Цагаанбух мэдэрчээ. Мэргидийн хөсөг зөвхөн бүсгүйг тайвшруулахын тулд түр буудаллаж, Сэлэнгэ мөрөнг өгсөж одлоо. Газрын хэвгйд сүйх тэрэг хотосхийн цахилах нь оньсон нумтайг илтгэнэ.

Мэргидүүдийг явсан хойгуур Цагаанбух хормойдоо наалдсан хонгорцогийг гэвсөөр үзэсгэлэнт бүсгүйн суусан бутыг чиглэж очив. Дэрсний дунд хонхор байна. Хонхорт угаагдаж хонхойсон элсэрхэг бор хөрснөөс барын чих хэмээх шар бөрлөн цэцэг дэлбээ нээсэн байв. Тэр цэцэг барын чих мэт үзүүртээ бор толботой, таван дэлбээтэй содон ургамал учраас Цагаанбух гүйцэд таньж "эхтэй хүн үхдэггүй гэдэг. Эхийн усаар цэцэг хүртэл умдаалж дэлбээ нээдэг юм байна. Энэ гоолиг хүүхэн болбол ер бусын рашаан биедээ тээж явдаг бумбын хэвлийтэй эмэгтэй юм" гэж бодсон билээ. Зайран буцаж ирээд Есүхэй баатарт ганцаарчлан,

-Чамд аз тохиов. Үзэсгэлэнт бүсгүй алтан хэвлийтэй, рашаан устай ажээ. Тэр хүүхнээс хаан хөвүүн төрнө. Тэнгэрийн таалал ийм байна. Бүсгүйн рашаанаа юүлсэн газарт барын чих хэмээх цэцэг дэлбээлж байхыг би нүдээрээ үзэв. Онгон шүтээн тэнгэр эцэгтээ талархав" хэмээн өчиглөжээ. Хаан хөвүүн төрнө гэж Цагаанбух зайранг өчихөд Есүхэйн залуухан ид хавгай царай дээгүүр үлэмжийн хүйтэн хөх гэрэл сүүмэлзээд өнгөрчээ.

\* \* \*

Орхон, Сэлэнгэ мөрний уулзварт Чилэдү цэрэгтэйгээ задгай гал яаралгүй асааж байна. Галын дөл улалзан бадамлаж түүнтэй ташралдан харагдах сундлаа уулс дайвалзан хөдлөх бөлгөө. Сүйх тэргээ буулгажээ. Цэргүүдийн морьд чийгтэй өвс үмхэлнэ. Нар жаргах дөхжээ.

Уулсын сүүдэр Орхон, Сэлэнгийн шаргал тохойг бүрхэж, мөрөн голын хөвөө битүү зэгсний дээгүүр ангир, нугас дэр дэрхийн нургин байлаа. Орчин тойрны нам гүм байдалд сэтгэл тайвширсан Чилэдү баатар,

-Энд хоноод маргааш хөдөлье гэв. Өүлэн хатан түүний үгийг сонсуут зэгс мэт найган,

-Үгүй. Одоохон хөдөлж замдаа орьё. Одоохон хөдлөе... хэмээн их мөрний тохойрч мушгирсан гүн цүнхээл тийш гөлрөв. Бүсгүйн сэтгэл тавгүйтсэнийг гадарласан Чилэдү амраг өөдөө харж,

-Чи яав. Хэн чамайг үргээв. Орхоны зэгс, бургасан дотор туршуул таарав уу гэв.

Чилэдүгийн дэргэд байсан Төгсжин бөө бүсгүйн сандарсаныг үл тоомсорлон бага зэрэг тохуурхах мэт,

-Усны шувуу агаарт хахаж байгаа бус уу. Ийм үед аймшигт араатан ч сайхан зантай болчихдог

бус уу гэлээ. Өүлэн бүсгүй бүүр ихээр тэвдэж,

-Явах минь. Яваад замдаа хоноглоё гэв.

-За яая гэхэв. Хатаны сэтгэл тавгүй хойно даруйхан сүйх тэргээ замд бэлтгэ. Өнөөдөр надад харийн сум исгэрэх сонсогдсон шүү. Умдалж дууссан бол морьдоо хөллөөрэй гэж Чилэдү баг цэрэгтээ тушааж хэн нэгний саналыг сонсохгүйг батлан гараа савав.

Өүлэний хонхот тэрэг голын эргээс түрүүлж холдлоо. Тэрэгний баруун, зүүн талд яваа улаачдын ташуур агаарт тас нясхийн дуугарч морины хондлойг ороолгох нь яарч буйн шинж биз ээ. Намаг шалбааг тойрч дугуйрсан харгуй замаар хөнгөн сүйх жирийж байна. Сүйхний дэргэд Чилэдү залуу эхнэрээ баясгалантай харан давхина.

Ямар нэгэн аюул тохиолдох юун хэмээх бодол мэргидийн баатарт мөнхүү төрж муу совин татаж эхлэв. Чухам яагаад Чилэдүгийн сэтгэл гэгэлзэн хар буусныг таамаглах аргагүй билээ. Өүлэн хатан Орхон, Сэлэнгийн бэлчирт буудаллах зуур ганцаараа бургасан шугуй тийш одож удаан алга болсноос тэр үү, эсвэл энэ соргог сэрмүүн газар хоноглохгүй хэмээн агадан зүтгэснээс болсон эсэхийг үл мэдэх ажээ.

Чилэдү эргэн харна. Нэхүүл үл үзэгдэнэ. Оройн тогтуунд нялх бургас туждаа ногоорч, хүрхэрсэн их усны дээгүүр нүүдлийн шувууд заарцаг татаж байлаа. Усны хүчит хүрхрэлтээс холдох тусам Өүлэний царай инээмсэглэлээр гэрэлтэн Чилэдү баатар хариу инээмсэглэн найрсаж байв. Чилэдү Өүлэнг ажиглав.

Өүлэний үл тайвшрах хар үргэсэн шувууны далавч мэт жирвэлзэн байх нь нууц шинжтэй. Гэнэт Төгсжин зайран уулга алдаж уулын оройгоор сум шиг хурдалж яваа гурван морьтоны дүрсийг заав. Гурван бараан морьтон

Чилэдүгийн бяцхан нүүдлийг амдан давхих ажээ. Тэдэнд буцах зам байсангүй. Гагцхүү нэхүүлүүдтэй тулгарч тулалдах хэрэгтэй болов. Хамгийн түрүүнд үсээ задгай намируулсан Есүхэй хэмээх чийрэг баатар эр Өүлэнээс ам сонсоогүй билээ. Харин ам өгсөн билээ. Гурав, гурваар есөн морьтон Чилэдүйн баг цэргийн хажуугаар зэрэгцэж давхина. Өүлэний сүйх тэрэг зүг буруулан Сэлэнгийн хөвөө рүү давхив. Хөнгөн сүйх тэрэгтэй зэрэгцэж яваа Чилэдү нумаа барин мөрдөн хөөгчдийн зүг эргэж,

-Сүйх тэрэгт ойртсоны нь нүдийг сох харвана гэж мэдээрэй. Чүү...чүү... хэрэв ойртвол зүрхэнд чинь сум зооно шүү гэж хашгирч морины эрэгцээнд өндөлзөнө. Аль хэдийнэ гурван мөрдөгч Чилэдүг тойрчээ. Тэд нум сум эгшээсэн бөгөөд Чилэдүг ясан гичирт сумаар сийчихэд бэлэн болжээ. Мөрдөгчдийн морьд омголон, цэрэг эрс зэвсгийн эрдэмд төгс агаад чонон харцтай ер бусын баатарлаг залуус байв.

Нэг цэрэг Чилэдүгээс нүд салгалгүй дуржигнан "харвах гээд үзээрэй тэнэг мэргид минь. Чиний нэг сумны оронд гурван сум онилж буй. Наад махан биеий тань зургаан удаа сийчнэ. Зургаан нүхээр цусаа юүлнэ. Нумаа буулга..." хэмээн зандрав. Морины эрэгцээн дунд Чилэдү гурван зүгт харж, гурван эрийг сумандаа онилох гэж эргэлдэнэ. Сүйх тэрэгнээс Өүлэн үсрэн бууж үдшийн шаргал гэгээгээр уулын оройг хэжэн зурсан шар зураас бүхий тэнгэрийн хаяаг

ширтэн байж,

-Эдэнд хэн хэрэгтэйг Чилэдү минь чи мэдэж буй. Хайран амиа бүү сүйтгэ хонгор минь! Амьд явбал эн таарах эхнэр чамд олдоно. Мухлаг бүрт, гэр бүрт хацар гоо охид буй. Тэдний хэн нь ч чамтай ханилан суухыг аз хэмээн бодмуй. Одоо амраг хүү минь өөрийгөө бод хэмээн эрс шийдмэг мөртөө гуйсан аясаар өгүүлэв. Өүлэний юу хэлсэнийг Чилэдү сайн ойлгосонгүй тул түүний өөдөөс дүрлийтэл ширтэнэ. Өүлэн бүсгүй түрүүчийн үгээ давтан хэлэв.

Чилэдү баатрын омголон морь газар цавчлан цэргүүдийн хүрээг сэт татахаар ухасхийв. Яг тэр үед Есүхэй өмнүүр нь хөндөлдөн,

-Чилэдү чамайг гурван өдөр, гурван шөнө мөшгөв. Чамайг өршөөе. Эд юмсаа аваад нутагтаа очихгун. Өүлэнг авч үлдлээ гэв.

Чилэдү бараг улих шахам,

-Сонгосон эхнэрээ чамд алдав. Боржигонууд мэргидийн зуултанд оров. Нэг нартай өдөр эргэж уулзанаа гайгуй... гээд хүрээний голд эргэлдэв.

Булаагдсан бүсгүйг нэг цэрэг хэзээний эмээл дээрээ дүүрчээ. Өүлэн тэвчээрээ баран цахдаж,

-Намайг санах юм бол өөр эхнэрийг шөнө тэврэхдээ миний нэрийг дуудаарай: Май, миний үнэр шингэсэн цамц. Үхлийн савраас мултарч үз гэхэд Чилэдү хар тэнхээгээрээ хашгирч "Эрийн өвөр хэсэх нь эмийн заяа хойно. Эргэж уулзах нүүртэйгээ үлд дээ" гээд эвшээсэн нумаа буулгахдаа цээж нь гиншиж байлаа. Чилэдүн баг цэрэг нутгийн зүг хурдалж одлоо. Морьт цэргийн араас Чилэдү салхи татуулан нэхэж довтолгов. Харуй бүрий дундуур Чилэдү уусан алга болж хаа холд морьдын туурай хатуу газрыг ууртай бөмбөрдөх аж.

Гэнэт Чилэдүйн сааралтсан баргил дуу голын тэртээгээс хадаж,

-Муусайн боржигончууд сонсож бай. Мэргидийн Чилэдү баатар би хэлж байна. Мэргид бол том аймаг билээ. Бид та нарыг хүйс тэмтрэх цаг ирнэ. Танай аймгийн ҮР хүүхэд эхийнхээ хэвлийд сөнөж эмс охид нь манай хатавчинд боол болон бохирч, газар нутаг, мал сүрэг тань мэргид эзэнтэй болно. Санаж яваарай... Есүхэй чи дуулав уу гэв. Есүхэйн дэргэд байсан Хотул хааны овгийн Цоожбаатар тэсч ядан,

-Мэргидийн Чилэдү баатар өс санаж байна. Юунд суллаж явуулсан юм гэхэд Есүхэй баатар Өүлэнг булааж авсандаа сэтгэл нь дүрэлзэн шатаж,

-Монголчууд хэзээнээс булаалдаж, дайтаж өдий хүрсэндэг. Дайтах өдрийг Чилэдү зөгнөж байгаа бол дайтна биз. Тэнгэр мэдэг гэв.

Намирсан их үст Есүхэй энэ үед Өүлэнг эмээл дээрээ сундлав. Өүлэн жихүүцсэн мэт дагжиж чичирнэ. Хэдийгээр хүчтэй баатар эрийн гарт нэгэнт булаагдсан ч хувь заяаны эрхээр Чилэдүг дагасан бол Өүлэн бүсгүй өдийд мэргидийн хот хүрээний зүг сүйх тэргэнд давхиж явах байлаа. Өүлэн дурамжхан юм шиг буруу харж Есүхэй баатарт тэврүүлэв. Есүхэйн

харвасан сум Орхон, Сэлэнгэ мөрний цутгаланд үлдсэнсэн. Хэзээ нэгэн цагт Бурхан Халдун уулын мод үндэслэж, навч нахиа нь багсайтал дэлгэрэх буй за. Хоёр их мөрний ай савд түмэн зүйлийн ургамал зэрэгцэн ургаж, эрэг тохой болгонд нь загас үсчиж, тэнгэр бүчиж байсан усны шувууд голын уснаа хөвөөлөн хотолжээ.

Дорно зүгийг чиглэж харгуй замаар Есүхэйн баг цэрэг шөнөжин довтолж үүрийн гэгээтэй золгов. Тэдний өмнө алтан нарны дугуй титэм солонгорон татаж түүний наагуур азарга, азарга адуу бэлчинэ. Өүлэн хувь заяатайгаа эвлэрч нимгэн цайвар царай, хар нүдэнд нь эмзэглэл тодорч байлаа. Монголын хээр тал нутагт айл нүүж явна. Том дугуй нарны өмнө Өүлэний төрсөн нутгийн далай их ус цэлэлзэж байж таарна.

Өүлэн сэтгэл татагдсан нэг баатарт булаагдан монголын хөвч тайга дамнан далай цэлийсэн нутгаасаа алслагдан, сүүмэн өвс халиурсан тал нутагт иржээ. Зуны эхэн сарын хөх ногоо урт, урт тал хөндийг багил ногооноор хучин бүтээж олон жилийн тэртээх өлөн цагаан өвс, жимсний хайрс, гол горхины уснаа хөвж одно.

-Боржигоны нутагт ирлээ дээ хэмээн Цоожбаатар хүрхрэх мэт дуугарахад угалзарсан урт гол хээр тал нутгийн дундуур урсан одож, нарны алтан титэмтэй нийлж дорно зүгийг зорих боловч газрын хэвлий рүү бус нарны утастай орооцолдон нарийссаар хөхрөгч хязгааргүй орчилд шингэв ээ.

Ольхон аймгийн удган Өүлэнг мордохын зуур сүйхээчлэн "Чи мэргидэд үл очно. Чи өөр эртэй учирна. Наад эр чинь зоригтой хэрнээ хүлээц тэвчээр муутай юм. Хэрэв замдаа булаагдвал үйл лайгаа дагаарай. Галын сорил надад үүнийг шивнэв" гэжээ. Мэргидийн Чилэдү баатар маш ууртай эргэж ирээд "Боржигоны Есүхэй баатар миний сүйт эмийг булаав. Арван үедээ марталгүй өш нэхэж боржигончуудыг тархидана" гэж хашгирч өдөр, шөнө гуравт гуниглан хэвтсэн гэдэг.

Хурим найрт бэлтгэсэн гурван мэргид зоог, шүүсээ асгаад задгай асарт чуулж, боржигон аймгийг мөхөөх цагийг хүлээхээр тогтжээ.

Энэ онцгой тохиолдолыг Цагаанбух зайран сэтгэн бодож Есүхэй баатрын тулгат галыг асаасан даруйдаа төрсөн дүү Халзанбух бөөтэйгээ Бурхан халдун уулнаа уулзахаар яаравчлан мордов. Цагийн учиг нэхэгдэн давхацна. Бартанбаатарын удам Есүхэйн үед дагтаршин бэхжиж, олон монгол овгийн эв найрыг зангидах ухааныг тогтоон шийдэх цаг тулж, нар, сар, гал гуравг монголчууд сүр сүлдээ даатгах болсон ажгуу. Есүхэйн эх Өүлэнг их удаан тэвэрчээ.

-Хөвүүн минь ханиа олоод ирэв гэж тэр эх өөриймсөг дотноор хэлэхэд боржигоны хот айлынхан хуурайлан шуугилдаж билээ.

## Дөрөвдүгээр бөлөг



*Цагаанбух бөө Есүхэй баатарт "энэ Өүлэн бүсгүй алтан хэвлийтэй юм байна. Хэвлийгээс нь рашаан ус гарч барын чих цэцэг ургахыг би үзэв. Өүлэнээс хаан хөвүүн төрнө" хэмээн хэлжээ*



Цал буурал морьтой, цагаан дээлтэй Цагаанбух зайран Бурхан халдун уулын евөрт нутаглаж буй шарга морьтой, шар дээлтэй Халзан бух бөөтэй яаравчлан уулзахаар явна. Бурхан халдуны оройгоор манан татаж уулын суга, хөмгөөс будан дэгдсэн өдөр байв. Ер бусын тохиолдол Цагаанбух зайрангийн сэтгэлээс салахгүй зовоох тул дүү зайрантайгаа зөвлөлдөхөөр уулыг зорьжээ. Боржигоны хот хүрээ, нутгийн айлууд Онон, Хэрлэн мөрний хөвөөгөөр зусч байлаа. Есүхэй баатар Өүлэн үжинтэй хуримлахад Цагаанбух зайран тэдний галыг асааж, тэнгэрийн таалал соёрхолд нийцүүлэн хаан хөвүүн гуйжээ. Отог овгийн дайн тулалдаанд туйлдсан монголчуудад тэнгэр заяат хаан туйлаас хэрэгтэй байжээ. Өүлэн эхийн хэвлийгээс ундрах рашаан усыг шинжсэн зайрантан барын чих хэмээх шар бөрлөн цэцгийн дэлбээ хэрхэн дэлгэрч төдхөнөө урган өндийхийг харсанаас хамаг хэрэг үүдэлтэй юмсанжээ. Цагаанбух зайрангийн дүү Халзанбух бөө бол Бурхан халдуны лус савдагтай нөхцсөн, тэндэхийн агуй хонгил, бут сөөг болгоныг мэддэг нэгэн билээ.

Мөнх тэнгэрийн хүчинд итгэдэг ах, дүү зайран лусын үгийг тэнгэрт таацуулан айлтгах ёстой байв. Ахын морины зүс, дээлийн өнгө, дөрөөний жингэнээг үл андах Халзанбух өрөмтэй цулхир, хужиртай цайгаа зооглож байснаа гэв гэнэт өндөсхийн босчээ. Өглөөнөөс үдшийн хооронд нартай байдаг хавтгай хадны дэргэд очив. Эндээс зөрөг замаар яваа гөрөөс хүртэл тодорхой харагддаг билээ. Уул хэжсэн зөргөөр ах Цагаанбух бөө айсуй. Ахын морь зүрхшээн, асганаас чулуу нурж байна. Ах нь байн байн нартай хадыг саравчлана. Халзанбух цагаан дээлтэйгээ тодоос тод үзэгдэхэд бөөгийн санаа амран, зөрөг замаар сүрдэн урагшлах мориныхоо цулбуурыг сул орхив. Ах, дүү зайран бөө, нартай хадны баруун, зүүн талд нүд, нүдээ харалцлаа. Цагаанбух бөөгийн сэтгэл түгшиж бас догдолсон байв. Халзанбух орь ганцаар ууланд нутаглах тул хүн, малын соргог дуу чимээг тун амархан ялгаж сурчээ.

Халзанбухын хойноос Цагаанбух зайран дагав. Нартай хадны нөгөө талын булаг шанд дотор цал буурал морио, шарга морьтой ижилсүүлэн орхив.

\* \* \*

Хоёр бөө уулын суга руу гүн оров. Цаашлах тусам өвс ургамлын өнгө солигдож, хад чулууны хэлбэр дүрс өөр болно. Дуут цохиог тойрлоо. Цагаанбух бөө цөөн удаан энд ирж байжээ. Учир юун хэмээвэл Цагаанбух зайран дайн тулаан, ан авд оролцож, боржигоны хот айлуудтай нүүдэллэж явдаг билээ. Шар дээлт Халзанбух бөө хааяа уулнаас бууж Онон, Хэрлэн мөрөнг өгсөж, уруудан явж, хүүхдэд нэр өгч, хөгшчүүл, бүсгүйчүүлийн судас барьдаг билээ. Ахынхаа гэгээн төрхийг харсандаа Халзанбух магнай тэнийжээ. Ахыгаа ирнэ хэмээн чилтэл хүлээж байв. Ах Цагаанбух нь шодон буурал гээгээ сүлжиж үзүүрт нь сур зангидсан аж. Түүний магнайд гүн үрчлээ суужээ. Цагаанбухын хөмсөгөнд цагаан сор гялалзана.

-Есүхэй баатар хуримлав. Мэргидээс булааж авсан Өүлэн бүсгүй хөл хүнд болжээ. Өүлэнээс хаан хөвүүн төрнө гэж би зөгнөв. Дүү энэ хэргийг болгоож, монгол овог, аймгууд явал зохиолтойг хэлнэ үү.

Цагаанбух зайран дүү бөөдөө ийнхүү мэдүүлэг өгөв. Халзанбухын шөвгөн харц хариугаа авав. Хариу нэхэж өрөмдөх мэт харж байснаа Халзанбух тайвшраад,

-Та их хэрэг сэджээ гэв.

Зайран бөө нар тунгалаг ногоон өнгөтэй тогоон нуурын хөвөөнд иржээ. Нуур нүдэнд үл мэдэгдэм мяралзан, ус дуслах, ус хоржигнох битүү чимээ сонсогдоно.

Гэв гэнэт тогоон нуурын усанд хоёр өвгөний дүрс туслаа. Шингэвтэр сахал, тэнүүн дух, босоо нүүр, самсай дагаж завьж руу орсон үрчлээ нь туйлын төстэй байв. Тэр дүрс өөрчлөгдөн модны үндэс, мөчир лугаа салаалж хөгшин хатингар болоход Цагаанбух зайран нүдээ чавчлав. Долоон зуун жаран зургаадугаар онд Бөртэ чонын хөх сүрэг Бурхан халдун уулнаа цугларч ирэхэд навч нахиагаа дэлгэж угтсан Жүд модон өвгөрч унаад үндсээ үлдээсэн нь нэгэн өвгөний дүрс бөлгөө. Нөгөө нь монголын анхдугаар жарны нэгдүгээр он дор Бодончар мунхаг хэмээх элэнцийг халихад найман живаа найлзуураа дэлгэж тоссон ялгуун модон хагдарч үндэс юугаа орхисон нь нөгөө өвгөний дүрс бөлгөө. Усанд тодрох дүрс чулуужсан ажгуу. Хамгийн гайхамшигтай нь нуурын голоос салаалж одсон хөх могой аж.



Ертөнцийн өвс ургамал, ой мод дээрээ тэнгэртэй, доороо устай Бурхан халдун уулнаас эхтэй юмсанжээ.

-Бурхан уулын оройд бус ёроолд суудаг хүн гэж Халзанбух бөө өөртөө гүвтнэв. Цагаанбух зайран, дүү бөөгийнхөө үгийг сонсоод,

-Тэнгэртээ харьодаг уул хэмээн баясгалан төгөлдөр өгүүлэв.

Тураг гөрөөсний хөлөөр асга шажигнаж, сүрэг адуу тургиж, цөөрмийн ангир ганганах дуун хоёр бөөгийн яг дэргэд мэт сонсогдоход тэдний магнайн үрчлээс улам гүн тодорч тэрхүү үрчлээсийг дагаж зөн совингийн цагаан гялбаа жирэлзэв.

\* \* \*

Ах дүү зайран бөө нар биеийнхээ илчийг нэгэндээ шингээх лугаа бөөрөө нийлүүлэн тухлан суужээ. Бурхан халдун уулыг үүдтэй, тоонотой гэдгийг тэнгэрийн түлхүүр тайлдаг ах, дүү хоёроос өөр хүмүүн үл мэдэх авч тэд боржигоны отогт суудаг урианхан бөлгөө. Тэнгэрийн зөн бөөгийн тархи толгойд хэдийд бууж ирэхийг хүлээцгээнэ. Бороо цутгахыг үүлшихэд мэдэж болно. Малчид, анчид өвс ногооны сөл хэдийд татарч, зуд турхан хаана нүүрлэхийг бөөгийн дуудлагаар бус мал сүрэг, хоточ нохой, араатан, жигүүртэний байц байдлаар дохио авч, нүүдэл суудал хийдэг билээ.

Бөөд бүх монголын элэг, зүрх оршжээ Бөө бол овгоо төдийгүй угсаатнаа төлөөлөх дуудлагатан бөлгөө. Бөөгөөс бөө төрөх нь ховор. Бөө бол бөө чигээрээ төгсөнө. Бөө бол жүд мод шиг, ялгуун мод шиг үндсээ үлдээж чадахгүй ч уураг тархиныхаа орон зайг тэнгэрт орхидог хосгүй шидтэн юм.

Тэнгэрээс дуудлага хэдийд өгөхийг Цагаанбух, Халзанбух хоёр үл мэднэ. Чухам хэнд нь дуудлага өгөхөө тэнгэр мэднэ. Нуурын мэлтийсэн ногоон ус өнгөө сольж хар цайр асгасан мэт болжээ. Дараа нь дугуй цөөрөмд шар титэм суусан байв. Агаарын урсгал хаанаас хаашаа чиглэснийг таахад бэрх. Орон зайн тэрхүү эргүүлэг дотор Цагаанбух, Халзанбух хоёулаа эргэлдэнэ.

-Монголчуудыг тэнгэр аварна хэмээн Цагаанбух бороошиж эхэлсэнээс хойш өдөр бүрий бодох болсоноо дүүдээ хэлэв.

-Есүхэй баатрын хатнаас хаан хөвүүн төрөх нь багтай юу гэж Халзанбух лавлав.

-Би хэлээ хазаж чадаагүй билээ. Есүхэй итгэчихсэн. Тэнгэрийн зөн, лусын зөн, миний зөн давхацсан юм. Барын чих цэцэг боржигоны бууцанд ургасан байна лээ.

-Монголчуудын заяа мэдэж дээ.

-Есүхэй баатар Сочихэл хатанаа яасан бэ.

-Татвар эм болгосон. Сочихэлийн ургийн тайчууд боржигоны мал сүргийг адгуулж, тараг айргийг хүртэж байна. Монголчууд монголоо хөнөөгөөд яваандаа мөхөж магадгүй боллоо.

Тэнгэрийн үгийг түмэн олонд дуулгах аваас монголчууд Онон мөрөн лугаа нэгэн урсгалд орох юм.

-Тэнгэр тэтгэнэ. Хэл мэдээ ирнэ. Хоёр хөх могойн судсыг хаан хөвүүн бол баруун, зүүн хөлөөрөө онож гишгээд Бурхан халдун уулын лус савдагтай холбогдож дэлхийгээр ширэлдсэн үндсийг эзэгнэх болно.

Цагаанбух, Халзанбух хоёр бөөгийн босоо нүүр, хавтгай хамар, тэрслүү зан адил билээ. Монголын овог, аймгууд өөрсдөө беетэй, лус аргадах дом шүтлэгтэй боловч тэнгэрийн таалал, гэсгээлийг нээх түлхүүрийг уураг тархиныхаа хаа нэгтээ хадгалж яваа ажээ.

\* \* \*

Цагаанбух Халзанбух хоёр өдөрт уулын суга руу шургаж, урьд өмнө яваагүй өөр, өөр замаар толин цөөрөмд хүрнэ. Шөнөдөө эргэж ирээд Халзанбухын утаа тортог бүхий гэрт гал өрдөж, мах чанаж идээд, хөх салхины үзүүрийг эрчлэн хууч хөөрнө.

-Есүхэй баатар Өүлэн хатнаас төрөх хөвүүнээ хаан болгохыг туйлаас хүснэ.

-Бөө бид тэнгэр угсаат боржигоны гал манаж буй тул хааны үр хойчийн төлөө сэтгэл зовно. Зовохоор үл барам тэнгэрийн таалалд нийцүүлэн аврал нигүүсэл гуйж тэнгэрт харъяалагдах эрхээ бататгах ёстой бус уу.

-Монголын заяа их ээ, их

-Өүлэн хатнаас хөвүүн төрж, хамаг монголчуудыг зөв урсгалд оруулбал элэг нэгтнүүд маань амар тайван амь зуух билээ.

-Тэнгэр хэдийд дуудлагаа илгээх бол. Насаа элээж хүлээх болжээ.

Урианханы хамгийн том бөө Харлагтэх хэмээх улаан өвгөн тэнгэрийн үгийг дамжуулж "Бартанбаатарын хөвгүүдээс Есүхэй боржигоны хаан болно. Нэгэнтээ баатар зоригоо гайхуулж тэрбээр татаар, найман иргэдийг нугаслав. Есүхэйд дүү нар байвч хурц дайчин бус, явдал суудал ядмаг ажээ" хэмээн айлдсансан. Харлагтэх бөөгийн айлдвараар Есүхэй хаан сууж тэрбээр ид хав, сүр хүчээр Өүлэнг булаан авчээ. Өүлэнг булаан авах шалтгааныг Цагаанбух зайран шинжиж билээ. Өдгөө ах дүү зайран тэнгэрийн зөнг тал нутгийн монголчуудад дуулгахаар Бурхан халдун уулын ян тагтын дотор нь оржээ.

Одод түгэхэд долоон бурхан, марал, мичид гялалзаж тэрхүү толин нуурын уснаа жирэлзэн хөвнө. Нар мандахад мөн тогоон нуурын мандал шаргалтан шар зос асгасан мэт мэлтийнэ. Сар саатахад тогоон нуур бидэр татан мөнгөрнө. Тогоон нуурын ус есөн эрдэнийн өнгөтэй бөлгөө.

Толин нуурын хөвөөнөөс дээд тэнгэр, нар, сар, одод үл үзэгдэх атал янз байдлаараа усан дотор харагдана. Өвс ногооны үндэс, хоёр хөх могой моддын салаа мөчир, чулуужсан хожуул бүхлээрээ тогоон нуурын усан дотор оршмуй. Тогоон нуур бол бөө Халзанбухын толь байлаа.

Бурхан халдун ууланд нууц толь байдгийг тэнэмэл бөө гэгдэх Халзанбух, дайнч бөө гэгдэх түүний ах Цагаанбух нараас өөр хэн ч үл мэднэ.

Онгон сэтэрт лус савдагийн унаа цал буурал морь, шарга морь хоёр ижилсэн жаран зургаа хоногийг өнгөрөөжээ.

\* \* \*

Цагаагчин могой жил шувтрав. Дайнч бөө Цагаанбух цагаан цасны доор ясаа тавьж хавар цастай цуг хайлж агаарт уур манангийн хамт дэгдэн хөөрсөн билээ. Цагаанбух хэл сураггүй алга болсонд Есүхэй баатар туйлаас харамсан Өүлэн хатнаас хөвүүн төрөхийг хүлээж байлаа. Нарны илч газарт шингэж чинагш өвсний үндэс дэвтсэн цагаан өдөр тэнэмэл бөө Халзанбух боржигоны хот айлд ирж баяр, гуниг хосолсон хэл дуулгав. Гунигтай нь түүний ах Цагаанбух зайран өөд болсон явдал байлаа. Баяртай нь тэнгэр тэтгэж Есүхэй баатрын хатнаас хөвүүн мэндэлнэ гэсэн тэнгэрийн чимээ аж.

Есүхэй баатар өргөөндөө Халзанбух зайранд шүүс бэлтгэж, морь малын тарга тэвээрэг, газрын гарц, татаар аймгийн увайгүй занг хуучлан хөөрөв. Халзанбух зайран боржигон овогтонд ээлтэй гурван бөөгийн нэрийг дурдав. Хорчи, Гүнгоо хоёр бол нутагтаа мэдэгдсэн бөө байлаа. Гүнгоогийн гэрт бөө хөвүүн төрсөн гэж Халзанбух өчив. Мөн хонхотны Чирха өвгөний хөвүүн Мэнлигийн гэрт бөө төрсөн гэдгийг Есүхэй баатарт бас дуулгалаа.

Намирсан хар үсээ Есүхэй баатар сүлжиж гөрөөд, эгмээ дамнуулан урагш унжуулж, гүргэр шанаагаа зангидан сууж байна. Тэнэмэл бөө Халзанбух өвдөг дээрээ цомцойн ах зайрантайгаа хөх тэнгэрийн чимээг сонсож учрыг тайлсанаа өгүүлнэ.

"Өүлэн хатнаас хөвүүн төрнө. Тэр хөвүүн баруун гартаа нөж атгасан байна. Түүний атгасан нөж бол тэнгэрийн тамга юм. Тэнгэрээс тамга атгуулсан бол тэрхүү хөвүүн оюун билиг сайтай, ухаантай, ялагдашгүй баатар эр бөгөөд хамаг монголын хаан болно."

-Ах зайрантайгаа цугтаа тэнгэрийн тааллыг ингэж мэдэв гэхэд Есүхэйн жийхгар чонон нүд байж ядан,

-Цагаанбух бөөгийн надад хэлдэг зөв юм. Тэнгэрийн зөнтэй таарч байна гэж дуу алдлаа. Есүхэй баатар хүдэр гараар ширдэг алгадаж,

-Хөвүүний тухай хэн зарлах юм гэхэд Халзанбухын босоо нүүр, мэлтэн духанд гэрэл тодорч,

-Би зар түгээнэ гэв.

-Намайг тэнгэр ивээжээ гэж дахин дуу алдахад гаднаас бие тулгар хэрнээ улам үзэсгэлэнтэй болсон Өүлэн хатан мориллоо. Есүхэй баатар дуугаа намсгаж "нууцыг хадгал" хэмээн бөөд хандав.

Тэр өдрөөс хойш татаарын ужиг самуун боржигон аймгийн мал адгуусыг дээрэмдэх, нутгийн хүн зоныг үймүүлэх зэргээр сэргэж эхлэв.

Бурхан халдун ууланд хүний овоо, газрын овоо, тэнгэрийн овоо гэж буй. Хүний овоонд хүүхэд нялхас, өвгөд хөгшид, эмс охид тайлга өргөдөг байлаа. Газрын овоог ихэнхдээ лус савдаг аргадахад бөө зайран нар очиж тайх бөгөөд лусын хорлол туссан хүмүүс биеэ домнодог заншилтай бөлгөө.

Тэнгэрийн овоо бол өөр юм. Бурхан халдун уул тэнгэрийн овоотой билээ. Тэр нь дотроосоо од, нар, сар гэрэлтдэг толин нуурын дунд буй. Тэнгэрийн овоог боржигоны өвөг дээдэс, хаад ноёд шүтсээр иржээ. Хамгийн хатуу цаг тулахад зайран бөөгийн хамт тийш одож тэнгэрийн овоогоор тэнгэрт ханддаг бөлгөө.

Есүхэй баатар, Халзанбух зайранг дагуулан тэнгэрийн овоог зорив. Хаврын тарчиг цаг байлаа. Зайрангийн шарга морь тарга хүчтэй аж. Есүхэй баатар нум, сумаа агсаж, хуяг дуулгаа өмсөж Бөртэ чонын үеэс уламжилж ирсэн гэх боржигоны билиг тэмдэг цагаан шонхор шувууны дүрсийг өвөртөлжээ. Хатан Өүлэнг төрөхөөс өмнө тэнгэрийн дуудлагаар Бурхан халдун уулыг зорьж очив. Тэнгэрийн овоо эзнээ хүлээж ядсан байлаа. Овооны чулуунаас хаг, хөвд ургаж битүү хөх ногоон, улаан шар болжээ. Аль цагт хөдөлснийг бүү мэд нэгэн чулууны өнцөг газраас ховхорсон аж.

Тэнгэрийн урсгал долгиулж байна. Есүхэй баатар сэтгэлдээ Өүлэний учир, хөвүүн төрөхийн учир ирлээ. Явал зохилтой вэ. Татаар аймаг зүүгээр хатгах мэт зүгээр суулгахыг болив. Монголын заяа төөргийг дээд тэнгэрээс заяат боржигон овгийнхон даахаар шийдэв.

"Боржигонд ивээл хайрла. Боржигонд хүч чадал хайрла" хэмээн сүсэглэн бодлоо. Жүд модон, Ялгуун модны чулуужсан хожуул, олон моддын голоос хөх могойн судас лугшин үндэстэй бүхнийг тэтгэж дэлэгнүүлэв. Газрын дэлэн толин нуур бөлгөө. Тэнгэрийн дуудлага толин нуурын дунд орших овоо байлаа.

-Есүхэй баатар Өүлэн хатан хоёрын дундаас хөвүүн төрнө. Хөвүүний баруун гарын алганд шагайн чинээ нөж байна. Тэнгэрийн тэмдэг болох шагайн чинээ нөжийг хамаг монголоор тараан цац. Хүн бүрийн тархиар дамжуулан зүрхний гүнд хөвүүнийг мэндлэнгүүт "нөж атгаж төржээ" гэж зар хүргэ. Тэнгэрийн дуудлага энэ байна. Хойши явдал учралыг Халзанбух бөө бусад бөө нар гүйцээнэ хэмээв.

\* \* \*

Есүхэй баатрын өвөрт байсан овгийн сүлд амилж түүний гар, мөр, магнай дээр цагаан шонхор шувуу дэрвэлзэн сууж байна. Цагаан шонхор шувууны аманд жүд модны навчис, ялгуун модны холтос зуулттай байна. Цагаан шонхор шувуу эрхэм бөөг тойрон талархав. Толин нуурын ус тогтуухан мяралзаж Бөртэ чоно баатар, түмэн дагуулын хамт зогсож байв.

Хотул хааны хөвүүн Алтан нөж атгаж төрөөгүй билээ.

Нэгүн тайшийн хөвүүн Хучар нөж атгаж төрөөгүй билээ Бартанбаатарын хөвүүд Сачу, Тайчу хоёр нөж атгаж

төрөөгүй билээ.

Есүхэй баатрын хөвүүн нөж атгаж төрнө. Баруун

гарын алгандаа нөж атгасан байна, хэмээн Бөртэ чонын


баатрууд уухайлав.

Бурхан халдун уулын оройд үүлс орооцолдон, тал талаасаа тэврэлдэх мэт сунан нүүж бөөгнөрсөөр хавар цагийн цэцгийн үнэртэй бороо шаагив. Их бороог Есүхэй баатар зүсэн хурдална. Түүний хүрэн нүүр бороонд угаагдан хүзүүвчтэй дуулга малгайн ус шоржигнон урсана. Бороог зүссэн гал цахилгаан мэт морьтон боржигоны их хүрээний төвд хүрлээ.

Зайран бөө Халзанбух гэртээ үлдэж товлосон цагт тэнгэрийн зараалаар хүрч очихоор болзжээ.

Есүхэй баатрын хас тэмдэгт дөрөө ханхийхэд их хүрээний гэрүүдийн үүд нэгэн зэрэг сөхөгдөн бороо дагуулж ирсэн баатар эзнээ харцгаалаа. Эзний харцанд бардам байдал ажиглагдана.

## Тавдугаар бөлөг



*Есүхэй баатар татаарын Тэмүжин үгээгийн толгойг тас цавчиж*

*"Миний хөвүүнд Тэмүжин хэмээх нэр өг" гэж зарлиг буулгав*

Буурал сар тэнгэрт хөөрч газар, дэлхийд сүүн гэрлээ илгээхэд тэнгэрийн дэвсгэр гил харлаж түүний дээр мичид, марал гоодрон анивчина. Зун цагийн дулаахан саран авхай ов тов бууралтжээ. Бөртэ чонын сүрэг Бурхан халдунд ирэх үед сарны сэвх одоотой адил бөрлөнтөж байсан ажгуу. Цагийн хүрд зуун зуунаар эргэж Есүхэй толгойлогч болоход хиан хэмээх цагаан ястны өвөг дээдсийн сар тэр үеийнхээрээ бөрлен байлаа. Арван тавны буурал сарыг тээршаасан адгуус, араатан сүүдэр бараадаж, харин Есүхэй баатрын хот хүрээ хөл хөдөлгөөнд умбана. Шөнө дүлийн цагаар мэнгэт буурал саранд Хуагчин сүү өргөнө. Бурхан халдуны лус савдагт Мээнэн билиг өргөл өргөнө. Боржигон овгийнхэн нэгэн учрал ерөөлийг хүсэмжилжээ.

Мөнөөх мэнгэт буурал сар Есүхэй баатрын их өргөөний тоонын цамхраан дээр тогтож, үл анивчих, үл түтгэлзэх сүүн туяа нь өргөөнд мэлтийнэ. Сар, тоонотой таширласан байлаа. Тооноор тэртээ алсад сар харагдаж байдгийг ичимхий охид, хүүхнүүд юун эс андахав. Гэтэл саран авхай их өргөөнд зочилжээ. Нярайлах дөхсөн бүсгүйн тамирдан гинших нь түгшүүртэй хэрнээ сэтгэлийн хөг аялгууг эгшиглүүлэх аж.

Хэнгэрэг дэлдэнэ. Толгойн оройд түүдэг гал асаажээ. Хэнгэрэгийн дуунаар ноход цочиж, хонь мал үргэж хуйлрах бөлгөө. Хуучин том ширэн хэнгэрэг дээр зээрийн шилбэн махир дохиур буухад нөгөө үзүүр нь мэнгэт буурал сарыг ононо. Хэнгэрэгийн дохиур бөөгийн гарын хөдөлгөөнд гялсхийн Цэгцэрийн шар талд бас бууна. Бөөгийн дохиур нь мэнгэт сар болоод тал хээр нутгийг ээлжлэн нүдэж, Онон, Хэрлэнгийн ус цалгина. Бурхан халдуны уул, нурууд

дээгүүр бөөгийн улих дуу цуурайтаж улмаар хээр тал нутагт зээрийн сүрэг сортолзон сэрж нэгэн шугамаар хошуурна. Бөөгийн улих дуун тэнгэрт оройлон цойлоход, үрийн гуйлга аргагүйдсэн олон иргэний зүрхийг цочроож хот айлынхан гэрийн гадна зогсоцгооно.

Өүлэн үжиний цайвар царай шингэрч, нүдний эргэн тойронд хөх туяа татаж, хамар дээгүүр тунгалаг хөлс бурзайжээ.

Унинаас дээс уяж, шээзгийг эхийн баруун, зүүн тохойд ивээс болгож, хагас босоо байдалтай хэвтэр засч төрөх эхийг хэвтүүлсэн байна. Өвдөх тоолонгоор дээснээс чангааж ханын шийр газрын хөрсөнд шигдэнэ. Ханын шийр доогуур гүндбалын ургамал сүлжин ургаж, толгойн орой дахь бөөгийн өндөг доор шургажээ. Бөөгийн нүүр чинэрчээ. Түүний цус огшиж галын гэрэлд бөөгийн нүүр час улаан харагдаж магнайн гүн үрчлээсээр хөлс урсана. Бөөгийн сөрөвгөр цагаан сахал дунд хар үс сор мэт чимэглэнэ.

Энэ эцэнхий босоо нүүртэй бөө тэнгэрээс хэчнээн удаа үрийн гуйлга гуйж гүндбалын ургамлын хөх судсыг өвдөглөсөн бол. Гүндбалын ургамлын хөх судас Бурхан халдун ууланд буй. Уулын гүнд орших тогоон нуураас эх авч өвсний үндсийг сүлжиж нэхсэн гүндбал, лууны ургамал бол газрын хөрсөнд лугших хөх могой юм. Зайран бөөгийн өвдөг дор ургамалын хөх судас лугшиж байна.

Бөө Халзанбух бол урианханы овгоос гаралтай бөгөөд тэр боогийн өвөг бөө Харлагтэх нь Амбагай хааны үеэс боржигон овогт зүтгэжээ. Харлагтэхийн дараа Цагаанбух бөө тэнгэрт халив. Урианхан овгийн бөө нараас ганц Халзанбух үлджээ. Үргэлж дайн самууны хөлд тийрэгдэж, үхэл харгислалтай тэрсэж явсан Цагаанбух дүү зайрангийнхаа умгар гэрт хэдэн сарыг өнгөрөөж бие чилээрхсэн тул ятуунд яваад эргэж ирэлгүй алга болж хавар цас хайлах үеэр цасны дороос яс нь олджээ. Халзанбух гэрлэж эхнэр аваагүй тул үр үндэсгүй явсаар бөлгөө. Тэрбээр шар дээл өмсөж айлаас айлд, гэр хүрээнээс гэр хүрээний хооронд залагдаж, зовлонтоны зовлонг нимгэлэх гэж явсаар отөлжээ.

Өтөл нас Халзанбух бөөд гайхалтай зохисон байна. Бөөгийн сахал шингэн сөрөвгөр хэрнээ хар сортой, нүүр үрчлээ ихтэй боловч жавхаалаг, урт босоо учир хүн бүрт танигдана. Халзанбух дээд тэнгэрийг аргадахын эрхэнд авгжээ. Монголд тал нутаг, мал сүрэг байна. Гэтэл овог аймгууд өвөр хоорондоо эмс булаалдаж дайтна. Эмс охид гэдэг дайн байлдааны цөм болж харчуулын цусыг урсгасныхаа үйл лайг эдэлж хүүхэд төрүүлдэг бус уу.

Байлдах дайтах тусам монголын эрчүүл хорогдож, бэлэвсэн хүүхнүүд хоцроно.

Эрт бэлэвсэрсэн эмсийн уй гашуудал тэнгэр эзлэн гунигийн дуу үлдээж, нулимс нь Онон мөрний цутгалан лугаа асгарчээ. Хэдий болтол монголчууд тайван бус амьдрах билээ. Монголчууд эв эеэ хичээвэл Алтан улсын идэш болно гэж үү.

Боржигоны нөмөрт тайчууд, жүрхэн, урианхан, баяд, дөрвөд, уруд, мангуд эвсэн биесийг хялайхаа больж гагцхүү Есүхэйг харцгаана. Урьд жилээс уур хилэн хүргэж мал сүрэг дээрэмдэж, нутаг бэлчээр булаалдаж асан татааруудыг номхотгохоор Есүхэй зориглон шийдэж, Цэгцэрийн шар талын баруун хаяаг дэрлэн зусаж бүхий иргэдийг саявтар тоносон сургаар цэрэглэн морджээ.

Хөл хүнд Өүлэн үжингийн духан дээр Есүхэй том гарынхаа алгаар дарж,

-Намайг иртэл... гэвэл Өүлэн нүүдэлчдийн ёс жаягийг дагаж "би алзахгүй" гэв.

Нүүдэлчид бол нүүдлийн замд төрж, үхэж, замбуулингийн өдөр хоногийг хээр талд үддэг хүмүүс билээ. Амьдралын энэхүү орчилд нүүдэлчин иргэд дасчээ. Өүлэн үжин, хааны хатан боловч эрийн нөмөр үгүйлж татаартай дайтахыг хориглосонгүй. Татаарыг сөхрүүлэхийг Есүхэй баатарт хүсэв. Эр нь дайнд алагдвал эмс түүнийгээ орлоно. Дайн байлдааны жамыг хүүхэд үүхэдгүй дагамуй.

Бөө Халзанбухын дуудлага Онон мөрөнг тойрсон сүүдэрт уулс, бух толгод, халзан гүвээг дамнан уул нуруудаар шуранхайлан алсарна. Моддын навч найлзуур, шилмүүс, шивээн толгой бөөгийн дуудлагын аясаар чичирч байлаа.

Удам залгах нуган хайрлаач... Улс монголын заяаг тэтгээч...

Дээд тэнгэр бөөгийн дуудлагаар өөрийн хөвүүнийг илгээж, хээр тал нутагт эмс хүүхнүүдийн нулимс татрах цаг ирүүжин... гэж Халзанбух бөөлж байв. Бөө толгойн оройд асаасан түүдгээ сэргээв. Галын очис бутран үсэрч байхад чоно улив. Чонын улилт дээд тэнгэрээс ч юм шиг, хөх ногоон уул нуруудаас ч юм шиг ойртон, холдон сонсогдоно.

Чоно улих нь сүргээс сүрэгт тархав бололтой тэнгэр, газраар цацрах сарны туяатай сүүлэлдэн хавтгайрав. Азарган чоно тэднийг манлайлав. Бөөгийн түүдэг гал дахиад бадамлана. Чоно улихад хоточ ноход хий боорлон, агт морьд зэвүүрхэн чихээ сортолзуулна. Түүдгийг тойрон майга хөлтэй цэргүүд дэвхцэж, сөөнгө гасланги хоолойгоор зайрангийн дуудлагыг давтлаа. Зайрангийн хөнгөн бие агаарт хөөрч хэнгэрэгийн дохиур нь Цэгцэрийн талд нэг онож, мэнгэт сарыг нэг онож байна. Галын угалз мэт дөл нэг нэгнийхээ дээр цоройлдон гарч хамгийн дээдэх дөл нь эрчлээт сум мэт тэнгэр өөд тэмүүлнэ.

Тамирдаж зүдрэхийн туйлд хүрсэн Өүлэн үжин гарт буй оосроо алдахад хүүхдийн чарлах дуу хадлаа. Хээр хоносон бөрлөн сар тэнгэрийн нэгээхэн зайд бүгэж нар мандсан байв.

-Тэргүүн Ононы Дэлүүн болдогт Есүхэй баатрын хатан Өүлэн үжин нуган хөвүүн төрүүллээ... Нуган хөвүүн нөж атгаж төрөв...хэмээн Халзанбух бөөлөн орь дуу тавив.

\* \* \*

Өүлэн эхийн царай зүс саруулсаж тайтгарчээ. Майга хөлтэй цэргүүд зайран беегийн шаргал морины араас цувралдан давхицгаалаа. Зайран бөө шар дээлтэй, шаргал морьтой тул асаасан гал мэт харагдана. Тэрхүү гал араасаа тоос дагуулжээ.

Монголын гуравдугаар жарны хар усан морин жилийн улаан морь сарын хар морин өдрийн морин цагт Есүхэй баатрын өргөөнд хөвүүн мэндлэв. Хөвүүн нөж атгаж төржээ. Морин цагийн босго давж хүүхэд чарлана. Чоно улихаа больжээ. Чонын сүрэг олзны хойноос шиншлэн цуварч оджээ. Хоточ ноход утаа суунаглаж намжаарах Онон мөрний хөндийд мал дагаж шогших бөгөөд боржигоны баг цэргийн тоос хэдэн гүвээ дагаж босоогоороо замхарч



байлаа.

Өүлэнгийн дэргэд Хуагчин, Мээнэнбилэг бүсгүйчүүл шөл, цай бэлтгэж, хүрээний айл хотлынхон дайтаж яваа эрчүүлийн төлөө зовцгооно. Цэгцэрийн уужим талын нэгэн сэжүүрт байлдаан өндөрлөж байв. Намирсан хар үсээ сураар зангидаж боосон Есүхэй баатар татаар иргэдийг сөгдүүлжээ. Лууны ургамлын хөх могой судас хагарч тэр хагархай руу сэлэмний хурц ир шигдэж голоороо хуга үсэрчээ. Баатар эрийн нуугдмал хэрцгий араншин асч "татарууд биднийг тохуурхаж иргэнийг алж, малыг булаав. Соргог бэлчээрт санаархав. Хоншоороо татаж аваагүй татаар иргэдийг нэхэж байлдаад илдний ирийг шалгалаа. Эмс нь царайлаг мөртөө хорлонтой байж мэднэ. Би татаар эм нэгийг ч үл хэрэглэнэ.

Хоншоороо татахгүй бол яадгийг мэдтүгэй" хэмээн бодож олзныхоны өмнө ташаа тулна.

Есүхэй баатар татаарын толгойлогчийг жартгай нүдээр ширтэнэ. Цэргүүд түүнийг хүчээр сөхрүүлэхэд

Есүхэйн урт шовгор шанаа гүрсхийн зангирав. Тэмүжин үгээ хэмээх татаарын баатар шазруун эр байлаа. Тэрбээр Есүхэйг заналтай ширтэж үсээ сэгсчив. Нүд догшин, мөр өргөн, хөл майга, бөгтөр нуруутай Тэмүжин үгээ амандаа зунгаарсан шүлсийг газарт нулимахад хөлстэй нүүр нь татвалзана.

-Сөхрөх дургүй бол босогтун! гэж Есүхэй омогдов. Татааруудын хөглөрсөн эд агуурс, алагдсан цэргийн хүүр дундуур явсан цэрэг эргэж ирээд, -Хуагчины эр үхжээ гэж өчив.

Үүнийг сонсоод Есүхэй баатар улангасан хашгирч "тэр үхэж үү" гэж асуугаад хариу сонсолгүй "Хуагчин яана... Хуагчин бэлэвсрэв" хэмээн шивнээд зүрхэндээ юүлэгдсэн нулимсыг залгих мэт, харууслаа гөвөх мэт гүнзгий шүүрс алдлаа. Цэрэг, баатруудын царайг цэвдэгшил бүрхэв. Шазуур зуун боссон Тэмүжин үгээгийн хүлээсийг Есүхэй баатар сэлэмний үзүүрээр гогдож тас огтоллоо. Боржигоны цэрэг эрс мөсөн нүүртэй болов.

-Миний өрийг өвтгөв. Тэмүжин үгээ чи сонс. Чамайг хүндэтгэж босоогоор чинь цавчина. Хуагчины эртэй чи цуг үхэх ёстой. Чиний амьсгалын тоо гүйцсэн гэж хэлж байтал гал морьтон цахилж айсуу харагдлаа. Сөгдөж унасан татаарын эмс бүсгүйчүүл, олзны цэргүүд, шархтанууд холилдон Есүхэй баатрын эрдүү дуунд хавталзаж байв. Шаргал морьтой, шар дээлтэй айсуу яваа нэгнийг нэхэж бөөн морьтон харагдахад,

-Тэр ирж яваа хэн буй. Юу болов гэж сэжиглэх мэт Мэнлиг хашгирав.

Цэвдэг нүүрт цэргүүдийн өмнө Есүхэй сэлмээ сугалж барьсан агаад түүний хурууны үе шалбарч няцарчээ. Тэмүжин үгээгээс ял асууж татаарын олзлогсдын зүрхийг үхүүлсэн Есүхэй чиглэн яваа морьтонг амдуулав. Амдсан морьтон эргэж цугтаа хатирч ойртон ирэв. Халзанбух бөө биеэрээ мөн байлаа. Зам товчлохыг бодвоос ихэд яарсан аж. Бөө адгаж баяссан байв. Боржигоны гэр хүрээнд яаралттай үйл явдал болсныг илтгэнэ. Есүхэйн царайны цэвдэг хүйтэн байдал илэрхий арилжээ. Өүлэн хатнаас хөвүүн төрсөн, охин төрсөн алин болохыг ялгаж ядна. Хатан минь амаржжээ гэж Есүхэй багтай сэтгэж байлаа.

Шаргал морины амьсгаа бөглөрөн түргэсэж завьжаар хөөс сахран самсай нь сарталзаж байх зуур бөө аль хэдийнэ сөгджээ. Бөөгийн ард түүнийг амдаж тоссон нэгэн цэрэг эр сөхөрнө. Халзанбух бөө саагисан тасархай амьсгал түрж,

-Өүлэн үжинээс нуган үр төрлөө гэж дуулгав. Есүхэй баатрын цээж оволзоно. Бөртэ чонын хорин нэгдэх үе залгагдав. Есүхэй баатрын өнгөн дээр гүндбалын ургамал, лууны ургамлын хөх могой судас холбогдов. Хэдийбээр хатуу чанга баатар эр боловч Есүхэй догдолсон ажгуу. Түүний бие чичирч занал, хорсол хурсан харцаа Тэмүжин үгээгийн нүднээс салгаагүй авч хөшинги царай нь ялигүй зөөлөрчээ. Ханцуй шамлаж, сэлэм сугалсан Есүхэйн багтрал чинээндээ тулжээ.

Есүхэй баатар зөнч өвгөн рүү хүйтнээр харав. Энэ харцыг хүлээж авсан Халзанбух зайраны бөглөрсөн хоолой цээлшиж уужраад,

-Есүхэй баатрын хөвүүн баруун гартаа нөж атгажээ...

Тэр хөвүүн шагайн чинээ нөж баруун гартаа атгаж төрлөө гэж зарлахад боржигоны цэргүүд уухайлав.

Айдастай, гайхамшигтай зарыг морин дээр хөндөлдөх цэрэг эрсийн зарим нь дутуу ойлгож хий дэмий хашгирсанаа биесийг харцгаан дүлий дүмбэ оргилоо. Олзны татаарууд айхтар тэвдлээ. Харин Есүхэй баатар сугалсан сэлмээ буцааж хуйлахын оронд татарын Тэмүжин үгээгийг толгойг хяргаж зүлгэсэн юм шиг гялалзах сэлмээ хараад,

-Миний хөвүүнд Тэмүжин нэр өг. Энэ сэлэм шиг гялалзаж яваг гэв.

Цагаанбух бөөгийн шинжин хэлсэн үгийг сая төрсөн Тэмүжин хөвүүн нотлов. Тэмүжингийн тухай яриа Цэгцэрийн шар талаас хальж Алтайн уулс, Хатан голын хөвөө хүртэл тархав. Есүхэй баатрынд төрсөн хөвүүн нөж атгажээ гэдгийг хамаг монгол даяар тараахын тулд, цаашдаа овог аймгуудад мэдүүлэхийн тулд ингэсэн билээ. Боржигоны хааны нүдэнд Сэлэнгийн хөвөөний барын чих хэмээх цэцэг санагдана. Өүлэн эхийн хэвлийд цэцэг ургуулагч рашаан ус байснаас болоод боржигонд булаагдсан юмсанж. Боржигон аймгийн цэрэг эрсийг харсаар байтал татаарын Тэмүжин үгээ гурав алхав. Гурав алхасны хойно түүний заггар толгой биенээс тасар унав. Толгой газарт унахын завдалгүй олгойдсон цус агаар шүршлээ. Агаарт үсэрсэн цусны дуслууд өвс ногоог улаанаар будаж Тэмүжин үгээ хүнд чимээтэй ойчиж сөгдсөн татааруудын толгой тасдуулсан мэт гудайв.

\* \* \*

Боржигон овгийн үр үндсийг бөхлөж үлдээхийн төлөө Есүхэй баатар сэлэм атгаж, цуст тулаанд амь өрсөж яваа билээ. Татаар аймгийн омгийг дарж, зоригийг шанталсан тэр өдөр бол Есүхэйд хатуу, зөөлөн хоёрын туйл нэгдсэн өдөр байв. Хуагчины эр үхэхэд Есүхэй ихэд гашууджээ. Хуагчин бол эрээр дутахгүй гоолиг төрсөн, ааль ааш сайхантай эхнэр байлаа. Эр, эм хоёрын аль нэг үгүй бол голомт хэлтгий болдог.

Хуагчины төлөө Есүхэй эмгэнэж байв. Тэмүжин хөвүүн төрсөн нь ёстой юм ёсоороо болжээ.

Тэмүжин хөвүүн өсч эрийн цээнд хүртэл боржигоны хот айлд зовлон ч ирэх биз, жаргал ч ирэх биз. Татаарын толгойлогчийн толгойг хяргаснаас үүдээд Есүхэй энэ өдөр ихээхэн өөрчлөгдөв. Тэр баатар эр хөвүүнтэй болж хөвүүний адармаат хувь заяа эхлэв.

\* \* \*

Ундуй, сундуй хөсөр хэвтэх үхдэлийг зайлуулж, гэр орноо ачаалан нүүхийг Есүхэй олзлогдсон татааруудад тушааж "эхнэр, хөвүүн хоёртоо бушуухан очих юмсан" хэмээх хязгааргүй хүсэлдээ дийлдсэн Есүхэй баатар Тэргүүн Ононы Дэлүүн болдогийг зорив. Сүүлд толгойгоо хяргуулсан Тэмүжин үгээгийн бие чазав татвас хөдөлж хөших болоогүй байв. Татаарын нэгэн эм үхдэлийн толгойг ширэн тулманд хийж элгээрээ тэгнэж хэвтэв. Тэмүжин үгээгийн толгойг тахиж түүний нэрээр нэрлэгдсэн хөвүүнийг хорлох сэтгэгдэл татаар эмд төрж байжээ. Эл явдлаас нэлээд хожим татаар эм овгийнхоо ахлагчид Есүхэй баатрыг хорлож чадвал Тэмүжин өнчирч боржигоны голомтны үнс хийснэ хэмээн сануулахын тулд амьд яваагаа ярьжээ.

\* \* \*

-Тэмүжин хөвүүний алгыг хүнд бүү харуул! гэж Халзанбух бөө Өүлэн хатан болоод асрагч эх Мээнэнбилэг, Хуагчин хоёрт амин захиас, аман даалгавраа үлдээгээд Бурхан халдунд тахил өргөхөөр оджээ. Зайран бөө хамгийн том үйл хэргийг биечлэн бүтээсэн билээ. Тэмүжин хөвүүний уйлах дуу Өүлэн эхийн хөхийг ивэлгэж, зүхэл хорсол, үхэл заналын бараан сүүдрийг үргээсээр Онон мөрөн цөн түрэх дараагийн хавартай золгожээ.

Онон мөрөн цөн түрэхэд хургатай хонь, ишигтэй ямаа урсаж алга болно. Цасны ус шимж зогссон янзагатай шаргачин цасны нурангитай цуг Онон мөрөнд үйжээ. Боржигоны агтчин Улаансухай, бусдын хүүхэдтэй эмээс зугатаан мөрний усанд үйж үхжээ. Онон мөрөн үхэл, амьдралын эргүүлэг олонтой билээ. Онон мөрний хөрсийг торлосон лууны ургамал, гүндбалын ургамалын хөх могой судас дээгүүр Тэмүжин гишгэж хөлд оржээ. Тэмүжиний баруун гартаа шагайн чинээ нөж атгаж төрсөнийг Онон мөрний усаар умдаалж байдаг овог аймгийнхан мартаж санана. Мартаж санасан эл явдлын гэрч Халзанбух тэнүүчлэн хэсч яваа биз. Тэр бөө эс мэдэгч царайлж яваа биз. Тэр бөө тэнгэрт нууц хадгалах андгайтай биз.

\* \* \*

Хүүхдийн хөл ногоон дундуур тун сурмаг атлаа болгоомжтой гишгэж байна. Хялгасан урхинд зурам оржээ. Зурам нүхэндээ зүтгэлнэ. Гэвч модон гадастай хялгасан урхийг яахин дийлэх билээ. Хөвүүн зурмыг сайтар ажиглан харна. Өвсний зууралдсан үндэс рүү орсон нүхний аманд урхи тавьсаныг тэнэг зурам эс мэдэж хүзүүгээ гогдуулжээ. Хөвүүн зүтгэж буй зурамны сүүлнээс угз татан гаргаад урхинаас сулав. Зурамны сүүл гозойн хар хурдаараа харайлгав. Эл үйлдлийг харж суусан Есүхэй баатар,

-Тэмүжин чи өрөвдөө юү гэж асуув.

-Нэг удаа амь өршөөх ёстой бус уу

-Дараа нь...

-Эргээд тэнэглэвэл арьсаа өвчүүлнэ.

-Буруу ...Чи шууд алах байсан юм.

Хөвүүн үл дуугарна. Есүхэй дургүйцэж байлаа. Тэр өдөр Есүхэй хонь нядалж арьсыг нь яах ийхийн зуур хуу татаад цусыг бортгонд юүлж, гэдэс дотрыг модон цар дээр овоолоод хөвүүнд өчин элэг огтолж өгөв. Тэмүжин эргэлзэнгүй харахад "тэнхээ тамир сэлбэдэг юм, ид" гэлээ. Хөвүүн түүхий элэг зажлахад завьжнаас цус булталзан улмаар эрүүний доогуур урсаж хүзүү, хэнхдэг рүү улаан судал татуулав.

-Амттай байна уу -Тиймээ

-Цус, сүү хоёрыг их увал цөс ихтэй баатар болдог юм. Аймхай хулчгар эр цус харж чадахгүйгээсээ болоод дайнд ялагдана. Манай монголчууд цуснаас айх ёсгүй хүмүүс. Хэрэв айх аваас Алтан улс, татаар аймагт байнга ялагдах цөв нүүрлэнэ.

Тэмүжин эцгийн үгийг чагнан зогсоно. Тэмүжинг төрсөн цагаас Есүхэй баатар энэ хүүд бусдаас илүү анхаарах болжээ. Мэргидийн Чилэдү баатраас Өүлэнг булааж аваач хэмээн Цагаанбух Есүхэйд хов дуулгасан юм. Цагаанбух цасан доор ясаа гээхэд Есүхэй баатар Өүлэн хатнаас хөвүүн төрвөл яах тухайгаа нягталж шийдвэр гаргасан нь санаагаар болж буй учраас Тэмүжин хөвүүнийг онцгойлох нууц шалтаг буй болжээ.

Ямартаа нэг удаа Тэмүжин хөвүүнийг нохойноос айн цочиход Есүхэй баатар ширүүнээр,

-Хөвүүн чиний гарт юу байнав гэв.

-Ташуур байна.

-Ташуур барьсан байтлаа нохойноос цочлоо гэж үү. Гараа хөдөлгөхөд хэцүү байна уу. Тэмүжин ташуураа далайсан боловч нохойн толгой дээр буулгаж эс зүрхлэв. Нохойн толгой нохойных атал хүний толгой шиг хөвүүнд санагджээ. Ийм явдал Тэмүжинд олонтаа тохиолдож байв. Тэмүжин хөвүүний хэтэрхий найрсаг занг Есүхэй эцэг үл таашаана.

Онон мөрний Дэлүүн болдогт сар дэндүү тод манддаг

ЮМ. Тэмүжин хөвүүний төрсөн тэр жилийнх шиг буурал цагаан сарны туяан дор тэнгэр хүнхийж, газар уужимсаж харагдана.

Сар гэрийн тооноор харагдах боловч гэрийн тоонон дээр үзэгдэнэ. Сар, тоонотой таширлаж байхад Есүхэй, Өүлэн хоёр түүний цагаан гэгээнд булхан, тайвширч , "> саруулсан нүдээр нэгнээ ширтэж байна. Өүлэн "ийм ^ их үстэй хүн байдаг аа" хэмээн эр нөхрийхөө гэгээр бүтээлгэж амьсгаадан байхдаа бодсон бол Есүхэй "бүсгүй заяа өрөвдөлтэй еэ" гэж анх удаа санагалзав.

Хувь заяатайгаа гүйцэд эвлэрсэн Өүлэн үжин бөгөөс Онон мөрөнд ирсэн бус төрсөн юм шиг

дасжээ. Онон мөрний цээлд Өүлэн загас лугаа зугаацан сэлнэ. Усанд гол төлөв сарны гэгээтэй холилдон шумбах дуртай байлаа. Саран өөд удаан харж хэвтэх үед Өүлэнд гуниг төрнө. Их цэнхэр усны хөвөөнд нутаглах олхонууд хот айлаа санаснаас тэр. Есүхэй баатар ан авд хорхойтой тул үе, үе тал нутаг руу алга болно. Ангийн олзоор боржигончууд ихэвчлэн зээрин гутал хийдэг байлаа. Зээрийн арьсыг гадагш харуулан ташуу, шулуун зүйдэлтэй хийсэн ширмэл гутал бөх бат билээ.

Зулаг сайтай гутал Өүлэнд үжинд олон бий. Яагаад орон дотроо гутлын тухай санасныг Өүлэн гэнэт гадарлаж,

-Ван хааныд морилохдоо Тэмүжин хөвүүнийг дагуулж явах уу хэмээн асууж "тэгнэ" гэсэн хариу сонсоод "тэгвэл гутал аваачиж бэлэглээрэй" гэж сануулав. Өүлэн дахин намуунаар,

-Ван хааныд юу болоод байгаа юм гэв.

-Харийн гийчид ирж дэвэн дээдийн сургаал айлдаж буй гэдэг. Намайг хөвүүнээ дагуулж ирнэ үү хэмээн хэл хүргүүлсэн байна.

-Хөвүүн дөнгөж дөрөвтэй шүү дээ

-Балчир насанд сонссон үг хадан дээр сийлсэн мэт ой тойнд тогтдог гэнэ лээ.

-Сар шинэгэхэд маргааш болно.

Өүлэн үжин эр нөхрийнхөө цээжинд нүүрээ нааж

"чамд хэдэн хөвүүн төрүүлж өгөх вэ" хэмээн янаг элгэмсүү асууж байна. "Хөвүүн олон тусмаа сайн" гэж Есүхэй баатар шивнэнэ.

\* \* \*

Асрагч эх Мээнэнбилэг нь Тэмүжин хөвүүний хучлагыг засахад түүний нүд өөдөөс нь харж байв. Мээнэнбилэг духан дээр нь гараа тавиад "Хүү минь унт. Өглөө эрт аян замд гарна. Хол газар авахад ядарна шүү" гэв. Мээнэнбилэг хөвүүнийг нялх багаас мэдэх тул түүний зөөлөн хатуу нь мэдэгдэхгүй ааштай, зөрүүд биш атлаа санасандаа хүрдэг занг гадарладаг билээ. Тэмүжин хөвүүн сар өөд ширтжээ. Маргааш аянд явах дургүй байгаа, эс бөгөөс дуртай байгаа нь үл ойлгогдоно.

-Сар жаргах уу, хээр хонох уу, Мээнэнбилэг ээжээ...?

-Чамд юу бодогдов. Зүүдлээгүй биз.

-Их хачин санагдаж байна. Энэ сар манай тоонон дээр гуниглаж хонох нь. Манай тоонон дээрхи сар хэзээч ийм гунигтай байдаггүйсэн.

-Чамд л тэгж санагдсан биз. Илүү дутуу бодлоо сарниагаад амарч үз, хөвүүн минь... Мээнэнбилэгийг Тэмүжин ээж хэмээн дуудаж хөлөө атгуулж духан дээрээ зөөлөн алгаар

даруулах дуртай байлаа. Сарны сүүн гэрэлд өвсний үндэс газрын гүний хос хөх могой судаснаасаа ер бусын тэжээлт чийг хөхөж байлаа. Энэ шөнө Бурхан халдун уулын элгэнд Халзанбух бөө бие барж түүний содон шар дээлэн дор жамъянмядаг цэцэг дэлгэрч хоножээ.

Шар цэцэгсийн хүрээлэн, цагаан уул цэцгийн хүрээлэнтэй залгажээ. Цагаанбух бөө цагаан уул цэцгэнд шингэжээ. Урианхан овгийн ах дүү зайран бөөд хорвоог орхихдоо монголын заяаг болгоож байжээ. Шар, цагаан хоёр од сарны гэгээнд тэнгэрт харваж байна.


Ван хааны гэр хүрээ монголын тэргүүлэгч овгийн толгойлогч Есүхэй баатрыг тосч авахаар мэнгэт бөрлөн сарны дор налайж байлаа.

## Зургадугаар бөлөг



*Тэмүжин бага наснаас саранд дурламтгай бөлгөө.*

*Хожим Бөртэтэй сарны туяагаар холбогддог байв*



Ван хааны хот хүрээнд Есүхэй баатар Тэмүжин хөвүүний хамт нэгэн улирал шувтлаад буцав. Хэрэйдийн гэр хүрээнийхэн Тэмүжинг илт шохоорхон найрсаг дөлгөөн зантай, хэрсүү, эцэгтээ ээнэгшүү болохыг аймаг овгоороо цугларсан үед мэдэж авчээ. Нэг улирал цэцэг тоос хүртэх төдийд өнгөрчээ. Цэнхэр ногоон нүдтэй, өндөр, царайлаг бөгөөд эрхэмсэг номлогч үл ойлгох хэлээр ярина. Хөвгүүнд түүний урт хуруу хэрхэн хөдөлж, нүд нь тогтуунаар бодлогоширч загасаар бороо орсон тухай дахин, дахин сонсож эзэний ивээлд багтах аваас өлсөж, өвдөж үхэхгүй гэдгийг мэджээ. Муу явдал холоос улбаатай болохыг тайлбарлахдаа баруун ууланд тэнгэр дуугарахад зүүн ууланд гялбаа нь харагдана гэжээ. Онон мөрний баруун ууланд тэнгэр нижигнэж дуу нь замхарсан хойно тооноор гэрэл гялсхийдэгийг Тэмүжин сайн санадаг юм. Мээнэнбилэг эхээсээ үүнийг асуухад "тэнгэр бол энгүй уудам шүү дээ. Тэнгэр биднийг харж байна. Тэнгэр зовхио нээхэд гэрэл гялсхийдэг юм" хэмээн амьд жишээн дээр тайлбарласан билээ.

Хэрэйдийн хааны гэр хүрээнд тусгай өргөөнд залардаг тэр эрхэм нэгэн өдөр ээлжит үлгэрээ ярьж дуусаад,

-Хөвгүүд баруун гарын алгаа харуул. Тэнгэрт хэн танигдах нь вэ гэлээ. Хөвгүүд цугаар алгаа харуулав.

Тэмүжин алгаа харуулах дургүй байв.

-Тэмүжин хөвүүн юунд цааргалав.

-Намайг бүтээсэн аав, ээжий хоёроос өөр хүнд алгаа бүү харуул гэж их бөө Халзанбух айлдсан гэнэ лээ. Мээнэнбилэг ээж хүртэл миний алгыг хардаггүй юм.

\* \* \*

Тоорил хаан жоготой жуумалзан цэнхэр нүдэтийг цаашлуулж,

-Хүүхдийн толгой эргүүлж чаддаггүй гээд хөхрөв. -Тэмүжин балчир биш. Тэр билгийн нүдтэй.

Түүнийг би байтугай та хуурч дөнгөнө гэж үү.

-Тэмүжин хөвүүний алганд нэг нууц байна даа. Хэн түүнийг алгаа хүнд бүү харуул гэсэн юм бол. Энэ балчир хөвүүнд хэн зааж өгөв. Гартаа нөж атгаж төрсөн гэдэг юм.

-Тэнгэр тамгаласан бус уу.

Энэ тухай ван хаан Тоорил толгойгоо гашилтал боддог байв. Есүхэйд тэнгэр байдаг бол надад тэнгэр буй. Есүхэй хөвүүнтэй бол би хөвүүнтэй. Заавал Есүхэйн хөвүүн нөж атгаж төрдөг нь юув. Нөжний учрыг олж мэдэх юмсан. Конс номлогч лав ухаарч, гүн итгэж чадахгүй байна. Тэр муу зэрлэг татаарын нэрийг хөвүүндээ хайрладаг байж. Хөвүүн төрж татаарын баатар Тэмүжин угээ үхэв. Амь солигдож Тэмүжин хөвүүн хоёр амьтай болов уу. Эсвэл Тэмүжин хөвүүн баруун, зүүн талдаа хоёр зүрхтэй юү. Өүлэнг мэргидийн Чилэдүгээс булаасан гэдэг. Тэмүжингээс хойш Өүлэн хоёр хөвүүн төрүүлсэн байдаг. Өүлэн үжинд учир байна уу. Олхонууд аймгийн царайлаг бүсгүй дандаа нуган төрүүлдэг. Хэрэйд аймаг одоохондоо боржигоноос хүчтэй атлаа дайнч биш юм. Надад Есүхэй баатар тусласан. Есүхэй баатрын цус Тэмүжинд урсаж байгаа бол хэтдээ эцэг шигээ тусархаг хүн болно. Тэнгэрийн заяа, хүний заяа, үйлийн заяа хожим яаж огтлолцохыг хэн мэдлээ.

Тэмүжин хөвүүн алгаа харуулахгүй байдаг нь их учир биш үү. Харахад бусад хөвгүүдээс ялгарах гойд совин Тэмүжинд алга. Цочимхой, найрсаг харагдах энэ хөвүүн сэлэм далайтал хол биз. Хөвгүүдээс надад Жамуха илүү lib таалагдана. Манай Нялх Сэнгүм хүүхэд шоглох дуртай. ШОГЛОЧИХООД нуугдана. Тэмүжин, Жамуха, Сэнгүм гурвын ааш яасан зөрүүтэй вэ. Монголын тал нутгийг хэн нь байлдан дагуулах бол. Эзнээ хүлээсэн хүлэг морьд, эрээ хүссэн гоо охид тал нутгийн энд, тэнд өсөж байна.

Есүхэй баатар хүүхэмсэг биш юм. Бүжигч охидоос яагаад өвөртлөхгүй байна. Шазуур



зуумтгай баатар , "> эртэй дөрөө хоршуулж явахад Тоорил вантаны агт мөнгө ^ арвижиж, адуу мал өсч, овог аймаг өнөржих бус уу. Маргааш Есүхэйг мордоход сэлэм бэлэглэх биш үү. Нүд унагаад байсан сэлмээ зүүж яваг.

Тоорил хаан бодолд дарагдаж сууснаа "хөвгүүдийг өстөл хэчнээн дайн тулаанд хэд нь үрэгдэх бол" хэмээн санаснаа "Есүхэй бид чинь адилхан гурван голын усаар умдаалдаг бус уу" гэж сэтгэв.

\* \* \*

Есүхэй баатарт аз тохиожээ. Халзанбух зайран бөө хан хурмастад залрав. Өүлэн хатнаас нуган хөвгүүд цувран төрж Есүхэйг бахардуулна. Есүхэй баатар Тэмүжин хөвүүнийг нүднээс үл салгана. Тэмүжин хөвүүнийг хатуу, зөөлөн хосломол аргаар өсгөхийг хичээнэ. Тэмүжин бол Хасар, Хачиун хоёр дүүтэй. Сочихэл эхээс төрсөн Бэгтэр, Бэлгүтэй хоёр Тэмүжинийг ах гэх боловч хорсолтой зан гаргана. Хөвгүүд урхиар зурам агнаж, өөшөөр загас гогдож, гоньд мангир мэт амтат ургамал түүж, морь малтай ноцолдоно.

Есүхэйн хөвүүн Тэмүжинг Ван хаан таалжээ.

-Хөвүүний ураг боржигон биз дээ гэж ванг егөөдөхөд Есүхэй баатар илт дургүйцэж,

-Тэнгэр заяат хэмээн Ван хааныг мохоов.

-Тэмүжин алгандаа нөж атгаж төрсөн үү гэхэд Есүхэй адарч,

-Эхийн сүүгээр угаачихсан гэжээ.

Тоорил ван, Есүхэй баатрыг туршиж ядаад,

-Хатуу ааруулыг хүлхэж дуусгадаг юм гээд алтан хундагатай архиа сөгнөв.

Тоорил хааны алтан эд агуурс, чамин зүүлт чимэг Есүхэй баатрын зарим бодол санааг өөрчилж "бэл зузаан бол ялагдал бага хүлээнэ гэсэн чиг баримжаа өгчээ.

\* \* \*

Хэрэйд аймгийн зочин Конс ноён янгирт ууланд ургамлын үндэс ухааж явав. Янгирт уулын ян оройгоос зуун уулын орой харагдав гэж Конс номлогч Ван хаанд хэлэв. Ван аягатай цайгаа цалгиулан "за, тэр" гэж дуугарчээ.

-Монголын уулс оройгоороо холбоотой юм гэж номлогч өгүүлэв.

Зуун уулсын орой нэгнээ харж байдаг. Харийн иргэнд зуун уулын орой тодорхой үзэгдэв гэнэ. Монгол иргэнд мянган уулын орой харагдана. Нэг уулын орой модтой, нэг уулын орой халзан байтал үлээх салхи болоод буух хур нь адил билээ. Мэргид, татаар, хэрэйд, боржигон, найман аймаг үг хэлээ ойлголцох атал зөв буруугаа үл хэлэлцэх бус уу.

Уул, уулын ургамал ондоо бөлгөө. Маханд төрсөн хүмүүн тэс өмнөө билээ. -Жамуха зальхай инээнэ. -Сэнгүм урваж бултана. -Тэмүжин ой тойндоо мэтгэнэ.

Нэгэн улирал дуустал үлгэр хөөрч суусан Конс ноёнтоны ойлгоц иймэрхүү байлаа.

-Тэмүжин ямархан эр болох вэ гэж Ван хаан лавлав.

-Биеийн чадал дундхан хэрнээ билгийн хараатай юм билээ гэж Конс өчив.

-Тэмүүжин гартаа нөж атгаж төрсөн юм билээ гэж Ван хааныг Конст ч юм шиг, өөртөө ч юм шиг асуулт тавихад тэнгисийн эрэг дээрхи үлгэрийн хотоос ирсэн цэнхэр нүдэт инээмсэглэж,

Та Тэмүжинд их санаа тавих юм. Танай эндээс хол нутагладаг боржигончууд таны нөхөр мөн үү. Та бол загасны түрс зооглодог, Тэмүжин хөвүүн сүү уудаг. Ялгаа их байна гэлээ.

Тоорил хаан ярианд автан жуумалзаж,

-Гурван голын эхэнд боржигонууд нутагладаг юм гэвэл Консын нүдний цэнхэр ногоон туяа гийнгэ болж,

Турван гол нэг уулнаас эхтэй юу гэж асуулаа.

-Тиймээ. Тэр уулын нэр Бурхан халдун. Оройдоо цастай, халиун өвстэй гэж Тоорил хаан өгүүлнэ.

-Халиун өвсийг тэнгэрийн өвс гэдэг юм. Би халиун өвсний үндэс олов гэж Конс далд санаагаа илчлэв. Тоорил хаан санаа алдав. Тоорилд нутаг усны лус савдаг үзэгдэнэ.

\* \* \*

Тэмүжин хөвүүний нөж атгаж төрсөн нь мэргид, татаар хийгээд тайчуудад шаналан болжээ. Тэмүжин балчир хөвүүн байтал чулуу мэт, чулуугаар үл барам уул мэт том бодогдоно. Будаа мэт жижиг Тэмүжин хөвүүнийг Ононы бургас лугаа зайгуй ургаж зам хаахаар тесөөлнө.

Мэргидийн гурван толгойлогч духаа нийлүүлж шивнэлдэв. Татаарын Цагдуулай эмсийн дунд хов цацаж үг сонсов. Тайчуудад мэргидийн элч ирлээ. Эрэлд хатаж яваа хөдсөн дээлтэй, хөмөн гуталтай мэргид боржигоны бага хүрээнд хэд хоножээ. Эрэлчиний морь Ононы ширэг хазлан таваглаатай байв. Удахгүй өвсний сөл татрах тийшээ ханджээ. Айлууд хонгор шар дэрстэй, хуурай агаартай намаржаандаа буухаар зэхнэ. Эрэлчин ирсэн шигээ чимээгүй алга болов.

Баруун зүгийн салхи хүчтэй үлээж хононо. Цатгалан тэмээд амаа ангайж салхи сөрнө.

Боржигоны их, бага хүрээний эрчүүл ав хоморгод зэхэж, морьдоо сойж жад, сум саадгаа базаана. Салхинд сүүмэн өвсний толгой халиурсан бүрхэг өдөр Есүхэйн том гэрт халуу дүүгэж байна. Хуагчин нохойн хошууны ханд буцалгаж Есүхэй, Өүлэн хоёрт аягалж бариад

үүд сэмхэнээр сөхөж гадагш одлоо.

-Хуагчин минь уйлсаар уу гэж Есүхэйг санааны мухартаа гансралтай асуухад нь Өүлэн үжин гэрийнхээ тооно өөд харах мөртөө,

-Эмсийн нулимс хатах биш дээ хэмээн дайн самууныг буруутган хавтгайруулж хариуллаа.

Ван хааны бэлэглэсэн алтадмал сэлмийг ханын толгойноос зүүлттэй байхыг ажсан гэрийн эзэн өөрийгөө Хуагчины нөхрийн үхэлд буруутай хэмээн санаж явах тул,

-Манайд насаа элээх учиртай бус уу гэвэл Өүлэн үжин биедээ хамаатуулан,

-Намайг нутгаа санаж уйлахад цуг уйлдагсан. Хуагчинд таарах эр зөндөө. Үхсэн эрээ мартахгүй хүн өөр эрээр яах билээ. Надтай үелээд тустай юмаа хэмээн өгүүлэв.

-Та нар хаашаа одно гэхэд Есүхэй,

-Тэрэгтийн талд гөрөөлнө гэв.

-Цас орох дөхжээ гэвэл Есүхэй,

-Өнөө шөнө хялмаална хэмээн батлав.

Бууц хүрээний шургааган хашаа, голын дээгүүр шаазгай шагширч, адгуу түргэн хэлээрээ шулганалдан хэл дамжуулна. Тэр шөнө ууланд цас орж, талд хялмаа хаяв. Онон мөрний ус дөнгөж зайрмагтаад бор ятуу нөмөр бараадаж бөвтгөн дэргэх болов.

\* \* \*

Боржигоны айл хүрээний эрс нүүгэлтэн дахиж задгай тал руу будантан одсоны хойно эрэлчин дахиад иржээ. Хүрээ бууцандаа үлдсэн эрчүүл мод түлээ татаж намаржаанаас нүүх нүүдэлд бэлтгэнэ. Эрэлчин холоос биш ойроос иржээ.

Боржигон аймгийн хот айлыг эрэлчин тойроод байлаа. Тайчуудын хүрээ хаяа залгаа тул хэн буув, хэн мордов гэдгийг хүүхэд, хөгшид андахгүй мэднэ. Намаржааны хөлөөр агь нүдэлж дэрс хонгортоно. Тэнгэр гийв. Баруун зүгийн салхи үүл хөөж одоход дулаахан таатай өдөр үргэлжлэв. Өндөр дэрсэн дотор шувууны үүр янзалж байсан Тэмүжиний шорвог хөлс, тоос холилдсон халуун агаар урсаж ирэхэд өвдгөө тэвэрч суув. Зунжин ууланд тэнэсэн сарлагууд савгагаа хийсгэн боохойд хөөгдсөн мэт салхи татуулж үерийн ус шиг урслаа.

Боржигон аймгийн их хүрээ үймээнд орлоо.

-Тэмүжин хайчив хэмээн Хуагчин чарлав. Мээнэнбилэг "Тэмүжээн" хэмээн дагаж орилоно. Өүлэн үжин хөхүүл Хачиуныг тэвэрсээр их өргөөнөөс гарлаа. Тэнгэр үүлгүй атал аадар цутгаж байгаа юм шиг нижигнэж хонгор шар дэрс хар хүрэгтэн оволзож байлаа.

-Тэмүүжээн, Тэмүжээн....

Мээнэнбилэг, Хуагчин хоёр дэрс рүү гүйж байна. Дэрс галд хуйхлагдах мэт шажигнан тэр хавийн болжмор, ятуу үргэн нисчээ. Дайрлага дайрчээ. Өвөлдөө ууланд тогшин араатны эрлэг болдог сарлагийн сүргийг намаржаан руу дайрч ирнэ гэж хэн санана. Туурайтны тоос дэгдэнэ. Сайрын чулуу шажигнан бутарна.

Дэрсний шилбэ үхрийн туураинд гишгэгдэн хугарч хонгор шаргал хөндий дундуур газрын хөрсийг хагалсан муруй хар зураас гарчээ.

Оволзсон тоос, турхираан, хүчит амьсгал өнгөрчээ. Чухамдаа юу болсныг Тэмүжин хөвүүн байтугай хүрээнийхэн ойлгоогүйгээр барахгүй мэгдэн сандарчээ. Талхлагдсан газраар гүйж ирсэн Мээнэнбилэг бүсгүй Тэмүжинг харангуут тэнхээгээрээ чарлан уйлж хөвүүнийг тэвэрч авав. Хөвүүн айх, гайхах зэрэгцэн уйлж байлаа. Мээнэнбилэг, Тэмүжин хоёрын уйлах чарлалдах дуунаар задгай сайр дундуур Хуагчин гүйж ирэв. Хуагчин хар тэнхээгээр аймсан орилоно.

Тэмүжиний хажууд тасар татагдсан могойны толгой, сүүл энд тэндгүй мурилзан хөглөрч, эрчилсэн шидмэс шиг хэвтэнэ. Тэмүжин хөвүүнийг ичээндээ цугларч асан жаран зургаан могой аварсан байжээ.

Тасар татуулсан могойн дундаас Тэмүжинг холдуулж хүрээнтэй зурвас руу харахад хэн нэгэн хүний улаан хоолойд цэр тээглэх мэт хяхнан үхэж буй дуу авиа чих дэлсэнэ. Баавгайд толгойгоо тас алгадуулсан эрэлчин үхэж байв. Мэргид аймгийн эрэлчин эр, толгойлогч нарынхаа үгссэн ёсоор тайчууд дунд хуйвалдаан хийж тайчуудын дэмжлэгийг авахаар иржээ. Тайчууд эрэлчинд итгэхгүй байлаа. Тайчуудын Таргудай Хирилтуг эрэлчинг сонсож дуусаад "татаарын дайны жил төрсөн юм шүү дээ, энэ Тэмүжин! Татаарын баатар Тэмүжин үгээгийн цустай толгойг өнхөрч унаагүй байхад Есүхэй хөвүүндээ Тэмүжин нэр хайрласан билээ. Муу ёрын хөвүүн төрсөн гэж би боддог. Баруун гартаа шагайн чинээ цус нөж атгаж терлөө гэж Халзанбух зайран зар тараасан. Би бас уг мухарт нь орох санаатай асрагч авгай нараас сурагласан чинь атга нөжийг харсан, үзсэн хэнч байгаагүй юм. Цаанаасаа учиртай. Танайхны Өүлэнд дургүйцдэг түмэн зөв билээ. Гэвч Тэмүжинтэй оролдох нь толгойд аюултай" гэж оөрийн бодлоо дуулгажээ.

-Намайг туршуул гэдгийг Есүхэйд огт дуулгаж болохгүй. Есүхэй цавчиж орхино.

-Эрлээ эрээд хэд хоног байна биз. Их удахаар болбол нэг бэлэвсэн эмийн гэрт орж суугтун. Эр хүнд арга буй.

-Энгүй шар талын элгэнд толгой хоргодох айл олдохдоо олдоно. Тэмүжин хөвүүнд гурван мэргид дургүй байна. Яавал дээр бол.

-Муу аргаар оролдоод үз. Тэгэхдээ надаас холхон бай. Есүхэй баатар надад таатай бус. Сочихэл эхнэр миний дүү юм. Түүнийг хатан, татвар эмийн хороонд байлгаж байна.

-Хэрэв би хэргээ бүтээвэл таны нүдэнд үл үзэгдэнэ.

Бид уулзсан ч уулзаагүй юм шиг явъя.

Боржигон аймгийн хот хүрээгээр хэсүүчилж айл амьтнаар хоног төөрүүлж явахдаа тэрхүү эрэлчин Тэмүжинг дайрлагад өртүүлэх арга мэх сэдсээр байжээ. Хорхой идсэн баавгайг Есүхэйн бууцанд оруулбал эрэлчин санасандаа хүрэх байлаа.

Цэгцэрийн шар тал, Онон, Хэрлэн мөрний цэлгэр хөндийгөөр мэхээрийн бор оготно хөөе хурааж, газар доорхи нүхэндээ хураана. Мэхээр бол амтлаг ургамал билээ. Тэрхүү амтат ургамлыг нутаг нугынхан цагаан тосонд хольж хүнсэндээ хэрэглэсээр ирсэн аж. Эрэлчин өдөр бүрий мэхээрийн бор оготнын хеег сэндийлэн ойд аваачиж нууна. Мэхээрийн ургамлыг зөгийн бал, жимсний дармалтай хольж зуураад улаан шоргоолжны үүр дээгүүр өнхрүүлж дахин дэлгэж өнхрүүлнэ. Иймэрхүү шоргоолжтой хольсон амтат бөөрөнхийг олноор бэлтгэсэн эрэлчин нэг өдөр Тэмүжин хөвүүний очдог шувууны үүрийг мэджээ. Хот айлаас холгүйхэн голын зэгст тохойд дэрс хэнзлэн үндсээрээ ногоорч ургажээ. Тэнд шувууны үүр байх бөлгөө.

Мэхээр, зөгийн бөл, жимсний дармал, шоргоолж хольсон амтат бөөрөнхийгөө ойр, ойрхон зайтай тавьсаар эрэлчин эр Тэмүжиний очдог шувууны үүрний яг дэргэд нэгийг орхив. Тэр амттанг хорхой идсэн баавгай үмхэхдээ Тэмүжинг алгадна хэмээн мэргидийн эрэлчин тооцов. Баавгайн жим дагуу тавьсан амтат бөөрөнхийг баавгай идэж байгааг эрэлчин харав. Баавгай маргааш хорхойсно. Баавгайн ходоодонд олон шоргоолж орж ойн зэрлэг араатныг байхын аргагүй болгож гэдэс дотрыг мэрж хатгана.

Тэр үед баавгай догширч амттаныг эрэн эрчилсэн дээс шиг чавхдана. Уул өгсөхөөр зэхэж буй сарлаг сүргээрээ эрчилсэн баавгайн долгионд авгаж тал хөндий рүү буужээ. Намар цагийн гандуу өвсний дундуур бор тоос бослоо. Тэрхүү бор тоос болбоос хорхой идсэн баавгайг дагасан сарлагийн сүрэг байлаа.

Гэв гэнэт Тэмүжин хөвүүн шувууны үүрийг үзэхээр үүрний чанх дэргэд хэвтэх бөөрөнхийг барьж үзэв. Бөөрөнхийд гарын хуруу наалдана. Эргүүлж үзвэл бөөрөнхий шоргоолж байх тул Тэмүжин хөвүүн шидэж орхив. Мөнөөх бөөрөнхий нь мэргидийн туршуул суухаар зэхсэн эрэг дээр унав. Дэрс дотор ус тогтож цүнхээл үүссэн хуучин эрэг байжээ.

Хорхой идсэн баавгай сарлагийн сүрэгтэй цуг Тэмүжин хөвүүнийг гишгэж өнгөртөл эрэлчин усны хуучин эрэг дор нуугдаж хэвтэхээр зэхсэн боловч гай дайрч амттай бөөрөнхий нь түүний толгойтой зэрэгцэв. Баавгай бөөрөнхийг үмхэхдээ эрэлчиний толгойг тас алгаджээ. Эрэлчин үхлээ эрж энд ирсэнээ эс мэдэж шороон түйрэн дунд өнгөрсөн ажээ. Хорхой идсэн баавгайтай цуг сарлагийн урсгал өнгөрснөөс нэлээд хойно хуга гишгэгдсэн дэрс эргэж өндийгөөд могойн тасарсан бие залгалдаад ичээндээ оров.

\* \* \*

Сарлагийн сүрэг дунд хорхойссон баавгай хутгалдан шаргал хөндийрүү хуйларч орох үед Тэмүжин дэрсэн дотор шувууны үүрийн сөрдийсөн өвс, хялгасыг засаж байжээ. Хонгор шаргал дэрсний ёзоор бүрт могой өвөлжихөөр ичээндээ цугларч ахуй үе билээ.

Хөвүүнийг өвдгөө тэврэн нугдайн суухад түүнийг жаран зургаан могой тойрч, шивээлсэн сум мэт толгойгоо цогнойлгон гадагш харж бор цоохор хүрээ болов. Улангассан далиу эвэрт

сарлагийн бухны эврийг зайлуулахын тулд нэгэн могой нүд рүү нь хатгав. Нүдээ хатгуулсан бух буруу тийш зуларч зэрэгцэж явсан бухыг дайрч унагаад чангаар гашуудан мөөрөв. Хөвүүн лүгээ шууд дайран яваа үхрийн дух, цээж рүү могой хатган бүлэхэд тэр үхэр хойшоогоо цахдаж зогдортой хэнхдэгээ чичрүүлэн мөр буруулж дараагийн хэд хэдэн сарлаг зогтусан бултаж өнгөрөв. Могой сарлагийн туурайд хуваагдана. Сарлагийн нүд, хэнхдэг цээжинд могой толгойгоо алдана. Хэд хэдэн сарлаг үхэв.

Өндөгний үүр, Тэмүжин хөвүүн хоер жаран зургаан могойн ивээлд багтаж, хараал идсэн харанхуй дайралтаас эсэн мэнд үлджээ.

\* \* \*

Өүлэн эхийн сэтгэлд байнгын нэгэн зөн нуугдана. Анх Чилэдүгийн эхнэр болж мордоход удган эмгэн "үйл лайгаа дага даа" гэж зайдуухан шивнэж билээ. Боржигоны толгойлогчийн эхнэр болоод сэтгэл тэнүүн, эв найртай амьдарч байв. Дайн тулаан, бөөгийн дуудлага, бусдын үхэл Өүлэний нүд сэтгэлд харуусал, өршөөл, гуниг үлдээнэ. Хөвүүний эл явдал, тасар татагдсан могой, хорхойссон баавгай сарлагийн сүрэг сайныг бус мууг зөгнөж байх шиг санагдана. Эрчүүд эзгүй хойгуур ийм явдал болжээ. Эрэлчин ямар мал эрж, хаанаас явааг хэн ч үл мэдэн оньсого лугаа таагдашгүй хоцров.

Тэмүжин хөвүүний баруун гарын алгыг Өүлэн тэнийлгэв. Түүний алга цайж нарийхан зураас, хэрчлээсээр дүүрэн аж. Өүлэн хөвүүний ал гыг бараг анх удаа дэлгэж харжээ. Өмнө нь хөвүүний алгыг харахаас эмээж байжээ.

-Алив хөвүүн минь ... гээд энгэрээ ярж хөхнийхээ саамшсан сүүнээс Өүлэн эх дусаав. Хасар бас ахыгаа дуурайн алгаа дэлгэж "ээжээ милий алган дээр" гэв. Хасар алган дээрхи сүүг ховдоглон долоов. Харил Тэмүжин харсаар байлаа. Тэмүжиний алганы хээ тодрон урт зураасыг тойрсон богинохон хэрчлээс дугуйрч шувууны өндөгний хэлбэртэй юм шиг харагдахад Өүлэн эх "нөж атгаж төрсний гэрч" гэж бодов.

Тэмүжин хөвүүнийг могой аварчээ. Могой тэнгэр гаралтай амьтан. Зөөлөн хэвлийт эх могой, зөнч эр могой, сүрэглэн чуулсан могой Тэмүжинтэй таарсан бөлгөө. Өвөлжөөнд буусны дараа олон овгийн эрчүүд ав хомроогоос буцаж ирцгээв. Өвлийн гурван сард сур, нэхий элдэх, нум сум, жад, сэлэм дархлах гээд эрчүүдийн ажил өрнөнө. Хүүхнүүд, эмс охид үйл урлана.

Аваас ирсэний дараа Есүхэй баатар Цэгцэрийн шар талд өвөлжиж буй жалайрын Гүнгоо зайрантай уулзаж ирээд "Тэнгэрийн амьтан зөнтэй. Могойн зөн хөвүүнийг өмгөөлсөн нь хөвүүнд элдэв учрал тохиолдохын эхлэл байж мэднэ гэж байна. Хөвүүний тухай цуу их тархжээ" гээд Есүхэй баатар Бурхан халдунд өргөл өргөжээ.

## Долоодугаар бөлөг



*Бөртнийн эцэг Дэй Сэцэн бөгөөс цагаан татаар угсаатан болой.*

*Зовлон туулж хонгирадын язгууртан болжээ*



Тооноор сарны гэгээ тунарсан шөнө байв. Сарны эртний бөрлөн цоохор сэвх тодорчээ. Хөх тэнгэрт мандсан сарны гэгээ цагаан байх тусам түүний толбо, мэнгэ нүдэнд маш тодорхой бөлгөө. Тэмүжин хөвүүн сарны гэгээг мэдрэхийн хэрээр сарны өнгийг ажиглана. Зуны бороотой үдшийн сар үүлний сиймхийгээр шагайх нь дулаахан ногоон өнгөтэй байдаг юм. Өвлийн шөнийн сар Тэмүжинд хүйтэн санагдана. Тоонын цамхраагаар таширлах сарыг улаан, ногоон, хөх, шар, цагаан өнгөтэй байхыг Тэмүжин мэднэ.

Тэмүжин хөвүүний сэтгэлийн доторхи өнгө ямар байна, сарны өнгө тийм байх бөлгөө. Сар бол Тэмүжинд нөлөөлдөг юм. Онон мөрний усанд туссан сарыг хөвүүн яаж хөвөхийг олонтаа харжээ. Сар дугуй юм шиг, зууван юм шиг болж хэлбэр нь зүггүйтнэ. Махир сэлэм мэт хавирган сар дүүрэн дүүрсээр тэргэл болж улмаар дундран дундарсаар хавирган болно.

Тэмүжин нэг удаа морины нүдэнд сар байхыг харсан ажээ. Морины тунгалаг том нүдэнд сар

мэлтийнэ. Морь нүдээ цавчлахад сар түүний нүднээс салахгүй байсаар байлаа. Тэгэхэд Тэмүжин хөвүүн "миний нүдэнд сар байгаа" хэмээн олзуурхан бодов. Тэмүжин хөвүүн сарыг харсаар авай. Асрагч эх Мээнэнбилэг хөвүүний хучлагыг засах зуур,

-Чиний нүдэнд сар бүтэн байна гэж Тэмүжинд хэлэв.

-Мээнэнбилэг ээжээ сар уйтгартай байна уу хэмээн Тэмүжин асуув.

-Яагаад гэж асрагч эхийг дуугарахад,

-Надад тэгж санагдсан юм хэмээн Тэмүжин өгүүлэв.

Сар уйтгартай бус Тэмүжин уйтгартай байснаас энэхүү яриа өрнөв. Маргааш Тэмүжин өөр овогт очихоор одно. Эцэг, эх хоёр нь түүнд бэр гуйна гэдгийг хэлжээ. Хасар, Бэгтэр хоёр хамт байжээ. Эцэг яаран бэр гуйх болсоны шалтгааныг хөвгүүд үл мэднэ. Гагцхүү Тэмүжинд атаархаж байв. Овгийнхон бүхний түрүүнд

Тэмүжин гэнэ. Овгийнхон Тэмүжин рүү чиглэнэ. Гэгээ тунарсан цагаан шөнө Тэмүжиний нойр хулжив.

\* \* \*

Өүлэн эх бол Есүхэйтэй дэр нийлүүлсэн цагаас ямагт ахуй амьдрал, үр хүүхдээ гэсээр өнөөдөр шиг гунигийн аяс цухалзуулж үзээгүй билээ. Хөвүүнд бэр гуйна гэдэг нь эхийн сэтгэлийг хайлуулсан билээ. Энэ хөвүүн тэнгэр заяатай боловч хүний хувь тавиланг эдлэх бус уу. Сайхан төрсөн эхнэр зовлонгийн үүдийг сөхдөг хэмээх үг байдаг. Заяа тавиланг тааж тааварлахад бэрх бус уу. Хөвүүн эцэг Есүхэйн энтэй болтол боржигон овгийнхоныг гал усны гашуун зовлон дайрвал яана. Овгийн баатар эрс дайнд үхэж мэднэ, олзлогдож мэднэ.

Өүлэн эх түгшиж байлаа. Өүлэн далд түгшүүрээ нууж нулимсаа сэм арчина. Орондоо уйлах муу зөн билээ. Орондоо дуулах муу ёр билээ. Эр нөхрийнхөө гэнэтийн эрс шийдвэрийг өөрчлөх эрхгүйдээ Өүлэн эх гоморхсон юм.

-Тэмүжин есөн настай. Бэр гуйх цаг болсон бус уу хэмээн Есүхэй хүнгэнэв.

-Миний төрсөн Олхонуд аймагт хацар гоо охид торниж буй. Тэд сайн бэр болно. Хөвүүндээ олхонуд аймгаас бэр буулгахад тэнгэр таалах биз гэж Өүлэн өгүүлэв.

Боржигоны баатар юунд яаран Тэмүжин хөвүүндээ бэр гуйхаар болов. Есүхэй баатрыг ямар нэгэн юм дуудаж байв. Түүний совин зөв эсэхийг аяндаа амьдрал, цаг хугацаа батлах юм чинь. Есүхэй тааламжтайгаар,

-Тэмүжинг ургийнхандаа орхиод ирвэл ямар вэ гэв.

-Манай ургийнхан талархана. Хөвүүнийг нохойноос бүү цочуул гэж захиарай, Есүхэй минь.

-Тэгнээ. Хөвүүн өрөвчхөн зантай. Сэтгэл өгөөмөр. Юм бодож байхад нь бодлыг үргээж



болохгүй гэдгийг би захиана.

-Маргааш хүүгээ мордоход алган дээр нь сүү дусаана. Сүүний үнэртэй яваг.

-Халзанбух бөөгийн захиасыг санана уу.

-Би төрүүлсэн юм хойно... Та бүтээсэн юм хойно бололгүй дээ. Өөр бусдад алгаа бүү харуулаг, Есүхэй минь. Эхийн хөхний сүү хөвүүний минь зам мөрийг мялааж аз тохиох болно.

Есүхэй баатрын их өргөөнд Тэмүжиний тухай яриа өрнөсөөр үүр цайхад зуны дунд сарын арван тавны тэргэл саран хээр хоносон байлаа.

Таван зууны тэртээ Бөртэ чонын хөх сүрэг морины шандас цуцаан давхиж өнгөрсөн Цэгцэрийн шар талаар Есүхэй баатар хөвүүний хамт давхиж яваад морин жимийг орхиж гурван чандмана хүрээний зүг эргэлээ. Гурван чандмана гэр дундаа их өргөөтэй Цэгцэрийн шар талд лууны ургамал, гүндбалын ургамал хос могой судсаа дэлгэжээ. Морьдын туурайд хэгц гишгэгдэж тэнд нь өвс ногоо дэлгэрнэ. Үе үеэрээ залгалдах ургамлын үндэс хот айлын зэл хүрч Хэрлэнгийн цаад дэнжийг бүрхэн ерхөгт тал хээрээр ургана. Хот айлын хаяагаар урсах голын хөвөөнд бодон өвс бандайна. Бодон өвс бол зууван навчтай, навчис нь налмайтал доош унжиж байдаг бодон гахайн чинээ ногоон бут юм.

Ялангуяа шөнийн цагт сүрэг бодон хэвтэж байгаа юм шиг үзэгдэнэ. Өдрийн цагт ногоон бутнууд хадаж овоолсон өвс мэт харагдана. Урагшлах тусам бодонгийн бут ихсэж газрын хөрс элсэрхэг болж тэмээн сүрэг таанын толгой шүүрнэ. Цэгцэрийн шар талын дорно хаяанд гурван чандмана бүгд есөн гэрийн дунд том өргөө дүнхийнэ.

Гэрүүдийн нэгнээс товшуурын аялгуу ингэний буйлаан мэт гунганан урсана.

Морьдын уяан дээр Есүхэй, Тэмүжин нар бараа бологсдын хамт ирэхэд ноход боргож байна. Ноход боргоход их өргөөний эсгий үүд сөхөгдөн сүү саалийн бүсгүйг гарч ирэхэд ноход сүүлээ хавчин шогшив. Бүсгүй хүндэтгэл илэрхийлж үүдээ сөхөхөд Есүхэй баатар хөвүүний хамт орлоо. Гэрийн эзэн гоёмсог торгон хантааз, булгаарин гуталтай, махлаг намхан эр найрсагаар бөхийснөө,

-Та тань боржигоны хаан Есүхэй баатар шив дээ. Өртөө хол тосох байтал өргөөндөө налайж монголоо алдлаа. Та саатан морил! хэмээн өгүүлэв. Дэй Сэцэний хүндэтгэлд сэтгэл ханасан Есүхэй баатар,

-Танайхан өвсний сор, усны тунгалагийг шилэн нүүдэллэж явна уу. Цагаан татаарын нутаг яасан уужим юм бэ гэхэд Дэй Сэцэн баясан хөөрсөнөө мэдэгдэхгүйг хичээн инэммсэглээд нарийн урлал бүхий ширмэл олбог дээр Есүхэй баатрыг урьж суулгав. Дэй Сэцэн хэрэг зоригийг асууж лавлаад "миний өчүүхэн гэрт саатаж, морь малаа амрааж тухла" гэлээ.

Дэй Сэцэн бол монголын цагаан татаар угсаатан болой. Татаарууд зөвхөн монголын өндөрлөг, хээр тал нутагт төдийгүй тархан нүүдэллэж зарим нь цус холилдон хэл, зүс ондоо болжээ.

Татаарыг дотор нь цагаан, хар, ягаан, шар хэмээн хуваах аж. Ягаан татаарууд Хатан голын хөндийд нутаглана. Хайлаар мөрнийг сэлбэн урсдаг Хатан голын хөндий үржил шимтэй тул тариа ногоо тарьж арвин ургац авдгийг юм үзэж нүд тайлсан Дэй Сэцэн сайн мэдэх юм. Тэр нутагт Дэй Сэцэн амьдарч үзжээ.

Шар татаар бол цэнхэр нүдтэй, монхор хамартай нүүдэлчид бөгөөд гурван зууны тэртээ монгол нутгаас нүүж Марал тэнгис хэмээх их усны хөвөө барааджээ. Шар татаар хэл өмнөө болж, балгад барьж суурьшаад ваар сав, дарханы урлал хийдгийг Монхормэндийг дагаж явахдаа Дэй Сэцэн үзсэн бөлгөө.

Харин монголын татаарууд биенээ хар, цагаан хэмээн нэрлэх боловч дөрвөн цагийн эргэлтэд нутаг сэлгэн буурь сольж нүүдэллэнэ. Тэр цагаан татаарын нэгэн толгойлогч нь Дэй Сэцэн хэмээх унаж, босож үзсэн явгууртан хүмүүн бөлгөө. Дэй Сэцэний нутаг ус Алтан улстай залгаа болохоор нанхиад, тангад, зүрчид иргэн хэд гурваараа доншуучлан тэнэж, гар урлалын хийц сайтай эд агуурс худалдаалахын зэрэгцээ нөмөр нөөлөг хонхорт шавар оромж барьж үлдээх явдал буй. Ойролцоох нүдэн нуурын хөвөөнд шавар оромж босгосон нь салхинд мөлийж, борооны усанд идэгдэж, хулгана зурам нүхэлж сийчжээ. Доншуур наймаачид үүнийг үл тоож хэд хоногоор саатаж өнгөрөх бөлгөө.

Дэй Сэцэний их өргөөний том ширдэг дээр Есүхэй баатар хуучилж сууна. Тэдний өмнө махир хөлтэй намхан ширээ тавьжээ. Ширээн дээр өнгөлсөн шавар вааран сав, суулга, зэс домбо, сүлжмэл таваг тавьж, өмнөд газрын хатаамал хар чавга, шар чангаанз тэргүүтэн жимс, ааруул өрөм, цецгий, сүү мэтийг гийчнийг хүндэтгэн өржээ. Есүхэй нэг гартаа мах барьж нарийн хийцтэй хутгаар зүсэж иднэ. Заримдаа огтолсон махаа гулууз чулуун давсаар арчиж үмхэнэ. Тэрбээр тун тавтай сайхан хооллож байв. Дэй Сэцэн ясыг сайтар мөлжих ажгуу. Тэд хэзээний танил тул дотно яриа хөврүүлсээр жин үдийн халуун өнгөрч, Хэрлэнгийн зүгээс ногооны үнэртэй салхи салхилахыг сая мэдэв. Товшуур ингэний буйлаан лугаа тавьж татаж уянгална.

Нэгэн чандмана гэрийн зүүн гэрээс паржигнатал хөхрөлдөх, эвшээх мэтээр цатгалан эрс шуугилдах сонсоно. Есүхэй, баатрын дагуулууд хооллож байлаа. Дэй Сэцэн цулцгар хацраа илж уруулаа тамшаан инээмсэглээд,

-Урьд шөнө би цагаан шонхор шувуу, нар сар хоёрыг атгаж ирэв гэж зүүдэлсэн билээ. Учрал ерөөлтэй байж дээ. Таны хөвүүн нүүрэндээ буянтай, нүдэндээ гэрэлтэй юм. Миний сэтгэлд ихэд таалагдлаа гэхэд Есүхэй толгой дохив. Есүхэй баатрын нүд жартайсан байлаа.

-Танай охин нүдэндээ цогтой юм. Хацар гоо, гавшгай тул надад бас таалагдав.

-Олон удаа гуйлгаж өгвөл эрхэмлэгдэх гэдэг. Манай Хонгирадууд тал нутаг шигээ тэнүүн сэтгэлтэй билээ. Бид нар дайн байлдааны сургууль хийдгээс бус бусад овог аймаг руу довтолдоггүй билээ. Малаа маллаад, хацар сайт охидоо сайн бэр болгохоор өсгөн байдаг. Би Есүхэй баатар танд шулуухан хэлье. Олхонуд иргэн рүү явах хэрэг байна уу. Миний охин арван настай. Нэр нь Бөртэ...

-Бөртэ, Бөртэ....

Есүхэй баатар сайхан хар үсээ илж хөхөлбөр царай нь гэрэлтэв. Түүний шанааны булчин зангирч гүрэлзэв. Догдолсон үедээ шүдээ зуудаг зантай хүн байлаа.

-Хонгирадын толгойлогч таны сайхан сэтгэлээс сүү үнэртэж байна. Тэмүжин хөвүүн өдгөө есөн настай, нохойноос баахан цочимтгой билээ. Би бодол, санаагаа хэлье.

Бөртэ охинд өндгөн сүй тавья. Хүлэг морио танай адуун сүрэгт нийлүүлье.

Дэй Сэцэн олбог дээрээ хоёр өвдгөө алгадаад авав. Дэй Сэцэн бахархсан байлаа.

-Хөвүүнээ манайд үлдээхгүйн. Таны хөвүүн одоо миний хөвүүн болог. Дараа хоёуланг аваарай. Хоорондоо дасч байг. Би ингэж бодно.

-Танай тайван аймагт миний хөвүүн жаргалтай байх биз. Замаас гарч танай руу эргэсэн тэнгэрийн таалал байжээ. Тэнгэр дандаа таалах юм.

-Тэнгэрийн таалал эхлээд Хонгирадад ирсэн юм. Би өглөөнөөс зүүдээ тайлах гэж ядсан. Та тайлж өгөв. Эрхэм худ тэрлэг дээлээ хөнгөл. Цотон хатанг ирэхээр найрлая.

Дэй Сэцэний үг нялуун бус санаа сэтгэлд нийцтэй тул Есүхэй баатар сэлмээ ханын толгойд өлгөж тухлав.

-Товшуур хэн бүүвэйлнэ гэж Есүхэй баатар сонирхов.

-Жадараны Жамуха хөвүүн манай энд цэргийн сургууль хийж буй. Тэр хөвүүн товшуур бүүвэйлэв гэж хонгирадын толгойлогч егүүлээд хөвүүнийг дуудуулав. Тээр жил Ван Тоорилын хүрээнд үргэлж инээмсэглэж явдаг Жамухыг харсанаа Есүхэй сайн санана. Жамуха инээмтгий, том толгойтой шохоорхсон харцтай нэгэн болжээ. Юу юунаас илүү цэргийн эрдэм гэдэг үт Есүхэйд содон сонсогдов. Дэй Сэцэний их өргөөний үүдэнд Тэмүжин, Бөртэ, Жамуха гурав баяр хөөртэй зогсоно.

-Жамуха хөвүүн товшуур аялгуулахдаа гарамгай. Бас сэлэм, жадаар цавчих, хатгах овсгоотой гэж архинд халамцаж улаа бутарсан Дэй Сэцэн онцгойлон магтав. Жамухын зүс царай өөрчлөгдсөнч инээмтгий зангаа орхиогүй байв. Тэд хоорондоо танилцаж, баясаж хөөрчээ. Боржигоны хаан Тэмүжин хөвүүнээ харваж гамнахдаа сүрхий болохыг үл өгүүлж "өөрөөсөө илүү чадалтай, илүү овсгоотой хүнийг дийлж сурвал дийлдэшгүй болохын эхлэл мөн" хэмээн хонгирадын толгойлогчийн толигор улаан нүүрийг харж байхдаа сэтгэв. Хонгирадын толгойлогч Дэй Сэцэн боржигоны баатарт хандаж,

-Таны сэтэрт хурдан хүлэг манай адуун сүрэгт чимэг болж яваг. Энэ баярт өдрийг би удаан хүлээлээ. Оройдоо найр хавтгайрна. Жамуха хөвүүн товшуураа бүүвэйлж боржигоны баатар эрсийг уяраагаарай. Шон хатгаж суран хэц татаж, ухрах, тулалдах, бултах газрыг хэмжээтэй болгосон хашаа баруун чандмана гэрийн дунд буй. Есүхэй баатар та сонирхож үзээрэй. Цэргийнхээ гар, хөлийн шөрмөсийг тэнийлгэж сэтгэл санааны бяд суулгахыг би чухалд боддог гэж өгүүлэв.

-Нээрэн хүний зориг ходоодондоо бус толгойдоо оршдог шүү гээд Есүхэй инээв.

-Тэмүжин хөвүүнээ би сэтгэлийн тэнхээтэй болгоно хэмээн Дэй Сэцэн шимтэв.

-Зөв гэж Есүхэй дэмжив.

-Та эргэлзэх юун. Бусад аймгийн довтолгооноос хамгаалах цэрэг эрс хэрэгтэй бус уу. Тэмүжин хөвүүн бас цавчих, тэмцэх ухаан заалгана гэж Дэй Сэцэн шимтэнгүй хэлэв. Есүхэй баатар таалж,

-Хөвгүүд сайхан нөхөрлө. Алив Бөртэ...Бэр минь ир дээ гээд наргиа хоолойгоор инээв. Жамуха Бөртэ рүү гайхан харсанаа гэрээс гарч гүйв. Бөртэ Есүхэй баатарт ойртлоо. Түүний адууных шиг тэгш том шүд, мөнхордуу хамар, өргөн шанаа, бядлаг гар охиныг тосч авлаа. Бөртэд энэ учрал сонин сайхан байлаа.

Дараа нь есүхэй баатар хөвүүндээ хандаж,

-Жамухатай тангарагт андууд болоорой хэмээн Тэмүжин лүгээ захив.

-Тэгье, хаан эцэг минь гэж Тэмүжин өгүүлэв.

\* \* \*

Зүүн гэрээс товшуурын аялгуу дуурсаж хээр талын өвсний дээгүүр бидэртэх салхины чимээ мэт сэтгэлийн гүнрүү урсана.

Хонхот тэргээр

Бэргэд ирж

Хонгор охидод

Сүй тавив.

Чингэлэгт тэргээр

Дарс ачаалж

Шинэхэн бэрийн Найр хийв.

Жамухын товшуурын аялгуут бүүвэйд гунигласан бачимдуу аяс илэрхий ажээ. Тэрбээр товшуураа өөрийн сурсанаар зүүн, баруун талдаа гарган, заримдаа дээшээ шидэж эргэлдүүлэн тоглож тайтгарахыг хичээж буй нь илт байлаа. Жамухын ганцаардал, гэнэтийн учрал Цэгцэрийн шар талыг доргионо. Цэгцэрийн талд өндгөн сүйний найр болж байлаа.

\* \* \*

Жамухыг товшуураа бүүвэйлж дуулж байхад Тэмүжин, Бөртэтэй Цэгцэрийн талын зах хязгааргүй алс тийш харж зогсоно. Цэгцэрийн шар талын хаяа Тэргэтийн талтай залгаж улмаар Малах, Бумбатын тал руу уусан алдардаг байлаа. Хотны ноход саглагар сүүлээ гозолзуулан дотносохоор дөхөн ирэх үед Бөртэ "хөвүүнийг нохойноос бүү цочуул" хэмээн Есүхэй баатар Дэй Сэцэн эцэгт нь захисныг санагалзан "жов, жов" гэж хөөв.

-Намайг нохойноос цочно гэж бодов уу. Харин би нохойг өрөвддөг. Нохой заримдаа хүн шиг санагддаг. Нохойгүй хот айлууд яах юм бэ. Нохой бол хүний нөхөр бус уу.

-Чи өрөвчхөн юм

-Нохой бол үнэрч, соргог амьтан хүний төлөө амиа тавьдаг амьтан шүү.

-Нохой чинь зөвхөн хүнээс эмээнэ. Тэгээд хүн рүү дотносохоор ирдэг. Нохой танихгүй хүн рүү хуцдаг. Адуу, үхэр, тэмээ хараад нохой хуцаж байхыг чи үзсэн үү. Хүн явбал боргооно.

-Нохой шиг хүний санааг мэддэг араатан үгүй

-Надад бас тэгж санагдцаг. Араатны яваа газрыг шиншилж мэдээд бараагий нь хараагүй мөртөө хуцаад байдаг юм. Араатны санааг мэдэж байгаа нь тэр.

Тэмүжин, Бөртэ хоёр их талын дунд хоёулахнаа юм шиг зогсож байхад Жамухын товшуурын аялгуу нэг тасарч, нэг гансарч ажгуу. Тэмүжиний өсгий дорхи лууны ургамал, Бөртийн өлмий дорхи гүндбалын ургамалтай залгалдаж байв.

\* \* \*

Үргэлжилсэн хөх ногоон тал. Тэмээ хөллөсөн мухлаг тэрэг бараа бологсдын хамт одож байна. Тэдний түрүүнд одтой хар морьтон яваа нь Есүхэй баатар бөлгөө. Талын хаяаны цэнхэр гүвээ дээгүүр Есүхэй баатар гүндбалын ургамалын үндсийг чичирхийтэл дэргүүлэн одоход хөвүүн Тэмүжиний сэтгэл зүрх түгших шиг болов. Тэмүжин Бөртэ хоёр Цэгцэрийн талд үлдэв.

Дэй Сэцэн цэргийн эрдэм суралцаж буй хөвгүүд дээр очихоор явлаа. Хээр талын хаяа нэлийн цэнхэртэж, бодон өвс нуурын хөвөөнд бандайна.

\* \* \*

Чандмана гурван гэрийн дунд цавчих, тэмцэх дадлага хийхэд Хэрлэнгийн урсгал шуугина. Хэрлэн мөрөн алсуур урсдаг юм. Цэгцэрийн уужим тал дундуур урсдаг Хэрлэн мөрөн монгол овогтоныг умдаалдаг, мал сүргийг ижилсүүлдэг билээ. Жин үд өнгөрч нарны илч саарах үед Хэрлэнгийн боргио тодхон сонсогддог бөлгөө.

-Тал нутаг цэлгэр юм. Дулаахан саруул юм гэж Тэмүжинг эцэгээ явсанаас хойш анх удаа ер бусын догдолсон янзаар өгүүлэхэд Дэй Сэцэн цулцгар зузаан хацартаа хонхорхой үүстэл таашааж "тал хээр нутагт дасна гэдэг бол Бөртэ охинд дасна гэсэн үг. Есүхэй баатрын хөвүүн дотогшоо хүн болно" хэмээн талархалтайяа хөхрөв. Дэй Сэцэн бага залуугаас зовлон

жаргалыг мэдэрсэн учраас дотор санаанд итгэлтэй бүлгээ. Өөрийгөө ухааж нягталдаг занд Дэй Сэцэн дуртай юм. Тэмүжин хөвүүний араншин хонгирадын толгойлогчид таалагджээ.

-Жамуха та хоёр хэрэйдийн Ван хааны хүрээнд тоглодог байсан гэв үү. Есүхэй баатар архи ууж суухдаа дурссан юм. Одоог бодвол балчир байж дээ хэмээн Дэй Сэцэнийг сонирхоход Тэмүжин,

-Цэнхэр нүдтэй харь хүнээр хичээл заалгасан. Би яаж мартана. Намайг алгаа харуул гэхэд дургүйцсэн гэж ний нуугүй хэлэв.

-Тэр цэнхэр нүдэт хүүхдийн алгыг харж яахнав хэмээн Дэй Сэцэн дургүйцсэн янз илэрхийлэхэд Тэмүжин хөвүүн "мэдэхгүй" гэж мэдэхгүйгээ хэлжээ. "Алгаа хүнд бүү харуул" гэж эртний мэргэдийн үг байдаг юм. Нээрэн Тэмүжин хөвүүнийг неж атгаж төрсөн гэдэг байхаа. Одоо саналаа. Даанч нэг мартагнаад байсан юм. Нөж атгаж төрсөн нь үнэн ч биз, худал ч биз, Есүхэй баатраас түүнийг асуудаг байж. Есүхэй хөвүүндээ амь билээ... гэж Дэй Сэцэн тэрхэн зуур санагалзав. Дэй Сэцэн, Тэмүжин хоёул үеийн юм шиг хөөрөлдөнө.

-Татаар иргэдийг мэдэх үү гэж Дэй Сэцэн асуухад Тэмүжин хөвүүн,

-Амбагай өвөг хааныг Алтан улсад хуурч хүргэсэн ялтай татаар иргэд хожим гэсгээл амсана гэж хэвнэг өгүүлэв. Дэй Сэцэн хөвүүний яриаг өлгөн авч,

-Манай монгол овог аймгууд хоорондоо дайтаж Алтан улсад өөш болдог гэж санаа алдан өгүүлэв. Тэмүжин нялх наснаас Амбагай хааны домгийг сонссон тул Алтан улсад өш зангидах сэтгэл түүний тархинд үүссэн байж,

-Хоорондоо байлдаад байвал монголчуудын хүч мохох бус уу гэхэд Тэмүжиний үгэнд урамшсан Дэй Сэцэн "боржигоны хааны хөвүүн мөн дөө" гэж бодоод,

-Ядахдаа отог, овогоо сайн хамгаалах хэрэгтэй гэв. Эцгийнхээ араас ширтэж байсан Тэмүжин эцэг одсон цаг мөчөөс эхлээд бие даасан эр хүн болон хувирч байв. Дэй Сэцэн модон сэлэм атгаж ирсэн Жамухад "Тэмүжин анддаа нэгийг авчир" гэж тушаав.

-Чамтай зэвсгийн эрдмээ соримоор байна гэхэд Тэмүжин Жамухын үгнээс ялигүй зүрхшээн,

-За яахав, үзэлцэе гэлээ.

-Хулчийхгүй биз.

Тэмүжиний зүрх оволзов.

Жамуха цавчих, тэмцэх эрдэмд зүгширсэн учраас Тэмүжингийн шарыг хөдөлгөн зүггүйтжээ. Хэвлүүхэн

зантай Бөртэ харж зогсоно. Боржигоны хааны хүүг Бөртэ шимтэн ширтэнэ. Жамухын цухал хөдлөвч Тэмүжинд үл мэдэгдэнэ. Харин Тэмүжинг цухалдуулахыг хүсч байв.

Тэмүжин эхлээд гэнэ алдаж зөвхөн сэлэмтэй тулалдахыг хичээв. Сэлэмний аясаар хоёр тийш үсчин нэгэнтээ гэнэдэж газарт ойчив. Бөртэ эцгийнхээ гараас атгажээ. Жамуха гарын аясаар Тэмүжинг хөдөлгөж, хий гарвал түүнийг унагаж өөртөө эрдэж хөөрчээ. Эл байдлыг харж байсан Дэй Сэцэн,

-Тэмүжээн хүнтэй тулалдаж байгаагаа бүү март гэж сануулав.

-Сэлэм бол сэлэм. Хүнээ хар, тулалдаж байгаа хүнийхээ нүдийг хар гэж Дэй Сэцэн зөвлөнө. Хонгирадын толгойлогч мэгдэнэ.

Тэмүжиний хөлс гарч нүүр улайжээ. Жамухын сэлэмийг хэдэнтээ хааж хөлийнхөө тэнцвэрийг олсон Тэмүжин унахаа болив. Жамухын хөдлөх хамгаалах арга барил Тэмүжинд шилжив. Хүүгийн овсгоог мэдсэн Дэй Сэцэн,

-Нүдээ бүү цавч гэж Тэмүжинд сануулга өгөв. Дэй Сэцэний сэтгэлд Тэмүжин хөвүүн нийцжээ. Барагтайд хөөрч догдолдоггүй хонгирадын толгойлогч Бөртэд өндгөн сүй тавьсанаас хойш ер бусын баясгалантай болжээ.

\* \* \*

Цэгцэрийн тал бол адуу, тэмээ, гөрөөсний орон билээ. Талын наран адуу, тэмээний шилбэнээс хөөрч жин үдийн алдад толгой дээр зоогдсон мэт баясгалант туяагаараа гийгүүлж өвс ногоог гандаах ажаам. Хонь мал бэлчээртээ гарч ногооны сорыг амталж ханаад халуунд нозоорон сүүдэртээ хорж зогсоно.

Өглөө эрт Дэй Сэцэн гардан тулаан зааж, хүүхдүүдийг өрөм, ааруулаар цайлж амсхийсний хойно нум сум харван сургуулилж байна. Нар хэвийхэд хүүхдүүдийн сүүдэр урт болов. Сүүдрээ харж тулалдаж тоглох хүүхдүүдэд бахтай байлаа.

Талын нар талдаа жаргаж байна. Тал дээгүүр өвч шаргал туяа татаж сөдийн бор буурцаг, хялганын цагаан шаргал иштэй намилзан гогцоорч шингэж буй нарны сүүлчийн гэрлийг чимэглэнэ.

Хоньд хотолсон хойно задгай гал өрдөж хоол чанаж байна. Хоточ ноход галд ойртон нэгнээ долоож эрхлэх боловч хааяа чулуудсан яс булаалдаж хэмхэлдэнэ. Дэй Сэцэн нохойд итгэдэг байв. Нохойн нүд, чих, хамар нийлэхээрээ хүнд тус болно доо гэж Дэй Сэцэн хэлээд хөх ноолууртай хөх нохойг зааж,

-Манай Хөхгарди мундаг нохой. Гөлөгнөөсөө хонь хариулж, араатнаас сүргээ хамгаалах аргад гаргууд болсон юм. Түүнд нэг ч араатан халдаж үл чадна гэлээ.

-Араатан амьтан хэмээн Тэмүжин санамсаргүй дуугарав.

-Араатнаас илүү хүн араатан бөлгөө гэж Дэй Сэцэн эртний үеийн сургаал үгийг хэлэхэд Цотон хатан хүүхдүүдээс түрүүлж толгой дохив. "Хүмүүс гэдэг тийм л юм" гэж Дэй Сэцэн өөртөө зөвшөөрөв. Мянга мянган жил талын нүүдэлчид нохойтой нөхөрлөж, идэш уушныхаа

илүүдэл, ан авын сэг зэмээр тэднийг хооллож иржээ. Хөх хүннүгийн үед нохойгоор хэл мэдээ хүргэдэг байв. Нохой цагийн уртад хүний үнэнч нөхөр байсаар шалгарч үлдсэнийг Дэй Сэцэн гадарлана. Тиймээс нохойдоо "Хөхгарди" хэмээх содон нэр хайрласан буй за. Хөхгарди өтөлж хөх зогдор нь хөглөрч хэвтрээсээ өндийх дургүй болсоор уджээ. Хөх гардийн үр төл олширч малаа дагана.

Товшуурын аялгуу урсаж Жамуха хөвүүн дуулж байна.

Цаад ууланд

Чоно улив

Наад ууланд

Навч дэлгэрэв.

Хөх хонготой

Хөвүүн төрөв

Хиан овогтоны

Наран мандав.

Дэй Сэцэн аягатай цайгаа хүч сэлбэх мэт сорон ууж, таатайяа чагнана. Тэмүжин эцэг Есүхэйг буцсан цагаас өөр болжээ. Эцэг хүүгээ үлдээхдээ "эр хүний нулимс харам шүү. Эмсийн нулимс ил байдаг. Эжийгээ санавал тэнгэрийн хаяа ширтэж бай. Уултай газар бол уулын орой ширтдэг юм" захижээ. Хөвүүн алсын бараа харж уужрах тухайд төсөөлөл багатай боловч Есүхэй баатрыг нутгийн зүг одсон хойно Тэмүжин эргэн тойрныхоо хүмүүсийн яриаг маш соргог өөрөөр мэдрэх болжээ. Тэмүжин хүүхэд насаа эрт гэв.

Дэй Сэцэн цайгаа удаан сорж уув. Дараа нь аягаа Тэмүжин хөвүүнд харуулав.

-Энэ бол чиний элэнц өвөг Амбагай хааны аяга байгаа юм. Татаар аймаг Амбагай хааныг Алтан улсад хуурч аваачихад хаантаны авч явсан аяга. Энэ аягыг би олж авсан юм. Есүхэй баатарт энэ тухай хуучлахад их талархаж бэлэгшээсэн шүү. Бөртнийн инжинд танайд очно гэж Дэй Сэцэн нухацтай дотночлон хэлж байв.

Тэгэхэд Жамуха тэдний хажууд яриа чагнана. Дэй Сэцэн инээмсэглээд,

-Өө Жамуха хөвүүн...Тэмүжин та хоёрын хэн түрүүлж боссон нь энэ аягаар цэгээ ууж бай гэв. Жамуха тээнэгэлзэн,

-Хүний аягаар... хэмээн дуу алдав.

-Монголын хааны аяга бус уу. Дээшээ харсан сав бус уу гэж Дэй Сэцэн өгүүлэв.



-Тэгье. Тэмүжин бид хоёр хэн нь эрт босохоо үзье. Хэн нь олон удаа нар мандахыг харна, тэр нь аяганы эзэн болно шүү гэж Жамухыг хэлэхэд Дэй Сэцэн, Тэмүжин хоёр нэгнээ харж Жамухын өөнтөгчийг мэдсэн билээ. Жамуха зальхай инээмсэглэнэ.

Үүр тэмдгэрч тал дээгүүр цагаан гэгээ татаж он жилийн борог өвс халиурч байна. Тал дүүрэн адуу бэлчинэ. Чандманлан буусан гэрүүдийн хаяаг сөхжээ.

Тэмүжин сэрээд, бөх нойронд дарагдсан Жамуха өөд харсанаа босч үүдрүү явав. Тэмүжиний гарт Амбагай хааны аяга байлаа. Тэмүжин цэгээ залгилж цэгээ нь түүний хүзүүгээр урсан сэрүү татна. Цэгээ залгилж ханаад тэрбээр аягаа шимтэн үзнэ. Модон аяганы хээ тодорч амсараараа мөлийсөн харагдана. "Би Жамухаас хүчтэй болно" гэж Тэмүжин ихэд баяртай байв. Гэнэт түүний нүүрэнд түгшүүр илэрчээ.

Тэмүжиний өмнө түүний өндгөн сүйт бяцхан Бөртэ махлаг хөөрхөн царайдаа айдастай зогсоно. Бөртийн тунгалаг хүрэн нүдэнд нулимс хуржээ. Тэрхүү мэлтийтэл хурсан нулимс "аав чинь" гэсэн ганцхан үгний дараа гялтганан уналаа. Тэрбээр нулимсаа барьж эс чадав. Тэмүжиний царай тэрхэн агшинд хувирлаа. Эцэг буцаад удаагүй тул хөвүүнээ ийм богинохон хугацаанд санасан гэж үү. Тал, тэнгэр хоёр уусан нийлсэн цэнхэр хаяа руу Есүхэй баатар дагуулуудын хамт шингэн одсон зураг тодорхой хэвээр байлаа. Тэдний гайхалтай дүрс Тэмүжиний нүдэнд харагдана. Тэмүжин хөвүүн эцэгээ Цэгцэрийн талыг зүсч одсоны дараахан хүүхэд зан, хүүхэд насаа гээсэн билээ. Урьд хожид ойр байж үзээгүй татаар иргэдийн тухай санажээ. Есүхэй баатар хүүдээ "түрэг иргэд монгол нутгаас нүүж одсон. Тэднүүс нүүхдээ хөшөө чулуугаа монгол газарт үлдээж дээр нь "баатар хөвгүүдээ нанхиадын боол, ариун охидоо нанхиадын дэвсгэр болгож бузарлуулахгүй хэмээн нүүв гэж тамга үсгээр дармалдан сийлжээ" хэмээн хүн чулууны дэргэдүүр өнгөрөхдөө ярьсансан. Тэмүжин ааваасаа,

-Татаар иргэд бас нүүх үү гэж асуув. Татаарын зуслан харагдана.

Татаарын зуслангаас чөрхөлсөн үхэр тэрэгтэй нэгэн эхнэр хонины унгас ачаалаад Хэрлэнгийн хөндий рүү одохуйд Тэмүжин эцгийн хамт гүйцэж очжээ. Татаар эхнэр Есүхэй баатрыг хөвүүний хамт нүдээ унагах шахам шохоорхон харсанаа харц буруулав. Тэр эхнэрийн нүдэнд хөх дөл сүүмэлзэнэ. Татаар эхнэр ард үлдэв.

Есүхэй баатар хөвүүний асуусныг санаж яваа тул, -Нүүнэ. Татаар бол монгол аймаг. Дөрвөн зүгт монголчууд нүүнэ хэмээн нүүдэл төгсгөлгүй болохыг сануулсан юмсанж.

Тэмүжиний бодлыг Бөртэ үргээв. Бөртэ охин Тэмүжинг явна гэхээс улам хоргодно. Бөртийн нүднээс нулимс дусав. Нулимсны дусалд Тэмүжиний нэг нүд, тал хацар, өрөөсөн гар эргэлдэв. Бөртэ, Тэмүжиний гарыг атгаж,

-Аав тань хөвүүнээ санаад байх тул ир гэж хэлүүлжээ гэв. Бөртэ сул нулимстай аж. Тэмүжин яахаа мэдэхгүй чингэлэг тэрэгний дугуйг налан Дэй Сэцэн өөд ширтэхэд,

-Худ хөвүүнээ санажээ. Одоохон явуулья. Богц ганзгалааг тох. Газар товчлох аваас түргэн хүрнэ. Удалгүй Бөртэдээ эргээд ир, хөвүүн минь гэж тайван өгүүлэв. Урт чингэлэгийн дэргэд

Жамуха, Тэмүжинг буцах болсонд гунихарсан аялгаар,

-Энэ шагайг андын бэлгэдэл болгож ав. Шившлэгтэй шагай аз авчирдаг юм гээд сарвайхад Тэмүжин тосч авав.

-Би Жамухатай анд болов. Миний шагай чамд байг. Аав маань тугалга суулгасан болохоор биднийг холбох болно гээд Жамухад шагайгаа өгөв. Дэй Сэцэн хөвгүүдийн нөхөрлөлийг баталж "Үнэнч андууд яваарай" гэж шивнэлээ.

Дэй Сэцэний зузаан махлаг царайд эргэлзээ төржээ. Тэмүжин хөвүүн эцэгтэйгээ хэд хоноод эргэж ирнэ гэж үү. Боржигоны элч надаас юу нууна вэ. Боржигоны хаан шийдвэрээ амархан өөрчлөх хүн биш дээ. Бөртэ, Тэмүжинд яасан их дасна вэ. Тэмүжинг мориндоо мордоход Бөртэ уйлж дөрөөнөөс шүүрэв. Дэй Сэцэн охиноо биедээ наалдуулан тэврэв. Бөртэ охины тунгалаг нулимс Тэмүжиний дөрөөнд гялталзан дуссан байлаа. Бөртэ охин Тэмүжинг мэгшүүлэн уйлж үдэв.

## Наймдугаар бөлөг



*Тэмүжин хөвүүнийг хорхой идсэн баавгай, улайрсан сарлагийн дайралтаас*

*жаран зургаан могой хэрэм болон хамгаалж аварсан түүхтэй билээ*

Бөртэ охины нулимстайгаа бөртиж хоцорсон Цэгцэрийн тал хөхөрнөм. Зээрийн сүрэг цахилах үзэгдэнэ. Татаарын хот айл зам дагуу нутаглаж байна. Татаарын баатар Тэмүжин үгээгийн толгойг тулманд уутлан авч одсон тэр эм Есүхэй баатрыг хөвүүнээ дагуулан олхонуд иргэний нутгийг зорих зам зуур таарсан юмсанж.

Татаар эмийн шунамхай харцанд хөх дөл сүүмэлзэж буруу харсаар үхэр тэргээ гуядана. "Боржигоны Есүхэй биеэрээ мөн. Хөвүүнээ дагуулжээ. Нөгөөх Тэмүжин нэрт хөвүүн том болж. Гартаа нөж атгаж төрсөн юм гэнэ лээ. Хаа хүрч яваа бол. Бодвол хөвүүндээ бэр гуйхаар яваа бус уу. Бэр гуйдаг насанд хүрчээ. Цаг нь ч бас мөн" татаар эм ийнхүү тархиа гашилгав. Хэрлэнгийн хөвөө ойртож татаарын хот айлд татаар эм очив.

-Есүхэй явж байна.

-Хаана тэр билээ.

-Цэгцэрийн талд....

-Хэнтэй явна гэж...

-Нөгөөх цуут Тэмүжин хөвүүнтэйгээ. Хөвүүн өсчээ. Цөөн дагуултай юм.

-Буцахдаа манай нутгаар дайрах бус уу

-Татаарын баатрын нэрийг хөвүүндээ зээлдэж өгсөн. Тэр хэрцгий баатрын нэр хөвүүнд муу ёр авчрах байтал өдий болтол төвшин явах юм.

-Есүхэйг буцахаас өмнө арга бодож олоё.

Цустай толгой тулманд ууталж дээр нь тэгнэн хэвтэж байсан татаар эм бол ёс бус санаанд гаргуун байжээ. Нэгэн удаа Тэмүжин хөвүүнийг гаргүй болвол тэрний сүнс зайлна хэмээн татаар эм өмхий санаа гаргажээ. Харин энэ удаа хорт хэлээ билүүдэж "Тэмүжиний нөж атгасан гарыг мухарлая гэвэл эцгийг нь хороох хэрэгтэй. Есүхэй хорлогдвол тэр хөвүүн мөн адил сөнөнө. Төрөхдөө цууд гарах ямар гай дагуулдагийг мэдэж аваг. Ерын тэр хөвүүнийг дараа нь бяц гишгэж болно. Тэгэхээр Есүхэй баатрын буцах замыг боож түүнийг хорлож алая" хэмээн сандарч өгүүлэв.

Есүхэйг буцахад нь отож найранд урь.

-Сэжиг авбал яах билээ.

-Алдар нэртэй баатар эр найрнаас жийрхэх юун. Хоймортоо суулгаж идээ, умдаа барь. Болж өгвөл согтоох хэрэгтэй. Согтсон хойно нь хор уулгана.

-Татаарыг нугаслаж дарласаны өшөөг өөрөөр яаж авах билээ.

Энэ үед нөгөөх татаар эм енгэнэтэл уйлж "Тэмүжин үгээгийн толгой нүдэнд харагдаад, зүүдэнд ороод байх юм. Тэр их баатрыг Есүхэй яаж цавчлаа. Толгой нь уначихаад байхад Тэмүжин үгээгийн бие хөшөө чулуу шиг удаан зогссон. Цусаа хүзүүгээрээ тургиж дуусаад татаарын баатар газар унасныг санаж байна. Би тийм аймшигийг нүдээр харсан гэрч шүү. Олзлогдсон татааруудын нүд хальтраад толгойгоо өндийлгөж чадаагүй гэсэн. Тэмүжин үгээгээс хойш би нохой боллоо. Намайг өршөөж хайрла. Есүхэйг хөнөөж өгөөч" хэмээн бархирна.

\* \* \*

Дөрвөн татаарын толгой нийлжээ. Гэрт айраг цэгээ ханхалж батгана шавна. Татаарын баатар Тэмүжин үгээгийн татвар эмийн нүүр халтартжээ. Татаар эм эрчүүлийн яриаг дуулгавартай сонсож сууна.

-Нэг едөр Тэмүжин өсч өндийнө. Хэрэв нөж атгаж төрсөн бөгөөс дийлдэшгүй дайчин болж татаарын үнс чандрууг тэнгэрт хийсгэнэ. Тийм бус уу.

Зулай халзан тэгш толгойт хижээл татаар,

-Есүхэй үхвэл боржигон сөнөнө гэдэг яриа төдий. Гагцхүү Тэмүжин өнчирч үлдвэл дуртай цагтаа тэднийг дайлж өвдөглүүлэх бус уу. Ганц Тэмүжин хүчирхэг болтол татаарууд Алтан улсын хааны ивээлд багтаж тал нутгийн эзэн болно. Намайг сонссон бол үгээ хэл гэж цаадуулаа шахна. Том шар шүдтэй татаар эр үгээ зажлан,

-Есүхэйн замд найрын гэр барьж, архи идээ базааж хүлээе. Есүхэй архидана, согтоно. Бид санаагаа гүйцээж болох биш үү гэж зааварлаж байна.

Боржигон, татаарын тулалдааны үед завьжиндаа одоогийх шиг үс ургуулж амжаагүй олзлогдсон майга залуу тас тас хөхрөн байж,

-Урхинд орноо, тэр Есүхэй баатар! орно хэмээн агадахад түрүүчийн халзан тэгш толгтойт "дуугаа аяд" хэмээн майга хөлтийг зандраад,

-Та нар тэнэг юм. Хонь өрлөх шиг амар санах юм. Есүхэй баатар ганцаараа биш дагуулуудтай. Цөмөөрөө зэвсэг агсаж яваа. Сэжиг авахуулах юм бол биднүүс хэрчүүлж таарна. Болгоомжтой үзнэ гэв.

-Яаж ...тэгээд...

-Ядахдаа найрын хувцастай байвал зохино. Хэдэн гэр баривал таарна. Эмс охид олон тусмаа сайн. Найр шиг найран дээр боржигоны баатрыг согтоож болно. Хар авах вий. Ээдээ хичээнэ шүү.

-Шууд цавчиж дайн өдөөж яахнав. Тэмүжинг өнчрүүлж гары мухарлах аргыг энэ хүүхэн есөн жилийн өмнө хэлж байсан. Есөн жилийн хойно шалтаг олдов. Есүхэй үхнэ. Боржигон бутарна. Тэмүжин ганцаардана. Маргааш ачаалж зам тосож бууцгаа.

-Илд бамбайгаа яахав. Зэвсэггүй байж болох уу. Зэвсгээ Хэрлэнгийн бургасанд нууя. Эрсэн айлаа бургасан дотроос олж очиход хэцүү билээ.

-Найрын гэрээс холгүй зэвсгээ хадгалж мануул. Эсгийгээр хучаад орхичих. Хэн мэдэх юм.

Дөрвөн татаар толгой гэдийв. Дөрвөн цэлдэн нүүр өөдөө харцгаав. Тэд үгсэв. Бэлэвсэн эхнэрийн нүд хорсолтой ажээ. Аргалын цог дээр халаасан цайнаас эрчүүлд аягалж барилаа. Татаарууд цайгаа хорсолтойгоо ууцгаав.

\* \* \*

Найрын өргөөнөөс Есүхэй гуйвалзсаар гарч ирэв. Тэр согтжээ. Түүний янхир шанаа гүрвэлзэн шүдээ зууж байна. Мэнлигийн мөр дээр том гараа тавьж "мордоцгооё" хэмээн дагуул цэргүүддээ тушаав. Салхи сөрж давхиснаа Есүхэй баатар жолоогоо татаж гэлдрүүлэн өгцөг дээр ташаалдаад,

-Энэ татаарууд ямар санаатай юм. Аягатай архийг хөнтрөхдөө "Тэмүжиний төлөө" гэж хэлж байна. Миний хөвүүний төлөө эднүүс архи хөнтөрлөө гэж үү. Мэнлиг чи юу бодно гэв.

-Татаарын Тэмүжин үгээг та хороосон шүүдээ. Өш зангидаагүй биз хэмээн Мэнлиг тааварлаж өгүүлэв.

Есүхэй эмээл дээрээ хөлбөрөн ташаа тулж,

-Тийм бол эргэж очоод цавчилдах бус уу гэснээ дөрөө жийн морио гуядлаа. Боржигоны баатар их согтжээ. Тэрбээр мориныхоо хоёр тал руу гуйвж ташуураар газар зурах авч тэнцвэрээ үл алдана. Бараа бологсодын зарим ард сүүлдэсхийж явна. Есүхэйг даган Мэнлиг дөрвөн цагийг шуранхайлан дуулж Хэрлэнгийн саруул дэнжээр өгсөв. Мэнлигт хар буусан хэрнээ дуутай, хууртай найран дээр үгний сэв арилсан биз хэмээн уужим сэтгэж байв. Өртөө хэртэй дуулалдан давхисаны эцэсттунгал аг бул аг дээр хоноглов. Маргааш нь Есүхэй баатрын уруул хүрэнгэж харлаад, нүд нь хөгц мэт ногоовтор туяатай болж, байн байн огино. Булгийн хүйтэн ус залгилавч тусыг эс олсон тул хот айлаас сүү авчирч боржигоны толгойлогч уулаа. Тамирдсан сөөнгө хоолойгоор Есүхэй,

-Түргэн гэртээ очье. Намайг хордуулжээ гэж Мэнлигт хэлэв. Мэнлиг хөмхий зуун "найран дээрээ хор өгдөг монгол ёс биш. Монголчууд бол шууд цавчилдаж нэгнээ буулгаж авдаг. Гарцаагүй өш зангиджээ" хэмээн уурсаж байлаа. Есүхэйн ходоод гэдэс тэсэхүйеэ бэрх базална. Түүний нүүрээр том, том гувдрүү барзайж, ясны хөлс цутгаж эвгүй үнэртэнэ.

Морьт цэргүүдээ дагуулан Есүхэй баатрыг эмээл дээрээ дүүрч хагируулсаар боржигоны хот айл хүрэв. Эмс нулимсаа асган Есүхэйн ергеөг тойрч зогсов. Есүхэй нүднийхээ зовхийг арайхийн хөдөлгөж Өүлэн үжинг харсанаа,

-Гэнэ алдав. Би үхэх нь. Бүсээ чанга бүслээд хүүхдүүдээ хүний зэрэгт хүргэдэг юм шүү. Намайг үгүй болбол боржигоны тугийг чи бариарай. Татаарт итгэснээс ийм болов хэмээн шивнэлээ. Омголтсон уруулын завсраар түүний тэгш том шүд цайрна. Өүлэн үжин сөхрөн унаж,

-Намайг битгий орхиоч. Яасан гэж энэ вэ, Есүхэй минь...гэвэл тэрээр,

-Мэнлиг чамайг, Тэмүжинг, хүүхдүүдийг минь асарна. Мэнлиг асарна. Хойт өдөр Тэмүжин хөвүүн...гээд шаналсан царай нь тайтгарч, маш тайван болж амьсгал хураав. Өүлэн эх Мэнлигт хандаж нулимсаа залгин байж "Тэмүжин хөвүүнийг авчир. Хөвүүн цочимхой учир элдвийг ярихаас болгоомжил" хэмээн захиж Хонгирад аймаг руу мордуулав.

Тэмүжиний баруун гартаа нөж атгаж төрсөнийг зарласан явдал эцгийн аминд нөлөөлжээ. Тэгээд ч татаар иргэд өс санахдаа чадамгай аж. Боржигоны эхнэр, эмс, охид уйлалдаж, өвгөд, хөгшид тэнгэрт өргөл өргөж, эрчүүл хаан эзнээ нутаглуулахаар бэлтгэнэ. Боржигончуудад гай нүүрлэжээ. Ямар гай нүүрлэснийг тэнгэр мэднэ. Өүлэн эх хэдэн өнчин хүүхэдтэйгээ хайлаас мэт ганхаж хоцров.

\* \* \*

Уяан дээр хонхотоны Мэнлиг хүлээж байв. Хөвүүн хурдаараа гүйн ирж Мэнлигт тулж зогтусав. Мэнлиг өтгөн хөмсөгөө өргөж "Тэмүжин чи бачимдах нь юун билээ. Тэмүжин чи худындаа байгаа бус уу" гэж зоригжуулав. Тэмүжиний нүд асуултаар дүүрэн байлаа.

Бэр гуйхаар мордох яг тэр үед Есүхэй баатар өргөөнийхөө гадаа хүлээнэ. Өүлэн эх хөвүүний баруун алган дээр сүү дусаав. Өүлэн эх гүнзгий санаа алдаж "чиний гарын алга ямар тод хээтэй юм бэ. Алгаа хүнд бүү үзүүлээрэй гэж Халзанбух зайран бөө айлдсан билээ. Би бас

бөөгийн санааг дэмжинэ" гэж хөвүүндээ дахин захисан юм. Алганы хонхорт дусаасан сүү харсаар байтал шингэв. Хаашаа шингэснийг бүү мэд. Хөвүүний гарын алганд Өүлэн эхийн хөхний сүү шингэхийн хэрээр Онон мөрний урсгал намуухан болж, гүндбалын ургамлын судас, лууны ургамлын үндэс лугшин нийлж Есүхэй баатрын омголон төрх зөөлөрсөн байжээ. Хүүг өргөөнөөс гарч ирэхэд Есүхэй "эжий чинь юу гэв" хэмээн асуугаад "аав нь мэднээ, мэднэ. Чи өөртөө хадгал" гэжээ.

Хонхотоны Мэнлиг нутаг буцах замдаа Тэмүжинд хэлсэн үгийг Бөртэ эцэгтээ хэлж байлаа.

-Есүхэй баатар Тэмүжингээ санаж байна гэж хэлж амжсан гэнэ лээ. Энэ бол түүний эцсийн үг байсан. Найран дээр татааруудад хорлогдож бие баржээ. Тэмүжин өнчирлөө. Би ч бас...

-Чамд хэн ингэж хэлэв.

-Тэнгэр хэл дуулгав. Тэнгэр....

Бөртэ газар сөхөрлөө. Талын ерхөг хялгана зулгаав. Талыг хучсан хялгана тэр аяараа налж бөхийсөн байв. Бөртгийн нулимс хялганын толгойд дуслаа. Нулимсны дусал шивээн толгой дамжин улаалан одно. Охины бие чичирч байна. Дэй Сэцэн охиныхоо дэргэд сөхөрч түүний чичигнэн хөдлөх бяцхан дал мөрийг аргадан илж "Боржигоны баатар тэнгэрт халисан ч Тэмүжин хөвүүн ор залгана. Удахгүй чамайг авахаар эргэж ирнэ. Тайвшир, охин минь" хэмээн гуйв. Бөртэ охины энэлэн даанч их ажээ. Хонгирадын тал нутагт Бөртэ охин ганцаардан уйлж байв.

\* \* \*

Жадараны Жамуха харваач хөвгүүдийн хамт сум тавьж гашуудал тайлна. Тэдний харавсан сум уралдан исгэрч, тэлж татсан арьсны голд улаан зоосоор тэмдэглэсэн дугуйд ар араасаа зоогдов. Сумны залуур өднүүд сөрвөлзөн ганхаж Бөртэ охины гунигийн дууг хуваалцах мэт хөдөлнө.

-Тэмүжин яана...! гэж Бөртэ тэнгэр задартал хашгирав.

\* \* \*

Тэмүжин овоонд чулуу нэмж байна. Бурхан халдун уулын овоонд эцгийн ариун сүнс хоцорчээ. Овоог сүрлэг том болгохын тулд Тэмүжин өдөр бүр овоо өөд бэлийн чулууг зөөх аж. Хаа нэгтээгээс эцгийн дуу сонсдож "Монголчуудад хүчирхэг гар хэрэгтэй. Чамд би итгэж байгаа, хөвүүн минь" гэж өгүүлнэ.

Чулуу зөөх тусам Тэмүжиний булчин шөрмөс, чангарч, өөдөөс үлээх салхийг сөрнө. Салхи хөвүүний хүчийг шалгах мэт тамирдуулах боловч Тэмүжин чулуугаа өргөн зүтгэж байна. Бурхан халдуны овоон дээрээс багил хар тайга хөглийн алсарч Онон, Хэрлэн Туулын урсгал урт хөндий үүсгэж, олон уулын суга зөрж сундалдан харагдана. Тэртээ алсад уулс бүүдийн хээр талын хормой руу дэрлэжээ. Овоон дээр гарах бүрийдээ Тэмүжин эцгийнхээ дууг сонсож зүрхээ чагнана.

Бурхан халдун ууланд Есүхэй баатрын дуу үлдсэн байжээ. Бэгтэр хөвүүн Тэмүжинийг дагавч сэжиглэх, хардах хосолж нэгэн нууцад нэвтрэхийг чармайна. Энэ овоо Тэмүжинийх үү, Бэгтэрийнх үү. Суудал мэт овоо босч байлаа.

\* \* \*

Өндөр өвсийг налуулан хэвтсэн Тэмүжиний дээрээс хэн нэгэн хар булган дахаар хучив. Хөнгөн дулаахан булган дахны илчинд Тэмүжин зүүрмэглэж бас зүүдлэв. Өүлэн эхийн нь оронд Бөртэ зогсоно. Би монголын хааны хатан Бөртэ үжин билээ гэж тэр өгүүлнэ.

-Тайчууд яагаад нүүв гэж Бөртэ асуув.

-Хар нутаг дээрээ хаяв гэж Тэмүжин хариулав.

-Одоо яанав. Бүү гасла! хэмээн Бөртэ чанга хатуу өгүүлнэ.

-Бэгтэр бид хоёр хаан суудал засаж байна. Тэр суудалд хэн нэг нь сууна. Хэрэв Бэгтэр суувал би үгүй болно. Би суух аваас Бэгтэр миний баруун гар болно гэж Тэмүжин хэлнэ.

-Бэгтэр чамайг юуны учир ад үзнэ. -Намайг мэргидийн толгойлогч Чилэдүгийн шээс гэж хэлсэн. Бэгтэр өөрөө Есүхэй баатрын хүү юм гэнэ. Есүхэй баатрын орыг би биш Бэгтэр залгамжлах ёстой юм гэнэ. Бэгтэр гаарч байна.

-Чи бол Есүхэй баатрын сүнс сүлд нь. Есүхэй баатар Бэгтэрт биш чамд бэр гуйсны учир энэ. Есүхэй баатар удам угсаагаа чамаар залгаж үлдээхийг хүссэн юм.

Хар булган дахыг хонгирадаас буцахад Дэй Сэцэн Тэмүжинд бэлэглэж түүний ганзагалаанд явуулсан байжээ. Энэхүү хар булган дах Тэмүжинг намар цагийн жиндүү хүйтэн салхинаас нөмөрлөж байв. Хожим хойно Ван Тоорил, анд Жамуха болоод Тэмүжиний гурвалсан холбоо үүсэхэд хар булган дах зуучилна гэж яахин санана. Хар булган дахны дор зүүрмэглэх зуур Тэмүжин хөвүүн гаслант амьдралаа түр мартагнаж зөн совингийн зүүд зүүдэлсэн билээ.



## Есдүгээр бөлөг



*Бурхан халдун ууланд толин нуур буй.*

*Толин нуурын усанд жүд модон, ялгуун модон харагдаж, хос хөх могой хөвнөм*



Нүүдэл айсуй. Нүүдэл цаашаа... Нүүдлийг ноход дагана. Нүүдлийн хойноос мал сүрэг хошуурна. Монголчууд хавар, зун, намар, өвөл хэмээх дөрвөн цагийн эргэлтэнд усаа дагаж нүүнэ. Гурван голын эхнээс Цэгцэрийн тал, Жавартын хөндийгөөс Хэрлэнгийн сав хүртэл урт нүүдэлд алжаалаа умартаж, хөсгийн хажууд, мал сүргийн дэргэд ноход сүүлээ цагирагуулан шогшино. Ноходын боргох зүг айлын утаа суунаглаж байх юмуу эс бөгөөс нүүдэлчид явна. Нүүдэлчидийн дээгүүр бүргэд элэн хальж, хэсүүчлэн эргэнэ.

Бурхан халдуны бэл рүү Тэмүжин хөвүүн бууж явлаа. Тэмүжин нэгэнтээ арван таван нас хүрчээ. Боржигоны гэр хүрээ Есүхэй баатраас хойш ундуй сундуй болов. Боржигоны хот айл цөөн буурай болсонч Тэмүжиний хүчээр нутаг сэлгэж, Тэмүжин эрийн цээнд хүрч хот хүрээгээ өөд татах ажээ. Уулын бэлд борог халиурна. Тэмүжин хол алхан борог дээгүүр

гулсан энгэр зайж хурдхан Ононы шугуй хүрэх гэж яарна. Хуцаж боргосоор ойртох нохойн нүд рүү Тэмүжинг ширтэж шуудхан ойртвол нохой зогтусаж түтгэлзээд сүүлээ годгонуулан найланхайтаад биеэ хурааж байснаа эргэж зугатаав. Нохойн зугадсан зүг рүү Тэмүжин хараа чилээж харсанаа шүд зуув.

Нохой бол шар, хөх, улаан, бор, хар нүдтэй цаггалан, туранхай байна. Саяын Тэмүжин өөд хуцсан нохой цаггалан аж. Золбин нохой аймтгай байдгийг Тэмүжин мэднэ. Хэний уяанд хэр хооллодог нохой болохыг Ононы өвст нугад дэрвэх хээнцэр цацар, мухлагт тэрэг, гэр хүрээний байдлаас Тэмүжин гадарлаж байлаа. Тайчууд Ононы сахлаг ногоог мөлжихөөр нүүн иржээ.

Хүрээнээс чинагш яваа хүний бараа харагддаг нэгмэдэхэд бургас, зэгс бүхий шугуйд шургаж алга болов. Ноход түүнийг таних тул үл тоов. "Нохойны хамар, чих, нүд хүнд мөн их тус болно шүү" хэмээн хонгирадын Дэй Сэцэн эцэг Тэмүжинд өгүүлж байсныг тэрбээр нэхэн санаж Таргудайн ноход надруу хуцдаг юм байна. Намайг танихгүй юм чинь хэмээн бодлоо.

Ноход цацар тийш зүглэжээ. Нутаг сэлгэх бүрийд ноход байж ядан зүг бүр тийш сэлгүүцэж, харсан болгоноо боргоодог билээ. Ноходын танил нь зэгсэнд нуугджээ.

Тэмүжиний гэр хүрээ цөөхүүлээ бөгөөд модон мухлагт тэрэг, аргамжааны морьдын хөлөөр тахлагдсан халцгай дэнжийн цаахна идээшлэх морьдоо харав. Хивж хэвтэх хоньдын дундуур нэгэн эмэгтэй явж байна. Тэр бол Өүлэн эх ажээ. Өүлэний санчигт тод цагаан үс гялалзана. Өүлэн намбалаг, эрхэмсэг байдалтай, нүдний нь харц тунгалаг аж. Бугын арьсан хөмөн гутлын мөр замагт шороон дээр тамга мэт үлдэнэ. Яг тэр жил Орхон, Сэлэнгэ мөрөнгийн цутгалан нийлэх уулзварт гишгэсэн Өүлэний мөр нь мөн ажээ. Голын гүехэн салааг Өүлэн гаталж эрэг дагуух хөхөртөн гандсан бургасыг хугачин баглана. Бургасны чөлөөгөөр гүйж яваа нэгнийг харсан боловч хараагүй мэт дүр эсгэж бөөн зэгс рүү орж алга болохыг Өүлэн эх мэдээд "Бэгтэр байна. Бэгтэр хөвүүн зүг буруулах нь юув" гэж бодов.

Эхийн дэргэд Тэмүжин ирж баглаатай бургасыг сэвхийтэл үүрч "ээжээ манай уугуул нутагт тайчууд дураараа дургиж байна. Эцэг Есүхэйгээс хойш биднүүс нүдэнд орсон хог, шүдэнд торсон мах гэгч боллоо. Нүүдэл хийвч тайчууд өрсеж бууна. Усны тунгалаг, бэлчээрийн соргогийг тайчууд эзэмшиж байна. Боржигон овгийг мөхсөн гэж эднүүс бодно. Боржигонд сэргэх цаг ирнэ" хэмээн цөс нь дэлссэн бололтой өгүүлнэ. Эх нь зоримог араншинтай тул "хүний мөрөөр явбал хаана хүрэхээ мэддэг юм. Малын мөрөөр явбал төөрдөг юм" гэв.

Тэмүжин эхийнхээ нүд өөд харав. Эхийн нүд булингар үгүй тунгалаг байв. Өүлэн эхийн цагаан цайвар царайд нарны туяа гэрэлтэн тусчээ.

-Тайчууд бол манай боржигон овогтоны хамаатан бус уу. Бид өнөөдөр тэднийг тойрч амьдарч байна. Маргааш тайчууд манийг тойрч амьдрах болно. Хувь тавиланг таахад хэцүү гэж Өүлэн эх хөвүүндээ захиас мэт хэлэв.

-Сочихэл эхийн ах Таргудай бус уу. Таргудай бол Бэгтэр, Бэлгүтэй хоёрын цусан ураг шүү. Таргудайн өмгөөл өл бидэнд тустай. Түүнтэй ойрхон яваа болохоор өөр овог аймаг довлохгүй байна.

-Таргудай биднээс салж нүүсэн бус уу.

-Сочихэл эхээ бодоод Таргудайд бүү өширх.

-Ээжээ, энэ Бэгтэр нагацдаа хайртай болов уу

-Таргудай эднийгээ бас хаясан, муу үздэг.

-Бэгтэр дүү тайчуудад хов зөөдөг...

-Чи чинь хавиргаа хадрах нь уу. Бэгтэрт итгэ. Эс итгэвээс Бэгтэр чамд дайсагнана.

-Бэлгүтэй дүү надад итгэдэг. Тэд тэс өөр хүмүүс. Эцгийн сүнстэй овооны чулууг Бэгтэр нурааж эцгийн сүнсэнд халдаж, Бурхан уулын лус савдагийг хилэгнүүлэв.

-Тэмүжин хөвүүн минь сэрэмжтэй байх түмэн зөв. Хажуудахаа хазах нь буруу шүү.

-Таргудайн ноход хуцаж намайг нойрноос сэрээв. Ноход тайчуудын нүүдэл тийш явсан. Зэгсэнд нуугдсан хүн рүү ноход хуцалгүй өнгөрөв. Тэр хүн Таргудайн ноходтой танил байна. Тэр хэн буй.

-Бэгтэр хөвүүн мөөгөө түүж яваа...

-Бэгтэрийг би таньсан. Тэр туршуул бус уу.

\* \* \*

Тайчуудын хүрээний голд байх гоёмсог цацрын торгон үүд ялигүй сөхөгдөн хэн нэгний эрүү цухуйв. Эрүүн дээр өтгөн хар сахал хөө мэт наалджээ. Түүний сахал харагдахаас бус нүүр царай үл үзэгдэнэ. Хар сахал далд ороход булцгар нүүртэй нэгэн үүдээр шурган оров. Ширдэг дээр Таргудай тэнтийтэл хэвтэж аягатайгаа ховдоглон үмхэх зуур хөвүүнийг баруун талд суу гэж хуруугаар чичиж тушаав. Бэгтэр Таргудайн махлаг улаан нүүрийг цоо ширтэн,

-Тэмүжин нохойноос цочихоо больжээ гэв.

-Хурганы үс гуужив. Төлөгний үс төлжив. Тэмүжин эрийн цээнд хүрчээ.

-Та намайг яах гэж байна.

-Танай мал эцэнхий. Овгийнхон Өүлэнд дургүй болсон гэлүү. Цаг нь болохоор би чамайг хаан болгоно.

-Тэмүжинг яах юм бэ?

-Нэг өдөр түүнийг нугаслана. Тун амархан...

Бэгтэрийн нүд дүрэлзэж чулуун шигтээтэй, хуйны дээд амсрыг мөнгөлсөн хутган дээр

унажээ. Бэгтэр нүдээ авч чадахгүй байлаа. Бүдүүн Таргудай жаал харж байснаа хутгаа авч хуйнд нь удаан гэгч хийснээ буцааж сугалаад торгон ирийг үлээж, хурууны өндгөөрөө дарж үзээд "миний ах Товуучир дарханы урласан эд дээ" гэж хэлэв. Хутгаа хуйлсанаа Бэгтэр рүү сарвайв. Хөвүүн хоёр алгаа дэлгэж нүдээ аньжээ.

-Хаан хүн сайхан зэвсэгтэй байх ёстой гэж Таргудай сургамжлав.

Хутганы хуйнаас хоёр хүний гар барьж байв. Хутганы хуйн дээр чулуун шигтгээ гялалзана. Хутга гараас гарт дамжив. Хутганд шунал, атаархал шингэжээ. Хутганы ирэнд хүний амь оршиж байв.

\* \* \*

Шөнийн түнэр харанхуй тайга, нуга, гол, уул, талыг нөмөрчээ. Хаа нэгтээ чоно ульж, адуу тургилна. Онон мөрний эгц эрэг дээр гал түлж нэгэн ёслолд бэлтгэжээ. Боржигон овгийнхон дугуйран зогсчээ. Хүрээний голд Өүлэн эх болоод Тэмүжин, Хасар, Хачиун, Тэмүгэ хөвгүүдтэйгээ, нөгөө талд Сочихэл хатан өөрийн хөвүүн Бэгтэр, Бэлгүтэй нарын хамт галын сорилгод орохоор зогсчээ.

Галын гэрэлд Өүлэн эхийн тайван царай тодрон, -Манай овгийнхон эртнээс галыг ариун шүтээнээ болгож тахиж ирсэн. Галын хүчийг сорих ариун сорил бол эртний ёс юм. Бид хэрэн хэсэж зүдлээ. Маньд толгойлогч хэрэгтэй байна. Тайчуудадхов зөөдөгурваач бас гарлаа. Бид өнөөдөр галын ариун ёсоор хаанаа сонгоно. Бас урвагчийг илчилнэ. Энэ үйлийг ёс журамтай сайхан үйлдэнэ шүү гэлээ. Дараа нь Сочихэл хатан салаалж гөрсөн урт үсээ хөхний дээгүүр унжуулан имэрч Өүлэн рүү омогдоно.

-Өүлэн чамайг тэнгэр гэсгээж чи үндэсгүй мод мэт хатаж байна. Би бол Есүхэй баатрын их хатан юм. Бартанбаатар намайг хүүдээ авч өгсөн юм. Чамайг улаан замаас хулгайлж авчирсан билээ. Миний хөвүүн Бэгтэр боржигон овгийн хаан бус уу. Өөр хэнийг хаанаар сонгох билээ. Есүхэй баатар бие бараад удав. Хэрэв ивээс хэрэгтэй бол миний ах Таргудай байна... Таргудай Хирилтуг байна...

Сочихэл багтрах шахжээ. Тэрбээр амьсгаадан түүний хөх оволзоно. Харин энэ үед Өүлэн тайван байлаа. Өүлэн эхийн гүнзгий шаналалд автсан цайвар царай дээгүүр галын гэрэл тоглоно. Сочихэл хатны нүүр цагаан, хар өнгөөр хуваагджээ. Сочихэл зөрүү харна. Гал тойрон газар өвдөглөсөн цагаан хувцастай өвгөдийн нүүр хүрэл цутгамал мэт хөдөлгөөнгүй дүнсийнэ. Хүрэл өвгөдийн царай хөшингө амгалан ажээ.

-Аавын анд Тоорил хаан биднийг хамгаална. Тэр хаан нөмөр нөөлөгтэй хүн гэж Хасар хашгирав.

-Сочихэл хатантан дэндүү увайгүй загнахаа аяд. Есүхэй баатарт гуравдах хатан авч өгье гэтэл дургүйцсэн юм. Надад дэндүү сайн байснаасаа болоод тэр гуравдах хатнаас татгалзсан хэрэг. Сочихэлийг байсаар байтал намайг авчирсаны учир тодорхой бус уу. Өөр тэнгэрийн шалтгаан буй!

-Өүлэн чи тайчуудын хар нутаг хэсэж яваа шүү. Тайчууд алс нүүвэл бид мангир түүж, загас шүүрдэж хэдий удах вэ. Бэгтэр хаан болбол тайчуудын ивээлд аяндаа багтах бус уу. Бэгтэрт итгэ.

-Есүхэй баатар анх Тэмүжин хөвүүндээ бэр гуйсан. Тэмүжин бол Есүхэйн удмыг залгамжлах маргаангүй хүн. Тэнгэрээс заяатай...

Гал тойрсон өвгөдийн хүрэл цутгамал нүүрийг гал долоож улаан болгосноо эргээд хар суудэр татуулна. Өрвөлзсөн их галын гэрэлд тэнгэр улам харанхуйлж Онон мөрний шугуйд хээлтэй гөрөөс зүүрмэглэж чадахгүй нүдээ дүрэлзүүлж араатны шиншилтээс зугатна.

Боржигон овгийнхоны хүүхэд, хөгшид, бүсгүйчүүл галын хоорондуур гарч байна. Хүүхдүүд галын сорилго, ариусгал хэрхэн өнгөрөхийг шохоорхож харна. Тэмүжин галын хоорондуур гарахад түүний сүүдэр сунаж тэрхэн зуур тэрбээр тэнгэрт тултал өндөрсөв. Тэмүжинг гал ивээв. Гал дундуур явж өнгөрөөд Тэмүжин зайдуу зогсох Бэгтэр рүү харц чулууудав. Бэгтэрийн ээлж иржээ. Бэгтэрт Сочихэл хатан ойртов. Галын дөлд Бэгтэр шатаж байх шиг харагдана. Бэгтэр шаналж бас шатаж байлаа.

-Хөвүүн минь явтугай. Чамд айх аюул юун. Чи хаан болно...

Сочихэлийн үгийг Бэгтэр сонссон, эс сонссон хоёрын хооронд харанхуйд гөлрөн, гал өөд харан явлаа. Галд дөхөж очоод Бэгтэрийн хөл гуйвлаа. Тэрбээр гал дундуур тэнцвэр алдан алхаж гарахдаа өврөөсөө мөнгөлсөн хуйтай, чулуун шигтгээтэй хутгаа унагаав. Хүмүүс дуу алдав. Бохирч суусан хөх өвгөд нүүрээ үрчийлгэв. Өвгөдийн хүрэл царай барайв.

-Энэ хутга Таргудай нагацын хутга... гэж Бэлгүтэй бүхнээс түрүүлж дуугарав. Бэлгүтэй хутгыг таньжээ.

Тал урвагчийг илчиллээ гэж Хасар хашгирав. Хасар хорсов.

Бэгтэр, Тэмүжинд ойртож зогсчээ. Хөх өвгөдийн хүрэл нүүр үрчийж татвалзан буйг харахад галын сорилгод итгэж Таргудай ноёны хутганд дургүйцсэн байжээ. Хөх өвгөд Бэгтэр тийш хүйтэн царайлав. Бэгтэрийн цаана уужим аугаа хөх тэнгэр хүнхийж байна. Бэгтэр өчиг өгөв. Бэгтэрийн ухаан галд шатлаа.

-Өршөө намайг, би буруугүй билээ. Би нагац Таргудай ноёнд бодож санаснаа ярьсан юм. Тэгтэл тэрбээр намайг албадах болсон. Намайг хов зөөгч гэж тал нутгаар тараана гэсэн. Намайг насан туршид минь гутамшиг болгоно гэлээ. Би яах юм бэ...Бэгтэр гаслан өгүүлэв.

Хүмүүсийн нүүр царай ширүүн, үг дуугүй байх бөлгөө. Хөх өвгөдийн духны үрчлээ сорви мэт гүнзгий харагдана. Боржигоны хүрээ сэтэрлээ. Тэмүжин хоёр галын дунд очоод Бэгтэр өөд харахад түүний толгой зантайж, нүд нь үхэр хулганых шиг бүлтийж харагдана. Бэгтэрийг амьтны төрөлд хувилж харагдахад Тэмүжин цочирдсон боловч гүндбалын үндэс дээр хөлөө суурилж бат бэх зоогджээ.

-Есүхэй баатрын хөвүүн Тэмүжин миний бие өвгөдийн заншилаар урвагчийг цаазлахыг

тушааж байна гэж Тэмүжин зарлигдав.

-Бэгтэрийн өмнөөс би ичиж байна. Тэмүжин ахын чанга хатуу зарлигийг сонслоо. Нэг эхийн хэвлийгээс ургасан Бэлгүтэй намайг Бэгтэр ах гутаасан тул зарлигийг ёсчлон биелүүлэхийг хүснэ хэмээн Бэлгүтэй өчив.

Сочихэл давчдан салаа гэзэгнээсээ хоёр гараар базалж "Бэгтэр бол хаан хүний үр шүү" хэмээн орь дуу хадаав. Бэгтэр үхэх болжээ. Өүлэн эх хилэгнэн "Таануус нэг эцгийн хүүхдүүд биенээ битгий хөнөө. Одоо сүүдрээс өөр нөхөргүй, сүүлнээс өөр ташуургүй байтал юунд ингэнэ. Бэгтэр осолджээ. Тайчуудаас хамтдаа өшөөгөө авна гэж Бэгтэрээс ам авч, түүний амийг өршөө!" гэв. Морин төвөргөөн пижигнэв. Бэгтэр зугатжээ.

-Та нар Таргудайн боол болнс.гэж морин төвөргөөн дунд Бэгтэр хашгирна. Сум шунгинан нисч зугатаж яваа Бэгтэр эмээл дээрээсээ тонгорцоглон уналаа. Тас харанхуйд гөлөм дархийх, сум исгэрэх, пидхийн унах чимээ зэрэгцэв.

-Хэн харвав гэж Тэмүжин асуув.

-Би харвасан билээ хэмээн Хасар хэлэв.

-Би харвасан... гэж Бэлгүтэй өчив.

-Хаандаа үнэнч байвал харц ард ч ноён болно гэж Тэмүжин боржигоны хүрээнийхэнд зарлиг болов.

-Мөнх тэнгэрийн гэсгээлийг Хасар, Бэлгүтэй хоёр ёсоор үйлдэж Бэгтэр гутамшигаас чөлөөлөгдөв. Цаашдаа Тэмүжин миний бие тэнгэртэй харьцах болно. Тэнгэрийн үгийг би дамжуулж байна гэж Тэмүжин өгүүлэв.

Галын гэрэлд хөх өвгөдийн таашаалтай харц Тэмүжинг чиглэв. Бэгтэрийг үхүүлэх шалтаг Тэмүжинд байлаа. Бурхан уулын хаан суудал эзнээ хүлээж байсан юм. Эзгүй суудал эзэнтэй болов.

Бурхан халдунд чоно улилаа. Чоно ульж галын сорилго дуусав.

Галын сорилго Бэгтэрийг хуйхалж, Тэмүжинг асаав. Галын сорилго Өүлэн, Сочихэл хоёрын тарыг таниулж, зүсийг ялгав. Гал асч байна. Галын дэргэд хүрэл өвгөд Бурхан халдуны лус савдагт өргөл өргөнө. Галын хүчийг шүтэж, боржигоны зовлонг хайлуулж, сэтгэлээ ариусгаж буй хүрэл өвгөдийн зүрхэнд Тэмүжиний дүр бүрэн оршиж, Ононы шугуйд тайчууд хөлчүүрнэ.

Сорилгын түүдэг гал хээр талаар дүүрэн асч байх шиг Тэмүжинд санагдана. Гал мөнх юм. Олон гал нийлбэл түймэр болно. Луу жилийн түүдэг гал түймэр болтлоо өргөжихийг боржигончууд хүсэн хүлээх үлдлээ. Түймрийн цучил Тэмүжин байлаа.

## Аравдугаар бөлөг



*Тэмүжиний толгой дээр цагаан шонхор шувууны сангас дусахад*

*Таргудай Хирилтуг ихэд аймсаж дөнгийг нь тулсан жаран зургаан могойг харжээ*



Хүрэл өвгөдийн царай шингэрч, галын сорилгод ядарсанаа мартан Ононг өгсөж, уруудан гэрийн зүг өөд одоцгоов. Өвгөд ижил зүстэй юм шиг, нэг зүрхтэй юм шиг галын улаан дөлөнд бадамлан суудаг байжээ. Галын сорилгын шүүгчид өвгөд юм. Өвгөдийн зүс царай, нүдний харц, гарын хөдөлгөөн галтай холбогдон заримдаа дүрэлзэн асч, заримдаа газар алгадаж хээтнэ.

Галын хээ голын ус лугаа жигд мяралзан тэнгэр өөд угалз мэтгэнэ. Гал бол цоройж тэмүүлэхдээ гаргууд агаад сүүдрийг үмхэн идэж махчин амьтдын нүдийг хурцалж өгдөг шидтэй юмсанжээ. Шөнийн гал өртөө холоос үзэгдэнэ. Галыг баримжаалан одогсод тал нутагт буй. Тал нутагт галаар дохио өгдөг эртний ёс байжээ. Хүрэл өвгөдийг одсон хойно тэнгэр гэгээрэв.

Үүр цайж байх үеэр Сочихэл тайчуудын хүрээ рүү давхиж байлаа. Бэгтэрийн үхэлд цочирдож гонсойсон эхийн сэтгэлийг тайтгаруулах арга үгүй байв. Боржигоны хүрээнд болсон явдлыг

сонсоод тайчууд Тэмүжинг барихаар шийдэв. Эсгий гэр шатаж хярвас ханхална. Эмс охид уйлалдаж боржигоны хүрээ төдхөнөө тайчуудад хуйхлагдав.

Тайчууд улайрчээ. Бэгтэрийн буруу, зөрүү явдал Сочихэл эхийг шаналгадаг байсан авч яг хөвүүнээ амь эрсдэх үед эхийн өмөөрөх сэтгэл туйлдаа хүртэл эрчлэгдэн зангирав. Бэгтэр буруутай боловч хаан эцгийн үр шүү дээ. Яагаад Бэлгүтэй нь Тэмүжинд эвсэх болов. Тэмүжингийн итгэл Бэлгүтэйд тэгтэл нөлөөлжээ. Ямагт овог, аймгаа өөд татахын төлөө, шударга явдлыг өөгшүүлэхийн төлөө явдаг Тэмүжинг дэмжих бодол Бэлгүтэйд төрдөг байв.

Бэлгүтэй эхийнхээ хойноос тайчууд тийш явж төвдсөнгүй. Хэрэв эх нь Таргудайн өмгөөлөлд орвол Бэлгүтэй морины цулбуур атгахаас цааш үл хэтэрнэ. Нэгэнтээ Тэмүжинд найдсан бол Бэлгүтэй найдвараа тасартал түүнтэй цуг байх ёстой бөлгөө. Нэлээд хожимдож ирсэн Таргудай ноён хүүхэд эмсийг бүсэлж зогссон морьтонуудын дундуур бүртгэх мэт гүйлгэн харж байна.

Тайчууд боржигоны хүрээг орхиж явсан ч ямагт нутаг бэлчээрийг талхлан эцэнхий малтай ядуу зудуу байлгахыг хичээсээр билээ. Нүүдэл хийх сургийг түрүүлж сонсоод малын хөлөөр өвс ногоог гишгүүлж заримдаа түймэрдэж хувхайруулдаг байв.

Будүүн Таргудай тайчуудын толгойлогчийн ёсоор их дуугаар зандарч,

-Тэмүжинг өг! Надад Тэмүжин хэрэгтэй. Өлөгчин боолуудаар ба яах юм гэж ташуур далайна. Нэг хөвүүний дух руу ташуураар чичиж "Тэмүжин хайчсан бэ" гэж асуухад хөвүүний нүд гялалзан "мэдэхгүй" хэмээн адрав. Таргудай Өүлэнг харж байснаа "өнчин мертөө ихэмсэг" гэж тавлав. Боржигоны гэр хүрээ ундуй сундуй болжээ. Энэ сацуу Тэмүжин шугуй руу шургаж явна. Тэрбээр эргэж харна. Утаа суунаглаж тайчууд хашгачих ажээ. Тэмүжиний араас морьтнууд хөөж байна. Тэмүжин мориныхоо цулбуурыг эвхэж "чүү" хэмээн хондлой дээр нь алгадахад морь нь зулран давхив. Шугуй руу Тэмүжинг шурган гүйхэд шувууд дэрхийн нисч энд тэндгүй тэнгэр хөдлөх мэт сүрэг, сүрэг шувуу долгилон үргэлээ. Тэмүжин хөвүүн нүүр, амаа мөчирт шалбалан байж шалмагаар уулын хормой бараадан хожуул, өгөр мөчирт тээглэн урагшлав.

Тайчууд ойг самнаж эхэллээ. Морьдын хүнд амьсгал Тэмүжиний чихний дотор сонсдоно. Тайчууд хамаг тэнхээгээрээ хашгиралдаж "Өлөн амьтан хаа холдох вэ", "турсагы нь хуулах юмсан", "Боржигоны толгойлогч болсон гэвүү, муу зулбасага" хэмээн өөр хоорондоо өштөнөө тавлана.

Ой өтгөрч явах бэрхтэй тул Тэмүжин модны мөчрөөс зуурч дөрвөн хөллөн мацаж байлаа. Өршөөхгүй гэдгийг тэрбээр мэдэж амьд мэнд гарахын тулд тэнхээгээ шавхана. Нэгэн том модыг нуруугаар налж түр амсхийв. Хөвүүний тархинд эцэг тэнгэрийн дуудлага үе үе зурсхийн уйлж үлдсэн хонгорхон Бөртэ нүдэнд тодорно. Сүй тавьсан бүсгүй нь байнга бодогдох бөгөөд Тэмүжинд ёр дуудлага шүглэж байв. Бөртийн нүдийг Тэмүжин мартаагүй билээ. Бөртэ махлаг биетэй, дулаахан харцтай, хэвлүүхэн зантай охин байв.

Шувууны сүүдэр шиг зүрхийг нь хайраад өнгөрөх хувь тавиланг Тэмүжин сөрнө. Бушуухан Бөртэдээ очихсон. Хэрэв Бөртэ байвал Тэмүжин ганцаардахгүй. Хамтдаа байж гэмээ нь



Тэмүжин хүчтэй, ухаантай байна гэж боддог болжээ. Бөргийн байгаа зүг рүү явахаар Тэмүжин шийдэв. Гэтэл морьт цэргүүд зурсхийн өнгөрлөө. Сайтар ажвал сүүдэр байж. Алсын ой шугуйд нөгөө өнгөрөн одсон сүүдэр хүн болж харагдана. Есүхэй баатар хөвүүнийхээ замыг зааж өгөөд тэр даруй цэргээ дагуулан холддог шиг Тэмүжинд санагдлаа. Тэмүжиний сэтгэл дотор Бөртэ нь, эцэг Есүхэй нь ээлжлэн бодогдож, намаг шалбааг, ой шугуйг гатчин туулахад тусалж байв аа. Тэмүжин зүг буруулан явав.

Тэмүжин Бөргийн байгаа эцгийн явсан зүгийг чиглэн одов.

\* \* \*

Харанхуй шөнө нөмрөв. Тайчууд толгойлогчийн тушаал биелүүлэн морьтой, явган ой самнан гэлдэрч, эцэж туйлджээ. Тэмүжин хаашаа одсоныг мэдэх аргагүйтэв. Ой дундуур урагшлах тусам улам шигүү болж, битүүрч байсан тул Тэмүжин хөвүүн Онон мөрөн тийш эргэв. Ононы ус эргээ мөргөн түрхэрч гүн цүнхээлдээ шаагин бууж хөвч тайгаас усны чимээ нэгэн хэмийн айдастай сонсдоно.

Ононы хөвөө рүү ойртох тусам мөрдөн хайгсадтай тулж мэдэх аюул буй учраас Тэмүжин сэрэмжтэй явж байна. Байн байн зогсож тэрбээр мөчир хугарах, шувуу дэргэх, ус цалгих чимээ сонсож болгоомжилно.

Тайчууд Ононы эргийг мелжиж мөшгинө. Ой тайга дундуур нэвтрэх аргагүйг тэд мэджээ. Онон мөрний цаад эрэгт Тэмүжин гарч чадваас тайчууд хөвүүнийг бүрмөсөн алдах байлаа.

Хүний хөлийн чимээнээр Тэмүжин амандаа сүрэл зуун усанд булхав. Голын эргээр явж буй эрийг Сорхоншар гэх агаад түүний хөвүүн Чулуун, Чимбай хоёр Тэмүжиний үе тэнгийнхэн билээ. Харин охин Хадаан нь багадаа

Тэмүжинтэй тоглож, хамт голын эрэг дээр эртний гунигт дуу сонсдог байсныг мэдэх юм. Хадаан эхгүй өнчин, Тэмүжин эцэггүй өнчин тул Сорхоншар хөвүүнийг ихэд өрөвдөнө. Ойрын хэдэн жил Тэмүжиний барааг хараагүй байжээ. Сорхон шар усны цалгих чимээнээр гүехэн тохойд дөхөж очоод эргүүлэг үүсэхийг олж үзэв. Эргүүлэг хүчтэй, том дугираг үүсгэж байна. Лавтайяа галуу, нугасны булхалт биш гэдгийг хашир ухаандаа Сорхоншар мэдрэв.

Усны гадаргуу дээр хар зураас татсан байв. Хэдийбээр шөнийн харанхуй авч шар сүрэл усны цээлд гэрэлтэж байжээ. Усны гүнд хэн байгааг Сорхоншар мэдээд эргэн тойрноо чагнав. Сорхоншар ус руу өнгийн үгээ нухацтай зоож огуулэв.

-Урсгал усанд мөр үл үлдэнэ. Одот тэнгэрээс мөр үл олно. Голын тохойд нуугдсан нь сайн хэрэг. Хөвүүн чи юутай цэцэн бэ. Усны гүнээс ч мэлмий тань гярхай, нүүрний тань буян илхэн гэрэлтдэгийн улмаас тайчууд чамаас айдаг юм. Тэмүжин хөвүүн эндээ үлд. Би сохор, дүлий, хэлгүй болж явъя. Хөвүүн минь Бурхан ууландаа очвол өлзийтэй бус уу. Шалавхан яваарай...

Тайчууд нэгнээ дуудан хураасаар одоход Тэмүжин уснаас гарч "Сорхон шар та буянтай хүн юм. Эцгийн минь оронд эцэг шиг үг хэлэв" хэмээн амандаа шивнэжээ.

Шугуй байн байн бөглөрч, балархай морин жимийг дагахаас өөр арга Тэмүжинд алга болов. Тэрбээр модны завсраар хөсөг айсуй явааг олж харлаа. Хөтөлгөө морьтой, нум сум агссан морьтнуудын дунд сүйх тэрэг явна. Тэмүжин улаачийн нүдийг хариулан байж сүйх тэрэгний үүдийг яран үсэрч оров. Сүйхэнд яваа бүсгүйн амыг дарж харц тулав. Тэмүжин Бөртийг танилаа. Бөртэ эргэлзэнгүй байдалтай болоход хөвүүн шивнэн "тайчууд миний амийг хуурай мөчир хугалах төдий таслах гэж хөөв. Надад тайчуудын нэг баатар Сорхоншар туслав" гэв. Бөртэ, Тэмүжин хоёр Онон мөрний гарам гаталтал даарсан юм шиг биенээ тэврэн, амраг хайрын сэтгэлдээ дэвтэн явлаа. Бөртийн үснээс цэцэгний ханд үнэртэнэ. Тэмүжиний цээжнээс тунгалаг усны замаг ханхалж байв.

-Бөртэ минь...

-Тэмүжин минь...

Ууль, галуу нургиж, турлиах хашгирч, мэлхий вааглаж, болжмор жиргэж морьдын хөлсний шорвог үнэр өглөөний сэрүүн агаарт нармай еед гашуун оргитол ханхалж байлаа. Гагцхүү Тэмүжин, Бөртэ хоёрын халуун илч биесээ төөнөж, бадарсан хайрын дуу гадагшаа бус дотогшоо оргилж байлаа.

-Би таны хатан байна.

-Үхлээс арайхийн мултарч тэнгэрийн ивээлээр чамтайгаа учирлаа. Эцэг тэнгэр намайг хөтөлж ирлээ.

-Тэмүжин минь... Сар харах бүрдээ таныг санадаг. -Боржигончууд намайг хаанаа болгосон...

Мухлагт тэрэгний гадна тайчууд орилолдон "өвгөөн, таны ачаанд юу байгаа юм бэ? Одоохон бараагаа харуул!" гэх ажээ. Дэй Сэцэн гөвгнөн,

-Таньж байна уу, би Хонгирадын ноён Дэй Сэцэн байна. Таргудайн найранд залагдаж ирэв. Юугий нэгжих гээв. Таргудай хаантанд бэлэг барихаар ирэв гэтэл тайчуудын сөөнгө дуутай цэрэг,

-Алив үзье. Хүн нуусан байвал найрлахаасаа өмнө хүзүүгээ хугалуулна шүү гэж сүрдүүлнэ. Дэй Сэцэн бараа бологчдоо мориныхоо цулбуурыг өгөөд,

-Мухлагт тэргэнд миний охин яваа юм. Тайчуудын хаан найрандаа хэр бэлтгэж буй гэвээс тайчуудын сөөнгө цэрэг,

-Талын монголчуудыг доргионо гэж гайхуулав.

Чамин тансаг бараан дээр Бөртэ сандайлжээ. Тайчууд бүсгүйн гоо төрсөнийг хараад мэл гайхаж гэдрэг ухарсанаа бүлтийлээ. Бөртэ инээмсэглэж "тайчуудын хүрээ хол уу" хэмээн

сонирхов.

-Энүүхэнд буй. Тав алдуулсан тул өршөө. Танай хонгирадууд найрсаг зочломтгой гэнэ лээ. Бид Тэмүжинг эрж явна.

-Эшш халуун арьсан дотор хүн байтугай бүүрэг тэснэ гэж үү

-Дэй Сэцэн таныг саатуулсандаа хүлцэл өчье. Ноёнтон та тавгай морил...

Дайн байлдааны хөлөөс хөндий хол орших хонгирадууд тайван бус боллоо. Морьдын хөлөөр боссон тоос намжихийн үед Дэй Сэцэн тэрэгний үүд сөхөв.

\* \* \*

Бөртэ эрх танхил зангаа орхиж гүжирмэг бүсгүй болжээ. Ангийн арьс, үс, торгон эдлэл, адуу малын ширмэл тоног хэрэглэлийг зайлуулахад хөлсөндөө нэвт норсон Тэмүжин Дэй Сэцэний налгар тавиун нүүр өөд харав. Дэй Сэцэн тун их эргэлзэж байвч Тэмүжин хөвүүнийг танив.

Тэмүжин цээж өргөн, нуруу цэх, шөрмөслөг залуу болсон аж. Дэй Сэцэн, Тэмүжинг мөрөндөө наагаад "хөвүүн минь" хэмээн элэгсэг дуугарав.

-Хөвүүн чамайг тайчууд босоо ороолон шиг үзэх нь

юүв.

-Миний гарыг чангарахаас өмнө шөрмөсий нь огтолно гэнэ. Надад тайван өдөр хоног огт алга байна.

-Хөвүүн минь тайчууд чиний аминд хүрчихвий гэж санаа зовно.

-Тайчууд намайг би тайчуудыг зовлонд унагах болно. Монголчууд овог аймгаараа талцаж байлдсаар сульдаж байгаа бус уу. Хүчтэй нь хүчгүйгээ сөгдүүлж байна.

-Тэмүжин минь хаашаа одох гэв.

-Тоорил хаанд бараалхахаар очно. Эцгийн их анд надад лавтайяа туслах юм.

-Тайчууд газар нүхлэх шахам чамайг эрж байна. Болгоомжтой яваарай.

-Удахгүй Бөртийгөө авна.

Тэмүжинг эргэж харахад Бөртэ тэнгэрийн гэгээн цэнхэр дэвсгэр дээр зурсан юм шиг харагджээ. Бөртэ бүсгүй хээр хоносон сар мэт үлдлээ. Сар хээр хонов.

\* \* \*

Сар хээр хонохоороо холын холд хүйтэн хөндий харагддагийг Тэмүжин ажигласан юм.

Нүдэнд буусан дулаан том сар Тэмүжиний хувьд багын явдал байлаа. Нүд дүүрэн, гэр дүүрэн сартай байхад Есүхэй эцэг амар мэнд байсан үесэн.

Эцэг бие барсанаас хойш түүний дүр төрх ихэд холдож тэрхүү хүйтэн хөндий сар лугаа санагдах болсоныг Тэмүжин заримдаа гайхна. Эцгийн төрх холдох тусам Тэмүжиний омог асна. Тэмүжиний дотор Тэмүжин бус Есүхэй хөтлөн залдаг байлаа. Гагцхүү эцгийн төрөлх царай үргэлж үл үзэгдэх тул холдож байв. Тэгтэл эцгийн нь сэтгэл санаа дагана.

Тэмүжиний амьдрал бол эцгийн санааг гүйцээхийн төлөө юм. Эцэг Есүхэй баатар Тэмүжинг зандарна. Түүнийг эцэг нь зоригжуулна. Тэмүжиний дотор Есүхэй бат нот оршжээ. Тэмүжин, Тэмүжин бус Есүхэй баатар мөн. Есүхэй баатар Тэмүжин хөвүүнийхээ гар, хөл, зүрх, тархи болж яваа бус уу.

## Арванэгдүгээр бөлөг



*Өүлэн эхийн дэргэд Мээнэнбилэг, Хуагчин хэмээх ёс журамт бүсгүйчүүл  
түүнийг асран амьдарч хөвгүүдийг хүний зэрэгт хүргэв*



Хонгирадын толгойлогч Дэй Сэцэн аймаг овгийнхоо цэрэг эрчүүдийг дагуулж ирээд Онон мөрний бут, бутны дэргэд тарааж "чимээ дэгдвэл овгоороо цуглана. Чимээ сонсож бай" гэжээ. Торхоор архи ачиж ирээд тайчуудыг согтоож байв. Дэй Сэцэний охин Бертэд өндгөн сүй тавьсан боржигоны Тэмүжиний заяа төөрөг эцгийн нь үхлээс хойш гудайжээ. Болж өгвөл Тэмүжинд тусалж түүнийг тайчуудаас чөлөөлөхийг Дэй Сэцэн хүсчээ. Гэтэл Тэмүжин гэнэт учирч "Таргудай Хирилтугийн найрыг тарааж түүнийг өөрийгөө хаанд өргөмжлөхийг болиулмаар байна. Би Таргудайд сайн дураар биеэ тушаана. Тоорил хааны дэмжлэг надад тус болно" гээд Тэмүжин салж оджээ. Тэмүжиний санааг Дэй Сэцэн ойлгов.

Голын гүн цүнхээл ногоорон эргэлдэж цагаан өвс, хатсан навч хөвнө. Тэмүжин уснаас үл айна. Голын цаад эрэгт тайчууд цуглажээ. Онон мөрний хамгийн гүнзгий эргүүлэгийг сэлж

туулахдаа Тэмүжин, Хасар хоёул угаас гарамгай билээ. Тайчуудын цуглаан Тэмүжиний анхаарлыг гойд татсан юм. Тайчуудын толгойлогч бүдүүн Таргудай отог овогтоо төдийгүй бусад аймагт зар хүргүүлж "миний хаанд өргөмжлөгдөх ёслолд ирнэ үү" хэмээжээ.

Есүхэй эцгийг бие барсаны дараа Таргудай боржигончуудыг адшоо үзэж хар нутаг дээрээ хаяж нүүжээ. Тэгэвч Онон мөрөний сав газраар босоо ороолон мэт нүүдэллэн нутаглаж, хөөрхий Өүлэн эхийг хэдэн өнчин хүүхдийн хамт залхаадаг болжээ.

Тайчуудын Таргудай Хирилтуг боржигоны тугийг атгахыг санаархана. Дээд тэнгэрээс заяат Бөртэ чонын хөх сүргийн нэг хэмээн биеэ тооно. "Намайг хаан болохоор боржигон овогтон миний өргөөний хатавчинд сөхөрнө" гэж Таргудай Хирилтуг хэлжээ. Онон мөрний нутаг бэлчээр түүнийх гэнэ. Таргудайн хоншоорыг тас цохиж, хаанд өөрийгөө өргөмжлөх задарсан санаархлыг зогсоохын тулд Тэмүжин эргэж ирэв. Тэмүжингийн санаа бол эцэг Есүхэй баатрын санаа билээ. Дэй Сэцэн толгойлогчийнд хоцрох яг тэр үед Тэмүжин өөрчлөгдсөн нь эцэг Есүхэйд хувилсаны дохио. Тайчуудын цугласан ойн цоорхой, голын эрэг хавиас утаа савсаж, мах шарж идэх, хашгиралдан ярилцах нь үл тасармуй. Тэмүжин ус руу үсрэн орж нэлээд удсаны эцэст шовосхийн урсгал дээр гарч сэлсээр зэгс рүү ойртов. Тайчуудын харуул алсын бараа өлийн ширтэж, хол ойроос найрт ирэгсдийг тосон авч байна. Зүлгэн дээр дэвссэн цагаан эсгийний тэг дунд Таргудай хажуулдан хэвтэж, хөнхөр ёроолтой мөнгөн аяганд архи дүүргэжээ.

Зэгс дундаас ус савируулан гарч ирсэн Тэмүжинг харсан тайчууд цочирдсон дуугаар Таргудайд хандан,

-Тэр Тэмүжин мөн байна... гэж хашгиралдав. Тайчууд балмагдаж бас сэтгэл тэнийжээ. Тэмүжиний хувцас, үснээс ус дусалж тэрбээр ногоон дээгүүр алхаж Таргудайд дөхөв. Тайчуудын харуулын хоёр цэрэг түүнийг барьж авав. Тэмүжиний хүзүү, цээж тэвхийж, зоримог алхаатай гүдэсхэн эр болжээ. Есүхэй баатрын хөвүүнийг ийнхүү эрийн цээнд хүрсэнийг Таргудай гайхан харж "саяхан л нулмисандаа хахаж цацан эхийнхээ өмнүүр хөндөлдөж байсан бус уу" хэмээн бодоход хүрчээ.

-Тэмүжин чи юунд үхэлд дурлаж ирэв гэж Таргудай хардаж сэрдсэн байдалтай асуув.

-Та нар намайг алахыг хүссэн бус уу. Би Бурхан ууландаа бүтэв. Онон мөрний усанд нуугдав. Эцэст өөрийгөө тушаахаар шийдэв. Эх, дүү нарыхаа төлөө ингэж шийдлээ.

-Орох оронгүй болоод иржээ, чи! Намайг хаан болбол чи боол болно.

-Эцгийн морины нь цулбуур барьж явсан Таргудай

МӨН үү. Тэнгэр харж байгаа шүү. Өнөөдөр би баригдав. Маргааш тайчууд надад дагаар орох бус уу. -Их үгтэй Тэмүжинг хүлж дөнгөл. Таргудай сүүжилдэж хэвтсэн чигээр хашгирав. Тайчуудын хүрээ өргөжин тэлж Ононы цэлгэр тохойд адуу мал шаваарч, хүмүүс шуугилдана. Бурхан халдун уул , "> түүнээс үргэлжилсэн их нуруун дээгүүр үүл хөвж байна. ^ Уул, ус амгалан оршиж хүзүүнд нь хус модыг баглаж хусаар оньсолсон дөнгө зүүсэн Тэмүжинийг тайчууд асар, цацар дамжуулан! явуулж "хүн бүр Есүхэйн хөвүүнийг

доогло! Тэмүжинийг харааж зүх! Эмс охид хүртэл хялай" гэж байв. Боржигоны хааны хөвүүнийг эгцэлж харах зүрхтэн тайчууд дотор ховор нь гайхмаар. Асар, цацар тоолон хэсүүлсэний дараа Тэмүжинг авчирч тайчуудын толгойлогч Таргудайн өмнө сөгдүүлэв.

-Би Таргудайд үл сөгдөв. Онон хатан ээждээ сөхрөв. гэж Тэмүжин бардамнав.

-Чамайг өдөр бүр айл, айл хэсүүлэн зарцлах болно. Шөнөд хорьж хонуулна. Хэрэв өршөөгдөө гэж бодвол намайг монголын хаан болоход тусла. Чи хамгийн түрүүнд эцгийнхээ их анд Тоорил хааны санааг мэдэж надад тус бол.

-Хов зөөснөөс үхсэн минь дээр гэж би бодно. Таргудай толгойлогч юун том санаатай вэ.

Таргудай Хирилтуг туйлаас зэвүүрхэн улаан судастай цатгалан нүдээр Тэмүжинг муухай ширтэв.

-Зуны тэргүүн сарын арван долоонд чамаар тэнгэр тахина. Ясыг чинь ноходод идүүлж, нүдийг чинь хон хэрээнд ухуулна. Боржигон овогтоны буурь эзгүйрч тайчуудын хаанчлах цаг ирэв. Тэмүжин чамаас Бэгтэрийг хороосны төлөө ял асууж байна. Тэмүжин чиний борви тэнийхийг хүлээлээ. Эрийн цээнд хүрэнгүүт чиний омог ихдэв. Хэрэв чамайг үхүүлэхгүй аваас монгол аймгуудын хооронд хорт шүлсээ цацах нь. Чиний нүднээс айл хотлоороо дальтирч байгааг сая харлаа гэж Таргудай занав.

Таргудай бүдүүн биеэ дааж ядан завилж суугаад

Тэмүжинд дээрхи үгийг зөөж хэлэхдээ "Есүхэйн шийрийг

хатаах чонын бэлтрэг юм даа" гэж боджээ.

\* \* \*

Тэмүжин үхлийн дөнгөнд оров. Урьд өмнө нүүр тулж байгаагүй үхэл гэгчийг хөвүүн нүдээрээ харав. Тэрбээр хоёр хөлөө жийж, хавтгай дөнгөний доор суужээ.

Дөнгөний хавтан том ажээ. Хавтангийн үзүүрт гар үл хүрнэ. Тайчууд өөрсдийн гараас мултарсан атлаа эргэж дөнгөд орсон Тэмүжинг туйлаас гайхна. Тэмүжиний харсан үхэл нь дөнгийг тойрч суусан тайчууд байлаа.

Бөөрөнхий хацар, бөөрөнхий эрүүтэй, бөөрөнхий гэдэстэй Таргудай Хирилтуг ямагт сүүжилдэн хэвтэхээ больж Тэмүжиний зулгарсан хацар, дух, омголтож эвэршсэн уруулыг харна. Энэхүү бөөрөнхий Таргудай хамгийн эхлээд хутгаа сугалж Тэмүжиний дөнгөн дээр тавив. Тайчуудын бусад баатар, ахлагч нар түүний толгойг тойруулж хутгаа өрцгөөв. Тэмүжин хөвүүний толгой дөнгөний голд цухуйж байна. Олон хутга арзайна.

Тайчууд нэгэн зэргээр хутгаа авч дөнгөний хусанд нэгэн зэргээр зоолоо. Тайчууд нэгэн зэргээр амьсгаа авч хүүгтэл үлээж байлаа. Ямар найр болох бол гэхээс айж эмээх, сандарч мэгдэх хосолж тайчуудын хөдлөх бүрийг бусад овог отгийнхон тал талаас ширтэнэ.

Таргудай ёозгүй царайлна. Түүний царайны аясаар тайчууд ёозгүй царайтай. Дөнгийг хус цавчиж хийжээ. Таргудай Хирилтуг чангаар бахирч,

-Мах аваад ир гэв.

Дөнгөн дээр асгасан махны шүүс доошоо савиран дусна. Таргудай Хирилтуг хутганы үзүүрт мах хатгаж Тэмүжиний аманд ойртуулаад "май, хутгатай нь үмхчих" хэмээн тавлана. Тэмүжин хорсож хөмхий зуухад түүний гүрээний судас чинэрнэ. "Яг Есүхэй шиг шүдээ зуух юм" гэж Таргудай бодсоноо "энэ чинь арай

Есүхэйн сүнс биш биз" хэмээн маш хартай хүйтнээр сэтгэв.

-Архи авчир гэж тайчуудын нэг агсрав. Модон тагштай архинаас Таргудай цангасан мэт залгилав. Таргудайн бөөрөнхий хацар час улаан болов. Тайчууд махнаас огтлон үмхэлж, хэржигнүүлэн зажилж иднэ.

Тайчуудын нүүр, нүд улайж хүрээнтээд, эруу ам нь дарвайж, гарын салаагаар тос цайж бултайна.

-Тэмүжинд архи уулга гэж Таргудай Хирилтуг увайгүй хашгирна. Хус модон дөнгөний залтас цайрч, хуу үсэрсэн холтосны оронд хүрэн бор өнгө гарчээ. Хусны холтосны хагарсан зураасыг дагаж шүүс савирна. Дугуй хүрэн яр хусны тууш судлыг эвдэж болцуутна.

Тэмүжингийн аманд архи цутгахаар тайчуудын нэгэн ахлагч босоод хөвүүний зуусан шүдийг татаж чангааснаа уурлаж хутгаар гэжихөд тайчууд чарлалдан хөхрөлдөв. Тайчууд нэгнээ өөгшүүлж бахиралдан урт, богино хутга барьж гөрөөс төхөөрч байгаа юм шиг язганалдана.

-Наадахдаа архи уулгаач гэж Таргудай уцаарлав.

-Шүдээ зуучихаад амаа ангайхгүй юм. Завьжий нь хутгаар хэрчих үү. Явал зохистой вэ гэхэд Таргудай,

-Архи уухгүй бол сүү уулга гэлээ. Нэгэн тайчууд эр Таргудай Хирилтугийн бөөрөнхий хацарт хушуугаа нааж шивнэхэд түүний бөөрөнхий гэдэс оволзон хөдөлж агдагнан хөхөрч,

-Архи, сүү уухгүй гэвэл биднүүс шээсээ уулгана шүү. Тэмүжин чи шүд зуухаа боль гэж архиран хэлсэнээ зэвүүцэж царайгаа хувиргаад мөнөөх өмхий санаат тайчууд эрийг зааж "ёр дуудсан энийг гурав, гурав ташуурдана" гэлээ. Тайчуудын ноён нэгнээ ташуурдаж ёолох, орилох дуу хадаав. Гэнэт тайчуудын толгойлогч эргэлзэж больцгоо таануус. Юунаас болж Тэмүжингийн бахыг хангав" гээд өөх авч нохойд чулуудлаа.

Дөнгө дээгүүр мах, архи, хутга, сав суулга хөглөрчээ. Тэмүжин дөнгө тойрч суугаад хоорондоо архиралдах тайчуудыг үл тооно. Нуруун дундуураа ташуурдуулсан тайчууд эрийн нүд хялайжээ. Түүний нурууг хуга цохижээ. Тайчууд үл эвлэрэх болжээ. Занасан, зүхсэн харцаар Тэмүжинг ширтэнэ. Хөө наасан юм шиг Таргудайн хар сахал бувалзан хөдөлж,

-Хэн түүнийг хөнөөв хэмээн будангуйрсан сэтгэлийг илчлэн өгүүлэхэд "биднүүс" гэж сахал



үсэндээ баригдсан, архидсанаас нүдний судас нь тэлж улаан нүдэлсэн тайчууд тонгойв. Тайчуудын толгойлогч үхдэлийн хутгыг харна. Тэмүжиний эрүүний тушаа хусанд зоосон төө иштэй, төө илүү хутга үхдэлийн хутга байв. Дөнгөтэй хөвүүний шүдийг гөнжиж үзээд Таргудайн чихэнд бузрын үг шивнэснээс тэрбээр үхдэл болов. Тайчууд нохойноос хурц шүдтэй аж. Зовхиныхоо дээд хэсэгт содон бор үстэй шар нохой махнаас нүдээ үл салгаж шүлсээ савируулна.

Шавхруу горьдох нохойны нүд гөлтөгнөнө. Дөрвөн нүдтэй нохой Дэй Сэцэний хөхгардийн үр төл байлаа. Нохойн нүд Тэмүжингээс дөлнө. Тайчууд шуугилдан архи залгилна. Тэмүжингийн нүдийг домботой цай, овоолсон мах, аягатай архи далдалж хусан дөнгийг тавиур болгожээ. Яваандаа тэдний архинд согтсон нүдэнд Тэмүжиний толгойг анзаарах сөхөө үгүй болжээ.

Сүрэг шонхор найрлагсдын дээгүүр салхи татуулан нисч өнгөрөөд эргэж хуйлран эргэлдлээ. Таргудай шонхор шувууны эрчлэн нисэхийг үзээд "Энэ боржигончууд намайг амраахгүй юм байна. Шонхорууд Тэмүжинг эргэнэ. Шонхортой тугийг би атгамаар байх юм" хэмээн шувуудыг дагаж бодно. Таргудайн нүдний дотор Тэмүжин байв. Тэмүжиний нүдний дотор Таргудай байв. Таргудайн нүднээс Тэмүжин өөрийгөө олж харлаа.

Тэмүжин хөмсгөө зангидаж нүдэндээ хорсол хурж байгааг харав. Түүний ялигүй монхордуу хамар, тэгш хэмт нүүр, том мөртөө гурвалжиндуу зовхитой нүд нь Таргудайн нүднээс эзнээ ширтэнэ. Таргудай өөрийгөө

Тэмүжиний нүднээс олов. Түүний бөөрөнхий хацар, бөөрөнхий эрүү, хөө хар сахал, бөөрөнхий гэдэс Тэмүжинд олзлогджээ. Есүхэй баатрын хөвүүн дөнгөтэй атлаа Таргудайн эрх чөлөөг боомилно. Хэн нь олзонд байгаагаа ойлгох хэцүү болов.

Хэрэв Таргудай хаанд өргөмжлөгдөхийг хичээж байвал Тэмүжинг нүдээрээ олзлох байв. Тэмүжин хөвүүн Таргудайн lib нүдэнд олзлогдохгүй аж. Тайчуудын толгойлогчийн нүдэнд ОЛЗЛОГДОХ НЬ битгий хэл Таргудайг олзолжээ. Таргудай тэвчээрээ барж байлаа.

Яг энэ мөчид шонхор шувууны далавч сэржигнэв. Шонхорын сангас Тэмүжиний толгойн эргүүлэг дээр дуслаа. Сангасны цагаан ширхэгүүд тайчуудын нүд. 3) НҮҮР РҮҮ цацрав. Тайчууд цөм нүдээ аньжээ. Тэрхүү , "> хормонд Жамуха андын хүрээний зүгээс товшуур яруухан fc чичирхийлэв. Жамуха анд дохио өгчээ.

Тайчууд нүд, нүүрээ арчицгаан Тэмүжиний толгойн эргүүлэг дээрхи сангасыг шохоорхож,

-Тэмүжинг тэнгэрийн шувуу дуудлаа хэмээн нэг нь хэллээ.

-Дөнгөнд байгаа хүнийг дууддаг тэнэг шувуу юм даа гэж Таргудай бачимдав.

Таргудай Хирилтугийн найранд ирэгсэд дөнгөтэй Тэмүжин рүү ойр, ойрхон харцгааж Есүхэй баатрын хөвүүнийг тайчууд дорд үзэж тохуурхах нь гэсгээлтэй санагдана. Шонхор шувууны сангас Тэмүжиний эргүүлэгийг онож, далавчны салхи түүнийг өдөөж өгчээ. Тэнгэр өөд хөвүүн харав. Тэнгэр навчин хээтэй байлаа. Модны саглагар мөчир асар дээгүүр дамналдан

ширдэг, дөнгө, тайчуудыг шүхэрлэжээ.

Залуухан цагаан мөчрүүд тэнгэрт навчин хээ тавьж, тэнгэрээс сул унжиж хөдөлнө. Шонхор шувууны далавчны салхи хусны мөчрийг хөнджээ. Тэмүжинд бас хөндүүр байв. Тайчуудын харцыг тэсвэрлэж Таргудай Хирилтугийг мохоосон боловч Бөртэ охины эргэлзсэн царай тодорно. Бөртийг орхиод явахдаа хээр хоносон сарыг харж бэтгэртэлээ санасан сэтгэлд нь хар буужээ. Сар харахаараа Тэмүжиний сэтгэл сэмэрч, аж амьдралын зөрчил будлианыг тэмтэрдэг байлаа.

Шонхор шувууны далавчны тэмтрүүл зөнтэй юм. Шонхорын дүрс тэнгэрт үлдэж улмаар жижгэрсээр аж. Баатар Есүхэйн бахим гарт бат атгагдаж явсан шонхор шувууны дүрс юмсан. Боржигон овогтон шонхорыг зүрхэндээ сийлсэн юм. Шонхор шувуу тэдний амьд сүлд билээ. Шонхорын нүд хурц учраас энгүй талын хаяанд идээшлэх туулайг олж амжина. Шонхор шувуу болбол хязгааргүй хөх тэнгэрт дүүлж дүүгүүрийн чулуу мэт шунгаж туулайг хярахаас өмнө барьдаг байлаа.

Тэнгэрт дүрсээ үлдээсэн шонхор шувууны хойноос Тэмүжин харсаар ахуйд Есүхэй эцгийн хувилгаан төрх хөвүүндээ шингэж байна. Залхаан цээрлүүлэхээр суулгасан Тэмүжин тайчуудын дээрэнгүй араншинг хүлцэж, мах шөлний үнэрт тэсэхүйеэ бэрхээр зүсэгдэх ходоодоо, мартаж чадав. Ходоодны гашуун шүүс аюулхай дээр тунарна. Тайчууд хөлгүй найранд умбахын өмнө уруд, жүрхэн, хонгирад, найман овгийнхонд Тэмүжингийн доройтсон царай зүсийг харуулахаар зар тараажээ.

Хүдэр чийрэг Тэмүжин нүдээр олзлохын аргагүй ханхар эр болжээ. Тайчуудын задгай асарт цугларсан овог аймгийнхан хусан дөнгө дээр овоолсон идээ, шүүс, дөнгөнд шаасан хутга тэргүүтнийг үл огоорч Тэмүжин хөвүүний гилэлзсэн хар хүрэн үс, гурвалжиндуу зовхин доорхи аймшиггүй хүрэн нүдийг харцгаав. Тэнгэрт тахигдахаар Тэмүжин юунд ирэв хэмээн бусад овгийнхон гайхна. Түүний толгойн эргүүлэг дээрхи шувууны сангас бүгдийг цочоов. Таргудай долоовор хуруугаар тэнгэр чичилж,

-Шонхорын сүрэг эргэж нисвэл харваж унагагтун. Мэргэн харваачид шагай хээр морь өгнө гэж амлав.

-Та амлав. Харваад гартвал унаа морьдоо танд өгсүү хэмээвэл Таргудай Хирилтуг баясан хөөрч,

-Тэнгэр намайг гэрчилнэ гэж их үг хэлэв.

Огт чилж, залхахгүй сууж буй Тэмүжинг тайчууд ихэд гайхаж дөнгөн дээр суув. Нэг тайчууд овогтон дөнгөний өнцөг дээр дэвсэж "өршөөл гуйхын оронд үхлээ эрсэн Тэмүжин чамайг яая даа" гэв. Дөнгө огт хөдөлсөнгүй. Дөнгө дээрхи мах шүүс, архи цэгээ, домбо сав ойчиж унаагүйгээр үл барам холбирч ганхах янзгүй байв.

Таргудай Хирилтуг дөнгөний доогуур шагайж харав. Дөнгөний дороос жаран зургаан могой хавтгай толгойгоо нааж, сүмбэн хэлээ гозолзуулна. Могойны шар нүднүүд Таргудайг шар гэрлээр сүлбэж хэсэг зуур тэрбээр хэвтэв. Жаран зургаан могой хэдийд хуран чуулсаныг хэн

мэднэ. Тайчуудын толгойлогч үхсэн мэт хэвтэнэ. Таргудай Хирилтугийг тайчууд өргөж босгов. Боссон Таргудай чарлаж газар дэвсээд,

-Тэмүжинг эндээс зайлуул гэж тэрээр хашгирав. Тэмүжин босов. Үхсэн тайчууд эрийн хутганаас бусад юмс өнхөрч уналаа. Цагаан эсгий ширдэг дээр бор могойнууд гулсана. Тайчуудын нүд орой дээрээ гарч алхам, алхмаар ухарцгаана. Могойн чуулган хүрээгээ тэлнэ. Тайчууд том асраа чирч гүйлдлээ.

Морьдын эмээлийн бүүрэг бүрт цагаан шонхор шовойжээ. Ташуурт шонхор өлгөөстэй, мөчир болгон шонхортой болжээ. Цагаан шонхор шувуу хэдийдээ хаанаас нисч ирэв ээ. Могойны долгионд шидэгдсэн тайчууд мөлхөж байна. Цагаан шонхор шувууны далавч хуй салхи үүсгэж тайчуудын малгай, гутал ховх сорогдов. Тайчуудын буудалласан ойн цоорхойн ногоон нугад илбийн явдал болж өнгөрөв.

Ташуур барьсан Таргудайд тайчууд овгийн эрэлхэг баатар "лус савдаг хилэгнэв" гэхэд тэрбээр үл тоон "лусын хаан намайг сорилоо. Одоо шагай хээр морины толгойгоор лус тахиж дээд тэнгэрийг тайтгаруулбал зохино" гэв.

Зөөж барьсан асарт тайчууд тухалж, өлссөн нүдний өмнө хооллохоос болгоомжлохыг хөөрөлдөнө. Дөнгөнд зоолттой хутгыг авчруулж газарт хатгахад гүндбалын ургамлын хөх судас таарч ус олгойдож Таргудай шалба норжээ. Бүх юмсыг тайчуудын толгойлогч тээршааж байв. Үхдэлийн хутгаар майхнаа цоо бүлэв.

## Арванхоёрдугаар бөлөг



*Урианханы Харлагтэх бөөгийн удам Цагаанбух, Халзанбух хэмээх зайрангууд*

*Тэмүжингийн тухай тэнгэрийн айлдварыг монголчуудад хүргэсэн билээ*



Олон хоног уул, тайга, гол мөрний ай саваар бэдэрч, адууны шагайнаас ханасан цус, газар хөглөрсөн жимс төдийхнөөр хооллож явсан Тэмүжин ихэд цангаж, өлсөж байв. Тайчуудын Таргудай түүний хар булган дахыг дэрлэжээ. Булган дахны сорлог үс наранд гялталзана. Бөртний инжинд Дэй Сэцэний өгсөн дах мөн авай. Тэмүжин дахны тухай бодох зуур цээж нь давчдан, ядарч туйлдсан тул дотор нь муухайрна. Тэмүжиний хоёр мөрөн дээгүүр дамналдуулан тавьсан хусан дөнгийг нарийн мөчрөөр холбон баглаж өнцөгт нь модоор оньсолжээ. Тэрхүү том гэгчийн дөрвөлжин мөглөнгийн дундаас Тэмүжиний толгой цухуйна. Тайчуудын толгойлогч гарын доорхи баатар, цэргүүдээ Тэмүжинг дахиад тойруулан суулгажээ. Тэмүжингийн толгойг цухуйлгаж хийсэн хавтгай дөнгөн дээр чанасан, шарсан мах овоолж тайчууд тал бүрээс нь айдастай идэцгээнэ. Тайчуудын зарим нь харц буруулан гөлтгөнөнө.

Тайчууд мах идэж байхдаа хурц цагаан шүдээ ярзалзуулан инээлдэж байв. Махны үнэрт Тэмүжиний ходоод халуун шатаж тэрхүү доромжлолыг тэсч ядан байлаа. Идээ цагаа, шүүс болсон найрын хөлд Онон мөрний жимст тохой мансуурч Тэмүжин тэлчилнэ. Таргудайн нэгэн боол Тэмүжинг сэрүүцүүлэх санаатай түүний толгой дээр цэгээ асгалаа. Модон шанагаар асгасан цэгээ хөвүүний цээжийг сэрүүцүүлэхэд тэрбээр мөрөө хөдөлгөв. Хусаар хийсэн мөглөнгийн дээр тавьсан мах газарт өнхөрч унав.

Хөлчүү тайчууд хусны цагаан залтас рүү хутгаа зоож, -Есүхэйн хөвүүн үхээгүй байна хэмээн тавлаж хөхрөлдөнө.

\* \* \*

Хавтгайрсан найрын үеэр морьд уралдаж, бөхчүүд барилдаж байлаа. Адууны салхинд харцуулын ам хатан сум тавина.

-Тэмүжин хөвүүнээр тэнгэр тахина гэв үү.

-Боржигсн овог сүйрэх нь ээ. Тайчууд яасан хонзон ч юм бэ. Есүхэй баатрын үед ах дүүс шиг байсан бус уу.

-Тэмүжинг үхүүлж байж Таргудай хаан болох санаатай. Таргудай айжээ

-Хэнээс...?

-Тэмүжин өслөө шүү дээ. -Тэмүжингээр зугаацаж байна.

-Таргудайн найран дээр Тэмүжин өөрөө ирлээ. Таргудай согтуу байна. Олон овгийн хүрээ нийлжээ. Есүхэйн хөвүүнийг өмөөрөх хүмүүс вий дээ.

-Хонгирадууд ирчихсэн байдаг...

Морьд багширч холоос гурийлах дуулдана.

\* \* \*

Тэмүжиний хүзүүнд багласан хусан мөглөн тийш харсан Бөртийн нүд нулимсаар дүүрчээ. Бөртэ энгийн дээл хувцастай авч түүний гуниглангүй нүд, нарийхан бэлхүүс, түрэнгэ махлаг цээж харсан болгоны харааг булаана. Бөртэ голоос ус авчирч бортогоо султгаад тайчуудын ноёны дун цагаан дэвсгэр эсгий рүү еширхөн харав. Тэнд хавтгай мөглөн мөрлөж сөхрөн сууж байсан Тэмүжин алга болжээ. Түүнийг бургасны захад аваачиж дэргэд нь харуул зогсоожээ. Бөртэ бүсгүй эцгийнхээ махлаг зузаан нүүр өөд харав. Дэй Сэцэн дорно зүгийн хээ хуар бүхий вааран аяганаас цэгээ залгилж байна. Дэй Сэцэний нүд бургас руу өнцөгдөн чиглэж "Тэмүжин хөвүүн тэсч бай. Удахгүй Таргудайн найр тарна. Таргудайн найрыг тараана" гэж хорсолдоо шатаж байв.

Бөртэд эцэг нь "Жамухад хэл хүргэхдээ осолдов. Тэмүжинг сулласны дараа хамтдаа яваарай" гэж хэлжээ.

Дэй Сэцэн асар уудам тэнгэрт алгуур хөвөх үүлсийг харж хонгирадын тал нутагт бороо асгана даа хэмээн сүслэн бодож суув- Бурхан халдуны оройгоос тасарсан үүл Цэгцэрийн шар талд бороошдог ажгуу.

\* \* \*

Товшуурын аялгуу Онон мөрний мойл жимсийг өнхрөн унатал уянгалан урсаж байл аа. Товшуураа босоо барьж инээмсэглэсэн Жамуха,

Хуур татаж

Дуугаа дуулав

Хундага өргөж

Хуримаа хийв...хэмээн нэгэн хэмээр цээжний түрлэгээр хахиран дуулна.

Аялгуут товшуурын эгшиг адуу малыг хүртэл толгой сэжихэд хүргэж, чимээгүй багил шугуй дээгүүр өвгөн бүргэд эргэж эхлэв. Жамухын товшуур алсаас ирсэн гийчдийн эртний явдлыг санагдуулна. Хацар сайт эмс, хүүхнүүд дур булаан мишээлд авгаж, харчуулд хөтлүүлэн Онон мөрөний шугуйд шургаж хэвлийдээ монгол удмыг сааж байв. Сорхоншарын охин Хадаан хоёр ахынхаа дунд зогсоод ийнхүү өгүүлэв.

-Тэмүжин яана вэ. Би Таргудайгаас айж байна. Айсан хүн адуу хөөнө. Ичсэн хүн хүн ална гэдэг. Тайчууд согтжээ. Ясаа мөлжиж дуусчээ. Одоохон унтана. Та хоёр Тэмүжинг суллаж явуул.

-Чулуун чиний морь бэлэн үү.

-Шугуйд уяатай байгаа. Өчигдөр юүлсэн гал шарга цуцна гэж үгүй. Тэмүжин хөвүүнийг хаа бол хаана хүргэнэ. Гал шаргаа сойчихсон.

-Хадаан дүү эцэгтээ тус бол. Биднээс хөндий бай. Хар авахуулж магад.

-Тэмүжингийн анд Жамуха яасан уяхан хүн бэ. Аль эртнээс товшуурдаж байна.

-Мэдээтэй байдаг юм шүү. Нэг юм болно. Товшуурын эгшиг учиртай бус уу.

Дэй Сэцэн дураар жиргэх болжморыг ехөөрдөн харж байснаа цэргүүдийн аягыг архиар дүүргэж "тогтоосугай" хэмээн уянгалуулав. Цэргүүд аягатай архийг хүд хүд залгилж бараад Дэй Сэцэн тийш "сөгнөтүгэй" гэж хариу гүвгнэцгээнэ. Цэргүүд архи ууж Дэй Сэцэн сөгнөсөөр ажээ.

Цэргүүдийн зарим нь эвшээж байна. Өдөржин найрласан өвгөд тэрлэгээ өрөөлдөн, эмээлээ тэрлээд тэрийжээ. Тайчуудын анхаарал сарниж ой шугуй дотроос "маргаашийн мандах нарнаар Тэмүжинээр тэнгэр тахина. Тэгээд Таргудай Хирилтуг хаан болно..." хэмээн орилолдоно. Товшуурын чавхдас гансарч, хааяа зүрхний угт хүрч хилэнгийн дөл асаана.

Инээд баясал дүүрэн Жамухын нүд очтон хуурай гялалзана.

\* \* \*

Дэй Сэцэн бортоготой архийг барьж согтуу цэргүүдэд харуулаад "Гуравтаа нэрсэн охь ийм байдаг юм. Наашаа харагтун" гээд хөх дел дээр дусаахад улаан гал бадамлан цорсхийв. Цэргүүд, барлагууд, эмс хүүхнүүд галыг хөгжөөхөд дагалдан бахиралдаж инээлдлээ. Дэй Сэцэн дэргэдээ зогсож буй Бөртэд,

-Жамухад цаг боллоо гэж хэл. Тэмүжиний харуулд аягатай архи барь гэв. Тайчууд хөглөрчээ. Өндийж боссон зарим нэгэнд нь шивэгчин бүсгүйчүүл архи уулгаж байна. Тайчууд ууж барахааргүй архи, цэгээнд умбажээ. Бөртэ, Жамухад хэл дуулгав. Жамуха товшуурдсаар байна. Жамуха ийш тийш харж товшуураар хөдөлгөөн үзүүлнэ. Чулуун, Чимбай хоёр Жамухын дохиог ойлгожээ.

Тайчуудын сойсон морьдын хэвлий доогуур Жамуха, Чулуун, Чимбай нар мөлхөн, хутгаараа эмээлийн олом жирмийг тас тас огтолно. Морьдын даруулга хөнгөрөхөд хөлс нь живхэрч, бие тавирсан адгуус байж ядан эрэгцэнэ. Бөхчүүд барилдаж дуусаагүй байв. Бөхчүүдийн тэнд дугуй тойрог үүсч харчуул мэх заан хашгиралдана.

Дэй Сэцэн аяга болгоныг архиар дүүргэхийг шивэгчин бүсгүйчүүлд шаардаж "ам үлдээлгүй цутгаад бай" гэж захирамжлав.

\* \* \*

Бөртэ тайчуудын харуул хавьцаа очлоо. Түүний барьсан аяга, бортоготой архийг харсан цэрэг "наадхи.. асга, ууж болохгүй" гээд асрын өмнө эсгий олбог дээр суусан толгойлогчоо харсанаа "өнхрөөд өгсөн байна. Алив..." гээд аягалсан архийг хөнтөрч Бөртийн сайхан царай өөд гөлрөв. Бөртэ мөрөөдөмтгий нүдтэй сахиулыг мишээлээр мялааж "бортогонд байгаа шүү" гэвэл сахиул "хийчих, дүүргэх" гэв.

Тэмүжин Бөртийг ширтэнэ.

\* \* \*

Тайчуудын найр яваандаа боржигончуудын найраар өндөрлөхөөр болчихсон байв. Тэмүжин ухасхийн босч хүнд мөглөнгийн өнцгөөр сахиулыг дэлсэхэд тэрбээр тэрий хадан ойчив. Хус модон мөглөнгийн баруун, зүүн өнцөгт буй оньсыг Бөртэ мултлав. Хавтгай мөглөн Тэмүжиний өвөр, нуруу руу салж уналаа. Тэмүжин суллагдав. Гэнэт морьд янцгаалдаж морьдын төвөргөөн өвсний тоосыг гөвөв.

Ононы хөндийгөөр дүүрэн чимээ шуугиан үүслээ. Өнхөрч унасан хелчүү харуул "Тэмүжин хайчив" хэмээн бархирав. Тайчуудын цэрэг эрс эмээлтэйгээ газарт өнхөрч байв.

-Тэмүжинг бариарай гэж хашгирна.

Шугуй дотор гал шаргын нуруунд Тэмүжинг үсэрч мордоход Чулуун,

-Мойлын жим дагуу хүлээж бай гэж хэллээ. Тэмүжин мориныхоо эргэцээн дунд "Бөртийг авчраарай" гэж сануулав.

\* \* \*

Бөртэ нь Тэмүжин лүгээ зорьж явна. Бөртийн араас Жамуха, Чулуун хийгээд арваад морьтон цувран Онон мөрөний хөндий тайчуудын хараал зүхэл, хашгираанд донсолж авай. Бөртийн эмээл дээр хар булган дах ганзаглаанд даруулаастай харагдана. Таргудайн сүүжин дор байсан дахыг Чулуун булааж аваад түүнийг эргэж харах хооронд магнай дээр нь ташуур буулгаж газар хэвгүүлжээ.

Таргудай бол Есүхэйн хатан Сочихэлийн ах юм. Есүхэйн үед нэр төргүй тарган цэрэг явсан тэрбээр Есүхэй баатрыг бие барсан өдрөөс хойш хамраа сөхөж "миний гурван үе Есүхэйн цулбуур атгасан бол миний гучин үе боржигоны хөвгүүдээр цулбуураа бариулна" гэж аархжээ.

Тайчууд овог боржигоны хаанд зиндаа дутаж байв. Таргудайн удам нүгэлт хар гөрөөчин Насантээрэмээс эхтэй билээ. Лус савдгийн хорлол болж баавгайд тархиа мулт алгадуулсан Насантээрэм сэг сэвсгүй алга болсон юм. Гөрөөчний хөвүүн Жигүүр эцгийн хойноос орж тайгын амьдралтай болжээ. Жигүүрээс хүү, охин хоёр төрсөн нь бүдүүн Таргудай, хацар гоо Сочихэл билээ.

Таргудай хоёр хүүтэй. Тээрэмчин, Гөрөөчин нэрт хөвгүүд тайчуудын баг цэрэгт шогшиж явна. Харин Сочихэл хатнаас төрсөн Бэгтэр хов, хор хоёрт хутгалдан ясан гичирт суманд зүрхээрээ сүлбүүлж үхсэн билээ. Бэлгүтэй нь боржигоны хот айлд Тэмүжин ахынхаа үнэнч анд болон өсч байна.

Таргудай тэр шөнө ухаан орохдоо модны ур мэт бөндийсөн духаа атгаж үзээд "Есүхэйн хөвүүний алгыг тэнийлгэж үзэх минь яав" хэмээн өөртөө гоморхон бахирчээ. Тэмүжиний баруун гар Таргудайд онцгой хэрэгтэй байсан юмсанжээ.

\* \* \*

Мойлын жим хэмээх тойром дунд Тэмүжин нөхдийн хамт хооллоно. Бөртэ бүсгүй Тэмүжиний шалбархай дээр эмийн шороо түрхэж өгөв. Мойлын жимийг тайчууд мэддэг юм. Боржигоны хот хүрээ, тайчуудын хот хүрээ хаяа залган буудаллаж, тайчууд Есүхэй баатрын далбаан дор захирагдаж явах үед тугал унага мойлын жим рүү алдагдаж, эргэж гарцаа ололгүй олон хонодог тул хөвгүүд ирж малаа авдаг байв.

Наху баяны ганц хөвүүн Боорчи итгэлт анд Тэмүжинийг тайчууд хөнөөхөөр оролдож буй сургаар ирсэн аж. Боорчийн эцэг Наху бол тал хээр нутгийн нүнжигтэй баян билээ. Наху эхээс арвуулаа төрсөн боловч түүнд ганц хөвүүн заяажээ. Эхнэр Бөөрөлзгөнө дотор хуучтай тул давсыг цээрлэж гагцхүү цагаан хужирыг цай, хоолондоо хэрэглэсээр хөвүүнээ өсөхийг үзжээ.

Эцэг, эх нь Боорчийг боржигон аймаг руу явна гэж зүтгэхэд "Есүхэй бол цуутай баатар хүн.



Тийм хүний хөвүүн лавтайяа эцгээ дуурайна. Эр хүний нөхөрлөлийг үхэл үл салгах тул Тэмүжин лүгээ явсу" хэмээв. Боорчи эцэг эхийн үгийг Тэмүжинд дуулгахад "найман шарга морио чамтай цуг олж найдвартай нөхөр юм байна гэж бодсоноос хойш Боорчи чамайг ирнэ хэмээн хүлээж байлаа.

Миний баруун гарт баруун гар минь болж явсу" гэв. Тэдний дунд жалайр овгийн Мухулай бас байв. Мухулайн эцэг Гүнгоо. Гүнгоогийн эцэг Цантай бөлгөө. Цантайн элэнц, хуланц Байдрагийн голоор өгсөж, уруудан нутаглаж говийн элсэнд ясаа тавьжээ. Хэдэн үеэрээ цэргийн эрхтэн бөө байсан гэдэг. "Намайг итгэж ирсэн Мухулай анд миний зүүн гарт зүүн гар минь болж зүтгэ" хэмээн Тэмүжин эрүү, хацрынхаа шалбархай дээрхи шороон эмийг даран байж өгүүллээ.

Дэй Сэцэн эрт нэгэн цагт эцгийнхээ үлдээсэн гурван тугалтай үнээг нэг шөнө чононд идүүлж хоосорчээ. Тэгээд Хатан гол орж шавар гэрт суудаг, ногоогоор хооллодог Лууван хэмээх хатингар зүрчид өвгөнийд хамт суудаг болов. Нааш цааш сүлжин явах худалдаачны нэг Монхормэндийг дагаж Алтан улсын Ихэр балгас орж эргээд Алтайн уулс хүртэл бядуучлан тэнэжээ. Монхормэнд овсгоо сүйхээтэй тул торго, ваар, модон сав суулга, ангийн арьс, үс наймаалсаар овоо хөлжиж мал ахуйтай болжээ. Монхормэндийг бие барахад гашуудан уйлж зогссон Дэй Сэцэн хонгирад нутгаасаа эхнэр авч, их замын уулзварт хөрөнгө зоорьтой, нэр нөлөөтэй язгууртан болсон бөгөөд аймгийн толгойлогч болов. Монгол аймгууд нэгнээ байнга дайлах тул цэргийн багахан хүрээ байгуулж, хавь ойрын хөвгүүдийг цэргийн эрдэмд бэлтгэж хатуужил суулгадаг байв.

Дэй Сэцэн, Тэмүжин хөвүүндээ "Чамд үхэл ирсэнгүй. Чамд хаан суудал ирэв. Тэгэхээр хөвүүн минь хичээгээрэй" гэлээ.

Мойлын жим хэмээх тасардаггүй угалз мэт харгуй дотор бөөсөн чинээ биеэ бээцийлж, амиа аргацааж явсан Тэмүжин бус Есүхэй баатрын сүнс зогсож байв. Түүнийг тойрсон нөхөд нь хэдийбээр цөөхүүл хэрнээ омог дүүрэн итгэл төгөлдөр, найрсаг, гарт атгасан шагай мэт нэгдэлтэй бөлгөө. Тайчууд Тэмүжиний араас нэхсэнгүй сул орхисон нь маргааш, нөгөөдөр ирэх үйлийн үрээс жийрхсэн хэрэг аж. Тэмүжин мойлын шугуйд гарынхаа алгыг нэг харжээ.

Хэн ч үл мэдэх, хэзээч үл ойлгогдох алганыхаа хээг Тэмүжин сайтар тунгаадаг байж. Гараа атгаж Жадраны Жамуха андтайгаа духаа нийлүүлж тэдний амьсгалсан агаар биеэс биед нь нэвчих үед тойрмын зах руу цувран мойлын жимийг сүлжлээ.

Онон мөрний эргээс холдож тал дундуур давхин одож буй Тэмүжиний багийг адуун сүрэг дагана. Адууны тоос тэнгэрт пургин хатингар өвсийг бүрхэн бууж, намар цагийн тасархай цоохор үүл Бурхан халдуны оройгоос урагшаа сунажээ. Морьтонууд Өүлэн эхийн нутгийг зорино.

Жамухын ар нуруунд өлгөөтэй саадаг дүүрэн сумтай бөгөөд түүнийг чагталж үүрсэн товшуурын толгой цухуйж морины хатираанд улам нягтарна. Ямагт инээж байдаг Жамуха багийнхаа түрүүнд эрчлэн давхиж байлаа. Түүний араас Тэмүжин, Бөртэ хоёр зэрэгцэнэ. Тал хээрийн салхи хойноос бус урдаас эргэн үлээж морьтнууд хөндлөнгөөрөө зэрэгцсэн шовх хүрэн уулын бэлээр дамнан орлоо.

Бөртийг авчирсанд Өүлэн эхийн шаргал царай нялхран мишээж,

-Есүхэй баатрын голомт бүтэн боллоо гэж өгүүлжээ. Түүний гэрэлтсэн царай дээгүүр тунгалаг нулимс бембөрөн унаж "Сочихэл эх тайчуудаас ирэв" хэмээн Тэмүжинг хэлбэл Бэлгүтэй санаа алджээ.

Үдэш боржигоны хүрээнд хөтөлгөө морьтон ирсэн нь урианханы Жарчудай дархан бөлгөө. Жарчудай дархан бол урианханы бөө Цагаанбух, Халзанбух нарын удмын нэгэн бөлгөө. Шар дээлт Халзанбух бөө Бурхан халдун уулын хормойд дээлээ үлдээж, дээл нь жамъянмядаг хэмээх далбагар том шар цэцэгт хувилж ургасан тэр жилээс гурван жилийн өмнө Жарчудай дарханы гэрт Зэлмэ хөвүүн төржээ. Түүнээс хоёр жилийн цаана Ононы Дэлүүн болдогт

Тэмүжин хөвүүнийг мэндлэхэд урианханы дархан Жарчудай булган өлгий бэлэглэж эцэг Есүхэйд хожим Зэлмийг Тэмүжинд өгөмз хэмээн амласан билээ. Тэрхүү амласан ёсоороо дарханы хөөрөг тулмаа үүрсэн Жарчудай хөвүүн Зэлмийг дагуулан ирж Тэмүжиний өмнө сөгдөөд,

-Зэлмийг өгнө хэмээн эцэг Есүхэй баатарт тань амласан билээ. Зэлмэ хөвүүнээр үүдээ сөхүүл, эмээлээ тохуул. Энэ биеийнхээ итгэлт анд болгож авсуу гэлээ.

Боржигоны хот хүрээнд айл амьтан нэмэгдэж буйд их бэлэгшээж "Зэлмэ минь дайнд туг болж, урагшлах тулаанд уриалан дуудаж яв" гэхэд Зэлмийн хөх царай ер бусын дурлийж Тэмүжиний нүд рүү онийж харав.

Маргаашийн мандах нарнаар Бурхан халдун уулын лус савдагийг баярлуулж Боржигоны Тэмүжин хаан Бөртэ хатантай ураглан хуримлав.

Уулын хавцал уруудан нүүдэл хөвөрч явна.

## Арвангуравдугаар бөлөг



*Мэргид, татаар, тайчууд Тэмүжинг хорлох,  
хороох арга сэдэвч тэр бүрийд дээд тэнгэрт үүнийг ивээж байлаа*



Тэмүжин, Бөртэ хоёр дөрөө харшуулан амрагийн явдалд ханасан нүдээр биенээ ширтэнэ. Цулбуураа зүүн гартаа хумиж атгасан Тэмүжин тэгш уужим самсайт хамраараа мангирын үнэрт найрсан агаар амьсгалж, гурвалжин зовхит том нүдээр хад асга шажигнуулан дэгдэх гөрөөсийг харж байна. Махлаг ягаан хацарт нь инээмсэглэл хурж, цэцэг хандалж угаасан үсээ сүлжиж гөрсөн Бөртэ дөрөөн дээрээ өндийсхийн хясааны ёроолд биеэ агдлан бүлтэгнэх туулайг үзжээ. Тунгалаг уст уулын горхи чимээтэй урсана.

Тайчууд хаашаа нүүж одсоныг хурмастын үүл мэдэх буй за. Боржигоны хот хүрээ сэргэснээс хойш тайчуудын сураг алдарч өвс бэлчээр, усны соргогийг түрүүлж талхалж боржигончуудыг хөсрий нутаг хэсүүлдэгээ болив. Туулай дэгдэн дүүлж байна.

Горхи хоржигнон уулын гол руу цутгаж байна. Боржигоны нүүдэл зогсож тэнүүн дэнж дээр буулаа. Өүлэн эх модон саахуундаа ус дүүргээд гэр өөдөө харна. Тэмүжиний их гэрийн үүд буулгаастай харагдана. Эхийн дээл мөрөөрөө гандаж цайсан боловч урьдын гоёмсог дэгжин

засал зүүлт хэвээрээ байлаа.

Сэмэрсэн хормойны нөхөөс хүр хорхой шаглаж хөвөрдсөн мэт донжтой аж. Өүлэний дээлийг олхонуд овгийн бэргэн Мээнэнбилэг нөхөж хөвөрдсөн билээ. Мээнэнбилэг бол Өүлэн хатны эцгийн дүү Мэргэншагайн охин бөлгөө. Мэргэншагайн хөвүүн Өндөрмэлтэн хэмээх дуучин эр их усны цаана орших нутагтаа буй. Мээнэнбилэг хааяа ахаа дурсаж Өндөрмэлтэнтэйгээ уулзахыг хүсч байгаагаа хэлэх авч боржигон овогтоныг дайрлага дайрсан цагаас дуугаа хураажээ.

Асрагч эх Мээнэнбилэг Тэмүжиний их өргөөнд ойртон очсоноо зогтусав. Гэрт залуу хосын гүн шөнийн явдал үргэлжилж тачаалын амтат гиншилт Мээнэнбилэгийн хөлийг тушжээ. Мээнэнбилэг барьж явсан булгийн цэнгэг усаа өлмийнийхээ тушаа орхиод буцав. Тэмүжин хөвүүний аз жаргал бол Мээнэнбилэгийн хувьд хэзээч хугаслаж үл болох баялаг бөлгөө. "Тэмүжиний хөвгүүд, охидыг би асрах хувьтай хүн" хэмээн Мээнэнбилэг эх, Өүлэн хатанд хүүрнэж байснаа саналаа. Ийм бас нэг санаатан бөгөөс Хуагчин хэмээх эхнэр юм.

\* \* \*

Өүлэн эхийн бардам тайван харц Мээнэнбилэгт хүч сэлбэх ажээ. Өүлэн "өглөө ниссэн хараацай идэшээ зуугаад буцаад ирлээ" гэхэд Мээнэнбилэг "хадат хясаагаар дүүрэн уран хараацайн үүр буй. Эм нь үүрээ манаж, эр нь идэшээ базаадаг бус уу" гэв. Эхнэр авсанаас хойш Тэмүжин гэр сахих болж Өүлэн эх түүнд зовнин байх бүлгээ.

-Хөвүүн тайвширч буйд зовно.

-Өүлэн хатантан амгалан байтун. Хөвүүн сэтгэлийн амрагтайгаа үхлийн ирмэгт тулж уулзсан нь нэн сайхан. Эдэнд маань дахиад тайван амьдрах өдөр, хоног хэчнээн бол. Би битүүхэн зовох боловч сайн зөнтэй байна.

-Хөвүүний зөөлөн араншин арилжээ. Тэр уг нь эртэч билээ. Үгэндээ харам билээ.

-Зүүн цөөрмийн галуу тайчуудын нутгийн зүг нислээ. Ноход боргох нь багаслаа. Ямар учиртай вэ хатаан!

-Мээнэнбилэг минь энэ уулын лус савдаг Тэмүжин хөвүүнийг өршөөлдөө авсан бус уу.

Уулын сүүдэр хүүшилж, цэцэгний өнгө бүдгэрэхэд Тэмүжин нөхдийн хамт хэжлүүр замаар бууж ирлээ. Цөмөөрөө алсан хандгайнхаа махыг хувааж модонд шорлож мөрлөсөн байлаа. Цавчих, гардан тулалдах, харвах сургууль хийхдээ хясааны замаар бууж хэнз ногоо бүхий цөөрмийн захад очдог нь боржигончуудын нууцлаг бэлтгэл болно.

Хэдийдээ ан авд одоод ирнэв.

-Хөвгүүдийн хорсол зангирч байгаа бус уу. Хөвгүүд Тэмүжинг харж байна. Тэмүжин тал нутгийн монголчуудын толгойлогч болжээ.

-Миний хөвүүн овоо доо.

-Бөртэ шаламгай, нүүрний баясгалан гойд. Түүгээр барахгүй харвахдаа гарамгай гээч.

-Мээнэнбилэг бэргэнтэн Бөртэ хатны хөл хүнд үү, аль эсвэл хөнгөн үү, анзаарав уу?

-Хатан та надаас илүү гярхай бус уу...Хацрын сэвх Бөртийг чимэх боллоо.

Намрын шар навч Бурхан халдуны ой тайгыг өвч хучив. Онон мөрний бургас цагаарч, хөх мөчрүүд хээ мэт сэрийж байвч жимсний төгөлүүд улаан, бор, хүрэн, шар, цэнхэр алагтав. Цаг улирч бороо хур татраад нарны элч өдөрт шатаам халуун болж, шөнөдөө сэрүүссэн байлаа.

Бөртэ бүсгүй Тэмүжингийн булчинлаг цээжийг дэрлэн хэвтэж байхдаа "намайг эхлээд хөвүүн төрүүлж өгөөрэй гэж ээж захисан. Тэгвэл хааны удам залгах хөвүүн төрүүлсэний төлөө чи боржигон аймагт тоогдох болно. Тэргэл сартай шөнө ээлтэй гэж хэлсэн"

-Аавынхаа захиасыг мартсан уу.

-Мартаагүй ээ. Аав дайн дажинд дургүй билээ. Эр хүн сумны бай болно гэдэг. Аав бас эр хүнийг илдний ир шалгадаг юм гэсэн. Хөвүүн төрүүлбэл тоогдохоос илүү шаналах нь эх хүний хувьд хэцүү санагдана.

-Чи надад олон хөвүүн төрүүлж боржигон аймагт байтугай монгол түмэнд дархлагдах учиртай бус уу.

-Хаан таны хүсэл бол тэнгэрийн таалал билээ. Хатан миний бие чадах чинээгээрээ хичээе.

Бөртэ, Тэмүжинг зүүдэлж хонов. Цагаан шонхор шувуу, сар, нарыг авчирч өгөв гэж зүүдэлжээ.

\* \* \*

Шөнийн эхлэл өглөө, өдрийн эхлэл үдэш байдаг. Намрын урт өдрүүдийг Тэмүжиний нөхдүүд Бурхан халдуны тунгалаг цөөрмийн хөвөөнөө байлдах, жадлах, харвах сургууль хийж өнгөрөөж байв. Жарчудай дархан хар хөлсөө савируулан төмөр давтаж сэлэм урлана. Сэлэм урлах төмрийг галд улайтгаж, усанд дүрж хатаах бөгөөд олон дахин давтахад бяр чадалтай хөвгүүд тусалж, заримдаа отгийн өвгөд оролццог байв. Тууль хайлж, үлгэр ярьдаг хөх өвгөд, шар эмгэд төмөр давтдаг залтас ханхалсан сараалжинд цуглаж өдрийг бардаг байлаа. Өргөөндөө байх үед Тэмүжин, Бөртэ хоёр тайван ярилцана.

Төмөр балбах чимээ гэрт тод сонсдож хаданд цуурайлж байхад энэ яриа болжээ.

-Манай омгийнхон дайн дажингүй баймаар байна. Мал сүргээ тайван адгуулж, гөрөө хийдэг тэднийг чөлөөтэй байлгахын тулд надад баатар, цэргүүд хэрэгтэй байна. Хүч султай нь хүчтэйдээ залгиулдаг учраас хүчтэй байхыг би хичээнэ. Цэргийн төдийгүй омог аймгийн бяр их байх нь дайтахыг хүсэгч аймгуудын зүрхийг үхүүлнэ. Надад хүн хүч хэрэгтэй. Зэр зэвсэг хэрэгтэй. Амсхийх чөлөөнд зэвсэг бэлтгэх нь зөв хэмээн бодно гэж Тэмүжин өгүүлнэ.

-Монголын овог аймгууд мөнхөд биетэйгээ дайтсаар байх хэрэг үү. Эмс бид чинь дайны

золиос болох хөвгүүдийг төрүүлэх юмуу. Илүү хүчтэй дайснаас илүү хүчтэй байвал айх аюул багасна гэж та бодно уу.

Бөртэ анх удаа Тэмүжинг та гэж дуудсан явдал түүний бодол санааг хүлээн зөвшөөрч эр нөхрөө дээдэлсэн хүндэтгэл байсан юм. Бөртэ хатаны үгийг Тэмүжин чих тавин сонсов. Хадны цуурай төмрийн дарханы гарын аясаар хан, янхийх нь "боржигон хүчтэй болох ёстой" гэж давтах мэт. Тэмүжиний нүд заримдаа гурвалжлан ер бусын ид шидтэй харагддаг билээ.

-Хаан ч бай, харц ч бай гэм хийвэл зэм хүртдэг баймааж монголчууд ямар нэгэн гавьяа байгуулж гэмээ цайруулбал зохино. Гэм нүгэлээ цагаатгасны дараа шан харамж хүртэх ёс тогтооно хэмээн Тэмүжин бодлогошрон өгүүлэв.

Хаданд цуурайлах сэлэм давтах дуун Тэмүжиний цээжийг донслуулан "Бяр тэнхээ суухад тангарагт андууд тусална. Жарчудай дархан шиг амласандаа хүрдэг нөхөдтэй болох юмсан" гэж агадан байлаа. Тийм сайхан цаг ойртож буйг Есүхэйн хөвүүн зөн совингоороо мэдрэвч, чухам хэдийд бодол санаагаа гүйцэлдүүлэхээ төсөөлж ядна. Гандаж хуурайшсан өвсөн дээгүүр Тэмүжин дээл нөмгөн хол, хол алхаж явахдаа "Тайчуудын нутаг руу галуу нислээ гэв үү. Эцэг Есүхэйгээс тайчууд урвасан бус уу. Бүл чадал муутай биднийг басамжлан, нүүдлийг шиншлэн, ус, бэлчээрийг харлуулдаг ёрын зан тайчуудад буй. Тайчуудыг хүнтэй, малтай, нутагтай нь хураах юмсан.

Тайчууд урвасныхаа шанг амсах ёстой. Хэрэв тайчуудыг хураахгүй юм бол би Есүхэй эцгийн ачийг яаж хариулна" хэмээн өөртөө шивнэв. Онон, Хэрлэн мөрөний дагуух асар өргөн тал хээр нутагт монгол аймгууд хоорондоо цус урсган дайтаж, албат иргэдээ ээлжлэн хурааж ирсэн нь Тэмүжиний цухлыг хүргэнэ.

"Нар манддаг, нар шингэдэг тал нутагт нэг хаан байж болохгүй гэж үү" хэмээх асуултыг Тэмүжин хонгирадын бууцанд байхдаа санаж олжээ. Төдхөн эцгийнхээ татаар иргэнд хорлогдсоны дараа Мэнлигт хандаж "Бартанбаатарын хөвүүн Есүхэй баатар бус уу. Есүхэй баатрын хөвүүн Тэмүжин бус уу. Эцгийн орыг хэн залгана" хэмээн асуужээ.

Мэнлиг буурал сортой сахлаа зүүн гараар шувтарч, уулын толгой харж байснаа,

-Надаас асуух юун. Хөвүүн чи эцгийн орыг залгах бус уу гээд тамшаалжээ. Эцэг Есүхэйн захиасыг сонссон хүн Мэнлиг тул Тэмүжин улам лавшруулан,

-Тайчуудын отог эзгүйрэх боллоо. Хэн дур мэдэн нүүлгэж буй хэмээвэл тэрбээр толгой сэгсэрч "эзнээсээ урвасан барлаг уг нь толгойгоо авахуулах ёстой. Өүлэн хатанг сайн асраарай. Тэмүжин хөвүүнийг эрийн цээнд хүргээрэй гэснээс бус тайчуудыг нүүх тухайд Есүхэй баатар бодоогүй биз" гэв.

-Боржигончуудад хэн туслахыг та мэдэх үү гэхэд. Мэнлигийн загзгар эрүүний шингэн сахал сөрвөлзөн хөдөлж "Хэрэйдийн Тоорил хаанд чиний эцэг Есүхэй баатар хоёр удаа гүн тусласан юм. Би Тоорил хааны албат байгаагүй болохоор тэр их хааныг үл мэднэ. Хэрэв жинхэнэ эр хүн бол Тоорил хаан чамд ямарч үед туслах учиртай гэж санана. Эцгийн тань тусыг амссан юмдаг" гэснийг Тэмүжин санасаар өдий хүрчээ. Энэ хэдэн жилд Мэнлиг

Тэмүжинээс "Хэрэйд аймгаас сурагтай юу" гэж асуудаг бөгөөд тэр нь Тоорил хааны тухай сануулга байжээ. "Тайчуудын нутаг руу галуу нислээ" хэмээн Өүлэн эхийн хэлсэн үг Тэмүжиний бугласан шархыг сэдрээжээ. Боржигоны хот хүрээнийхэн бог малтайгаа Онон мөрний сав хөндий рүү бууж, ууланд үхэр, адуугаа үлдээжээ. Бурхан халдун уулын цуурай хээр тал нутгаар тархаж "Тэмүжиний борви тэнийжээ" гэсэн аядуу үгс малчдын нүүдэл, аянчины зам дагуу сонсогдох болжээ.

Тэмүжин, Бөртэд,

-Би Тоорил хаанаас тусламж хүсч тайчуудыг хураан авч хүчээ зузаатгамаар байна гэж хэлэв.

-Эцгийн тань хуучны анд нөхөр чамд туслаж боржигоны хаан таны анд нөхөр болмоорсон. Нэр нөлөөтэй хаанд ийм бодол лав бий.

-Манай хот айл дөнгөж сэргэж байна шүүдээ. Хэрэйд бол бэхэжсэн аймаг. Арвин мал сүрэгтэй, алт эрдэнэс элбэгтэй, дайн байлдааны туршлагатай болохоор боржигоныг тоох болов уу. Хэдийбээр боржигоны уугуул нутаг хумигдсан, зүдрүүхэн байгаа ч гэсэн би тэр овгийн хаан. Үнэндээ би Тоорил хаанд бараалхахыг аль эртнээс санаархаж байсан. Миний удам нэрэлхүү, омог тегөлдөр хүмүүс билээ. Би Хэрэйдийн хаанд гар хоосон очих юм гэж үү.

-Тэмүжин минь хаан хүн хаандаа зочилж байгаа мэт очихгун. Дорд ядуус бол өөр хэрэг. Миний инжинд өгсөн хар булган дахыг хэрэйдийн хаанд бэлэглээрэй. Тэр даханд Таргудай Хирилтугийн сүнс хоргодсон юм. Сүнс, сүлд нь Тоорил хааны нударганд орж Таргудай тонилог.

-Бөртэ минь, хатан хүний ёсоор мэргэн санаа хэллээ. Эхээс асууж эцсийн шийдвэрт хүрье.

Өүлэн эх зүүн хоймроо сүү ууж сууна. Эх, хөвүүн, бэр гурав тавтай сууж яриг гэж бодсон Мээнэнбилэг одод түгсэн зүйдэлгүй хөх тэнгэрийг тоонын замхраа таширлуулан харж "Тэмүлэн зүүдлэмхий билээ. Хучлагаа тийрч дарах магад" хэмээн Өүлэн эхэд өгүүлээд цартай махан дээр тавьсан хутгыг хураав. Тулгатай гал бадамлаж байна. Олхонуд төрхөмдөө байхаас Өүлэн эх сүүнд дуртайсан. Бэр болж мордохдоо Өүлэн аягатай сүүндээ нулимс дусаасан юм. Сүүгээ тэрбээр нулимстайгаа уучихжээ. Эл бүхнийг сортолзон харсан Тэнүүн удган уулга алдаж "заяа нь төөрчихөж" гэж хэлэхэд Өүлэний эх "ангир хүртэл буданд төөрдөг. Гэвч нуурынхаа зэгсийг олдог юм" хэмээн үл тоосон гэдэг. Өүлэн эхийн заяа төөрөг анхандаа буданд төөрсөн ангир мэт байжээ. Бөртийн зам мөр ямар байхыг зөвхөн тэнгэр мэдэх хэрэг буй за.

-Хэрэйдийн хаанд бараалхах өдрийн бодол, шөнийн зүүд надад байна. Есүхэй эцэг зүүдэнд ирэв. Намайг бодсоноороо яв гэж эцэг ятгав. Эцэг юу өгүүлнэ вэ хэмээн Тэмүжин байргашсан цээл хоолойгоор эхийнхээ сүү уух зуур өгүүлэв. Өүлэн эхийн цайвар царайд аягатай сүүний гэгээ тусчээ.

-Ван хааныг ядрах цагт Есүхэй баатар татаж босгосон юм. Тэр их хаан Тэмүжин хөвүүнд минь хариу барих биз ээ гэж Өүлэн эх бодол санаагаа ил өчив.

-Надад хар булган дах Бөртэ үжиний инжинд өгсөнийг Ван хаанд бэлэглэхээр зэхэв. Ээж та юу гэж бодно гэхэд Бөртэ үжин тэдний яриаг эвтэйхэн өлгөн авч "Ван хаанд булган дахаа бэлэглэх нь ерөөлтэй бус уу" хэмээн өөрийн санаагаа хавчуулж амжив.

-Булган дах бол ховор үнэт эдлэл. Ван хаан лавтайяа баярлах биз ээ хэмээн Өүлэн эх дотор санаагаа уудалж хэлээд уужим амьсгал авлаа.

Их өргөөнд морилсон хойноо Тэмүжин,

-Энэ дах намайг осгохоос аварч байсан. Булган дах бид хоёрын ариун хайрыг сахиус мэт хамгаалж байгаа шүү. Энэ үнэт дахны доор охин биеэ гэсэн бус уу гэж Бөртийг таашаангуй харахад Бөртийн булбарай царайд гэгээ татаж,

-Одоо чамд Бөртэ би байна шүү дээ. Би бол чиний алганы хээ шиг чамд тодорхой юм гэлээ.

Тэр шөнө арван зургааны тэргэл сартай шөнө байлаа.



## Арвандөрөвдүгээр бөлөг



*Туулын хар түнд Тоорил вангийн хэрэйдүүд нутаглана. Тоорил хаан бол халзандуу толгойтой шохоорхон сонжсон харц бүхий нүд нь хөнхөр ухархайдаа гонсгор харагддаг, хүзүүндээ том гэгчийн мөнгөн загалмай дээр цовдлуулсан хүний дүрс зүүж явдаг, ихэмсэг гэдгэр нэгэн билээ. Баргийн хүнтэй угийн солио муутай, нэлээд шөрмөслөг биетэй, нас хэвийсэн хойноо Нялх Сэнгүмийг төрүүлж хүүтэй болжээ.*



Боржигоны хаан Есүхэйг нас эцэслэсэн сураг дуулаад "ээ хайран сайхан хүн...хайран...ээ хайран... мундаг баатар юмсан" гэж гурван өдөр халаглав. Тайчуудын увайгүй занг Тоорил хаан мэдэж "Тэмүжин хөвүүнийг хороочих вий. Яасан тангараггүй хүмүүс вэ. Таргудай Хирилтуг ирэх өдөр нугасаа чичүүлнэ" гэж халаглаж байв.

Тоорил хааны нутгийн зүг явахаар Тэмүжин, Хасар, Бэлгүтэй, Боорчи нар богцоо авав. Нэгэн богц дотор хар булган дахыг эвхэж хийгээд Тэмүжинд ганзагалуулж "морины хөлс шингэчих вий, морио юүлэхдээ хичээ" гэж Бөртэ захив.

-Нугас, галуу буцав. Нуур цөөрөм дүнсийв. Хүн, малын нутгийг сэлгэнэ хэмээн Тэмүжин итгэлтэй өгүүлээд дүү нараа дагуулан Боорчийн хамт тарган агт хөтөлж Туул голыг уруудлаа.

Алтан дээвэрт өргөөний хоймор түшлэгт олбог дээр тухалсан Тоорил хааны ажигч нүдэнд юуны түрүүнд Тэмүжин өртжээ. "Ямар шалмаг залуу болоо вэ. Яг Есүхэй шиг үл шантрах харцтай, шулуухан яриатай эр болж. Одоохондоо нүүр өгч өөртөө дасгах хэрэгтэй. Боржигон аймаг их хүчирхэжвэл маньд саадаатай. Уяагий нь тааруулахгүй бол нэгэн цагт идүүлж мэднэ. Тэр Хасар, Бэлгүтэй хоёр нь бух шиг юм гээч. Цаана нь хэчнээн ийм эрчүүл бий бол..." гэж бодов.

-Би Есүхэйн бутарсан улсыг буцаан хурааж өгье.

Задарсан тайчуудыг зандарч номхотгоё. Тэмүжин хөвүүн надад юу амлах вэ.

-Ван хаан таны босгыг хүндэтгэж алхав. Баруун ууланд тэнгэр дуугарахад зүүн ууланд гялбаа нь цахидаг гэж эрт цагт та номлож билээ. Эртний номлол нүдэнд ил байдгийн адил эцгийн анд таны сайхан сэтгэлд талархана. Ван таны нөмөр нөөлөгт багтаж явахаа амлая.

-Миний гурван мянган цэрэг тайчуудыг номхотгож, иргэд нутгий нь хурааж хумихаар Тэргүүн өндөрлөгт очно. Шинийн таванд тосож бай. Тарган цаггалан намар цагаар тайчуудын хүчийг сориод үзмээр санагдана.

Тэмүжинг өргөөний баруун хойморт суулгаж зэс тавганд ааруул, өрөм, бяслал, модон царанд тарган иргийн сүүл тавьжээ. Мөн загасны түрс, цөцгийтэй хольжээ. Тоорил вангийн төрөлхийн нимгэн шаргал царайд үл эргэлзэх байдал тодорч, амьтан руу болгоомжлон гэтэх мэт нүд нь ёлтолзоно. Ван өвдөгцөө хар булган дахыг тохож тавиад "нүнжигтэй эд байна" гэж амандаа гөвтнөв. Хэрэйдийн ван нэгэн өргөө зэхүүлжТэмүжин.Хасар, Бэлгүтэй, Боорчи нарыг амрааж замдаа идэх чанасан мах, уух цэгээг богц туламд нь ууталж, юүлж өгчээ.

\* \* \*

Ван хааны хүрээ бусад монгол аймгуудын хот айлаас өөр бөлгөө. Хальсалж зосоор будсан халтар модоор хашаа хатган, хашааны дөрвөн талд шургааг дугуйруулан өндөр тотгонд модон загалмай дээр цовдлуулсан хүний дүрсийг товойлгон сийлжээ. Харуул хамгаалалт сайтай цэлгэр дугуй хүрээний голд Ван ханы алтан дээвэрт өргөө асарлана.

Өргөөний чанх хойно Дүнжингарав уулын модод багилтан өм цөм шарлаж, Туул гол бургасны чөлөөгөөр үе үе цэнхэртэнэ.

Тоорил ван алтан тоногтой өргөн суран бүс хэлхэгэр дээлэн дээр бүсэлж чийрэг хөлөөрөө газар дэвслэх мэт бардам алхаж ирээд "Тэмүжин хөвүүн байгальд дуртай хэвээрээ шив" гэснээ,

Миний шадар цэргээс бүрдсэн баг таануусыг Хэрлэн мөрний гарам хүргэж өгөг! Цаашаа Бурхан халдун уулын Тэргүүн өндөрлөг хүртэл бутны туулай үргэхээргүй шулуун буй за. Тиймүү? гэв.

-Ван эцэг таны хишигт талархав. Ирсэн шигээ зогсолтгүй довтолгосоор нутагтаа хүрэмз.

-Болзсон болзоо хэвээр тул би амласнаа биелүүлнэ. Үүл ихтэй байна. Бороошиж магад. Морьдоо гамнаарай.

Ван хааны хүзүүнд зүүсэн алтан загалмай цээжрүү унжиж байхад түүнийгээ баруун гараар Тэмүжиний явах зүгрүү чиглүүлж дохив.

\* \* \*

Хэрлэнгийн бургас намрын наранд хүрэнтэж зарим газраа хөхөртөж гандсан байв. Тоорил хааны баг цэргийг буцаж одсоны дараа цацархаг том биетэй Хасар Тэмүжин ахдаа хандан,

-Тоорил хаан дээрэлхүү хүн байна гэв.

-Чамд яагаад ийм санаа төрөв.

-Би ихэд сүрдэв. Ямар их алттай юм бэ.

-Манай боржигон алтаар бага ч санаагаар илүү буй за. Ван хааны өмнө сөгдөж болно. Одоохондоо гэдийж үл болно. Биднийг гартаа оруулах санаатай байна. Хасар дүү энэ хатуу үгийг урьдчилж сануулсан нь сайн.

Морины хатираанд залуусын бие агсагдан байвч элдвийг хүүрнэлдэн шовх, шовх хүрэн уулсын дундуур зөрж, уруудаж, өгсөж одсон морин харгуйг нэхэн давхина. Тэртээ алсад цэнхэр хөндий нүүгэлтэн

Хэрлэнгийн урсгал хэсэг бусаг толгодын дундуур нэлийж үзэгдэнэ.

-Тоорил ван алттай учраас түрэмгий шунахай байж таарна. Тайчуудыг хураасныхаа төлөөсөнд юу авах бол.. Дайны олзыг бүгдийг авч явах уу..

-Юу дуртайгаа аваг. Гагцхүү тайчууд хүн малтайгаа, нутаг бэлчээртэйгээ боржигоны эрхшээлд орвол тэдний үр үндсийг хесрий мод шиг болгоно.

-Эцгийн оронд эцэг болсон Тоорил хаанд итгэхгүй юм бол хэнд итгэх билээ. Жамуха анд хүчирхэгжиж бяд суугаагүй байгаа бус уу. Андын нутаг хол байна.

Тэмүжиний сэтгэлд нэгэн үйл явдал тод үлджээ. Таван настай бяцхан Тэмүжин эцгийн хамт Тоорил вангийн дунд зочилж, холын гийчин өндөр нуруутай, өтгөн гэгчийн урт сахалтай, ногоон цэнхэр нүдтэй эр дунд насны номлогчийг харсансан. Номлогч эр өдөр бүр монгол аймгийн хаад, ноёдын хөвгүүдэд байгаль дэлхийн үүслийн тухай домог өгүүлж, хооллох үедээ баруун, зүүн гарын алгыг нийлүүлэн хавсарч "эзэн тэнгэр өршөөх болтугай" хэмээн гүн итгэлтэй хэлдэг байж билээ. Таван настай бяцхан Тэмүжиний байгалийн үүслийн тухай анхны төсөөлөл тэгэхэд буй болж гурван сарын дараа гэртээ ирэхдээ тун хэвлүүхэн яриа хөөрөөтэй болсонд Бэгтэр,

-Тоорил хааны шавхруу амттай юмуу гэж шогложээ. Бэгтэр их хорлонтой тул Тэмүжин аргаа бардаг байж. Нэг удаа будан дунд сүртэйеэ дүнхийх Бурхан халдун тийш сүсэглэн харж

зогсоход Бэгтэр, Тэмүжинийг байрнаас нь түлхэж холдуулаад,

-Чи юу гэж харав гэхэд Тэмүжин "Халзанбух зайран үзэгдэв" гэжээ. Бэгтэр бол Тэмүжиний аяганд хоол идэхийг хүснэ. Тэмүжиний суусан газар сууж, зогссон газар зогсохыг Бэгтэр эрмэлзэнэ. Хоёр бяцхан хөвүүн хөөцөлдөн тоглоход Бэгтэр дэгээдэж унагана.

Бэгтэрийн тоглоомд Тэмүжин уурлахгүй боловч өдөр өнгөрөх бүрийд нэг зүйлийг хэнээс ч асуулгүйгээр ойлгож байлаа.

Хорлонтой, өөнтөгч зантай Бэгтэр өдгөө Тоорил вангийн санааг мэдэхэд Тэмүжинд тусалсан санагдах нь юуных вэ.

Тэмүжин тусламж гуйсныхаа дараа сэтгэл тайтгарч "боржигоны отог сэргэх цаг болжээ" гэж бодсон авч гэгэлзэн зовох өчнөөн ачаа байлаа. Лууны ургамлын судсанд холбогдсон хатсан өвс хэрмэл замыг морьдын туурай самардан тоос татах тоолонд хугарч унана.

\* \* \*

Хэрэйдийн их цэргийн түрүүч ирлээ. Ван хаан жижиг цагираг бүхий битүү хуяг өмсөж дагуул баатруудын хамт Тэргүүн өндөрлөг дээр дүнхийнэ. Түүний тухлан буух цацарыг барьж үүдийг тэлүүрдэн татжээ.

Тоорил ван бөөрөнхий улаан зос гаргаж элдсэн цагаан нэхийний дээр Онон, Хэрлэн мөрөнг тэмдэглээд гол усны дагуух ай савыг зааж тэмдэглээд тайчуудын хүрээ бууцыг маргааш самарна гэж Тэмүжинд нотлов. Нэхийний өрөөсөн талд бөөрөнхий мод уясан нь амархан хуйлж эвхэх зориулалттай байв.

-Төмрийн хүдэр хаанаас олов. Сэлэм хэн давтав гэж Тэмүжингээс Ван эцэг лавлав.

-Урианханы Жарчудай дархан урлав гэж Тэмүжин хариулав.

Жарчудай дарханы нүүр хөөтэй, том гар нэлдээ харласан харагдана. Дарханы цэхэр нүд, гөлгөр хөх нүүр Тоорил хааны сэтгэлд үл нийцсэн тул "энэ ууланд төмрийн хүдэр байгаа юу" гэж шаардангуй хэлэхэд дархан Тэмүжин рүү нүд буландан харсанаа "зүүн ууланд төмөртэй" гэв. Тоорил ван их дуугаар инээж "зүүн уул хэчнээн олон вэ... Тэмүжин хөвүүн зэвсэгтэй бол би зэвсэгтэй гэсэн үг" гэж битүү утгаар ёжлонгүй өгүүлэв.

Онон, Хэрлэн мөрний саваар нүүдэллэн буусан тайчуудын хот хүрээ, отог бууцыг Хэрэйдийн цэрэг довтлон сандааж, хэд хоногийн дараа олзны хүн, малыг хурааж авчрав. Тэмүжин тайчуудын дотор Таргудай Хирилтуг байгаагүйд гонсойхын дээдээр гонсойж "тарган ноёныг барьж ир" хэмээн уул, талаар нэгжүүл тавьсан боловч олдохгүй байлаа. Ван Тоорил гүн ухархайтай гөлтгөр нүдээр Тэмүжинийг ширтэж "нэхэл хатуу хүн юм" хэмээн дотроо бодоод,

-Таргудайн тантгар бие хаашаа одохов. Чогчиго болоод тэнгэрт дүүлэх биш, зурам болоод нүхэнд шургах биш Таргудай хаачдаг юм хэмээн басамжлав. Хөндий дүүрэн мал, олзлогдсон айл, гэр, энгийн ардууд, цэрэг даамлыг тоймлож бүртгэж суусан Ван хаан,

-Тайчуудаас өшөөгөө авав. Тэднийг яахав гэхэд Тэмүжин,

-Үрийн үр, ургийн урагт өөдөө нар харахгүй бөхийлгөмз. Тайчуудаас гадна татаар аймаг байна. Өрийг минь өрлөсөн тэднээс өшлийг өшиж, хяслыг хясах өдөр ирнэ. Ван ахын нөмөрт багтсандаа тайвширна гэв.

Тэмүжиний бахим бие, өргөн мөрийг Ван Тоорил элгэмсэгээр тэвэрч "дайны олзноос би хувь хүртэхгүй. Яахаа хөвүүн шийд" гэхэд Тэмүжин эргэлзэн "Ван ахад би өртэй үлдэж яахин болно. Азаргаар адуу өгье. Авдраар алт менгө ав. Зуун тэмээнд ачаад Хэрэйдийн шугуйд аваачиж албат иргэддээ тарааж өгсүү" гэхэд Тоорил хаан ходоодныхоо мухарт хүд, хүд инээж "өр цайрах гэдэг санаа сайтайнх биз" гэж егөөдөн өгүүлэв.

Тайчууд Тэмүжиний гарт хумигдав.

Боржигоны хүрээ хэрхэн томрохыг Тоорил үзэж "Монгол аймгуудыг энэ мэтээр хурааж болох нь" хэмээн санаж намрын шар наран дор Тэмүжингээс салж одов. Тэнгэрийн баруун хаяанд нар зоогдсон мэт мэлтийн шаргалтана.

\* \* \*

Үхэр тэргэн дээр Ширээт хоёр хүүтэйгээ хамсан Таргудайг хүлж Тэмүжинд тушаахаар авч явсанаа "Эзэндээ халдаж болохгүйг" гэнэт санажээ. Өвстэй, налуу хотгорт үхэр тэргээ зогсоож Таргудайн хүлгийг тайлав. Таргудай биеийнхээ чилээг гаргаж суниагаад "Ширээт чи замаараа тонил. Намайг дутаалгасан гэж бүү чалч. Амаа хамхиж яв!" гэв. Ширээт эзнийхээ нүднээс бултасхийн "Тэмүжиний туршуулд баригдвал алагдана. Мэдээтэй явдаг юм шүү" гэж захилаа.

Таргудай тарган, богино чацтай тул модны хаяа тийш торолзон бүрэлзэн явсаар байхыг Ширээт үхэр тэргээ гуядан хөтөл өөд зүтгүүлэхдээ харав. Гэнэт Ширээтийн урд дөрвөн морьтон газраас ургасан юм шиг зогсож байлаа.

-Чи муу боол хэнийг дутаалгав.

-Ноён Таргудайг амь гуйгаад байхаар явуулав. Надад тэрслэх санаа үгүй билээ. Та нар түүнийг мөшгиж явна

уу-

-Тайчуудыг Тэмүжин хураасны хойно Таргудайг барьж хороох зарлиг буулгасан. Ширээт чамайг хамт хороовол зохино.

Үхэр тэрэгнийхээ дэргэд Ширээт сөгдөж амь гуйгаад нөгөөдүүл паржигнатал хехрелдөн элэглэж морио гуядлаа. Ширээт ойн цоорхой тийш мөлхөж байгаа юм шиг удаан яваа Таргудайг харж, "барьсан чигтээ Тэмүжиний цэрэгт тушаачихсан бол Таргудай алагдах байсан болов уу, амь хэлтрэх байсан болов уу" хэмээн өөрөөсөө асуугаад хормойныхоо шороо, өвс тоосыг гөвлөө.

Морьт цэргүүд гуаглан давхиж дөрвөн сум Таргудайн ар зоонд зэрэг шахам шив, шивхийн зоогдоход тэрбээр хүнд биеэ дааж ядан газар мөргөж унав. Таргудайг дээш харуулахад том улаан судастай нүд бүлтийж, завьжаар нь цустай хөөс пургиж байв. Тэмүжин эзэндээ хэл хүргүүлэхэд Тэмүжин хилэгнэн "Толгой нь хаа байна" гэж хашгирчээ. Таргудай Хирилтугийн толгойг яг Тэмүжиний хашгирах үед үнэг мөлжиж байжээ.

## Арвантавдугаар бөлөг



*Хамаг монголын хаан Чингис дөчин нэгэн насандаа Хуланд дурлажээ.*

*Хулан бол мөнгөн загас мэт бүсгүй байлаа*



Тайчуудыг хураан авсаны хойт хаврын сүүл сард баруун ууланд аянга цахилан, зүүн ууланд гялбаа нь зурваслан шөнөдөө аадар бороо цутгаж, өдөртөө үүлшиж, хээр талд хөх ногоо хөглөрчээ. Боржигоны хот хүрээ хаяа тэлж, нүүдэлчид уван цуван нэмэгдсээр байлаа.

Бороо асгана. Хар борооноор Сочихэл бор хоормог усаар дүүрсэн сархиаг дундуур гаталж явна. Уулнаас буух үерийн ус Сочихэлийн хашгирах дууг алгадан холдуулж байлаа. Сочихэл гэр хүрээндээ ойрхон ирээд,

-Дээрэмчид айсуй. Манайхныг чиглээд ирж явна. Бушуухан зугатаарай хэмээн тэнхээ мэдэн хашгирахад Мээнэнбилэг, Хуагчин, Өүлэн эх, Бөртэ хатан бороон дундуур тэргээ хөллөж, майхнаа буулган ачаална.

Өүлэн эх Бөртийг хонхот тэргэнд суулгаж өөрөө хөтлөх гэсэнд Боорчи болиулж Өүлэн эхийг Мээнэнбилэгийн хамт мордуулав. Боржигоны хот хүрээний дайчид анд мордож гэр

хүрээндээ Боорчийг эхнэр хүүхдийн хамт үлдээсэн байв. Хонхот тэргэнд Бөртийн хамт Хуагчин сууж зугатаав.

Санд мэнд зугтаагсад харанхуй бороон дундуур ул мөргүй арилж харин Бөртийн суусан хонхот тэрэгний өрөөсөн дугуй мултарч унаад тэрэгний бул газарт зоогджээ. Бөртэ, Хуагчин хоёр аргаа баран ноцолдож тэрэгний дугуйг засч эс дөнгөв. Сочихэл толгодын дундуур сүлжин давхисаар Хуагчин рүү ирж "Бөртийг тэргэндээ нуу" Эд нар мэргид байна" гэж хэлээд давхиж өнгөртөл гүвээн дээрээс нэгэн морьтон сум шиг хурдалж Сочихэлийн мориог цулбуурдаж авлаа. Шөнөжин шавартай хутгалдсан Хуагчин тэрэгнийхээ дэргэд зогсоно. Хуагчин бол Бартанбаатарын дүү Хутагтмонхорын хөвүүн Хайчингийн эхнэр байгаад татаарын тулалдаанд бэлэвсэрч Өүлэн хатны дэргэд үүрд үлдсэн эм билээ.

Сочихэлийн морины цулбуураас хөтөлсөн цэрэг тэр чигтээ гүвээ давахад цаанаас нь хэсэг нэхүүл гарч Хуагчинг бүчиж авав.

-Шөнөжингөө хаагуур тэнэв. Юунд зугатаав.

-Би Тэмүжиний албат билээ. Боржигоны хүрээнд хонь хяргаад буцтал бороо цутгав. Тэрэгний дугуй мултарч унав. Яалтай билээ, хээр хонолоо.

-Энэ тэрэг хэнийх вэ. -Өүлэн хатаных

-Хонхот тэргэнд хааны ач үрс юмуу бэр, бэргэд суудаг бус уу.

-Хуучин тэргээр намайг явуулсан билээ. -Тэргэн дотор юу байна. -Миний хувцас хунар, цацар төдийхөн буй. -Алив үүдий нь сөх...

Хуагчиний тэгш сайхан бие чичигнэн, шөнийн бороонд норж нэвтэрснээс болсон уу, айснаасаа тэрүү дагжиталаа чичрэв.

-Наад зарцаа орхи, цаашаа! Тэргэнд энэ эхнэрийн хог новш чихээстэй байна.

Цэргүүд ирсэн замаараа хатиран одов. Хуагчин сая чөлөөтэй амьсгаа авч, зууван нүднийхээ харцыг мэргидийн цэрэг хатиран одсон гүн сайр тийш бэлчээв.

\* \* \*

Тэрэгний арлыг шажигнуулан Хуагчинг налах үед хэмхэрч яйжийсан тэрэгнээс Бөртэ гарч ирээд "Та яав. Битгий сандар. Бид хоёр аврагдлаа" гээд түүний биеийг түшлээ. Тэрхэн зуур Хуагчин тамирдан ядарчээ.

-Сочихэл хайчив аа. Сочихэл олзлогдов.

-Мэргидүүд тэр хүүхнээр яах гэв. Би түүний төлөө зовж байна.

-Олзны эмсийг зарц шивэгчин болгодог биз дээ.



-Эм амьтны заяа юутай хөөрхийлөлтэй.

-Манайхан ав хоморгоос буцаж ирээд мэргидээс Сочихэл эхийг заавал булааж авна.

Тэднийг ийн ярилцаж зогстол тарлан өвстэй нуруугаар морьт цэргүүд шовс шовсхийн ил гарч, цаадах тэнгэрийн дэвсгэр дээр дүрс зураг мэт үзэгдэнэ. Хуагчин эхнэр "тэнгэр биднийг өршөөсөн байтал эд нар хэн буй. Гай дайрах нь энэ үү" гэж амандаа бувтнан өгүүлээд,

-Хоёулаа ой руу зугатъя гэж Бөртөөс лавлав.

-Мэргидийн цэргүүд буцаж иржээ.

-Бөртэ минь эвдэрхий тэргэндээ орж нуугдахгун.

Хонхот тэрэгний үүд хаагдан Бөртэ нуугдах зуур мэргидүүд давхилдан ирэв.

-Өнөөх эхнэр байна шүү дээ хэмээн ахлагч нь бололтой өвч зэвсэглэсэн эрийг ширүүхэн дуугарахад нойтон газарт мориноос дэвхрэн буусан цэрэг,

-Сайтар нэгжинэ гээд үүд сөхтөл Бөртэ үжин цэргийн цээж рүү түлхэн бууж ирэв. Цэрэг ухарч Бөртийн гоо үзэсгэлэнд сөгдөх шахам тонгойход мэргидийн баг цэргийн ахлагч,

-Чи хэн буй хэмээн хашгирав.

-Би бол Тэмүжиний хатан Бөртэ байна. Та нар юунд зам хөндөлсөнө гэж Бөртэ цээл уяхан хоолойгоор өгүүлээд, өндөр биеийн бэлхүүсийг хотолзуулан тэдэн рүү ойртоход баг цэргийн ахлагч "наадхи эхнэрээ барь" гэж зэвхий дуугаар бархирна. Бөртэ тэрхүү зэвхий дуугаас,

-Чи аминдаа хайртай юу гэж асуув.

-Олзлогдсон эм надаас амины хайр асууна гэнээ. Чиний амь үнэтэй юу, тэгвэл ...гэж мөнөөх зэвхий дуут нохойтов. Бөртэ зориг шулуудан түүнд ойртон очоод "Тэмүжиний гараас амьд мултрахгүй шүү" хэмээн шүд зуун хэлж түүний хацрыг хорстол алгадав. Байдал нэгэнт бишдэж Хуагчин, Бөртэ хоёр мэргидийн олзонд оров. Мэргидүүд олз хураах дуртай бөлгөө.

Нэгэн цаг дор мэргидийн Чилэдү баатар Өүлэн хатанг эхнэр болгон авч Орхон, Сэлэнгийн сав дагуу буцаж явахад Есүхэй баатар булааж гэргий болгосон нь өш зангидах эхлэл болжээ. Бөртэд алгадуулсан зэвхий дуут "Есүхэй баатрын хөвүүн Тэмүжиний хатанг булааж урьд цагт Чилэдүгийн эхнэр Өүлэнг алдсаны өшийг би өшив. Намайг мэргид аймаг баатарт өргөмжлөх ажаамуу" хэмээн бардам санана.

\* \* \*

Мэргидийн хүрээнд Бөртийг хүргэж ирэхэд зэс домбоноос цай ууж суусан хаад мэргид Хаатай Дармала, увас мэргидийн Дайр-Үсүнд "Надад Сочихэл байна. Тэр эмийг би номхруулсан. Наадуулаа та мэдэгтүн" гэлээ. Дайр-Үсүн толгойгоо хэлтгий болгож Бөртийг шиншиж, "Аргагүй л удам сайт эхнэрууд юм. Өмссөн хувцас нь эрдэнэсийн чулуун чимэгтэй

байна. Үс гээгнээс нь хүртэл хүдрийн заар ханхалж байна. Чилгэр бөхөд асруулбал таарна. Чилэдү баатар миний аавын ах байвч Чилгэр бөх түүний төрсөн дүү билээ. Шөнөд өвөртөлж, өдөрт асарч яваг" гээд үүд рүү заав. Хуагчинг гэнэт Дайр-Үсүн "Бөртийн зарц мөн үү" гэв.

-Бөртийг би асарч яваа билээ гэж Хуагчин нам дуугаар өгүүлэв.

-Чилгэр бөхийн гэрт аваач хэмээн Дайр-Үсүн шүдээ хавирав. Увас мэргидийн Дайр-Үсүн шөнийн турш Бөртийг бодож цагийг барна.

Олзлогдсон Сочихэлийг хаад мэргидийн Хаатай Дармала шөнө өвөртөлж хонох гэтэл "дуртай эмээ эмлэх таны хүсэл боловч бүү горьд. Есүхэй баатрын эх намайг хүүдээ гуйж, гурав хоног уйлсаны эцэст биеэ өгсөн юм шүү. Гэтэл өмхий мэргидийн дурыг хангах юм гэнэ. Надад амьд явах, үхэж далд орох ялгаагүй" гэж хэлжээ.

Дармала мэргидийн хүрээгээр дүүрэн шуугиан дэгдэж Сочихэлийн үснээс чирэн нэвширтэл зоджээ. Сочихэлийг зарц, шивэгчидийн оромжинд оруулж хаяв.

Хаатай Дармалагийн зодуурын дараа Сочихэл дурамжхан амьдарч мэргидийн хүрээний захын цацарт i орогнох болжээ. Мэргидийн олон хот хүрээний гадна зовсон ЭМ, ЗООЛСОН ноход ЗӨНДӨӨ бүлгээ.

\* \* \*

Чилгэр бөх бол Чилэдү баатрын дүү бөгөөд том ханхар цээжтэй, дөрвөлжин сархинаган духтай ерөнхийдөө маанаг аймхай эр байлаа. Бөртийг тэдний гэрт аваачихад илтэд цочиж,

-Буруу, зөрүү явдлыг би яахин тэвчинэ. Ахын үйл лайг дүү нь үүрдэг ёс бий юү. Намайг энэ эм үл тоовол яанам. Өөр гэрт хүргэж өгвөл дээр бус уу гэхэд мэргидийн толгойлогч,

-Үг дуугүй асарч ав! гэж тушаав.

Гэр өргөөний зүүн хоймор Бөртийг суулгахад Чилгэр бөх унь өөд харж дальдчин байснаа "сахал өвс түүж завь зангидах минь" гэсээр гарч одлоо. Бөртэ ихэд аймсан,

-Энэ Чилгэр бөх мангар эр юм. Одоо би яана. Шөнийн бор хоногийг яаж өнгөрөөнө гэхэд Хуагчин гунигтай дуугаар,

-Тэмүжин мөд ирнэ буй за гэв.

-Надад аймшигтай байна. Өдөр атал наргүй мэт, сартай байтал саргүй мэт ёроолгүй зовлонд унав, би.

-Тайвшир охин минь. Өдөр шөнийн алинд ч чамаас би үл холдоно. Тэнхээгээ барах юун...

-Мэргидийн хэдэн давхар хүрээнээс яаж амь мултарна. Золбин нохой ихтэй юм. Хонгирадын тал нутаг санагдаад байна.

Бөртэ үжин уйлсаар арайхийн тайвширч түүний зөөлөн хүрэн үс Хуагчины өвөр дээр бутран намирчээ. Хуагчин аргадах аргаа олохгүй цөхнө. Сийлбэртэй явган ширээн дээр тавагтай мах, бортоготой сүү, данхтай цай, цагаан идээ сэлтийг өржээ. Хуагчины хоолойгоор хоол, цай давахад хэцүү байлаа. Гунихарч цөхөрсөн Бөртэ том хөхөө чичрүүлэн санаа алдаад,

-Миний цамцны энгэр норчихсон байна гэж Хуагчинд шивэгнэн өгүүлэв.

-Бие тулгар болжээ, охин минь. Тэмүжинг тэвчээртэй хүлээе. Чилгэр бөхөөс бүү ай. Шөнөд хоёулаа ор дэрээ сольж унтая. Цаадхи сархинаган духтын чинь учрыг би олно гэж Хуагчин амлажээ.

Бөртийн намирсан хүрэн үсийг Хуагчин гөрж өглөө. Өнжөөд Чилгэр бөх тэмтчин явсаар Бөртийн ор руу очиход, Хуагчин тосч авна. Хуагчин, Бөртийн дүрд хувилж Чилгэр бөхийн хүслийг хангаж заримдаа татаарт алагдсан эр нөхрийнхөө сүнстэй орооцолдож байна уу хэмээн боддог болжээ. Чилгэр бөхийн гэрт байх зуур Дайр-Үсүн хэрхэн буй талаар Бөртийг байцааж шаналгана.

## Арванзургаадугаар бөлөг



*Сочихэл хатаны том хөвүүн Бэгтэр галын сорилгод илчлэгдэж амиа алдав.*

*Сочихэл эх мэргидийн хаяа бууцыг барааджээ*



Ав хоморгоос эргэж ирээд хөглөрсөн гэр хүрээгээ орхиж дүрвэж нүүсэн айл хотныхоноо олж очоод Бөртэ байхгүй байсанд Тэмүжин ой шугуй доргитол орилж,

- Намайг тэнгэр ниргэв хэмээн гаслав. Орь дуу тавьсан түүнийг тайтгаруулах гэж оролдсонгүй зөнд нь орхижээ. Есүхэй эцгийг бие барсаны дараа Тэмүжин гашуудан хөлбөрч байснаасаа илүү ихээр гансарч "Бөртэ алга болов. Би өнчрөв. Бөртэ байхгүй байна. Би ганцаардав" хэмээн уулын цуурай түртэл гэнэжээ. Тэмүжин уул руу алга болж тэр үдэшдээ өлсөж цангасан амьтан буцаж иржээ.

-Надад Тоорил вангаас өөр хэн тусална. Би дахин түүнд бараалхая. Хасар, Бэлгүгэй, Боорчи, Зэлмэ Чимбай бид Тоорил вангийн зуслан руу хурдан довтолгож тусламж гуйя хэмээн

Тэмүжин шийдэв.

Өүлэн эх хүүгийнхээ зовлонг хугаслах санаатай "хөвүүн чи зөв боджээ" гэвэл Тэмүжин эхийнхээ шаналасан царайг өрөвдөн хараад "Боржигоны тэнгэрт од харвав" гэж харамсалтай мөртлөө салаа утга бүхий үгийг хэлэв. Эх нь Тэмүжинг өргөөндөө дагуулан орж "хөвүүн минь алгаа тэнийлгэ" гэв. Тэмүжиний алганы зураас гүн тод мөртөө амьдралын зам мөр дээр чагт тогтжээ.

-Мэргид сөнөнө. Амар тайван цаг төгсөв гэж эхдээ Тэмүжин өчив. Анх есөн настайдаа Тэмүжин алгаа харж татаарт хорлогдон морины нуруун дээр хөх сүүдэр шиг яваа эцэг Есүхэй баатрыг харсансан. Тэгэхэд Есүхэй баатар аньсан зовхио хөдөлгөж нүдээ нээгээд "Би өнгөрлөө, Чи үлдэв. Зовох үедээ хөвүүн минь бүү гасла. Жаргах цагтаа бүү тайтгар. Чамаас олон хөвүүн төрнө. Чиний хөвгүүдийн эх Бөртэ мен" гэж хэлэхийг өвс хонгортсон хонгирадын тал хээр нутагт Тэмүжин сонсчээ. Тэмүжин тайчуудаас зугтаж явахдаа эцэг Есүхэй нь зам зааж түүнийг хөтөлж явсаныг мэдэх юм.

Тоорил вангаас тусламж гуйхаар мордохын өмнө Бурхан халдун уул зайран бөө Халзанбухын дүрд нэг хувилсанаа больж Есүхэй эцэг мэт өргөн туушинтай загзгар эрүү нь гүрвэлзэн шүдээ зуух мэт адил зангирч "Хөвүүн минь аавынхаа сэлмийг атгаж явсуу. Наад сэлмээр чинь би татаарын Тэмүжин үгээгийн толгойг хяргасан юм. Салхи сөрж явахдаа сэлмээрээ агаар зүсч хурцалж бай. Онон.Хэрлэн мөрөний бургас өдгөө мэргидийн нуур цөөрмийн хөвөөнд ургаж байгаа, цаашдаа Марал, Каспи, Азовын тэнгисийн сав, Хөх, Шар мөрний эрэг дэнжид чиний нум сум зоогдож Бурхан халдун уулнаас үндэс хөөсөн гүндбалын ургамлын судастай нийлж лугшина" гэв.

"Эцэг минь та миний дуулаагүй, үзээгүй газар усыг юунд нэрлэнэ" гэвэл Есүхэй баатар,

-Би дээд тэнгэрээс бүгдийг тольдож байна гэжээ.

-Тэнгэр эцэг минь...гэж Тэмүжин Бурхан халдун ууланд гурвантаа сөгдөв.

Өүлэн эх хөвүүнийхээ алган дээр сүү дусааж байхдаа "тэр шагайн чинээ нөж хүүгийн алганд шингэжээ. Тэмүжиний баруун гарт үл үзэгдэх учир буй" хэмээн бодоод Бурхан халдун ууланд цацал өргөв.

\* \* \*

Туул голын эхэнд хясаа бүхий өндөр мөргөцөг дээр Ван Тоорилын зуслангийн асар, майхан цацар хүрээлжээ. Асрын хойморт Тоорил хаан Тэмүжиний бэлэглэсэн хар булган дахыг өвдөг дээгүүрээ тэр жилийнх шигээ тохож Тэмүжиний үл шантрах харцыг ажиглангаа "хөвүүн минь мэргидүүд Бөртийг булаав гэж би зүүдэндээ сонсов. Чамайг ирэхийг хүлээх зуур хар булган дахыг авчруулсан билээ. Энэ булган даханд Бөртийн үнэр шингэсэн хэмээн би бодно" гээд Тэмүжинг дэргэдээ суулган,

-Май илж үз дээ. Бөртийн үнэр мөн үү гэж зөөлөн асуув.Тэмүжиний самсай шархирч эвгүйрхэхэд "Есүхэй эцгийнхээ эр хүний нулимс далд байдаг юм" хэмээн зандарч хэлсэн

үгийг санав.

-Тайчуудыг хураахад хялбар байсан. Мэргид том аймаг, их хүчтэй тул амар биш. Жамуха надтай хүч хавсарч чамд туслана гэж амласан. Ногоо нялх байна. Мал цадаж тэнхрэхийг хүлээе. Мэргидийг дарая гэвэл хүлээх хэрэгтэй гэж аминчлан ярина. Тоорилын нүд гүнзгий ухархайдаа хорсолтой гялалзаж байлаа.

Туулын хөвөөний цавчим хадан хясаанд сэлэмний янхийх чимээ цуурайтаж хэрэйд цэргүүдийн зэвсгийн сургууль тасралтгүй үргэлжилнэ. Тоорил ван өрөмтэй цай уух зуур Тэмүжиний аяга руу нойтон өрөм хутгаж хийж загасны түрс, өрөмтэй идэхийг зөвлөнө.

-Надтай дарс хувааж зоогло гэхэд Тэмүжин толгой сэгсрэв.

-Би сөн түших дуртай гэж Тоорил ван өгүүлэв.

-Ван ахын хишигт дуртай гэж Тэмүжинг өчихөд Ван хаан агдганан хөхөрч алгаа чанга ташвал гурван хүүхэн орж ирээд цуурын татаж тавих аялгуунд биелнэ. Хөл, гар, хуруу нь үегүй мэт хөдөлнө.

Тоорил ван,

-Зовлонгоо мартагын тулд дарс хүртдэг юм. Миний

архи хорз мэт, гал дээр дусаавал хөх гал дүрсхийнэ.

Могойн толгойд дусаахад муужирч унана гэв. Вангийн энгүүн байдалд автсан Тэмүжин, - Бөртийг булааж аваагүй цагт би үл тайвширна гэхэд, -Эхнэр солих нь нар, сар мандахтай адил зүйл.

Монголын хаад эхнэрээс болж урвайж байсан түүх үгүй

байхаа гэв.

Тоорил ван хаан Тэмүжинг хурцалж өгчээ.

-Би чиний хүмүүсийг зэвсэг, морь бөхийн эрдэм чадлаар

сорьж үзье гэж Тоорил хаан Тэмүжингээс зөвшөөрөл эрсэн

билээ.

\* \* \*

Ван хааны цэргийн хүрээнд ямааны арьсыг тэлэн татаж, эгнүүлэн сураар холбосон байтай ажгуу. Харваач цэргүүд бай руу чиглүүлэн нум, сумаа онилсон нь Ванг хүлээж буйгаас илт байв. Ван хааны нүдний зовхи цэлхэрч бага зэрэг гархилж хоносон нь өчигдөрийн хүртсэн нанчид, гиншиж хонодог хүүхнээс болжээ. Түүний гар шөрмөслөг, нүд гярхай болохыг

Тэмүжин анхнаасаа сайтар мэдсэнсэн.

Харваач цэргүүд сумаа зэрэг тавилаа. Элдсэн арьс руу шунган исгэрч ороод шургаахан хашаанд зоогдож байна. Ван хаан,

-Уухай...уухай...хэмээн гараа дэлгэв.

-Хасар дүүгийн цэцийг үзье.

-Уухай...уухай...

Хасар харваач цэргүүдийн ард морьтойгоо зогсож байснаа дерөөн дээрээ босч байны эсрэг зүг рүү хурдлан давхиснаа мориныхоо амыг гэнэт хантайртал татаж эргүүлээд нум, сумаа мөрөн дээгүүрээ сурмаг гэгч авч явдал дундаа харвав. Дүүгийн эрдэмд сэтгэл тэнүүн явдаг Тэмүжин яг энэ агшинд түгшиж байлаа. Хасарын эхний сум бай эс оновол Тоорил ван "хоолны сав" хэмээн доромж үг чулуудах энүүхэнд тул Тэмүжин түгшсэн аж. Харваач цэргүүдийн толгой дээгүүр сум ар араасаа дүүлж ямааны арьсыг нүхлэн, шургааган хашааны холтсонд чив, чивхийн зоогдов. Сумны нисэлтэд тааруулсан өд сөд чичирч ганхана. Ван Тоорилын хор хөдөлж дэргэдээ алхаж яваа Тэмүжиний нум, сумыг авч тэнгэрт эргэлдэх харцага тийш илгээв. Цэргийн хүрээнийхэн тэнгэрийн цөл өөд харцгаана. Суманд эгмээ хавуулсан харцага хүрээний төвд үхэтхийн унахад Тэмүжин "цөл газрын хорхой идэж уйгараас амьд ирсэн нь үнэн юм" гэж бодож амжив.

Баруун, зүүн жигүүрт хоёр, хоёр майхан босгосон ажээ. Ван хааны зуслангийн эмс охид, зарц барлагууд, цэрэг, ардууд хүрээлэн тал дугуй үүсгэжээ. Ван хааныг дагалдан шадар цэргүүд, жанжин баатрууд ирэв. Ван өөрийн суудалд суусангүй дээлээ сугалдаргалж, бүсээ чангалав. Түрүүчийн барилдаанд Бэлгүтэй шөвгөрч түүнтэй үзэх бөх олдохгүй байсанд Ван хаан барилдахаар өрөв.

Ван хаан их дуугаар,

-Бэлгүтэй хоёулаа бяраа мэдэлцэе гэлээ.

Ван Тоорил, Бэлгүтэй хоёр хав дөрвөлжин золгож барилдлаа. Ван хаан бол шөрмөслөг мэх олонтой, бусгаж барилддаг хүн байв. Бэлгүтэй залуу хэрнээ тарган махлаг, баргийн сэгсрэлтэд тэнцвэр алдахгүй бөлгөө. Ван хаан хөлөөрөө дэгээ орооход Бэлгүтэй хазайж тогтов.

Барилдааныг сонирхож буй хүмүүс хөгжиж баяссан ажээ. Бэлгүтэйн хөл цочоонд хол гишгэхэд Тэмүжин мэдэгдэхүйц өлмийдөв.

Бэлгүтэй ахын дохиог авч Ванг муриж ташаалдахад дагаж хавирах гээд унахад Тоорил ван тэгнэн цээжээрээ дарлаа. Тоорил хааны албатууц уухайлан баясахад тэрбээр зальтайхан инээвхийлээд "Тэмүжиний залуус идэр настай, золбоолог юм" гэж атаархан бодож байлаа. Тайчуудыг хурааж авах тулалдааны дараа "Боржигоны хүрээ томорвол дийлдэхээ болино" гэж Тоорил хаан бодсоноо энэ удаа бас санаж билээ. Ацат шонгоос уяатай морьд ялаархана.

Бэлгүтэй унасан газартаа суусан чигээрээ бортоготой цэгээ залгилж, нэг гартаа шаант чөмөг зулгааж байна.

Вангийн хүрээний морьд тарган, угсаа сайт хүлэг унасан охид, хөвгүүд хэрэн сүлжилдэж байв.

\* \* \*

Ван Тоорил Хасарт бугын эвэрт нум, сум бэлэглэсэн билээ. Хасар байн байн нумаа илж байснаа тэсгэл алдан шувуу харваж унагав. Тоорил ван мориныхоо дэл болоод сүүлнээс цөөн үс авч шатаагаад орхив. Эл домьг Тэмүжин давгав.

-Хүлгийнхээ шандасыг сорих уу хэмээн Ван хаан шимтэнгүй өгүүлэв.

-Хэрэйдийн хүрээ цөм уралдах уу гэж Тэмүжин асуув.

Хэрэйд аймгийн морьтон ард, цэргүүд тэднийг бүчив. Ван хаан их дуугаар,

-Мээм манхан хүртэл уралдана шүү гээд морио давиран чүү ...хэмээн уухайлав. Морьгнууд хашгаралдан морьдын туурайгаар газар бөмбөрдөн ухасхийлээ. Туул голын задгай хөндий морьдын хөлс, амьсгаанд давчдан тоосонд умбав. Хурдан хүлгүүд хойно, урдаа орон, хөвгүүд, охидын хашгираан замбараагаа алдаж, ташуурын сур агаарт салхи татуулж байлаа.

Мээм манханы ар шил дээр Ван Тоорил, Тэмүжиний хамт зуузай холбон гарч ирээд "чиний шарга морь асч байгаа гал шиг хурдлах юм" гэж Тоорил ванг магтахад Тэмүжин "таны цагаан азарга аянга цахилгаан шиг хурдан" хэмээвэл хоёул баясан хөхрөлдлөө. Мэргидийг дайлахаар тусламж гуйж очиход Тоорил вангийн ийнхүү аяглах нь Тэмүжинд таатай байлаа. Ямар нэгэн сорилтонд орж байгаагаа Тэмүжин мэдэрч "Тоорил вангийн сайхан зан мөд замхарч магад" хэмээн бодох мөртөө,

-Жамуха андаа бэтгэртэлээ санаж байна гэвэл Тоорил

ван,

-Жамуха ч Бөртийн төлөө сэлмээ сугалах хүндээ гэж өдөөв. Дэй Сэцэний гэрт байдгаараа инээчихсэн Жамухын товшуурдаж байсан дүр зураг тодроход Жамуха Бөртийг сүүдэр шиг дагадаг нь санаанд орж Тэмүжиний сэтгэлд жихүүцэл төрөв. Тэмүжинг гэртээ буцахад Жамуха, Дэй Сэцэнийд үлдсэн. Бөртэ, Жамуха хоёр удаан хамт байсан бус уу. Мал бол удах тусам ижилсэж, хүн болохоор уйддаг гэл үү. Жамуха, Бөртийн төлөө сэлмээ сугална гэдгийг Тоорил ван яаж мэдэв.

Намайг Ван Тоорил хүүтэйгээ ах, дүү болгодог нь нэг л учиртай. Нялх Сэнгүм бол над шиг зовлон зүдүүр тулаагүй эрх танхи хүн. Хат суугаагүй эрийг итгэхэд бэрхтэй.

Тэмүжинг бодолд дарагдан явтал Туул голын гүн цүнхээл тушаах хадан хясаагаар ёл шувуу бөөнөөрөө эргэлдэнэ.



-Тэнд үхдэл гарчээ гэхэд Ван хаан,

-Цовдолсон цэргийг ёлын идэш болгож байгаа юм гэв.

-Яагаад тэр билээ, вантаан!

-Адууны хулгайчийг амьдаар нь ёлын идэш болгодог хуультай юмаа.

-Хатуу хууль байна.

Хадан хясаанд цовдолсон цэрэг хэдийнээ үхэж хэлхээтэй араг яс санжиж байлаа. Үхдэл үзээгүй цэргүүдийн үнхэлцэг хагарч тул ёлын хоол хаднаас удаан хугацаанд зүүгээстэй байдаг бөлгөө.

\* \* \*

Уулын хэц дэрлэсэн бөрлөн сарны наана адуу тургиж, хөвд өвсөн дотор хярсан туулайг махчин үнэг барьж идэхээр отож хэвтэнэ. Асарт ван Тоорил шалдан хүүхний биед төөнүүлэн бодол болно "Тэмүжин зүгээ олжээ. Тэмүжин хөвүүн оготно, зурамхан барьдаг сар шувуу биш болжээ. Мэргидийг дайлахад Есүхэйн хөвүүний тар танигдана. Есүхэй мохдоггүй баатар байсан юм" Ван Тоорил хүүхний шалдан гуяыг илж бодож байлаа.

Тусгайлан бэлтгэсэн асарт Тэмүжинг нөхдийн хамт оруулсан билээ. Үдэш Тоорил хаан, Тэмүжиний чихэнд хушугаа нааж "хэрэйдийн охид энхрий шүү" . гэхэд Тэмүжин найр тавьж "дараа ирэхдээ амраглая" гэж шуудхан хариу өгчээ. Тоорилын зальтай нүд Тэмүжинийг янзгүй өрөмдөн харж "ганцаараа хоноход сэрүүхэн бус уу" хэмээн цаашлуулна.

"Тоорил ван намайг хүлж авах бодолтой байна. Ван хаан шалиг хүн юм. Эцгийн гэрээсийг биелүүлэхийн тулд Ван Тоорилтой найрсаг байж, хэрэйдийн хааны аяыг олоё" Тэмүжиний нойрон дунд бороо шаагиж, нохой хуцна.

Маргааш нь Ван хаан, Тэмүжинд аминчлан,

-Нар буцаж бороо цутгаж эхлэв. Жамуха анддаа болзоог сонсгож хэл хүргэ. Сэнгүм та хоёр ах дүү мэт явагтун гэж захив.

Ван хааны асраас малчдын хот айл хүртэл Тэмүжин мориныхоо жолоог татан хатирч, шовх, шовх уулын модтой хаяагаар дэргүүлсээр хэрэйдийн нутгаас холдлоо. Хасар, Бэлгүтэй хоёр ахынхаа хоёр талд дөрөө хоршуулж явахдаа,

-Хууль хатуу байвал иргэдийн чих зөөлөн гэж Тоорил хааны өгүүлсэнийг нягтлан болгоохыг Тэмүжинд сануулж байв.

-Манай Боржигон аймагт хууль хэрэгтэй бусуу хэмээн Тэмүжин бодно.

## Арвандолоодугаар бөлөг



*Жамуха анд Мөнгөлөнгоо хатаныхаа аманд хурганы сүүл үмхүүлж нөгцөөгөөд*

*"өөр эрийн бус миний зүрхэнд мөнх орш" хэмээн өгүүлж Тэмүжинээс урвав*



Морьт цэргүүд галд автсан мэргидийн суурин хүрээнд дайрч орлоо. Мэргидийн ард иргэд айдас хүйтэст авган чарлаж хашгирна. Хүрээлж буусан гэрүүд шатна. Гэрийн хаяагаар эгнүүлж тавьсан үхэр тэрэг, морин тэрэг, хураалттай бараа, ноосонд гал авалцан хиншүү хярвас ханхлаж, дотор муухайрам хашгираан, сандарч мэгдсэн хүмүүс ой руу дутаан шургах ажээ. Түүдэг барьсан цэргүүд галдан шатаахын ТУЛД улангассан байлаа. Түлээ ачсан үхэр тэргэнд хөллөгөөтэй бух зүтгэсээр байгаад тэргээ хөмрүүлж орхив. Мэргид цэргийн цавчих, тулалдах муугүй бололтой. Ой шугуйгаар дүүрэн сандралдаан гэв гэнэт үүсч, боржигоны баатрууд уухайлан орж ирсэн нь мэргидийн хүрээг түймэрт автахад хүргэжээ.

Тэмүжиний нүд тогтворгүй эргэлдэн эхнэрээ эрсээр байна. Ханцуй шамлаж, сэлэм атгасан түүнийг Боорчи, Хасар, Мухулай гурав дагалдана. Аравт, зуутаар хуваагдсан баг цэргүүд мэргидийн хот айлын гадна хүрээг сандаачин, зугатагсдыг хөөн гүйцэж эмс хүүхнүүдийг нэгэн дор бөөгнүүлэн хашиж байв. Зарим газар өвс ногоо хуйхлагдан харлана.

Морины омруун дор харагдах гэрийн туургыг Тэмүжин сэлэмний үзүүрээр хүү татаж хаяад,

-Энд хэн буй, гараад ир! ...хэмээн омогдов.

Арайхийн овог аймгаа бөөгнүүлэн байтал Бөртэ булаагдаж эртний өш нэхсэн мэргидүүд боржигоны хот хүрээг талж орхив. Бөртийн төлөө гашуудан шаналсан Тэмүжин, Тоорил хаан, Жамуха андтайгаа хүч хавсран мэргидээс өш нэхэж иржээ. Мэргид бол том аймаг билээ.

Загасчид, булганы анчид, завьчид мэргид аймагт олон бөгөөд том нуур, голын усыг эзэгнэн аж төрж, наймаа арилжааны хүчээр эд агуурс хурааж хуримтлуулсан нь арвин бөлгөө.

\* \* \*

Өчигдөрхөн хусан ойн цоорхойд байрласан Дайр-Үсүний өргөөнд Бөртийг авчрав. Дайр-Үсүн гэгч оворжуу, шар сахалтай толгойлогч зарц руугаа толгой дохив. Зарц ухасхийн нимгэн торгомсог дээл авчирч Бөртэд нөмрүүлэв. Бөртийн тунгалаг хүрэн нүд нэгэн цэгийг онож огт хөдөлгөөнгүй зогсоно.

-Чамайг Чилгэр бөхөд асруулав. Маанаг бөхийн дэргэд хэцүү бус уу. Миний өргөөнд ирэх үү гэж Дайр-Үсүнийг шаардангуй өгүүлэхэд Бөртэ "Мед Тэмүжин ирнэ. Яахыг Тэмүжин танд хэлэх биз" гэхэд мэргидийн толгойлогчийн баруун нүд сөлөртөн гөлтөгнөв. Тэгээд Дайр-Үсүн,

-Боржигоны Есүхэй баатар Өүлэнг булаасан. Хорин жилийн дараа мэргидүүд өшөөгөө авч Бөртийг авчрав. Хэний буруу вэ. Намайг Тэмүжинээр айлгана гэвэл нөхрийн чинь баруун гарыг цавчиж чамд өгнө гэж хэлэв.

Бөртэд нөмрүүлсэн торгомсог дээл түүний тэгш сайхан нуруу руу гулгасаар ширдэг дээр уналаа. Энэ сацуу Дайр-Үсүн туламтай алтан үрэл гаргаж самарсанаа нэг атгыг Бөртийн толгой дээр бороо шиг савируулан урсгав. Алтан үрэл газраар тогтворгүй өнхрөн ширдэг дүүрэн асгарч өнхөрлөө.

-Алт мөнгөн үрлээр наадах уу хэмээн Дайр-Үсүн арга ядсан байдалтай Бөртөөс асуухад бүсгүйн нүдний хүүхэн хараа томорч, ягаахан хацар дээгүүр сэвх тодроод ирлээ. Бөртийн нүүр, хамарт үл мэдэг сэвх тогтож, хэвлий нь тэгш болсныг мэргидийн толгойлогч ажиглав. "Чилгэр бөхийнх мөн үү" хэмээн Дайр-Үсүн толгой гашилган бодож "Чилэдү ах минь Өүлэн эхийн савыг хоосон буцаасан. Өүлэнгээс хойш гурав гэрлэсэн боловч Чилэдү ахаас хүүхэд төрөөгүй бус уу. Гэтэл одоо Бөртэ тулгар аж. Хуагчин мэдэх нь мэднэ. Надад хэлэх болов уу, үгүй болов уу" хэмээн шаналж байлаа.

Ширдэг бүтээж унасан дээл түүний нугалаа, хормой хотсоор алтан үрэл өнхрөн хөглөрч Дайр-Үсүн шүдээ хавирч сууна.

-Бөртэ чи миний хатан бол. Надтай суучих.

-Би Есүхэй баатрын хөвүүн Тэмүжиний хатан билээ.

-Чамайг Чилгэр бөхөд асруулчихсан байхад уу.

-Хорьсоныхоо хариуг Чилгэр бөх амсах байлгүй.

-Бие давхар мөртөө Тэмүжиний тасарсан гарыг харахыг хүсээд байна уу.

-Мэргидийн толгойлогч та надад одоо өөрөө толгойгүй харагдаж байна шүү.

Мэргидийн шивэгчин гэрт Хуагчинг түлхэж оруулав. Хуагчины хотгор нуруу, урт гэзэг, хацар дээр нь гогцоорсон шанхны үс Дайр-Үсүнд ер бусын жавхаалаг, хөгжимлөг санагдав. Ташуу энгэртээ дээлийн нь имжээр ялигүй сэмэрч, хацар нь шуугдаж хонхойсон боловч Хуагчин гоо үзэсгэлэнтэй байлаа. Дайр-Үсүн үгний сэвэнд дургүйцэж Бөртийг харахаас цэрвэнэ.

Өргөөний зүүн хатавчинд хөдөлгөөнгүй зогсох Бөртэ хөшөө чулуу болж Дайр-Үсүнд санагдахад нүдээ сөлөртүүлэн аньж үзээд "ийм үзэсгэлэн төгс чулуу байдаггүй юмсан" хэмээн бодож "муу ёр шүглэжээ" гэж өөрийгөө тайвшруулж үзэв. Дайр-Үсүн гэнэт нөмгөн тэрлэгээ чулуудаад,

-Бузар эмсийг гэрээс холдуул гэж байдаг чадлаараа хашгирав. Зарц барлагууд Бөртэ, Хуагчин хоёрыг хөтөлж өргөөнд нь аваачив.

\* \* \*

Тэр шөнө Дайр-Үсүн үхрийн ширээр оёсон хантааз өмсөж, нум сум, сэлэм хоёроо ёрлон барьж үзсээр хоножээ.

Олзлогдсон Бөртэ намайг толгойгүй харагдаж байна гэв үү. Шуурганд дайвалзан ганхах хус лугаа сэтгэл нь тогтворгүйтсэн Дайр-Үсүн мандах нарнаар аймшигт шуугианыг сонсоод шөнө дүл өнгөрөөж унтсан тул нүдээ нухалж бослоо.

Дайр-Үсүн эмээлтэйгээ хоносон борлог мориндоо үсрэн мордож боржигончуудын довголгооноос зугаджээ.

\* \* \*

Гол, горхи, нуур цөөрмийн завсар тохой эрэг мөргөцөг, хавтгай дэвсэг дэнжид буусан айлуудын үхэр мал мөөрч бужигнаанд оров. Бөртийг олж хараагүйдээ хорссон Тэмүжин "Надад Бөртэ хэрэгтэй. Мэргид иргэнийг амьд үлдээж болохгүй" хэмээн зар тараав. Мэргидийн баруун талаас Хэрэйдийн цэрэг, зүүн талаас Жамухын цэрэг гуагчин орж, үнс нурам, хөө тортог усны цэнгэг мандал дээр хийсэн бууна. Ван хааны гүн ухархайтай гөлтөр нүд Тэмүжинг буландаж,

-Эрсэн хүнээ олбол хэл дуулгаарай гэх мөртөө цусанд шунасан мэт гөлмөө давиран дархийлгэв. Ванг хэрэйдийн гурван жанжин баатар таширлан дагах ажээ. Нэгний нь морины хүзүүнд сум зоогдоход баатар эр суга татвал морины гүрээнээс сацарсан цус дэргэдэх цэргийн нүүрийг будав. Морь үхэтхийн унав.

Мөнөөх цусан нүүрт цэрэг Хадагбаатар хэмээх жанжинг морьгүй болмогц өөрийн морийг унуулж, зэрэгцэн давхих мэргидийн араар сундлангуут зоо нуруу руу нь сэлмээр дүрж алаад эмээл дээрээс нь ховх татаж шидлээ. Хүзүүгээрээ бугуйлдуулсан мэргид эрийн толгой тасарч, их бие рүү нь модны хожуул шааж орохыг Хадагбаатар бахархан харна. Алаанд улангассан цэргүүд тал тал тийш морины хурдаар дүүлж байна.

\* \* \*

Хоёрдох өдрийн үдээс хойш үймээн дундаас Сочихэл ургасан юм шиг гарч ирэхийг Тэмүжин харлаа. Түүний хувцас ноорч, нүүр царай нь халтартаж, эрүү уртассан байлаа. Дээлийн ханцуй ханзархай тул улаан суга нь харагдахад Тэмүжинд өрөвдөх сэтгэл төрөв. Онхолдож дутуу шатсан модон тэрэгний цаагуур Сочихэлийг далд орохыг Тэмүжин үзээд морины хурдаар нэхэн довтолгов. Гэвч Тэмүжиний яг чанх урд Хасар морьтойгоо хөндөлсөн орж,

-Бөртэ мэргидийн зүүн хүрээнд буй гэнэ. Тийшээ очъё хэмээн агаар эрчлүүлэн хашгирав. - Сочихэл эх үзэгдэв гэвэл Хасар -Орхи...! Хоёулаа тийшээ явья гэлээ.

Морьдын хөл дор өвсний үндэс шороотой зууралдсан хэвээр ховх үсэрлээ. Хасарын араас Тэмүжин морины хурдаар одоход аргамагийн амьсгаа нүүр рүү төөнөж адууны эхүүн шорвог хөлс өвсөн дээгүүр дусалж байв. Хасарын очсон гэрийн үүдэнд мэргид цэрэг зогсож байснаа сэлмээ сугалан архиран дайрлаа. Цэргийн нүүрийг Хасарын сэлэм хоёр хувааж, үүдээр цухуйсан нэг цэргийн нугасыг тас цохив. Мориноос үсрэн буусан Тэмүжин гэрт гүйж орвол Бөртэ үсээ задгайлж цааш харан явган суужээ.

Бөртийн тэгш гоолиг сайхан нуруу, бөхийсөн тэргүүн нь Тэмүжинд сэжиг бүхий санагдахад гайхав. Бөртэ огт хөдөлгөөнгүй сууна. Тэрбээр үл тайтгарах шаналалд автжээ. Тэмүжиний араас Хасар үүд сөхөж,

-Энэ Чилгэр бөхийн орон гэр юм байна гэхэд Тэмүжин "байз, би Бөртийг олсон" хэмээн гүвтнэв. Бөртэ суусаар байснаа аяархан босч Тэмүжин рүү эргэж харав. Сөхсөн үүдийг Хасар буулгав. Бүсгүйн нүүр царай гэрэлтэж, гэрлийн цаана сэвх борлож байхыг Тэмүжин харна. Тэмүжиний цээж дэлбэрэх шахам оволзож "Хуагчин хайчсан бэ" гэж асуувал "намайг асарч буй" хэмээн Бөртэ өгүүллээ.

Бөртийн нүдний харц гэгээ татаж Тэмүжиний зангидсан хөмсөгний хооронд зурвас гэрэл ойж, үсний нь ширхэг сувд дуссан шиг харагдана. Хүүхний харц эр нөхрийхөө нүд рүү уусан шингэж чичирсэн гараа сарвайлаа. Бөртийн хурууны өндөг жимс мэт ягаарч, тод ирмэгтэй уруул нь хүүхдийнх шиг хөдөлж Тэмүжинд дөхөв.

Тэмүжин Бөртийг хөтлөн гэрээс гарвал Хасар бүсгүйг эмээл дээрээ сэвхийтэл өргөн дүүрэв. Бөртийн нүднээс тув тунгалаг нулимс мэлтрэн Тэмүжиний гар дээр уналаа. Тэр нулимс бөнжийтэл тогтож Тэмүжин болоод Бөртийн хос нүд хоёр талд нь ширтэж байлаа. Дусал бөөрөнхий нулимс дотор эр, эм хоёрын хос нүүр бас багтав.

\* \* \*

Мэргидийн зүүн хүрээ эзгүйрч, тэнд байсан иргэд эр, эмгүй хүүхдээ дагуулан дүрвэжээ. Чилгэр бөхийн гэрийн үүднээс үхсэн цэргийн хоёр хүүрийг зайлуулж хаяв. Өндөр хусны оройгоор шүргэх шахам шувууд дэрхийхэд Тэмүжин сэжиг авч тийш дөхлөө. Гэнэт Тэмүжиний хойно эцэг нь явах мэт болов. Есүхэй баатар үе үе хөвүүнийхээ дэргэд ирэх юмуу эсвэл уул, үүл болон хувирч Тэмүжинг хардаг билээ. Тэмүжин эцгийнхээ тамирлаг алхалт, хүйтэн царайг харахаар эргэв. Эцэг байсангүй. Дахиад нөгөө зүг рүү эргэв. Тэндээс Чилгэр бөх уулгалан дайрч айсуу. Чилгэр бөхийн хүрэн нүүр, том уншуу хамар, шүлэнгэтсэн зузаан уруул Тэмүжиний нүүрийг нөмрөн авав. Тэмүжин гавшгай хөдөлж суун тусаж бултахад мөнөөх Чилгэр бөх биеийнхээ хүчинд дийлдэн хэд харайгаад эргэж дайрав. Түүний хуншгүй байдал Тэмүжинг барьж аваад хүзүүг нь хуга мушгих санаатай аж. Тэмүжиний гарт сэлэм эргэлдэн, алга нь халуун шатаж, бух байвч газар мөргүүлж чадахаар тэнхээ амтагдана.

Барьж авах оролдлого бүтэлгүйдэхэд Чилгэр бөх хурц үзүүртэй ац модон жад атгаж Тэмүжинг сүлбэхээр бэлтгэв.

-Тэмүжин бибээр Чилгэр бөх чамайг үхүүлнэ.

Надад амь байвч амь үгүй мэт, сүр байвч сүр үгүй мэт, сүүдэр байвч сүүдэр үгүй мэт болжээ.

-Чиний үхээрийг удахгүй хэрээ тоншиж, судас шөрмөсөөр чинь өт хорхой тархан гүйлдэнэ. Хатныг минь асарсан чи түмэн нүгэлтэй бус уу.

-Амийг минь өршөөвөл өвдөг доор чинь өвдөглүүлж, өлмий доор чинь гишгүүлж явъя.

-Намайг бүү ширт! Нүдээ ань...

Чилгэр бөх үгийн солионд тамирдаж туйлдсан бөгөөд Тэмүжиний хэлсэн ёсоор нүдээ аньжээ. Хорхой идсэн баавгай лугаа давшилж, дайрч байсан Чилгэр бөхийн зориг илт мөхсөн тул Тэмүжин эргэлзэв. Гэтэл Чилгэр бөх уулгалан дайрчээ. Ирт сэлэмээрээ хусан жадыг ташуу хувааж орхив. Дараагийн агшинд Чилгэр бөхийн мөрийг цуулж, унжуулахад тэрбээр ташуу цавчигдсан модоороо газар хатган унав. Цусанд будагдсан сэлмээрээ Тэмүжин агаар зүсэхэд өнгө нь улам гялалзаж байлаа. Тэрхэн зуур

Хуагчин хаанаас ирсэнийг бүү мэд Чилгэр бөхийн хажууд зогсоно. Хуагчин мэгшин уйлна.

-Хуагчин чи юунд харамсана гэвээс Тэмүжиний зориг зүрхийг мэдэх хойно эхэр татсан хэвээр,

-Чилгэр бөх буруугуй. Тэр огт буруугүй... гэв.

-Түүнийг яагаад өмөөрнө вэ? гэж Тэмүжин асуув.

-Бертийг хүмүүст захиж үлдээгээд намайг авч оргосон билээ. Тэр их аймхай хүн. Замаасаа буцсан. Чамд цавчуулжээ. Чилгэр бөх хагсарсан эм намайг тоож байсан юм. Одоо би Бертийгөө очиж асрах минь...

Хуагчины өчиг Тэмүжиний цээжийг цээлшүүлэв. Тэрбээр гүн хөх тэнгэр өөд гараа сарвайж

"тэнгэр эцэг минь" хэмээн дуу алдлаа. Тэнгэрийн хөх дайдад эрднийн шигтгээ мэт үй түмэн гялбаа хөөцөлдөн, зах хязгаар руу хошууран одогч тэрхүү урсгал үл тасрах ажээ. Багадаа хаан суудлыг чулуугаар өрж Бэгтэр хоёул өрсөлдөн сууж Тэмүжин хоцрох бүрдээ хорсдог байжээ. Харин Бэгтэр хоцрох юм бол үл тооно. Хаан суудлыг Бэгтэр нурааж хорлоно.

Багаасаа Тэмүжин өөрийгөө нууж чаддаггүй байжээ. Тэмүжиний нууц түүний баруун гарт байдгийг татаар, тайчууд, мэргидийн толгойлогч нар хожим мартаж санасандаа дэндүү гэмшжээ.

## Арваннаймдугаар бөлөг



*Монголчууд өөр хоорондоо мал сүрэг, нутаг бэлчээр, эмс охидоо булаалдан дайтдаг байсныг*

*Чингис хаан тасалж нэг гарт атгаж нэгтгэв*



Бөртэ гөлөрчээ. Түүнийг Хуагчин алгадав. Бөртийн нүднээс нулимс асарч Хуагчины дээлийн энгэр ус цацсан мэт нойтон болов. Аргаа барсан Хуагчин, Бөртийг цочоож хэвийн байдалд оруулахын тулд, нөгөөтэйгүүр олзны хэдэн сард доромжлуулах вий хэмээн айснаас үүдсэн сэтгэлийн хүлээсийг алдруулж таслахын тулд алгаджээ. Алгадсан хойноо Хуагчин аймсаж ширвээтэв. Тэд тэврэлдэн сууна. Хээрийн задгай цацрын үүдээр төгсгөл болоогүй дайн дажины бужигнаан, утаа униар харагдаж, уйлах, чарлах, зандрах сонсдоно.

-Аяга шөлөө ооччих гэж Хуагчин хушуу цорвойно.

-Дотор эвгуйрхээд ...хэмээн Бөртэ цааргална.

-Тэмүжин уурласан уу

-Үгүй дээ, тэр уужим бодолтой юм



-Сочихэлийг олж авсан болов уу

-Мэргидээсээ салах дургүй юмсан уу. Уг нь Сочихэл бид хоёрыг Есүхэй баатар эм болгосон юмдаг. Сочихэл мартаагүй баймаарсан. Тэр хүүхэн татвар эм шиг байсан боловч Есүхэй баатрын хоёр хөвүүнийг тээж төрүүлсэн биш үү. Одоо тэгээд мэргидийг дагах болов. Онон мөрөний хөвөөнд тээр жил нэг газарчин ирж Сочихэлтэй унтаад явсан гэдэг. Тэр нь мэргид байж мэднэ. Сочихэлийг морины цулбуураас хөглөөд давхичихсан эрийг би хальт харсан. Одоо бодоход тэр газарчин мөн санагдана.

-Хов зөөдөг эмд хонгирадууд угаас дургүй. Боржигончууд мөн адил дургүй

-Хөөрхий Сочихэл минь мэргидийн хаяа бууцанд зовж явна уу. жаргаж явна уу, хэн мэдэх билээ.

-Хуагчин та байгаагүйсэн бол би бузарлагдах байлаа. Таны ачийг яаж хариулах билээ.

-Анхны хүүхдээ хээр төрүүлэх нь дээ, Бөртэ минь! Энэ хүүхдийн хувь заяа ээдрээтэй байна. Миний эр нөхрийг татаарын Тэмүжин үгэ цавчиж алаад баригдахад Есүхэй баатар Тэмүжин үгээг цавчиж алсан гэдэг. Яг тэгэхэд Тэмүжин төрсөн юмдаг. Боржигон болоод татаарын үсэрсэн цус Тэмүжинд наалдсан. Чиний төрүүлэх хүүхдэд мэргэдийн цус наалдана. Чилгэр бөхийг Тэмүжин цуу цавчив.

-Мангар том биетэй, аймхай эр үхэв. Би ихэд өрөвдөнө.

-Би амаржих нь. Хүүхдэд өлгий зэхэх юм шүү.

Бөртийн хамар дээгүүр хүйтэн хөлс дааварлаж, тунгалаг нүд нь зовиуртай хэрнээ зөөлөн ээнэгшүү болжээ. Хуагчин, Бөртэ хоёрын шивнэн ярьсан үгс морин туурайд замхран арилж, гөлөм дэрхийв. Дайны талбар дээгүүр сүрэг, сүрэг хар шувуу бужигнан үймж үхдэл сэгийг тонших ажгуу.

\* \* \*

Хэрэйдийн хааны цэргийн цацарт очин очитолоо Тэмүжин зөвхөн Сочихэл эхийн тухай бодсоор байлаа. Тайчууд эзгүй бууринд хаяад нүүхэд Сочихэл боржигоны хот айлд цуг үлдэж цөөн мал, багахан хүрээгээ хараад нулимс дуслуулж билээ. Бэгтэрийн булхай илэрч алуулсан хойно тайчууд руу нүүж одоод гурван хаврын нүүр үзэлгүй буцаж ирсэн Сочихэл хот айлдаа эв найртай амьдарсаар байсан ч гэлээ цаанаа тогтворгүй ялангуяа Өүлэн эхтэй машид атаархана. Өүлэний гишгэсэн газар гишгэж, Өүлэний уусан цайг ууна. Ер нь боржигоны хот айлд Өүлэн, Сочихэл хоёрын эрх мэдэл эн тэнцүү байсаар атал Сочихэл "намайг хэн гадуурхав, хэн ад үзэв" гэх шиг бусдаас өө эрнэ.

Сочихэл үзэсгэлэнт нэгэн бөлгөө. Хонхотны Мэнлиг, Чирха эцгээ өөд болсоноос хойш өөрийн эмийг бус Сочихэлийг бараадан, шөнө дунд сүүдэр мэт тэдний гэрт хоноглож, үүрийн цайвар гэгээнээр адууны бэлчээрээс давхин ирэхийг мэдсэн Өүлэн эх нэг удаа "хэрүүл дэгдвэл хөвгүүдэд муу бус уу" гэв. Мэнлиг хариу болгож "эр эмийн явдалд нүд сохор,

чих дүлий явах нь дээр биш үү. Есүхэйн захиасыг умартсан бол маргааш ачаалай" гэжээ. Хонхотны Мэнлиг эхнэр, хөвгүүдээ дагуулан нүүж одсон билээ.

Тэднийг нүүсэн хойно Сочихэл гомдол мэдүүлэн "Өүлэн минь намайг гоочлох юун. Өглөө эрт босож, шөнө аажуу унтаж, өнчин хөвгүүд, охидыг арчилж тэтгэсний төлөө юунд Мэнлигийг буруушаав. Надад ч, чамд ч эр сүвтэн хэрэгтэй бус уу" хэмээн өөрийг нь дайруулан хэлжээ.

Мэргидийн зүүн хүрээний эзгүйрсэн буурин дээр Сочихэл эх Тэмүжинг үзсэн атлаа үзээгүй юм шиг, харсан мөртөө хараагүй юм шиг зугатаж хаяа нь үл үзэгдэх хусан төгөл рүү шургажээ. Сочихэл эхийн үзэсгэлэн хэвээр байтал хувцас хунар гандуу ажгуу. Тэмүжин, Бэлгүтэй дүүдээ "Сочихэл эхийг ологтун" гэж даалгав.

Хугас өдрийн дараа Бэлгүтэйн том гүжир бие цөхрөлд автсан байлаа.

-Эхийгээ олов. Тэр бас зугатав.

-Өндгөө тоншдог хөх бух биш дээ. Буруу үйл хийсэндээ үрээсээ бултана уу. Гэмийг гэм гэлгүй арчлан тойлж явах юмсан. Яах нь энэв.

-Ичиж байгаа бус уу. Ичих нүүртэй учраас ойд алга болов.

-Эжийтэй минь адилхан эжий билээ. Их, бага гэрийн ялгаа юун. Ордог үүд, уудаг аяга, унадаг морь нэгтэй явсан Сочихэл эх минь юунд нүүр буруулав гээд Тэмүжин Ван хааны цэргийн отог өөд давхив.

\* \* \*

Тэмүжин рүү Тоорил хаан жоготой харж, -Юу бодно, юу хүснэ хэмээн гелтгөр нүдээрээ инээвхийлэв.

-Бөртийг олж мэргэдийг дарахад та туслав. Тусыг би тусаар хариулна.

-Нэгмэдэхэд өдөлдөг нь шувууны ангаахай юмсан. Нүдэн дээр өсч өндийдөг нь хүний үрс билээ. Мэргидээс олзолсон эмс, охид, зэр зэвсэг эд зоорийг Жамухатай гурвуулаа эн тэнцүү хувааж авбал ямар вэ.

-Надад Бөртээс өөр үнэт эрдэнэ үгүй. Ван эцэг та, Жамуха анд хоёул олзыг авсуу. Би эргэж уулзах нүүртэй үлдэе.

-Тэмүжин хөвүүн минь Нялх Сэнгүмийн эрхийнээс хөтөлж, хэрэйд, боржигон овогтны холбоог мэдтүгэй.

Тэмүжин, Тоорил вангийн үгийг анхааран сонсож байхдаа "үргэлж Нялх Сэнгүмийг надад даатгах юм. Тэр танхи хөвүүн ямар санаатайг тэнгэр мэдэхээс би яахин мэднэ. Нялх Сэнгүм намайг гэвэл найрсаг байя. Ван ахын бодол өөрийн үрийн тулд юм. Сэнгүм хүчтэй болбол эцгээ ад үзэж, намайг тээр шаах магад. Жамуха анд Сэнгүм хоёр дэндүү сүжрэх болжээ" хэмээн саналаа. Яг энэ үед Жамуха байдгаараа инээмсэглэн давхиж ирээд ямар нэгэн хар

авсан байдалтай,

-Мэргид баян юмаа. Булганы арьс, алтан үрэл, мөнгөн бөмбөлөг, завь хуртэл байна шүү. Зугаацах эмсийн дунд хөв хөх нүдтэй охин байна. Одоохон очиж найр хийе гэвээс Тоорил ван эрхэмсэг тэргүүнээ өргөж зэмлэх янзтай,

-Тэмүжин хөвүүн Бөртэ рүүгээ яарч байна. Гэтэл чи эд агуурст шунаж байдаг гэснээ "алив миний богцыг авчир" гэж тушаав. Хээрийн цацраас шадар цэрэг тас хар богц авчрав. Тоорил ван богцноос бариулыг алтан арслангаар урласан хоёр төө хутга гаргаж хуйнаас сугалсанаа,

-Бөртээс хөвүүн төрнө гэж би бодно. Үүнийг түүнд өмч болгож өгье гээд сарвайхад Тэмүжин хутгыг ёс төртэй хоёр гардан авч хуйлсанаа,

-Хөвүүн гэв үү... Хөвүүн... хэмээн дуулдахуйц шивнэн хэлэв. Жамуха андын инээд аажмаар замхарч Тоорил ванд илт дургүйцсэн мэт болоход "Тоорил ван ч надад өршөөлтэй юм" гэж Тэмүжин бодов. Жамуха дахиад инээвхийлэхийг оролдовч түүний завьжинд үрчлээ үүсч алт, мөнгөнд дурласан хүйтэн харцаа Тэмүжиний гарт буй хутган дээр тогтоон,

-Охин төрвөл яана... гэж байж ядан өгүүлэхэд Ван хаан холын цэнхэр уул дээгүүр харах мэт тэргүүнээ өргөөд,

-Надад мөнгөн могой ороосон гоёлын сав буй хэмээн Жамухыг хатгав. Жамуха, Тоорил хааны цацар руу нүд булаандан "Та ч алт эрдэнэс цуглуулчихсан юм шив" гэхэд Ван хааны гөлтгөр нүдэнд өрвөлзсөн шар гэрэл гялалзан,

-Та хоёрт байгалийн үүслийн тухай заадаг монхор цагаан залуу, тэнгисийн эрэг дээрхи Константинополь балгадаас авчирсан эд шүү. Би олзноос хумслах дургүй хэмээн Жамухыг мохоолоо.

Тэмүжинийг мордохоор завдахад Тоорил ван, Жамухад хандаж,

-Олзыг хоёр хуваана гэв. Жамуха инээдээ барьж ядан,

-Тэмүжин анд олзонд дургүй юмуу гэхэд Тоорил ван, -Бүл нэмэх гээд сандарч буй гэлээ. Толгойн оройгоос бууж яваа Тэмүжиний араас Жамуха давхин очиж,

-Анд минь Хурханаг Жибурын хөндийд айл бууя. Ван Тоорил чамайг туршиж байна. Бөртийг тэнхэрсэн хойно нүүж очоорой гэж хэлээд буцав. Ван Тоорил дотроо "Жамуха хөвүүн Тэмүжин рүү давхина. Бас над руу давхина. Хоёр аймгийн хооронд давхих тусам чиний хүлэг сульдана" хэмээн сэтгэж байв.

\* \* \*

Ван хааны цэргийн цацраас Тэмүжинийг буцаж ирэх үед Бөртэ дуншиж байлаа. Мэргэдийн хүрээнээс авчирсан хуучин модон өлгийг Бөртэ "гаргаж хая" гэж Хуагчинд шивнээд "нохойны идүүр авчир" гэлээ. Ойр тойронд байсан цэрэг эрс мордон давхиж төдхөнөө хусны үндэс төнхөж хийсэн цар хэлбэрт идүүрийг мэргэдийн шатсан хүрээний захаас олж авчрав.

Гурван марал гудайхад Бөртэ дуншсан хэвээр. Түүний нүд хуурайшиж, уруул омголтжээ. Цацрын гурван талд гал өрджээ. Галын гэрэлд бөөгийн нүүр таллаж харагдана. Түүний цаана цэрэгэрсийн нүүр цөмөөрөө таллажхарагдана. Галын дөл өөдөө цоролзон асаж, бөөгийн хэнгэрэг ханхийж байлаа. Олон тал нүүртний дотор Хасар, Бэлгүтэй, Боорчи нарын царай нэг тодорч, нэг харанхуйлна. Тэдний чанх ард Тэмүжин бүүр алсарч холдсон ой тайга, нуур цөөрмийн дээгүүр үзэгдэх, үзэгдэхгүйн хооронд бараантах тэнгэртэй нийлэх зах хязгаар руу харж үхэх, төрөхийн аль нь ч Тэмүжинд ялгал үгүй санагдаж билээ. Чилгэр бөхийн цуулагдсан биеийг хараад Хуагчины харамссан дуу алдалт Тэмүжинд цочрол өгчээ. Бөртийг бус Хуагчин эхнэрийг

Чилгэр бөх эмэлж байсан гэж үү хэмээн Тэмүжин санаж зогсов. Харин Бөртийг асран өмгөөлж мэргидээс харамладаг байсан бол Чилгэр бөх юуны буруутай вэ.

Бөртийн тамирдан ёолох дуу Тэмүжиний зүрхийг хавж байна. Цэгцэрийн шар талын хаяанд зусч буй Дэй Сэцэний охин Бөртэд эцэг Есүхэй сүй тавьж хөтөлгөө морио хонгирадын толгойлогчийн адуун сүрэгт нийлүүлсэн бус уу. Их дэлтэй цэнхэр аргамагийг Тэмүжин унаж эцгийн шарил тэнгэрт цуцрах тэр үед иржээ. Тэр цэнхэр морио унаж мэргидээс Бөртийгөө булаасан. Тэмүжин хоёр хөл дээрээ бат зогсож, самсай өөд халуун оргин чивчигнэх нулимсаа барьж ядна. Хэзээ ингэж их уйлсанаа тэр сайн мэдэх юм. Эцгээ бие барахад Тэмүжин гаслан мэгшиж байжээ.

Бөртийг мэргидүүд булааж одов гэдгийг дуулаад Тэмүжин эр хүний харамч нулимсаа зүрхэндээ юүлсэнсэн. Задгай галын гэрэл бүдгэрч тэнгэрийн дорно хаяанаас туяа татаж эхлэхэд хүүхдийн чарлан уйлах тайга дээгүүр цуурайлав. Элдвийг бодож лууны ургамлын судас дээр өлмийдөж зогссон Тэмүжин "хөвүүн төрвөл илдний дор толгойгоо дэвсэх, охин төрвөл эрийн дор биеэ дэвсэх тавилантай бус уу..." хэмээн үерлэн ирсэн гуниг харамсал, баяр хөөрөө залгин бодож байлаа.

Дорнын гэгээ аажмаар хөх тэнгэрийг сүүлэхэд "Хөвүүн төрлөө" гэж Хуагчин эхнэр Тэмүжинд хэлэв.

-Байз... хэнийх вэ? гэж Тэмүүжин асуув.

-Бөртэ олзлогдохдоо хамар, хацар хоёртоо гэрэлтсэн сэвхтэй ирсэн билээ.

-Үнэн биз.

-Тэргүүн Ононы Дэлүүн болдогт чамайг төрөхийг бид мэднэ. Өүлэн эх мэргидээс булаагдаж ирэхдээ нүүрэндээ сэвхгүй байсан юмдаг. Үнэнийг би гэрчилнэ. Худал бол намайг хороож болно.

-Хөвүүнийг юунд өлгийдөв.

-Бөртэ хатны санааг дагасан билээ.

Бөртэ хатны алтан заадас салгаж хөвүүн төрөхөд Тэмүжин түүнд "Зүчи" хэмээх нэр хайрлав.

## Зүчи бол

Тэмүжиний анхдугаар хөвүүн болой. Зүчийг цөөрмийн цэнгэг усаар угааж, зөнөг жингэрийн идүүрт тосч авчээ. Зүчийн нэрийг боржигончууцын нэгэн адил мэргидүүд сонсов.

-Хөвүүнээ амлуул хэмээн Хуагчинг өгүүлэхэд Бөртэ цээжээ эгшээн уртаар шүүрс алдаж "хээр төрсөн хөвүүн хэлтгий заяатай бус уу. Тэмүжин түүнийг гийчин гэсэн нь салаа утгатай үг байна. Зүчи бол Тэмүжиний гэрт гийчин болж очно. Харин надад бол гийчин бус үр минь билээ" хэмээгээд хөхөө өвдөхөд ярвайж байлаа. Хөвүүн эхийнхээ уургийг ховдоглон хөхөж, хөхөж унтчихав. Цацрын гаднах гал унтарч, бөөгийн уухирдан цамнах дуу татарч, нар мандаж шаргал туяагаа цацах үед Тэмүжин зогссон байрнаасаа хөдөлж, тайтгарч ядарсан Бөртэ рүү очлоо. Бөртэ уйлав. Түүний ариун нулимсыг Тэмүжин эрхийдээ шингээв.

-Хөвүүнийг идүүртэй нь нохойд хаяж болох байсан гэж Бөртэ гомдлоо тайлж билээ.

## Арванесдүгээр бөлөг



*Монголын өндөрлөг дээрээс мянган уулын орой харагдана.*

*Бурхан халдун уулын оройд тэнгэрийн хишиг халиун өвс урганам*



Сэлэнгэ мөрөнг уруудан цуварч яваа Жамухын цэрэг баруун тийш эргэж хадтай толгойн хоёр талаар могой мэт орооход Тэмүжин түйтгэрт зам салаалж буйг ойлгожээ. Жамуха зэрэгцэж яваа өрөөсөн нүдэт баатраас,

-Алтан үрлийг тоолж хуваасан уу, атгаж хуваасан уу гэж асуув. Хэнэггүй царайт баатар ширгэсэн нүдээ нухсанаа "богцныхоо хэмжээгээр дүүргэж авсан" хэмээн өчив. Жамуха байдгаараа инээж,

-Хэний богц том байв гэлээ.

-Минийх... гээд түүнийг паржигнуулан хөхрөхөд Жамуха агзасхийн инээдээ хулжааж,

-Хорлонтой эмээс боллоо. Нүцгэн бөгсөө биенээ салгалгүй хонолоо. Тэгээгүй бол алтнаас ахиухан хүртэх байсан юм гэв.

Нэг нүдэт хэрэгт дурлав.

-Хүүхнийг яасан гэж асуув.

-Цавчихсан гэж Жамуха өгүүлэв.

-Надад өгчихгүй яасан юм хэмээн өрөөсөн нүдэт баатар толгой дохиж саймширахад "шалдан эм ямар бол" хэмээн бодолхийлэх зуураа "энэ Жамуха яагаад цавчихсан юм бол" гэж гайхав.

-Тэр эмийг та юунд цавчив гэж асуувал Жамуха "гэрч үлдээж болохгүй" хэмээн тайван, жоготой хэлэв.

\* \* \*

Жамухын хот айл задгай дэнжийг бүрхэн хүрээлж буужээ. Жаалхүү гэрийн туурганд толгойгоор тулж ханын нүдээр шагайв. Гэрийн хатавчийг эргэн тойрон сөхөж, туургыг гэрийн хошлонд хавчуулжээ. Хүүгийн сониучхан нүдэнд Жамуха, Мөнгөлөнгоогийн задгай үсийг тоолох мэт имрэн илж байх харагдана. Мөнгөлөнгоогийн мөр чичигнэн, булбарай цагаан хүзүүгээ эрийнхээ чийрэг мөр дээр налуулан наалинхай хонгор дуугаар чихэнд нь шивэгнэв.

Жамуха бүсгүйн дээлийн товчийг мулталж, хэлхийсэн уужим цамцыг сөхөж дун цагаан мээмийг илж байна.

Жаалхүү улам сонирхон гүүн зэлэн дээр унага цахдан тонгочихыг харах завгүй шунамхайрнам. Жингэнэсэн цээл дуу гарахад жаалхүү ханын нүднээс толгойгоо эргүүлж дуу гарсан зүг рүү харвал өндөр хадны оройд элээ янцгаах ажаам. Хөгшин элээний цээж, бөгтөр сэрвээ нь залгалтан цайжээ. Тэр элээ дахиад янцгаахад тэнгэрийн хаа нэгтээгээс залуухан тас хар элээ шунган дэвсээр айсуй.

Жаалхүү ханын нүдээр дахиад шагайлаа. Жамуха, Мөнгөлөнгоо хоёрын бие нийлсэн харагдана. Тэдний нялхамсаж найрсан бүдэг аялгуу жаалхүүгийн урьд өмнө сонсоогүй чимээ байв. Жамухыг товшуураар дуулж хуурдахыг жаалхүү сонсож байжээ. Жамухын толгой хөдөлж, хуруу нь үегүй мэт товшуурын утас дээгүүр бүжиглэхийг жаалгүй олон удаа харжээ. Харин Мөнгөлөнгоо бүсгүйтэй ингэтлээ эрхэлж байхыг хараагүй юмсанжээ. Мөнгөлөнгоо аяархан гиншиж байснаа,

-Гэрийн хаяанд хүн байна гэлээ. Жамуха тачаалын цалманд хүлүүлсэн чигтээ "би хэнээс дутуу юм бэ" гэж хариу сонсохын оронд "амраг чинь би байна" хэмээн янаглах бүлгээ. Айраг бүлэх хажуугийн гэрээс сонсдоно.

Мөнгөлөнгоогийн янаглалд согтсон Жамуха хүүгийн нүдийг хуруугаар дараад орхив. Жаалхүү шалавхан босч нүдээ нухаснаа гүйв. Түүнийг гүйсээр голын эрэгт очтол нэгэндээ наалдсан дун хорхой тааралдав. Дун хорхойн гадар яс мэт атал хэвлий нь зөөлөн ягаан аж. Жаалхүү жаргах нарны туяан доогуур харахад адууны тоос босно.

Их гэрт Жамуха гайхалтай уужирсан Мөнгөлөнгоогоос

-Тэмүжинг би харсан. Тэмүжин мөн байсан гэж шалгаахад бүсгүй эрийнхээ амыг хуруугаар таглаж,

-Буруу харжээ гэв.

-Тэгвэл...

-Мэдэхгүй... Айраг залгилаад мордсон агтчинг надтай хардав.

Мөнгөлөнгоо наалинхайтан байвч "Хар авчээ. Нөхцсөн эрийхээ тоог Жамухад мэдүүлбэл аминд халгаатай" гэж бодно. Жамуха хүүхний нүцгэн гуаыг илж "энэ хүүхнийг нэг эр лав хангахгүй" хэмээн бачуурсан сэтгэлээ бөглөж ядна.

\* \* \*

Жамуха бол дуунд дуртай гэгэлгэн нэгэн бөлгөө. Тэрбээр Хар Хадааны хөвүүн билээ. Тайчар хэмээх сагсуу дүүтэй байлаа. Эхнэр Мөнгөлөнгоо даанч шалиг тул Жамухын дур гутааж явах боловч түүнээс өөр эхнэр авахыг үл хүснэ.

Хурхунаг Жибурын хөндийгөөс Тэмүжинийг нүүж одсон хойно Жамуха эгц өндөр эрэг дээр өдөржин товшуурдаж,

Уйлан санах эр чинь

Ус олныг гаглав

Тэврэх хайрт эр чинь.

Тэртээ давааг давав... хэмээн дуулжээ. Чухам хэнд, юуны тулд ийнхүү дуулав гэдгийг Жадаран овгийн гэр хүрээнийхэн мэдсэнгүй ажээ. Жамухын дээд өвөг урианхан атал дараа, дараагийн удамдаа Жадаран болон хувирсаныг чухамдаа тэнгэр мэдэх боловчиг тогтворгүй зантай, чалчаа үгтэй, шалиг эхнэртэй Жамухын заяа төөрөг буруу эргэжээ.

Өндөр эрэг дээрээс бууж ирсэн шөнөө Жамуха бүсгүйнхээ үзэсгэлэнг ам мэдэн магтавч "Мөнгөлөнгоо чамаас илүү үзэсгэлэн төгс бүсгүй буй гэнэ. Түүнийг Гүрвэлжингоо гэдэг гэнэ. Тэмүжин Гүрвэлжингоог ихэд тоож тэр гоо эмийг авч суух хүсэлтэйгээ надад ярьсан билээ. Тийшээгээ Тэмүжин нүүв. Тэмүжинг чи дахиад харахгүй" гэв.

-Жамуха, энэ бол чиний санаа болохоос Тэмүжиний санаа биш байна.

-Тэмүжиний санаа ямар бол...

-Тэмүжин бол башир хүн биш хашир зантай билээ. Намайг үл тоовч чамд тэгж хэлнэ гэж үү. Бөртэ бол Тэмүжин та хоёрын дунд чулуу хаясан. Тэр чулуу чиний толгойг онов.



-Үгүй дээ, Мөнгөлөнгоо минь. Чиний хаясан чулуу намайг онов. Би Тэмүжинд дийлдлээ. Тэр намайг үхүүлж чамайг авна. Би өнөө болтол чиний үгээр явав. Одоо боллоо. Толгойгүй болсонч өөрийнхөөрөө яваад дуусах нь зөв байжээ.

-Жамуха чи юу ярина.

-Хүний доог болохыг би үл хүснэ.

-Жамухаа би тэгээд яах ёстойв.

-Чи юу... чи Тэмүжиний зүрхэнд бус миний зүрхэнд нойрсох ёстой билээ. Чи олон эр хүйстэнийг жаргаасан боловч над шиг жаргасан нь ховор. Санаж байна уу.

Жамуха гунигтай инээмсэглэв. Шөнө дөлийн цаг байлаа. Мөнгөлөнгоо сэжиглэнгүй харах хэрнээ зөөлөн хөнжлөөр биеэ хулдаж хэвтэв. Жамуха хурганы суул Мөнгөлөнгоогийн аманд үмхүүлж түүний амыг гараар таглан буруу харахад Мөнгөлөнгоо хэдэнтээ тэлчлээд хөдлөхөө болилоо. Жамуха гэрээс гараад "морь" гэж хашгирав.

Жамухын нөхөд юу болсныг гадарлан хүйтэн хөшингө царайгаар угтаж задгай галыг гэрт оруулан шидэж төдөлгүй бөөн гал утаа оволзон дүрэлзэв. Жамуха цэргүүдийн хамт давхин харанхуйд залгигдан холдлоо. Гүн харанхуйн араас нэхэх мэт галын дөл сүүмэлзэн, гоо сайхандаа эрсэдсэн залуу хатны сүнс гүндбалын ургамлын судас руу хайлж байв.

## Хорьдугаар бөлөг



*Чингис хаан "Би ганцаардав. Ван хаан Тоорил эцэг, анд Жамуха, ясан ургийн*

*Алтан, Хучар, Сачу, Тайчу нар надаас юунд дутаав" хэмээн харамсана*



"Олон монгол аймгийг хураав, би. намайг Ван эцэг та их мэднэ. Мөн миний гурвантаа андын тангараг тавьсан Жамуха их мэднэ буй за.

Хотул хааны хөвүүн Алтан дээд овгийн ёсоор намайг гадарлах буй. Ясан төрлийн Нэгүн тайшийн хөвүүн Хучар сэтгэлээ нууж надаас хараат явахыг юунд хүснэ. Бартанбаатарын хөвүүд эцэг Есүхэй баатрын дүү Сачу, Тайчу авга нар нуруугаа дагахгүй байгаа нь зовлон бус уу. Тэднүүс нуруутай явсан бол би шаналахгүй байсан.

Олон монгол аймгийг хураасан Чингис хаан миний мэнгэ голлов. Миний мэнгэ бол Есүхэй баатрын бүтээсэн ой ухаанд буй. Мөн Өүлэн эхээс заяасан мах, цусанд буй. Би мэнгээ дагаж яваа билээ. Миний мэнгийг хэн таав. Миний мэнгэ гарын алганд буй. Ил байгаа мэнгэ маань зөвхөн тэмдэг төдий биз ээ. Далд мэнгэ нь сэтгэл, зүрх хоёрт шаналал, зовлон, уйтгар авчирч монгол аймгуудыг хурааж хумисанаасаа илүү надаас тэвчээр зориг шаардах боллоо. Би өөртэйгээ ярьж байна. Би ганцаардаж байна.

Овог аймгаараа намайг хаан өргөмжлөв, гэвч ойр дотны та нар одоо хаана явна. Ван эцэг хэрэйдийн хаан болой. Жамуха андыг жадаран хийгээд таван аймгийн иргэд уухайлан гүр хаанд ергөмжилсөн бус уу. Удам сайтай хаан хүнийг би хааны ёсоор дээдлэн хүндэтгэж, халуун сэтгэлээр хандана. Хааныг хаан бол гэх болзол үгүй. Харин хаан бол гэж Алтан, Хучар, Сачу, Тайчу дөрвийг би ятгасанд "Үгүй. Тэмүжин чи хаан бол. Чамайг хаан болбол илдний чинь ир, эмээлийн чинь дөрөө болоё хэмээн андгай өгсөн билээ. Гэтэл өдгөө миний дэргэд дөрвүүлээ алга байна".

Хамаг монголын хааны төлөө Ван эцэг Тоорил хаан шаналж яваа бололтой. Анхнаасаа ван эцэг хамаг монголыг хураахын төлөө явсаныг Жамуха анд мэднэ, би мэднэ. Бид гурвын зангилаа энд үүссэн. Бид гурав бэхлэгдэж холбогдсон байсан. Зангилааны гурван үзүүрээс Тоорил хаан, Жамуха анд, Тэмүжин миний бие атгажээ.

Гартаа атгасан зангилааны үзүүрийг эхлээд Жамуха анд тавив. Зангилаа, зангилаа биш болж Тоорил хаан бид хоёр үлдэв. Би атгасан үзүүрээ тавихгүйг хичээв. Тоорил хаан бүүр чармайв. Тэгэхэд би өөртөө асуулт тавьлаа.

-Хэн хамаг монголын хаан болох вэ?

-Тоорил хаан загалмайдаа үнэнч тул хамгийг эрхшээж үл чадна.

-Жамуха анд хөнгөн хуумгай, зальхай учир их хэсгийг умартах буй за.

-Намайг хаан бол хэмээн тэнгэр явгуурт ахан дүүс зөвшөөрөн хүлээсэн билээ.

Угаас Тоорил хаан, Жамуха бид гурав баруун, зүүн гар болж явсан. Эцэстээ биднүүс чоно болж хувирчээ. Намайг яаж хөдлөхийг тэд хянана. Тэд хэрхэн авирлахыг би ажна. Буруу зөрүү явбал багалзуур тасдах аюул нүүрлэв. Жамуха анд зүг буруулан дутааж Тоорил хаантай үгсэв. Би Тоорил хааны дээлтэй төрсөн хөвүүн билээ. Тоорил хааны нүцгэн хөвүүн Нялх Сэнгүм эцэг хаанаа эс тоож өдөөн хатгалгаар турхирна. Намайг ван хаан хайрлавч өөрийн хөвүүнийг яалтай вэ.

Жамуха анд ван хаанд дагаар оров уу. Эсвэл ахмад настай ван эцгийг дагуулж явна уу. Надад сайхан бодол төрөхөө больжээ.

-Би чамтай хэзээд найрамдана гэж ван эцэг өндөгний цусаа дусааж явуулжээ. Ван эцэг мухардаж байна. Ван эцгийг түүний хөвүүн Нялх Сэнгүм хазаарлаж байна. Ван эцэг надтай эвлэлдэх санаатай юм. Тэгэвч хөвүүнээ яах билээ.

-Би үхвэл хэрэйд аймаг мөхнө гэж Ван хаан хэлсэн байдаг. Ван хаан хөвүүндээ үл итгэнэ. Нялх Сэнгүм эцгийнхээ алтан аргамжийг тасдахаас өөр юу хийж чадна. Нялх Сэнгүм биеэ мэдэхгүй байна. Эцгээ амьд байтал үхсэнд тооцжээ.

-Бүх цэргийг би захирна гэж тэрбээр омгорхжээ.

-Захир! гэж Тоорил хаан хэлжээ.

Хэн захирна, тэр надтай байлдана. Хамаг монголчууд хүрээгээ өргөжүүлж тэр хүрээндээ хэрэйд аймгийг багтаахыг хичээж байхад Нялх Сэнгүм байлдана, дайтна, хэмээн биеэ мэдэхгүй их үг хэлнэ. Ван эцгээс зөрөх тусам

Сэнгүм буруу замаар орох бус уу. Нялх Сэнгүмийн явж байгаа замыг би буруутгаж бодно. Нар мандаж жаргадаг юм. Навч ногоо ургаж хагдардаг юм. Сар гэрэлтэж шингэдэг жамтай бус уу. Нэг дороо явъя гэтэл Ван эцэг толгой мэдлээ алдаж Жамуха анд болоод хөвүүн Нялх Сэнгүмийн гүн ятгалгад автжээ.

Ван хааны цусыг үзээд түүнийг өрөвдөв. Хаан байтал ямар өчүүхэн бэ. Олон жилийн өмнө ван эцэг ямар байлаа даа. Номлогч Конс хүртэл танаас эмээдэг байсан. Таны санааг гүйцээхийн тулд Конс миний алгыг харах гээд харж чадаагүйг бодоход та уужим сэтгэдэг байжээ. Ван эцэг ирэх юм бол би аварна. Та янз нь туйлдаж яваа бололтой. Та баргийн хүнд цусаа үзүүлнэ гэж үү.

Би таны цусыг хадгалах болно. Их хаан та надад итгэдэг байжээ. Таны илгээсэн цусан тангараг үүнийг баталж байна. Цус улаан өнгөтэй боловч цагаан сүүнээс бүтдэг бус уу.

Та надаас холдох тоолондоо бүдэрч байсан. Таны тусыг би үл мартаж учир өршөөлт тус хүргэхийг зорьсоор өдий хүрэв. Та надаас салахдаа эргэж уулзах нүүртэйгээ санадаг байх. Эргэж уулзах бүрдээ салж хагацахаа боддог байх. Ван эцэг та миний сэтгэлийн нүдийг нээж өгсөн шүү. Таны алтан асарт морилохдоо Бөртийн инжинд ирсэн хар булган дахыг өвдөг дээр чинь тохож өгөхөд,

-Тэмүжин хөвүүн энэ дах үнэтэй эд юм гэж та хэлж билээ.

Тэгэхэд та надад дахнаас үнэтэй юм байдгийг ухааруулсан.

Бөртийг булаалгав гэж хүйтэн сарны хүйтэн гэрэл өвөртөлж хоноход "эхнэр бол булаагдахын тулд эхнэр байдаг. Эмс бол хүүхэд төрүүлэхийн тулд заяадаг юм" хэмээн хаан хүний эрх мэдлийг ойлгуулсан. Ван эцэг таны нэр нөлөө, эд хөрөнгө сарнин бутарч байна. Хураасныг ингэж цацаж болно гэж үү. Хураах хэцүү, үрэх амархан бус уу.

Ван эцэг таныг үгүй болбол Сэнгүм хумхийн тоос төдий. Баатар эр нэгэн суманд үхдэг. Би эрийг дорд үздэг хиан овогтон биш ээ. Хиан бол хүн овог шүү. Өвөг овгийнхон

тэнгэр язгууртай тул би баруун гартаа нөж атгаж төрсөн билээ.

Миний баруун гарыг толгойноосоо үнэтэй гэдгийг татаар, тайчууд, мэргид, хэрэйд цөм мэддэг учраас утасны үзүүр түүний дээр зангилагдсан хэвээрээ байна. Толгой нь гараа захирдаг юм. Толгой тушаавал гар хөдөлнө. Толгой мэдэлгүй аваас гар мэдэл үгүй. Толгой, гар хоёрын хүчийг тэнцүү бодсоноос намайг хаанд ергемжилж эрх мэдэл өгсөн билээ.

Ван эцэг таныхаа гэгээн мэлмийг би одоо харж байна. Таны нүд гунигтай байна. Таны сэтгэлийн эрч суларчээ. Та бардам, эрхэмсэг, хүчтэй байсан шүү. Тоорил үгүй бол монголчууд монголоороо явна. Тоорил хаанаар монголчууд дутах юм гэж үү. Тоорил хаанд монголчууд

хэрэгтэй бус

уу-

\* \* \*

Ван хаан Тоорил таны мэлмийд хурсан гунигийг би арчиж өгөх юмсан. Ван эцэг та морилон ирэх аваас уравсан ял үл хэлэлцэж, угаас баруун, зүүн гар болж явсанаараа явья. Таны өндөгний цусыг мялааж сүү дусаая. Хаан Тоорилын цусыг ханах гэж хөвүүн Сэнгүм чинь Жамуха андын дэргэд санжигнаж яваа бус уу.

Жамуха анд зангаа юунд хувиргав. Бөртэд өндгөн сүй тавихад цуг байсан Жамуха андын товшуурын эгшиг миний зүрхэнд уянгална. Цэгцэрийн тал нутаг ямархан тэнүүн билээ, анд минь!

Чи дандаа дуулж явсан. Би бодолдоо бэтгэрч байсан. Чи намайг дуугаараа уяраасан шигээ Бөртийг бас уйлуулсан. Онон мөрөний мөсөн дээр тоглож, тайчуудын найрыг тарааж, гурван мэргидийг дайлж морьдын хөлс үнэртэж явсан шүү дээ, бид. Хамт явсан өдрүүд сэтгэлд уяатай үлджээ. Намайг бодолтойгоо хатаж явахад Жамуха анд минь Ван хааны сүвээнд наалдаж "Тэмүжинг бут цохъё" хэмээн ятгаж Нялх Сэнгүмийн тэнэгийг хөдөлгөж байна.

Чиний эхнэр Мөнгөлөнгоогоос би нүдээ нуудаггүй байсан. Үнэндээ тэр эхнэр чамайг хөнөөв. Чи хартай. Чи эхнэрээ хардаж "Гүрвэлжингоо хатан дэндүү гоо гэнэ. Манай Мөнгөлөнгоо түүний дэргэд үзэсгэлэн өчүүхэн..." хэмээн надад хэлсэн. Би сонссон.

Гоо эмийн хүсэл, тачаалыг огоорох атал анд минь шуналдаа ташуурсаар надаас холдлоо. Гурвантаа андгай тавьсан билээ, бид! Жамуха андаа би хүлээж байна. Жамуха анд эртхэн эргэж ирвэл өлзий учрал тэгширнэ. Надаас холдсоноороо холдвол тэнгэр гэгсгээх буй за. Андыг минь хэн асарч байна. Нялх Сэнгүмд асрамж хэрэгтэй. Тэр хуудуу бодолт хөвүүн чамайг ятгаж дөнгөнө гэж үү.

Жамуха анд зальхай, уйдамхай зантай боловч хүчтэй. Хамаг монгол аймгийн их хүрээг сэтэлж дийлэхгүйгээ Жамуха мэдмээрсэн.

Мөрөн голууд үертэй байна. Жамуха андыг байтугай Тоорил хааныг урсгана. Үерийн усны чимээ дуулахгүй байна гэж үү. Жамуха надаас, би Жамухаас хагацамгүй байна. Нэгэн урсгалд нийлье гэтэл Жамуха анд сөрөх боллоо. Эцэг Есүхэй баатрын захиасаар бид анд нөхөд болсон юмсан. Сөрж дийлнэ гэвэл би зөвшөөрнө.

Монголын өндөр уул нуруу, тэнүүн тал хээр нутагт нэг эзэн хэрэгтэй. Нэг эзэн хэн бэ. Чингис хаан, Тоорил хаан, гүр хаан Жамуха гурвын бядыг сорьж эзэн суулгана. Дийлсэн нэг нь хоёр хааны гавлыг мөнгөлж аяга хийх болж дээ. Гурван хаан байтугай хоёр хаан зэрэгцэж суух учиргүй.

Дээд тэнгэрт нар ганц, сар ганц байна. Хааны тулгат галыг хэн манах вэ. Хаан титэм зөвхөн нэг хааны тэргүүнд залрах бус уу.

Чингис миний бие хатуу бодолтойгоо эвлэрэв.

Долоодойн хаваржаанд Алтанг нутаглаж ахуйд очив. Өвөг хааны хөвүүн Алтан намайг харангуут "Тэмүжин морил" хэмээн найр тавив.

-Алтан авга та хамаг монголын хаан болно уу гэж би түүнээс гуйв. Алтан авга жуумагнан инээмхийлж намайг өргөөнийхөө хойморт суулгаад,

-Би хаан болохгүй гэж шууд хэлсэн. -Яагаад гэхэд Алтан авга,

-Чи хааны одонд төрсөн хүн. Тэмүжин хаан болно гэж даяараа шуугина гэлээ.

-Яагаад гэвэл Алтан авга,

-Тэмүжин чамд би хүчээ өгч зүггэнэ гэв.

Өвөг хааны хөвүүн Алтан авга надаас дутаав. Хаан болсон би буруутай юу. Намайг юунд ганцаардуулав. Ван эцгийн угаадаст тэр юунд дурлана. Надад цэрэг байна. Надад хүч чадал байна. Нүүр буруулсан бол тэндээ хоргод. Гуйвах бол гутамшиг. Хэрэв над руу ирвэл тангараг ёсоор толгойгүй болгоно. Нэгүн тайшийн хөвүүн Хучар мөн адил. Алтан, Хучар хоёр хаан болохоос татгалзаж сүүлээ хөдөлгөж байснаа бүү мартсу!

Алтан, Хучар хоёр сүүжээ нийлүүлээд байсны учрыг мэдлээ. Намайг балчирт боджээ. Эсвэл намайг сорьжээ. Нурууны яс долоон үетэй байдаг. Нирун улсын үеэс ясан ургийн домог хэлхэгдэнэ. Гэтэл ясан ураг атал Алтан, Хучар хоёр бусдын гүзээнд дэлүү мэт наалдав. Дэлүүг ховх татаж нохойд хаяж болдог. Ноход дэлүүнд дуртайг эднүүс эс мэдэв. Намайг басав.

Надад гомдох, учирлах, өрөвдөх сэтгэл буй боловч урвагчийг цаазлахаас өөр өршөөл үгүй. Амь гуйх нүүр Алтан, Хучар хоёрт үгүй гэдгийг сануулья. Хаан төмөр нүүртэй байдаг юм.

Аавын хоёр дүү алиа хонгор зантай бус уу. Эцгийн хоёр дүү элбэрэл журам сахидаг бус уу. Бартанбаатарын хөвгүүд атал Сачу, Тайчу хоёр надаас дутаав. Миний шар хөдлөв. Сачу, Тайчу хоёрт би хэлсэн юмсан.

-Та хоёрын хэн нь хаан болох вэ гэхэд хоёулаа толгой сэгсэрч,

-Тэмүжин хаан болно гэж баталсан.

Тэмүжин намайг хаан болгосон атлаа Тэмүжин надаас юунд дутаав. Тэмүжиний илд мохоо бус. Тэмүжиний зориг зүрх шантрамхай бус. Гэтэл хаан эзнээ байсаар байтал Тоорил хаан, Жамуха андыг яагаад дагав. Хамаг монголыг дийлнэ хэмээн сэтгэв гэж үү. Мөс, цас наранд хайлдаг бус уу. Мөрөн дээрээ толгойтой мөртөө Сачу, Тайчу толгойгүй авирлав. Тэдний толгойд мөс байсанч гэсэх хугацаа өнгөрлөө. Хилэнцэт хорхой үр зулзагаа иддэг гэнэ лээ. Эцгийн дүү нар хилэнцэт хорхойн үлгэрийг сануулав.

Хот айл руу дутаасанч, хорин бээр дутаасанч ялгал үгүй. Нэгэнт дутаасан бол ууцандаа сум зоолгоно. 'Бусдын тогооноос хооллосныг зөвтгөх шалтаг үгүй. Бусдын хоолонд цадаж, хэхэрч

болно. Харин хоолшино хэмээн зүүдлэх хэрэггүй биз ээ. Сачу.Тайчу нарын өрийг өрлөх өдөр ирнэ. Хаан хүйтэн сэтгэлтэй байдаг бус уу.

\* \* \*

Миний дэргэд Боорчи, Мухулай, Хасар, Бэлгүтэй, Чулуун гээд баатар эрс, сайн нөхөд маань цөм элэг нэгтэй яваа билээ. Би юунд ганцаардах болов. Би сэтгэлээ уудалж болох уу. Намайг хүн бүр мэдэж болно гэж үү. Надаас холдож явсаныг би яахин мартана. Надруу ойртож ирсэнийг би түлхэж үл чадна. Намайг эзэлж, намайг онгойлгох эрхтэн байх ёсгүй. Зургаадай од нь өглөгч, хичээнгүй, тэсвэр хатуужилт, мохошгүй сайхан сэтгэлт, оюун ухаант хэмээх боловч миний нууцыг надаас өөр хэн нэгэн тайлахгүй биз ээ. Миний алганы хээг ээж минь сайтар харж, хөхнийхөө сүүг дусааж зөөллөнө. Эхээс нь өөр хэн хөвүүний алгыг харж болно гэж үү.

Өүлэн эх бол миний нууц түлхүүр юм. Намайг эх минь мэдэрмүй. Дайн дажинаас ирэхэд эх минь угтдаг. Эхийн нүдэнд би бяцхан хэвээрээ үзэгдэж хайрлах, харамсах сэтгэлээ надад нээдэг шүү дээ.

\* \* \*

Чингис хаан Хулан хатантайгаа эхдээ золгохоор яваа чимээг Өүлэн үжин сонсоод бодов. "Тэмүжин хөвүүн цочимхой бус уу. Цочимхой хүний ой ухаан дэндүү сэргэг билээ. Тийм цочимхой мэдрэмж гэгээн мөртөө хардамтгай бус уу.

Тэмүжин хөвүүн могой зүүдлэмтгий байв. Тэр угаасаа саранд дурламтгай билээ. Би хөвүүнээ ойлговч тэр намайг ойлгоно гэж үү. Миний зүрх зогсох аваас Тэмүжин нууцын чанад үлдэх бус уу."

Өүлэн эх, Чингис хааныг Хулан хатантайгаа ирэхийг хүлээх зуур хөвүүнээ ийнхүү бодно.

## Хориннэгдүгээр бөлөг



Өүлэн эх "миний хөвүүн нөж атгаж төрсөн бус уу. Миний хөвүүн алгандаа мэнгэтэй бус уу.

*Миний хөвүүн алгандаа нүдтэй бус уу" хэмээн өгүүлэв*



Чингис хаан Хуланг өргөөнд нь үлдээгээд Тэргүүн өндөрлөгт зусаж буй Өүлэн эхтэйгээ хөөрөлдөхөөр одлоо. Он жилийн нугалаа Өүлэн эхийн аньсага, зовхинд үрчлээ тогтоож, амгалан дүртэй, намбалаг хөгшин болгожээ. Хаан эхийнхээ зуслан хүрэх замд Ван хаан Тоорил, эрт багын анд Жамуха, ясан ургийн ахан дүүсийн барилдлагаат Алтан, Хучар, Сачу, Тайчу нарын өөрөөс нь урваж шарвасны учрыг бодсоор явав. Сүүлийн өдрүүдэд Чингис энэ бодлоосоо хагацаж үл чадан ихэд зовингуйрдаг байлаа. Хуланд дурласан явдал нэг хэсэгтээ хаанд тааламжтай гэгэлзүүр байсан гэж болно. Чингисийн хатан Хуланг эх нь хараад "нялхаараа амьтан байна" гэжээ. Харин Өүлэн эх хөвүүндээ "хааны мэдэл хязгаартай бус уу" хэмээн Чингис хааныг зэмлэсэн ч юм шиг, аргадсан ч юм шиг аялгаар хэлсэн нь Хулангаас үүдсэн үг байжээ.

Хааныг очиход эх нь ердийн тайван угтаж, санчигийг нь илээд "хүнд хүчир аян дайны тоос буужээ. Есүхэй эцэг тань намирсан хар үстэйгээ хорвоог орхисон. Гэтэл хөвүүн нь..." гээд зөөлөн шүүрс алдав. Өүлэн эх олон жилийн өмнөх шигээ байсангүй. Түүний цайвар царайд бодлогоширч гунигласан аяс илэрхий. Хаан хөвүүнтэйгээ эх зэрэгцэн тухлаад,



-Чи юу бодно. Юунд гунигтай байх юм гэж элгэмсэгээр асуулаа.

-Ижий минь та амар төвшин байвал намайг тэнгэр ивээнэ. Таны өтлөхийг ямар цаазалж хорих биш дээ. Онон мөрөн мянга мянган жил урссан байтал миний бага насных шиг харгиатах юм. Хүний насыг аргамжих арга алга, урсаад өнгөрөх юм гэж бодлоо ээдрүүлэн өгүүлэв. Өүлэн эх аяганд дэвтээсэн ааруулаа хуруугаар этэн хаанд авч өгөөд,

-Шүдтэй хүнд юухан байхав гэхэд хөвүүний сахал хөдөлж инээмсэглэн "ижий минь та намайг хүүхэд шиг бодох юм" хэмээн баяр хөөртэй хэлээд ааруулыг тачигнатал хазах зуур ээжийнхээ дулаахан гарыг атгалаа. Өүлэн эхийн нүд баясгалантайяа гэрэлтэн Чингис хааны бууралтаж буй санчигийг ширтэнэ.

Өүлэн эх хөвүүнийхээ сэтгэлийг мэдэж байлаа. Түүний яагаад гунигтай байгааг эх нь зөнгөөрөө мэдэрч тэрхүү зовлонг хугаслахын тулд намууханаар "ижийдээ юунд ойр ойрхон ирнэ. Хол явах нь уу. Эсвэл нутгаа санана уу" гэлээ. Гэрийн үүдээр зэрэглээн дунд Хэрлэнгийн толгод гүвэлзэж байгаа харагдана. Голын хөвөөгөөр хоньд налайж нэгэн морьтон өвсний дундуур толгойгоо шоволзуулан давхиж байна. Гэнэт Чингис хаан ижийгээ, нугат хөндийгөө, Онон, Хэрлэн мөрөнгийнхөө шаагин шуугих урсгалыг яасан их санасанаа бодов. Дайны халуун шуурганд энэ бүхнийг бодох цаг, зав үгүй билээ. Дайн бол дайн. Сэтгэл, зүрхийг шимшрүүлж, нөхөр, дайснаа ялгаж таних төдийд хувилгаан төрхөө харуулж нэг нь үхэж, нөгөө нь урвана. Дайны шуурганд нэгэнтээ татагдаж орсон бол түүнийг сөрж давна, эс бөгөөс ялагдаж дуусна. Дайны хар шуурга, хүчит эргүүлэгт Чингис хаан татагдан орсон учраас төгсгөл нь гээгдэж алга болох ганцхан жамтай байлаа.

Хаан хөвүүнийхээ хувь тавиланг бат нот гадарладаг

Өүлэн эх нь,

-Миний хөвүүн өршөөлтэй бай. Чамаас хэн урвав.

Чам дор хэн нийлэв. Чухам чиний төлөө бус уу. Чамайг алтайн даваа, Шивэрийн мөсөн тайга зогсоож дийлэв үү. Чамайг бас Цагаан хэрэм хааж чадав уу. Чиний эрх мэдэлд хязгаар үгүй тул өршөөлтэй байхыг хичээ хэмээн захижээ.

Эхийн үгийг дуулгавартайяа сонссон Чингис, -Би эвийг хичээгч билээ. Та миний алганы хээг одоо нэг хар даа гэлээ,

Баруун гарын алгыг Өүлэн эхийн нүдний өмнө тэрбээр дэлгэлээ. Эх уулга алдаж,

-Тэнгэр минь! хөвүүн алгандаа нүдтэй юм байна шүү дээ. Би чамайг алгандаа мэнгэтэй гэж боддог байлаа. Гэтэл нүдтэй бус уу хэмээн Өүлэн үжин цээж хэнхдэгээ дарав.

-Нөж бус мэнгэ, мэнгэ бус нүд байсан юм, ээжээ..

-Хорчи, Мухулай, Дэвтэнгэр гурав мэдэх үү.

-Хэн ч мэдэхгүй. Би алгаа танаас өөр хэнд ч харуулах билээ. Ялангуяа бөө зайран нар миний

алгыг яаж танина.

Дэвтэнгэрт би үл итгэнэ. Тэр дэндүү даварч иргэдийн толгойг эргүүлэхийг хичээнэ. Тийм явдал олон удаа гарвал Дэвтэнгэр цээрлэл амсана. Хорчи бол анд Жамухын хэвлий нэгтэн. Хорчиос хор гарахгүй. Түүний сэтгэл өгөөмөр билээ. Миний зүүн гарын баатар Мухулай цэргийн жанжин төдийгүй дайны догшин бөө бус уу. Мухулай надад үнэнч.

-Хөвүүн өөр юу санана. Ээждээ хэлээрэй.

-Би мартжээ. Мэргидийг дайлах үеэр хүн бус сүг дүрстэй зайран бөө баригдаж ирэхэд түүний гарт шатаасан дал байлаа. Би тэр далны мэргийг гав ганцаараа үзэв. Мэргидийн бөөгийн далны бүх зураас миний алганы хээтэй таарч байсан шүү. Ээжээ... Тэр бөөг Төгсжин гэсэн ...Төгсжин...

-Хөвүүн тэр хүнээ төсөөлөөд хэл дээ.

-Далны яс шиг төрхтэй. Нүд нь жижиг бөөрөнхий, хамар унжуу, эрүү далны толгой мэт.

-Төгсжин гэв үү. Надтай таарч байсан юм.

-Дайр-Үсүний бөө юм билээ.

-Би санаж байна. Чилэдү баатрыг дагаж явсан бөө мөн. Тэр хүнээс би их айж билээ. Тэр бөө далаар мэргэлдэг бөгөөд намайг огт таалаагүй гэдэг.

Чингис хаан эхийнхээ шаргалтаж зэвхийрсэн царайг ажиглаад "бие тань зүгээр үү" хэмээн сэтгэлийн гүнээс аймсан асуулаа. Өүлэн эх нэгэн явдлыг тодруулан сэтгэж байв. Тэр явдал олхонуд аймагт болжээ.

\* \* \*

Хонхот сүйх тэрэгний ард Төгсжин хэмээх дал шиг төрхтэй бөө ташаа тулсан Чилэдүгийн өмнө зогсоод далныхаа мэргийг уншиж байлаа. Хэдийбээр хуримын ёслол шувтраагүй байсан ч тэд аминчлан ярилцав.

-Та далны хуудасны зураасыг хар. Замдаа тасарч алга болжээ. Энэ бол муу ёр. Маргааш буцах аваас саад тотгор байна. Шинийн арван дөрвөнд хөдөлж болох юм. Тэгвэл зам шулуун, заяа тэгш бөлгөө.

- Мэрэг төөрсөн бус уу.

- Зам шулуурч өгөхгүй байна. Саадтай байна.

- Зайрантан эндүүрсэн биш биз. -Толгойгоо тавьж болох юм.

- Амь насанд цөв бий юу. Найрын бэлтгэл дууссан бус

уу-

- Амины гарз алга.

- Тэгвэл маргааш мордоно. Дал бариад өмнүүр сүүтэгнээд байхаа боль. Тэнгэр намайг ивээдэг юм. Чамайг бас ивээнэ.

Халамцуу Чилэдү баатар Төгсжин зайрангийн гараас далыг булааж аваад бяц атгав. Түүний хүчирхэг атганд дал шажигнан бяцлагдаж дун хорхой мэт хагарав.

Далны үнсийг хийсгэж Төгсжиний духанд гараа арчаад Чилэдү баатар "төлөгч нар заримдаа чалчдаг юм. Алганы амт үзээгүй дээрээ холд" гэхэд зайран илүү гэр тийш зүглэв. Найрын гэрээс дуу хангинаж байлаа. Чилэдү баатрын нүд талимаарч будан суусан цэнхэр далайг ширтэж "зоргоороо дал түлээд сэтгэл сэвтээх юм" гэж Төгсжинг буруутгаж байжээ.

Гэтэл замд Өүлэн булаагдаж, Төгсжин булчингаа сэт харвуулж, Чилэдүгийн омогтой толгой хашгирч давчидсаар гурван мэргидийн нутагт очсон билээ. Хэрэв тэгэхэд Төгсжин зайрангийн үгнээс гажаагүй бол Чилэдү олон голынхоо уулзвар нутагт жаргах байсан ажээ. Зайрангийн шившлэгтэй дал онч мэргэн болохыг Өүлэн эх мэдэх юм.

-Төгсжин зайран хаа яваа бол гэж Өүлэн эхийг асуухад Чингис хаан,

- Их цэргийн тоосон дунд яваа гэж хариулав.

- Лут бөөтэй болжээ.

- Шөвөг бариад үхсэн мэргидийн гавал нүхлээд явсан гэнэ лээ. Гавлын ясны цоорхойгоор мөлхөө ургамал орооцолдож ургаад овоо босдог юм гэнэ лээ. Зайран тэгж айлдсан гэнэ лээ.

- Чамд зүтгэх ам тангараг өгсөн үү

- Тэгсэн, ээжээ. Тэр миний алгыг хараагүй, гэхдээ далаа харсан. Би тэр далыг бяц атгаад үнсий нь зайрангийн духанд түрхэж домносон. Далны мэргээ март гэж зайранд зарлигдсан. Зайран бөө, Дайр-Үсүн хоёр Хуланг надад авчирч амь гуйж сөхрөхөд нь би өршөөсөн юмсан. Зайранг явал зохилтой вэ.

-Миний хөвүүн түүнээс сэжиглэх юун. Чамд тустай бус уу. Чамд ээлтэй ч юм бил үү.

-Ээжээ тэр зайран бөө таныг бас Бөртийг тэгээд намайг мэдэх юм байна. Бидний зам нэг бус уу. Хулан хатанг мэднэ шүү дээ.

Өүлэн эхийн нүдний бодлогоширсон сүүмгэр харц эргэлзэж тээнэгэлзсэн байдалтай ажээ. Боржигоны хот айлаар мэргидийн нэг эрэлчин эргэж байгаад хорхой идсэн баавгайд толгойгоо тас алгадуулсан нь өдгөө домог болжээ. Есүхэй эцгийг амьд ахуйд Төгсжин зайран нэг удаа боржигоны хүрээгээр явсан нь Тэмүжин хөвүүний дэргэдүүр хорхой идсэн баавгай, улайрсан сарлаг урсаж өнгөрсөн эрт үетэй давхцаж байв. Өүлэн эх олон явдлын нууцыг хадгалж үлдэх хувь зохиолтой байж. Эл явдлыг хаан хөвүүндээ дурсаж ярих байтугай өөртөө

төвөг удаж бодохоос Өүлэн эх татгалзав.

Амьдрал гэдэг үертэй Ононы урсгал шиг ажээ. Урссан амьдрал эргэж ирэх биш дээ. Зарим нь живж алга болно. Зарим нь хүчит урсгалын давалгаанд шидэгдэж мартагдана.

Нэгэн эмэгтэй байтугай овог аймгийн дааж давашгүй ачааг Өүлэн эх үүрч өнгөрснөө дурсан санах эрхтэй билээ. Эхийн магнайн үрчлээ болгонд хөвгүүдийн амьдрал, хувь заяа шингэжээ. Чингис хаан эхийнхээ хамт мордлоо.

Эх нь түүнд аминчлан Тэргүүн Ононы Дэлүүн болдогт очмоор байна гэснийг ёсоор болгож, явдал зөөлөн зүрх цагаан хилэн хар мориндоо, бүүрэг намхан хатан эмээл тохож Өүлэн эх тайвуухан галигуулсаар Дэлүүн болдогт иржээ.

- Миний зүрх хөөрөөд байна. Чамайг төрүүлж найр наадам хийсэн газарт би дахин ирнэ гэж санасангүй. Тэр саглагар модны дор найр болсон юм даа гэж Өүлэн эх Чингист хэлэв.

- Тэгэхэд чиний эцэг Есүхэй баатар надад "Хөвүүнээс бүү холд. Найр тараад хонхот сүйхээрээ яв гэсэн юм". Одоо бодоход чамайг эмзэг гэдгийг сануулжээ.

- Хасар эмзэг үү.? -Тэр цул...

- Надад эмзэг дүү бий юу

- Хэвлий тусдаа хэр нь Бэлгүтэй ойролцоо бус уу.

- Нөхөд тань цугларчээ.

Монголын тал хээр нутаг цэнхэртээд, зүг зүгээс хамаг монголын хаан руу нүүдэл ирж байна. Саглагар модны доор буудаллаж хөл хөдөлгөөн ихсэв. Саглагар модны салаа мөчир өтгөрчээ. Модны цаана багил ногоон ой дуниартана. Саглагар модноос наашлаад их өвстэй нүцгэн хээр тал үргэлжилж Онон мөрөнд тулжээ. Ононы давчуу урсгал нь гүн цүнхээл эргүүлэг үүсгэнэ. Эргүүлэг дээгүүр шоовдор алагтуу хашгичин цамнаж хөх түрүү, хэдгэнийг ховдоглон үмхэж байлаа. Аймаг, овгуудын дугуй хүрээ үүсч хуур, жимбүүр, цоор, товшуурын эгшиглэнт дуу гаслан зовлон нүүрлэсэн тал хээр нутгийг амаржуулж авай.

\* \* \*

Тэргүүн өндөрлөг дээр Чингис хаан эхийн хамт зогсоно. Өглөө нь Өүлэн эх хөвүүнтэйгээ явахаар зэхэхэд Чингис инээмсэглэж,

-Та уйдаа юу хэмээн дотночлов.

Өүлэн үжиний харцанд сүүдэр хургаж,

-Хөвүүнээ санах юм байна шүү хэмээн дахин өгүүлэв.

-Надад юунд зовно.

-Эхийн санаа үрд гэдэг юм.

-Өнөөдрийн нүүдлийг та юунд ихэд сонирхоно.

-Тийм ээ, хөвгүүд, ач нараа үдэж өгье.

Цэрэг дайны бөө хэнгэрэгээ дэлдэв. Цэргийн жанжин Мухулай бөө хувцастай байлаа. Хэнгэрэгийн дуу нүргэлэв. Нүргэлсэн их дуунаар Хөдөө арал хуйларч, Онон мөрөн усаа цалгитал эрэг юугаан мөргөнө. Урьд хожид үзэгдээгүй үй олон агт морьд, цэрэг эрчүүд цугларчээ. Нүүдэл дагасан аянчин эгэлгүй их байв. Тэмээн жин, хөтөлгөө морьд, идэшний бог мал хөндийгөөр дүүрэн аж. Энэ бол Чингисийн их цэрэг юм. Монголчуудын дайн байлдааны их нүүдэл юм. Нүүдлийн их давалгаан хаашаа ч цутгаж урсахад бэлэн ажээ.

Өүлэн эх нь хаан хөвүүнийхээ алган дээр эцсийн удаа сүү дусааж, ерөөл өргөж байгаагаа эс мэдэвч түүний хараанд бяцхан Тэмүжин үзэгдэнэ. Хөвүүний алган дээр сүү тогтжээ.

Сүүний цагаахан дусал Чингис хааны алган дээр нүдний нулимс мэт үзэгдэнэ. Тэрхүү нулимс нь мэнгэ мэт харагдмуй. Цэргийн түмэн хэнгэрэг Хөдөө аралд нүргэлэв. Нүргээнийг дагаад адуу янцгааж догшин эрс уухайлав.

Чингис хаан эхийнхээ сүүний үнэртэй цээжинд хацраа нааж "Намайг иртэл мэнд амар сууж байгаарай, ижий минь. Хөвүүндээ бүү зовогтун" хэмээн шүүрс алдан хэлэв. Их цэргийн түрүүч хөдлөхөд Онон мөрөнг өгсөөд нүүдэл айсуу. Бөртэ чоно баатрын хөх цэргүүд хөх тугаа салхинд хийсгэж одов оо.

Чингисийн тооллын 796-800 дугаар он. Нийтийн он тооллын 2002-2006 он. Зөн билгийн туульс жаргавай.

# ГЭГЭЭН ЧИНГИС ХААН

(Кино зохиол)

Тэмүжин

(Эхний хэсэг)

Сарны наана чоно улина. Бүтэн дугариг сарны дэвсгэр дээр чононы дүрс зураг давхцана. Аажмаар сар чоно хоёр улам ойртож хөх тэнгэрийн хаа нэгтээгээс ямар нэгэн ид хавыг даллан дуудах мэт уянгатай улих ажээ.

Уулын онгон сүрлэг овоо, тахилга тэргүүтнийг тойрон Тэв тэнгэр хоёр бөөгийн хамт:

Тэв тэнгэр: - Хөх тэнгэр эцэг минь ершөө Хөрст газар эх минь болгоо Хүлцэл өчиж сөгдөн мөргөө Хүн зоноо ивээлдээ багтааж хайрла гэж



цамнан бүжиглэх нь хэнгэрэгийн дэлдэлтэнд эрчлэн омогшиж нарны гэрэл сүүдэр хоршиж тэрхүү бөөнүүдийг эмнэг догшин болгоно. Цаанаа сартай наанаа нартай сундлаа олон уулсын зоон дээгүүр чонын улилт, бөөнүүдийн догшролт болоод татаж тавин бүжиглэх нь ямарваа нэгэн зөн совин далд хүчийг тэнгэрээс дуудаж газартай холбож байх амой.

Дээд тэнгэрээс заяат төрсөн Бөртэ чоно, гэргий Гуа маралын хамт дайчин баатар эрсээ дагуулан тэнгис далайг гатлан ирнэ.

Сиян тагнаас Цагаан хэрэм, Байгаль нуураас дорнотын их тал нутаг хүртэл монгол туургатан оршин суудаг газрын зураг зохиогчийн үгний дэвсгэр болж гарна.

Зохиогч: Монголын олон үндэстэн аймгууд нь өөрийн өвөг дээдэс Хүннүгийн үеэс өмнөд талаараа урт цагаан хэрэм, зүүн талаараа Хянганы даваа, баруун талаараа Сиян тагна, Алтай, Тэнгэр уулыг хүрч, хойт талаараа Байгаль нуур, Сибирийн хөвөө хязгааргүй уудам нутгаар хиллэж байлаа.

## Чингисийн элч

Тал дундуур хөтөлгөө морьтон тоос татуулан давхина.

Чингисийн цэргийн нүүгэлтсэн их цуваа.

Нэгэн өндөрлөг дээр Чингис хаан өөрийн өрлөг баатрууд болох Хасар, Боорчи, Борохул, Зэв, Зэлмэ, Хубилай, Сүбэдэй, Бэлгүтэй нарын хамт зогсоно. Гэтэл алсаас:

Хөтөлгөө морьтон давхисаар Чингисийн цэргүүдийн өмнө ирж зогсоно.

Элч мориноос үсрэн бууж сөгдөхөд Чингисийн эрт багын анд Чулуун цээж нүцгэнээр хөтөлгөө морин дээр хөшиж түүний цээжин бие дээр цусаар сийлсэн үгс харагдвай. Боорчи Чингис хаанд бичгийг уншиж сонсгоно!

Боорчи: -Зэрлэг нүүдэлчин чиний 100 элчийн хоёры нь толгойг их биетэй нь буцаав.



Чингис хаан: -Хар багаас сонсох чих, үзэх нүд болж явсан Чулуун минь. Би дэлхийн хүмүүн үүссэн энэ газрын хүйснээс дөрвөн зүг, найман зовхист найрсаг харьцаж амьдарья хэмээн хүслээ. Монгол нутгаас нүүсэн түмэн хэлийн улс нэг нартай атал, Лалын хаан Мухамед чи өөр нартай мэт Монголчуудад догшин авиралжээ. Энхийг хүсэж миний явуулсан 450 худалдаачдын торгы нь булааж толгойгий нь ороон цавчихад эхлээд би юу ч эс хэлэв. Дотроо би уйлавч дайтахыг эс хүсэж илгээсэн миний 100 элчийг дахин хөнөөж, хорвоо хotoйх бузрын дээдийг дахин чи үйлджээ. Сүү шиг сайхан сэтгэл рүү минь цустай шороо цацлаа Би яахин тэвчинэ. Хэрвээ Мухамед чи ертөнцөөс ангижрах мэт тусгаарлаж алан хядагчидаа өөгшүүлбэл би та нартай лалын чинь хатуу хуулиар харьцах болно хэмээн догширон шивнэж хэллээ.

Чулууны минь шарилыг хаан мэт онголон тахь гэснээ хэдүйн дэргэд нь ирсэн идэр залуу Зүч рүү харан -Хөвгүүдийн минь ахмад Зүч чи сонс! гэв.

"ЧИНГИС ХААН" гэсэн бичиг хуучин монголоор гарна.



### Өэлүн эх төрөв

Монголчуудын их нүүдэл. Аяны замд морьтон баатрууд тэрэг ачаатай тэмээ энгийн ард иргэд цуваанд үргэлжлэн хөвөрнө. Их нүүдэл Бурхан Халдун уулыг чиглэн хөвөрч ахуйд зохиогч дараах үгийг хэлж дүрсжин гарна.

Есүхэй баатрын баг цэрэг, бие тулгар Өүлэн хатан, асрагч Хуагчин нарын хамт явж байна.

Өүлэн хатан үе үе дуншуулж эмээлийн бүүрэгнээс атгана.

Өүлэн хатан эмээлийн бүүрэгнээс улам чанга зуурч, битүү дуншиж хамаг хөлс нь чийхарч явааг Хуагчин эмгэн ажиглаж нүүдлийг зогсоов. Өэлүн эх төрөх гээд орь дуу тавин эмээлийн араар суух үед Сочигэл томорч буй гэдсээ даран ёозгүйхэн ярвайж байснаа Өэлүн хатны тийш алхлаа.



Баг цэрэг хүрээ үүсгэн дугуйран зогсож түүний голд Өүлэн эх, Хуагчин хоёр үлдэв.

Хуагчин, Өүлэнийг мориноос буулгах гэж оролдоход тэрвээр эмээлийн араар хөлбөрөн сууж биеэ сул тавилаа. Дугуйран зогссон баг цэргүүд ар шилээрээ харж буй мэт хүрлийн зогсоно. Цэргүүдийн чихэнд хүүхдийн уйлах дуу часхийн сонсдоно.

Чирха өвгөн хүүхдийн дуутай зэрэгцэх шахам Өүлэн хатан, Хуагчин эмгэн хоёрын дэргэд дөхөж очлоо.

Эмгэн тэр даруйд хүүхдийг хэзээний гар дээрээ барьж,

Хуагчин: -Есүхэй баатар хүүтэй боллоо гэж баярын дуугаар бахирлаа. 1162 он гэсэн бичиг энэ үед дэлгэцэн дээр гарна.

### Өэлүний бодол

Өүлэний дөнгөж төрсөн нялх царай дээр Есүхэй баатарт булаагдаж ирэхээс емнө мэргидийн Чилэдү баатартай хамт морин дээр янаглан давхиж байсан нь агшнаа бодогдов.



Энэхүү бодлыг Чирха өвгөний,

Чирха: -Есүхэй баатар хүүтэй болсон баярт мэдээг би даруйхан хүргэе хэмээн хяхатнасан дуугаар хашгирлаа. Мэдээ хүргэхээр давхисан морьт цэргүүд...



## Татаарын эзлэгдсэн хүрээ

Татаарын олзлогдсон сөхөрч суусан цэргүүд...

Их дайны дараахи уугин шатсан гэр, хүрээ, эвдэрч хэмхэрсэн гэр тэргүүд харагдана.

Дайн болсныг алсаас харж мэдсэн Чирха өвгөн морины хурдаар Есүхэй баатар руу давхин очиж,

Чирха: -Есүхэй баатар болгоон соёрх. Мөнх тэнгэр таалж Өэлүн хатан танд хүү төрүүлээ гэж баярлаж бахардан хашгирлаа.



Есүхэй баатар дэргэдэх цэргийнхээ сэлмийг суга татан татаарын баатар руу шидэж өгөв. Есүхэй морьтой холдоод эргэж ухасхийн довголлоо.

Есүхэй баатрын сэлэмд газарт өөрийгөө хамгаалан зогсоо татаарын баатар Тэмүжиний толгой тас цавчигдан их биеэс нь цус цацрав.

Тэмүжиний толгой амь тавиагүйн шинж илэрхийлэн харцаа Есүхэйн өөдөөс чиглүүлэн хөшив.

Эн сацуу түүний толгойгүй бие тэнцвэр алдалгүй хэд алхлаа.

Энэ бүгдийг харсан татаарын Мэгүжин сүүлт хөмхий зуун зангидсан нударгаараа газар шааж өшөө хорслоо багтааж ядан,

Мэгүжин сүүлт: -Татаарын хан зоригт эр чиний өшөөг авна хэмээн тангараглав. Есүхэй баатар сэлмээ өргөн, Есүхэй: -Татаарын баатар Тэмүжиний нэрийг хүүд өг гэв.

### Есүхэйн бодол

Есүхэйн баг цэрэг Өүлэн, Чилэдү хоёрын морин дээр сундалдаад тэврэлдэж буйг харж буй...

Есүхэй нум, сумаа хөвчлөн татаж Чилэдүг харваж буй...

Есүхэй баатар гар нь суларсан Чилэдүйн өмнөөс Өүлэнийг тэврэн татаж өмнүүрээ дүүрэн давхиж буй... Өүлэний нулимстай царай...

Чилэдүгийн араас харж байгаа Өүлэний нүд дүүрэн нулимстай царай ээлжлэн хоромхоноо бодогдлоо.

Есүхэй баатрын энэхүү бодлыг,

-Есүхэй баатар хүүтэй боллоо. Монголын боржигон аймгийн хаан Тэмүжин хэмээх хүүтэй боллоо...

Есүхэй баатрын хөвүүн Тэмүжин, Тэмүжин, Тэмүжин ....хэмээн хашгиралдаж цэргүүдийн дуу түүний бодлыг сарниулав.

Цэргүүдийн баяр хөөртэй нүүр, царайнууд...



### **Өэлүн хатны өргөө**

Есүхэй баатар өлгийтэй хүүхдийг авч,

Есүхэй: -Энэ мэргидийн зулбасагыг усанд хаяж орхи гээд шидэхээр дээш нь өргөхөд Өүлэн эх гараас нь зууран хашгирч,

Өэлүн: - Миний хүү, миний хүү... хэмээн гараа сарвалзуулан бахирлаа. Энэ бахираан нь Өүлэн хатны зүүд байлаа.

Тэрээр хий юм самардан сэрээд хажууд байх ёстой хүүгээ тэмтчин эрлээ. Өлгийтэй хүүхэд алга байв. Өүлэн гэр дотуур нүд гүйлгэн харснаа гэрийн үүдийг цэлийтэл нээж харлаа.



### **ОНОН МӨРНИЙ ЭРЭГ**

Түүний нүднээ Онон мөрний өндөр эрэг дээр зогсоод хүүгээ хоёр гар дээрээ өндөр өргөж байгаа Есүхэй баатар,

Есүхэй: -Миний хүү Тэмүжин чи их Монголын бөртө чоно болоорой гэж хэлээд нүдний аяга нь нулимсаар дүүрэн байлаа.

Өүлэн Есүхэйн хөлд сөхрөн унаж нулимс нь ангасан газарт гол мэт урсав.

Өүлэн Чилэдүйгээс булаагдсаны дараа Есүхэйн хүдэр чийрэг гарт тэврүүлэн түүний их өргөөний хоймрын орон дээр өргүүлсээр очих үед Есүхэй түүнийг өөр рүүгээ татан дээлий нь энгэрийг ярж таалан үнслээ.



Өүлэн хатан бодлоос салж өөрийн нялх хүүг энхрийлэн тэврээд хөхөө гаргахад Есүхэй түүнд туслан хүүг ойртууллаа... Энэ үед тулгар биетэй Сочигал тэднийг агаархангуй ширтэж байв.

Хүүгийн атгасан баруун гарыг Есүхэй зөөлөн тэнийлгэхэд түүний гарт нөж атгаастай байлаа. Өүлэн хүүгийн алган дээрхи нөж рүү сүү дусаахад цус шингэрэн арилна. Есүхэй Өүлэн хоёр бие биенээ энхрийлж дотноссон харцаар харна.


Хүүгийн жижиг алган дээр эхийн хөхнөөс дусаах сүү...

## ЕСҮХЭЙН ХҮРЭЭ

Өвөл цаг Их цас лавсан орсон дун цагаан өдөр Есүхэй баатар хүү Тэмүжинд бэр гуйхаар мордох болов. 50-60 хүнтэй баг цэрэг гэр хүрээний гадаа зэр зэвсэг агсан зогсоно.

Хээ нь тодорсон Тэмүжин хүүгийн баруун гарын алган дээр Өүлэн эх сүү дусаалаа.

Өүлэн эх Тэмүжин хүүг элгэндээ наан тэвэрлээ. Тэмүжин хүү 9 настай байлаа. Орон дээр бяцхан хүүхэд уйлагнана.



Өүлэн хатан хүүгээ хөтөлсөөр хэдүйнээ мориндоо мордсон Есүхэй баатар дээр ирлээ. Хуагчины авчирсан сүү идээг Өүлэн хатан авч хүүгийнхээ дөрөөг мялаагаад мордууллаа. Мориндоо мордоод эргэн харах Тэмүжиний нүдэнд Есүхэйн хатан Сочигал, Бэлгүдэй, Бэгтэр нарын хамт харагдана.

Мөн түүний нүдэнд дүү Хасар, Хачиун, Тэмүгэ нарын хамт зогсон сүүн цацал өргөх Өүлэн их содон харагдлаа.

## АЯН ЗАМД

Цасанд хучигдаж дүнсийсэн их уул тал давааны замаар Есүхэйн баг цэрэг морины ам таталгүй довтолгож морьдын цээж толгой, дэл сүүл цантан цагаан хуягт дуулга өмссөн мэт уур савсан догшин эрэмгий чанга үзэгдэнэ.

Баг цэргийн түрүүнд Есүхэй баатар бяцхан Тэмүжиний хамт давхиулна. Морины явдал дунд Тэмүжин хүү

Тэмүжин: - Энэ юу вэ? Аав аа

Есүхэй баатар: - Эртний Түрэгийн жанжин Тонюкукын хөшөө, манай монгол нутагт эрт цагт Кидан, Уйгар, Хиргэс, Түрэг олон аймаг байв. Тэд цем эндээс нүүж одсон. Бидний евөг дээдэс Хүннүчүүдийн хагас ч өрнө зүгт нүүн суурьшсан.



Хүн гэдэг амьтан сууривал сөнөнө. Нүүж л явах ёстой, хүмүүн төрөлхтөн нүүж яваа... Зөвхөн бид л нүүдэлчид биш шүү дээ. Хүннүгийн Монголын Атилла хааныг минь өрнөдийнхөн андахгүй. Тэр өрнийн, дорно руу харах нүдийг нээсэн юм.

Тэмүжин: - Яагаад нүүсэн юм бэ? гэж гайхаж учрыг лавлан асуулаа.

Есүхэй: -Өр өрөө өмлөх аюул бусдын тийрэх хөлөөс болж өөрсдийн дурсгал хөшөө чулуун дээрхи захиас бичээсээ үлдээж нүүсэн юм аа. Одоогоос таван зуун жилийн өмнө түргийн Билгэ хаан Монголын өндөрлөгөөс нүүхдээ үлдээсэн.

Орхоны хөндийн чулуун дээрхи бичээсээс үзэхэд "хүчирхэг хөвгүүд нь нанхиадын боол боллоо, ариун охид нь нанхиадын шивэгчин боллоо" гэж бичиглэсэн байдаг юм. Ингэж л тэд Алтан улсаас айж энэ газраас нүүн дүрвэх болсон билээ.

Тэмүжин: -Алтан улс гэнэ ээ...?

Есүхэй: - Өмнөд цагаан хэрмийн урд орших нанхиад хэмээх хятадуудыг хэлдэг юмаа.

Тэмүжин: -Тэр Алтан улс чинь дийлдэшгүй тийм хүчтэй юмуу?

Есүхэй: -За Тэмүжин чи сонс. Алтан улс гэж маниас айж барьсан цагаан хэрэмнийхээ цаана шавар гэртээ шавааралдан суудаг, нэг хэсэг нь хийснээ наймаалцаж, нөгөө хэсэг нь газар малтан тариа тарьж амьдардаг. Чиний байтугай миний үзээгүй зэвсгээр дайтдаг үй түмэн цэрэгтэй улс бий. Тэд татаар аймагтай эвсэж манай Монголын гурван хааныг аваачиж алсан ялтай. Бүр чиний дээд авга Амбагай хааныг Алтан улсад хуурч аваачин хөнөөсөн юм. Миний өшөөг арван хуруугаа тэмтэртэл санаж амь насаа үл хайрлан ав гэж захисан юм.

Тэмүжин: - Алтан улстай байлдахын тулд эхлээд Монголын аймгуудыг нэгтгэх хэрэгтэй гэж том хүн лугаа адил хэвлүүн нь аргагүй хэллээ.

Есүхэй баатар морины давхиан дунд хүүгээ энэ юу хэлэв гэсэн мэт гайхаж бахархсан харцаар ажлаа.

## БӨРТЭД СҮЙ ТАВИВ

Есүхэйн баг цэрэг цас маналзуулан эргэлдэн зогслоо.

Цэргүүд нумаа бэлдэж Есүхэйн тушаалыг хүлээн жигдрэв. Цаанаас нь гарч ирсэн баг цэрэг мөн жагсаалаа эмхлэх нь үзэгдвэй.

Есүхэй: -Та нар хэний хэн бэ? Нэртэй хүний зүстэй хүн бол нэрээ хэлтүгэй.

Дай Сэцэн: Би Хонгирад аймгийн Дай Сэцэн байна. Чи хэн гэгч вэ?

Есүхэй: -Би Боржигон аймгийн хаан Есүхэй баатар! гэж хэлээд хоёр баг цэрэг чимээгүй боллоцов.

Есүхэй хүү Тэмүжинд хандан,

Есүхэй: -Хонгирад аймаг Алтан улсын наана оршдог, тэднийг цагаан татаарчууд хэмээнэ. Нутаг нь үржил шимтэй мал сүрэг эд агуурс элбэг баян. Дай Сэцэнтэй учирсан минь сайны ерөөл буй заа.



Энэ завсар Дай Сэцэн угтан ирж яваа Есүхэй баатрыг тосон очих зуураа охин жижиг Бөртэ. Тэмүжингээс 2-3 насаар ах байрын Жамуха хүүг хамт дагуулан,

Дай Сэцэн: - Энэ Есүхэй баатар бол хар татаарын заналт дайсан. Боржигон аймгийн хаан билээ. Бид энэ Есүхэйтэй эвсэн дотносож, элэг нэгсэх тохиолдлыг үл алдаж болно. Жамуха

аа найртай уулзая гэж хэлээд эгнэж зогссон цэргүүдээсээ тасран өөд өөдөөсөө явсаар уулзлаа.

Бөртэ, Тэмүжинг сонирхон инээмсэглэн харна.

Бөртэ охины харцанд Тэмүжин ичингүйрэн далдираад Жамуха дээр харц тогтов.

Жамухын мөрөн дээр шонхор шувуу байна.

Дай Сэцэн, Есүхэй баатар хоёр хүүхдүүдийг ийн харалцах хугацаанд нилээн зүйл ярьж амжсан бололтой. Жамуха алсад дэгдэн гүйх туулай руу шонхор шувуугаа нисгэн тавьлаа.

Дай Сэцэн: Есүхэй баатараа би таны хүүг ихэд тоов гэж таашаалдан зогсоод энэрэнгүй сайхнаар өгүүлэв.

Есүхэй баатар: -Би чонын авд явдаг эм огт үзсэнгүй тул чиний охиныг тоов. Би чиний охинд сүй тавья. Олзны зам дээр учирсан тул лав хувь зохиол өлзийтэй биз ээ гээд,... Энэ хүү чинь хэн билээ хэмээн асуулаа.

Дай Сэцэн : -Жадаран аймгийн Жамух гэгч. Манай энд цэргийн эрдэм суралцаж байгаа юм. Би урьд шөнө танай аймгийн сүлдийг зүүдэлсэн нь сүй бэлгийн ерөөл байж.

Есүхэй баатар: - Хэрэг ийм дээрээ тулсан тул би даруй гэдрэг буцсугай. Жамуха алсаас шонхроо мөрөн дээрээ суулган саяхан авласан туулайг хоёр чихнээс нь барин айсуу.

Дай Сэцэн: -Есүхэй баатар та Тэмүжин хүүг надад үлдээ. Сүй тавьсан гэрт үлдэх ёс манайд бий.

Энэ үгийг Тэмүжин хүү сонсоод эцэг рүүгээ харлаа. Есүхэй мориндоо мордонгоо,

Есүхэй: - За тэгье. Хүүг минь нохойноос бүү цочоо. Бүр багын нохойноос цочдог юм.

Дай Сэцэн, Есүхэй баатарт чонын болон ангийн олз сагсайтал ачсан морины цулбуурыг өгч,

Дай Сэцэн:-Тэмүжин хүүд бүү санаа зов. Би өөрийн хүү мэт асарна. Манай хонгирад хэдийнээс зээгийн зүсээр охидын өнгөөр явж, өндөр суурь эзлэгчдийн ерөөлт хань нь болдог гэхэд Есүхэй баатар талархалтай хараад хүүгийнхээ морийг хөтлөн эргэж харалгүй морио давирлаа.

Энэ үед Тэмүжин цасан дунд хаягдсан ганц тариан ширхэг шиг үлдээд Тэмүжин: - Ааваа... ааваа... гээд давхин одож буй морьт цэргийн араас явганаар гүйлээ.

Эцэг Есүхэй цас маналзуулан давхиснаа зогтусан эргэн харлаа.

Цав цагаан цасан дээгүүр мөр татуулан гүйж яваа Тэмүжин хүү...

Есүхэйн баг цэрэг эргэж харан нэгэн зэрэг сум тавихад Тэмүжиний өмнө шивээлсэн сум

хана адил цасанд зоогдож түүний замыг хаан цоройлдон харагдав.

Давхилдан одох Есүхэйн баг цэрэг...

Нүүрэндээ цас наан тэрийн унасан Тэмүжиний нүднээс нүүрэнд наалдсан цасыг нь хайлуулан бүлээн нулимс урсаж байв.

## ТЭМҮЖИНИЙ БОДОЛ

Түүний нүднээ эртний домогт Бөртэ чоно, Гуа Марал хоёр ер бусын хувцас чимэглэлтэй баатруудын хамт түүнд дөхөн ирж нум, саадаг сарвайн,

Бөртэ чоно: -Май, чи бөртө чоно биш үү. Эр хүний нулимс ил байдаггүй, зүрхэндээ шингэдэг юм хэмээгээд ногоон тал дундуур давхилдаж одов.



## ЕСҮХЭЙ БААТАР БУЦАВ

Тэмүжингийн дэргэд Бөртэ, Жамуха хоёр ирээд түүнийг тайтгаруулав. Тэдний нүдэнд Есүхэйн баг цэрэг цас маналзуулан давхилдан одлоо.



## ЭР ӨСӨВ

Сум шивхийн исгэрч байнд зоогдов. Үзвэл сум тавигч нь Тэмүжин ажээ. Бөртэ: -Тэмүжээн дахиад сум тавь! хэмээн хөөрөн баясана.

Энэ үед Тэмүжинтэй зэрэгцэн ирсэн Жамуха нэгэн сум тавьсанаа,

Жамуха: -Тэмүжин! хоёул үнэнч анд болоё. Би чамд алтан шагайгаа өгье.

Тэмүжин өврөө тэмтрэн,

Тэмүжин: -Би зээрийн алтан шагайгаа тангарагийн баталгаа болгоё гээд хоёр шагайгаа ёс төртэйгээр солилцлоо.

Тэмүжин: - Нэг тэрэгний арал мэт итгэлт анд боллоо бид.

Жамуха: - Мартсанаа сануулж унтсанаа сэрүүлж явья гээд тэд тэврэлдэв.



Энэ үед цагаан алчуур дэрвүүлсэн Бөртэ морьтой давхиж ирээд Тэмүжингийн хүзүүнээ зүүж еглөө.

Эдгээр үйл явдлыг харж байсан Жамуха гэнэт эргэн давхиж одов.

## ЕСҮХЭЙ ХОРЛОГДОВ

Элстэй манхан дунд баригдсан нэгэн цагаан гэрийн гадна урьд хожид үзэгдэж харагдаагүй үзэсгэлэнт бүсгүй саравчлан зогслоо.

Есүхэй баг цэрэг дагуулан гэрийн хажуугаар өнгөрөх гэснээ больж гэрийн зүг арав орчим цэргийн хамт дөхөн очлоо.

Үзэсгэлэнт бүсгүй Есүхэйг инээмсэглэн харлаа.

Өндөр буттай элсэн толгодын араас баг цэрэг дагуулсан татаарын Мэгүжин сүүлт хорсол заналыг нүүрэндээ илтгэн харах боловч үзэсгэлэнт бүсгүй Есүхэй хоёрын гүн дотно харьцаанд зөөлрөх мэт заналтайгаар инээвхийлэв.

Гэрийн гадна зассан суудлыг Есүхэй баатар эзэлж үзэсгэлэнт хүүхнийг шимтэн харсаар байлаа. Тусгайлан тавьсан идээ, сархад тойрсон цэргүүдэд барьж буй гоо бүсгүй үнэхээр дур булаам ажээ.

Есүхэй баатрын цэргүүд гоо үзэсгэлэнт эмэгтэйг ичгүүр сонжуургүй нэвт шувт ширтэн үйл хөдөлгөөн болгоны нь дагуулан харна.

Татаарын Мэгүжин Сүүлт алсаас дуулалдаж эхлэх Есүхэй баатрын цэргүүдийн дуу, хөөр баяслыг бахтайяа сонсон харна.

Баатар эрс үзэсгэлэнт эмд сэтгэлээ бүрэн тавьж туусан бололтой ая дуу өргөж эхлэв.

Үзэсгэлэнт эмэгтэй тагштай архийг баатар эрчүүдэд цувуулан барих зуураа нэгэн сонин хачин аялгууг гарган өөрөө дуулан бүжиглэж эхлэв.

Аагтай дарсаа сөгнөө



Алтан мутраа дэлгээ

Аялгат бийгээ бүжье

Алсын зочноо угтая



Альа гэвэл хор байна Аврая гэвэл үг байна Хүний эрээн дотроо бий Хорхойн эрээн гаднаа бий Хүрэл чулуун зүрхтэн бий Хүү минь бодолтой яв даа

Энэ бие хэврэг гэнэ лээ шүү Эрхэм нэр мөнх гэнэ лээ шүү, Түүнийг сонссон цэргүүд алмайран гайхаж байснаа Есүхэй баатраас эхлэн аяны түрлэг нэмж мөр цохин суудал дээрээ намуухан хөдөлж бүгдээр дуулж байв.

Элсэн бутны араас татаарын Мэгүжин Сүүлт дуулах, инээх хоёрын завсар баясан хөөрч туйлын өшөө хорсол бадарсан авиа гарган чангаар инээлээ.

Сэтгэл зүрх нь ихэд хөөрч омогшсон Есүхэйн баатар эрс дуугаа ээлжлэн дуулсаар мориндоо мордох үед нэгэн хүдэр чийрэг баатар эр үзэсгэлэнт эмэгтэйг эмээл дээрээ дүүрч инээлдэн давхиж одоцгоов.

## ШӨНӨ ЕСҮХЭЙН ХҮРЭЭ

Гэрийн гадаа зогсох Өэлүн эхийн өөдөөс айхтар хүчтэй салхи эрчлэн үлээж салхин дундуур Есүхэй баатрын сүнс омголон хүлгийн нуруунаа давхин ирэх шиг болсноо дээгүүр нь эрчлэн өнгөрөхөд Өэлүн гайхасхийн эргэж харлаа. Энэ элсэн шуурга эргүүлэг үүсгэн хуйлран эргэлдэх эрчлэн дундаас "Тэмүжээн..." гэх дуун... Тэмүжин цочин хүчтэй салхинд ороогдон байлаа.



Есүхэй: -Тэмүжээн, Бурхан Халдун ууландаа, Онон мөрөндөө эргэж ирээч... хэмээн эцэг Есүхэйн дуу тодоос тод сонсогдох ажээ.

Тэмүжин:- Аав аа... гэв Тэмүжин илдээ шүүрч бат атгалаа. Элсэн шуурган дунд нэгэн баатар эр дахин харагдав. Баатар эр илдээ эргэлдүүлэн Тэмүжин рүү дайрав. Тэмүжин эсэргүүцэн

тулалдлаа.

Тэмүжин Үгэ: - Би бол татаарын Тэмүжин Үгэ чамайг Монголын өндөрлөгийн ад чөтгөр болгохын тулд миний нэрийг эцэг Есүхэй чинь чамд өгсөн юм. Монголыг дэлхий дахиныг цөмийг эвдэн цөлмөж шатаан устгаж гаслант там мэт өөрийн эзэнт гүрнээ байгуул... хэмээн үгээ цуурайтуулав. Баатар эр гэнэт хий үзэгдэл мэт алга болов. Энэ үед Жамуха Бөртийн хамт хүрч ирлээ. Тэмүжин илдээ атгасан чигээр зогсоно. Жамуха: - Юу болсон бэ? гэж асуув.

Тэмүжин: - Эцгийн минь дуу... Эцэг Есүхэйд ямар нэгэн юм тохиолдов уу?

Жамуха, Бөртэ би нутаг буцъя. Хүчит хуй салхины нэг үзүүрт Өэлүн эх нөгөө үзүүрт Тэмүжин хоромхон зуур дайрагдаад өнгөрөх нь тэр.

## ЕСҮХЭЙ БААТРЫН ХҮРЭЭ, ГАШУУДАЛ

Есүхэйн гэр хүрээний дундуур гүйх Өэлүн эх түрүүчийн салхи шуургатай цуг амьсгаадан өнгөрөх морьдын нэгэн адил хүчтэй бахардан амьсгалж гүйсээр Есүхэйн баг цэргийг тосч очлоо.

Өүлэн: -Ээ хөх тэнгэр минь, Есүхэй минь хэмээн цурхирав. Тэгснээ Өүлэн хатан Есүхэй баатрын дөрөөнөөс зууран,

Өэлүн: -Яачих нь энэ вэ. хаантан минь? Есүхэй минь, дээлтэй минь хатаах нь энэ үү хэмээгээд уйлан бачуурлаа. Есүхэй баатрын хөдөлгөөнгүй дүрс түүнийг тэнгэрийн оронд заларсныг бидэнд бэлхнээ илтгэнэ. Есүхэйн баатар



эрсийг хооллож ундлан ая дуу барьж байсан үзэсгэлэнт эмэгтэй мөнхүү хөшөн гөлөрчээ.

Айл гэрүүдээс толгойтой үсээ зулгаан хашгиралдан гүйлдэх авгай хүүхнүүдийн аймшигт чимээн галав юүлэхийг сануулах мэт тэдний дунд Сочигал хоёр хүүхдийн хамт байна. Есүхэй баатрын цэргүүд хөшсөн мэт ажин түжин байв.

## НҮҮДЭЛ

Ялаа нисэвч дуулдахааргүй чив чимээгүй анир нам гүмд тал дүүрэн овог аймгийнхан гэр бараагаа буулган үг дуун үгүй ачаалцгаана.

Нэгэн өндөрлөг дээр Өүлэн хатан Хасар, Хачиун, Тэмүгэ, Тэмүлэн, Бэгтэр, Бэлгүтэй, Сочихэл нар зогсоцгоох ажээ.

Өндөрлөж хураасан модон дээр Есүхэй баатрыг өвч бүрэн хувцаслан завилуулан суулгасан байлаа.

Хөшин гөлөрсөн Есүхэй баатрын нүүрнээ монгол аймаг таран бутарч тал тал тийш нүүж байгаа мэт унаа хөсгийн цуваа алсад тасралтгүй үргэлжилнэ.

Өүлэн эх нэгэн зүг рүү хараа тогтоон харлаа.

Алсаас морины хурдаар Чирха өвгөний хамт залуу хөвүүн Тэмүжин эцгийн суугаа шарилын өмнө мориноос харайн бууж сөхөрлөө.

: Энэ үед хөсөг цувааны зүгээс Таргудай хэсэг морьтоны

хамт давхин ирлээ. Түүний гарт гал улаан бамбар дүрэлзэнэ. Таргудай бамбараа шарилын хөл рүү шидэнгээ,



Таргудай: -Өүлэн чи яагаад ачаалж хөдлөхгүй байна гээд Есүхэйн дэргэд хүндэтгэн залсан аймгийн сүлд тугийг шүүрч авлаа.

Өэлүн: -Таргудай чи юунд аймшиггүйгээр аймгийн их сүлдэнд гар хүрэв. Есүхэйн их сүлдэнд хөвүүн Тэмүжингээс өөр хэн ч гар хүрэх ёсгүй гэж хашгирч дэргэд нь давхин очив.

Өэлүний үг сая л Тэмүжинийг харамсалт гашуудлаас сэхээв.

Таргудай тугийг өргөж, Өэлүнийг хүн гэж үл тоосон давлиун дуугаар

Таргудай: -Өэлүн чи сонс. Есүхэй бие барж,чи хэдэн хүүхдийн хамт хаврын хагд өвс мэт салхины аясанд сул ганхаж хоцорсноо эс санав уу. Уулаас Тайчууд бид үеийн үед боржигин аймагт нэгдэн амьдрах цаг дууслаа. Амбагай хаанаас хойш бид зөвхөн Есүхэйн цус нэгтэйг санан эвлэрч байсан биш үү. Одоо цээлийн ус ширгэв, цэгээн чулуу хагарав. Бид Боржигин аймгийг эрхэндээ оруулж нэгтгэн асрах үе эхэллээ. Есүхэйн ард үлдсэн та хэд нүдэнд орсон хог, шүдэнд орсон мах мэт болов. Үүнийг бүү март... гэж зандчив.

Өэлүн нулимс урсгаж:

Өэлүн: - Хааны шарил хан тэнгэрт одоогүй байхад Таргудай чи хаяагаар шургах могой адил хорт үг юунд хэлэв. Чи Есүхэйн хөвүүдийг хар. Энд Тэмүжин зогсож байна. Түүнийг байхад чи яаж ингэж хэлж зүрхэлнэв гэж хариулав.

Таргудай: -Чи нялх хүүхдийг үгийн завсарт бүү хавчуул. Есүхэй хөвүүдийнхээ дотроос хэн

нэгийг захиж үлдээгээгүй. Одоо Боржигоньхон бүгд Тайчуудыг даган нүүж байна. Харин...би Өэлүн чамаар үдэш гутлаа тайлуулж, өглөө цайгаа аягалуулан асарч явахыг баталъя.

Таргудайн үнэн санаа энэ байв. Тэмүжиний нүдэнд хөөрхий муу эх нь хэнд ч хэрэггүй ядуу эм болж үзэгдэнэ.

Таргудай:- Өэлүн чи намайг эс дагаж, маргааш өдөр өст татаарын мэсэнд өнчин хүүхдүүдийнхээ толгойг тасчуулах гээ юу гэж хашгирсан нь эхийн тамирыг нэг мөсөн барж, харин Тэмүжиний хорслыг нэмэгдүүлэв.

Тэмүжин Таргудайд ойртон дөхлөө. Энэ үед Бэгтэр ихэд зоригтойгоор Өэлүн эхийн дэргэд очиж түүний хамгаалагчаар зогссон нь ингэхэд бас хүргэв. Хасар, бусад хөвгүүд ч эхийн дэргэд ирэв.

Таргудай: -Та нар хар тэр нүүдлийг... Таргудайн заасан зүгт, Есүхэйн хаяанаас их нүүдэл хөдөлж байв.

Таргудай: -Боржигиньхон намайг даган энэ үхээрийн нутгаас дайжиж байна... Энэ удаа би та нарыг эцгийн чинь шарилын дэргэд зүгээр орхиё. Гэвч энэ мэт удахгүйг санаж яв... гээд Таргудай ухасхийн давхилаа.

Тэмүжин залуу ирвэс мэт Таргудайг хөөж гүйцээд дөрөөн дээр нь гарч тугны ишнээс хоёр гараар зууралдан тэмцэв. Энэ үед Тэмүжин уур омгоо дарж эс чадан их үгийг хашгирав.

Тэмүжин: -Миний аав өөд болсон ч Тайчууд та нар Есүхэйн их хүү Тэмүжин надаас асуулгүй юунд нүүдэл хөдөлгөв... гэж шингэн дуугаар хашгирчээ. Таргудай агсам морины ам таталгүй давхих зуур дэлүү шиг наалдсан гавшгай Тэмүжинийг унагах гэж дийлэлгүй бас хорсож:

Таргудай:-Муу бэлтрэг сонс. Чамайг эцэг чинь үл тоож, үхэхдээ нэрийг чинь эс дурьдлаа. Монгол аймгийг Тайчууд захирах ээлж боллоо. Энэ үед Хасар ахын араас гүйсэн боловч тэнхэл хүрсэнгүй.

Тэмүжин: Эцэг чинь үл тоосон гэнэ ээ... Есүхэй аавын сэлэм миний гарт байна.

Таргудай чи хэзээ ч боржигон овгийг тэргүүлэхгүй гэж үглэн зууралдтал тугны иш хугарч, Тэмүжин гарт үлдсэн дарцагтай хэсгийг барьсан чигээр хатуу газар тэртээ хол шидэгдлээ. Хөсөр шидэгдсэн Тэмүжин хүүг Таргудай омголон мориор гишгүүлэхээр ухасхийв.

Тэмүжинг газарт шидэгдэхэд ойрмог газраас Чирха өвгөн давхин ирж Таргудайг хөндөлсөн

Чирха: -Таргудай чи тогтож аяд. Боржигин аймгийнхныг бүү үймүүл. Тэд угаас Есүхэй, Өэлүн хоёрт захирагдаж ирсэн улс. Бүү нүүлгэ. Хэрхэхийг Тэмүжин мэднэ гэж хашгирвал Таргудай түүнийг үл тоож:

Таргудай: -Чи замд бүү тээг бол. Үүнийг нэгэн олноор хэлэлцэж тохирсон гэж хилэгнэн дэргэдэх хүний жадыг мултлан авч өвгөний нуруу руу жадлан хөсөр унагаад, нүүдлийг хөөж давхилаа.

Өэлүн: -Мэнлигийг дууд

Бэгтэр: -Мэнлиг явж одсон

Өэлүн: -Мэнлиг ч явжээ.

Өэлүн: -Сорхон шар ч явсан гэж Өэлүн тэднийг буцаа гэж давтан өгүүлж байв.

Дэргэд нь Хасар ирж зэрэгцэн зогсов. Өэлүн эх хөв хөх царайтай давхин ирээд

Өэлүн: -Эцэг чинь өөд болов. Хөвүүн чи эцгийн оронд энэ гэрийн тулгуур болж үлд. Бүү буц гэж хатуу хэлэв. Эхийн хөв хөх царайг харсан Хасар Тэмүжинд

Хасар-. Эхийн нулимс хатжээ гэж шивнэв.

Тэмүжин: Энэ өдрөөс хойш чи миний шударга туслагч болоорой. Миний тушаалыг зөрчиж болохгүй. Үүний хариуд чи миний дараагаар энэ гэрт эрх барихыг би чамд зөвшөөрнө гэж хэлэв. Бэгтэрт Тэмүжиний шийдвэр таатай бус сонсогдсон боловч тэр юу ч эс хэлэв.

Их бууц эзгүйрэн ганц гэр долоон хүүхэдтэй Өэлүн л торойн хоцров... Хугархай ишт тугийг барьсан Тэмүжин болоод хүүхдүүдээ харахад Өэлүний сэтгэлд түгшүүр төрнө. Энэ үед Бэгтэр. Бэлгүтэй дүүгийн хамт Есүхэйн шатаж буй шарилын дэргэд зогсох нь үзэгдэнэ.

Галын дэргэд суух Тэмүжин хүүгээ Өэлүн яаж тайтгаруулах аргаа эс олов.

Эцгийн ард үлдсэн энэ хэдэн нялзрайг хэний ч нүдэнд хог мэт үзэгдүүлэхгүйн тулд хатамжлан бүсээ чанга бүсэлж мориндоо мордлоо.

Тэмүжин хүү саяхан алалдан байж авчирсан эцгийн голомтын туг сүлдийг элгэндээ нааж тэврэн эцгийн шарилыг ширтэн нулимс, харуусал дүүрнээр бархиран уйлж яг л өөрийн биеийг шатааж байх мэт сөхрөн суусаар байлаа. Энэ үед Есүхэйн сүнс тэнгэр өөд нисэн оджээ.

## **БЭГТЭРИЙН ҮХЭЛ**

Онон мөрний нэгэн цутгалангийн харгиат уснаа Хасар дүү Хачиуны хамт бургасан тороор загас шүүрдэж гялалзсан өнгөт том саргусан загас орсонд Хасар баясан, голын эрэгт байсан Тэмүжинг дуудан дээр өргөж үзүүлэв.

Хасар: -Тэмүжин ахаа... би загас гогодов.

Голын хөвөөний дэнжид Өэлүн эх гэрийн дэргэдээс хөвгүүдийн юу хийхийг харж байлаа.

Хасарын ийнхүү сүр дуу болон гайхуулсан загасыг Бэгтэр үзмэгц ус үсчүүлэн гүйж ирээд булаан авахад, Хасар эсэргүүцэвч Бэлгүтэй Бэгтэр нар загасыг булаан авав.

Тэмүжин нумаа авч онилов. Сум Бэгтэрийн барьсан загасанд шунхийн зоогдож бас

хүүхдүүдийг цочоолоо...

Сумнаас айсан дүү нар нь уснаас гүйн гарч Бэгтэр сумтай загасаа барьсаар усанд үлдэв. Тэмүжин нумаа авч түүний тушаах голын эрэг дээр ирж зогсоод:

Тэмүжин: Чи юунд ингэж бидний олзыг булааж хэрүүл өднө вэ. Би чамд энэ удаа зүгээр анхааруулъя. Бидний хэрүүлээс болж Өэлүн эх шаналж байна. Чи юунд ингэж сайхан сэтгэлт эхийг минь зовооно... гэж ширүүн хэлэв.

Бэгтэр усанд завилан сууж:

Бэгтэр: Би Тэмүжин чиний юу чалчихыг сонсоно гэж үү. Чи бол Есүхэйн хүү биш. Би, Бэлгүтэй, Хасар. Хачиун, Тэмүгэ, Тэмүлүн бид бүгд Есүхэйн хүүхэд. чи л ганцаар биш. Чамаас бусад бүх хүн үүнийг мэднэ. Чиний биед мэргидийн цус урсаж буй. Чи бол Өэлүний биеийг зээлж төрсөн зочин.



Тэмүжин: Чи юунд дэмий үг чалчина вэ гэж бачимдан хашгирч хоёр алхам урагшилж нумаа өргөв.

Бэгтэр: Чи эхээсээ асуу... Тэр чамд хэлнэ. Эцэг Есүхэй чамайг Дай Сэцэнийд аваачиж төөрүүлснийг чи мартав уу.

Энэ үг Тэмүжинд цохилт болж чадав.

Тэмүжиний энэ дүйнгэ байдалд Бэгтэр урамшиж:

Бэгтэр: -Би энэ өдрөөс хойш чиний ямар ч үгийг сонсохгүй. Ах ч гэж үзэхгүй.

Есүхэйн цусыг биедээ шингээсэн Бэгтэр би энэ гэрт тушаал буулгагч хаан байх ёстой...

Энэ үг Тэмүжиний тэсвэрийг барагдуулж Бэгтэрийг амьд үлдээж болохгүй гэсэн шийдвэр төрж нумаа татлаа.

Тэмүжиний эрс шийдмэг харцыг хүлээн авсан Хасар өөрийн нум сумыг авч Бэгтэрийн зугатах замыг хаах мэт голын нөгөө эргээс ус руу орлоо.

Бэгтэр үүнийг үзмэгц:

Бэгтэр: -Та нар намайг алахаар шийдэв үү? Зориг чинь хүрэх юм уу. Харва харва. Харин Хасар аа? Чи түрүүлж харва. Би энэ мэргидийн орхидсын суманд үхэхгүй... гээд Бэгтэр усан

дотор Тэмүжинд нуруугаа харуулан суухад түүний нуруунд Тэмүжиний тавьсан сум тусан үүнтэй зэрэг шахуу Хасарын сум цээжинд нь зоогдлоо.

Эл байдлыг ой мод дотор мангир түүх зуур ажиглаж байсан Өэлүн хашгиран гүйж ирлээ.

Амь тавьж буй Бэгтэрийн цогцос нэг тонгос гээд урсгалд орон хөвж эхэллээ. Дараачийн сумыг Тэмүжин Бэлгүтэйд зориулахаар шийдэн онилсон боловч эхийн орилон гүйх ахуйд түр түдгэлзэн хүлээв. Хасар ч тангараг ёсоор Тэмүжиний хэрхэхийг хүлээж байв.

Өэлүн нэгэнт гүн эргүүлэгт орж эргэлдэн хөвөх Бэгтэрийн цогцсыг эрэг дээгүүр даган гүйхдээ уур хилэн нь эцэсгүй. Бас тэр:

Өэлүн: -Та нар юу шиг. Тоотой хэдэн хань ижлийнхээ өөдтэйг та нар аллаа. Хавиргаа хазах хар нохой мэт, хаданд довглох харцага шонхор мангас мэт, сүүдрээ довглох сүрхий араатан мэт, цугийг залгих цурхай загас мэт, ботгоо хазах өл буур мэт... Ханиа алагсад... Хамгаа барагсад... гэж үгээ дуусгаж чадалгүй бахардан унахад эхийн энэ хилэнгээс цочсон Тэмүжин айж үхдэл царайлан зогссон Бэлгүтэй рүү чиглүүлсэн сумаа тэнгэрт харваж орхив.

Энэ суманд тэнгэрт нисэх ангир оногдон Бэгтэрийн дэргэд унаж эргүүлэг дунд хамт эргэлдэн байв...

Тэмүжин голын дэнж дэх ганц гэр.бахардан унасан эх, голын эрэгт зогсох Хасар болоод бусад дүү нар бас хөөрхий өнчин Бэлгүтэйг дахин нэг харав. Түүнд айдас аймшиг төрсөнгүй ч Бэгтэрийн гашуун үг зүрх хатгах тул моринд мордон хээр талыг чиглэн давхив. Сочигал гүн усанд зогсон миний хүү Бэгтэр ээ гэж цуурай татуулан хашгирлаа.

## НАЙМАН ШАРГА

Үдэш орой. Тэмүжин, Боорчи хоёрыг найман шарга морио хөөсөөр эсэн мэнд ирэхийг үзээд Хасар, Бэлгүтэй хоёр уралдан тосч иржээ...

Хасар: -Тэмүжин ах тэвчээр зоригтойгоороо агтаа олж авчирлаа гэж Хасар гэрийн гадаа хараачилж зогсох эхдээ хэлэв.



Тэмүжин: -Би биш. Боорчи...Боорчи гэж хашгирч нүд сэтгэл нь дүрэлзэж

Та нар сонс. Энэ агтыг Боорчи гэж нэг сайн нөхөр минь ололцлоо. Би анх удаа сохор зоосны үнэгүй хэргийн төлөө амиа ч бодохгүй гэдэсхийн босдог хүнийг үзлээ. Энэ залууг Боорчи гэнэ... Энэ залуу тайчууд ч биш, мэргид ч биш. Энэ бол

Монголын нэг овгийн хүн. Боорчи бол лавгайтэнгис далайг гатлан ирсэн жинхэнэ Бөртэ чонын цус биед урсан буй хүн мөн... гэж огт урд өмнө нь үзээгүй дүрээр өгүүлэхэд хоёр дүү нь гайхан харлаа.

Боорчи мөн адил Тэмүжингийн дүү нарыг бахдан харж байлаа.

Өэлүн эх: -Миний хөвүүн одоо эрийн цээнд хүрлээ. Өрх гэрээ үүсгэх цаг болсон бусуу хэмээн өгүүлэв.

## БӨРТЭ ЧОНО

Дай Сэцэний охин Бөртийн гэрт нүүрэндээ чонын баг зүүсэн дөрвөн залуу үүдээр сэвхийн орж ирээд зэрэгцэн зогслоо.

Цочих айх зэрэгцсэн Бөртэ "Тэмүжин" хэмээн дуу алдахад чонын дүрст багаа авсан Тэмүжин ганцаар хоцров.

Тэмүжиний нүдэнд Бөртийн бие "махбод гэрэл цацрах шиг сайхан харагдав. Бөртийн бор өнгөтэй үс нь гэрэлтэн харагдахаар барахгүй царай ба хүзүү нь булбарай зөөлөн харагдах аж.

Тэмүжин Бөртийг хараад эмэгтэй хүн гэдгийн жинхэнэ дүрийг энд анх удаа олж үзэх шиг санагдав. Тэмүжин үүдний дэргэд зогсоод Бөртийг нүд цавчилгүй ажиглана.

Тэмүжиний сэтгэлд хачин сонин бодол төрөв. Нүдний өмнө нь байгаа энэ хүүхэн гоо сайхан байтал үхээнц дорой бус булбарай зөөлөн атал эр хүнээс дутуугүй мэт харагдана.

Удалгүй Бөртэ суудлаасаа босов. Хүзүүний хөх өнгөтэй засал чимэг нь биеийн хөдлөхийг дагалдан шажигнаж байв. Бөртэ өөрийн биеийн байдлаа эр нөхөр болох гэж байгаа энэ залууд бүхлээр нь үзүүлэхийн тул үг дуугуй нам талбиун зогссоор байв. Махлаг өргөн цээжээ тэнийлгэн зогссон байдал нь цог жавхаатай бөгөөд омог төгөлдөр харагдана.



Тэмүжин түүнд ойртох гэсэн боловч хөл нь ер урагшлахгүй байв. Өөрөө ойртохыг хүсэвч ямар нэгэн юм саад хийх мэт байдал Тэмүжинд анх удаа тохиолдож байгаа аж. Юунаас ч айдаггүй, юунд ойртохоосоо ч ер татгалздаггүй байсан Тэмүжиний хөлийг чухам ямар юм торгоож байгаа бол.

Энэ үед Бөртэ хоёр алхам урагшилж Тэмүжинд ойртов. Тэгэхийн сацуу Бөртийн амнаас ямар нэгэн охорхон үг гарав. Энэ бол өөрийнх нь нэрийг дуудан байгаа нь тодорхой сонсдов.



Бөртэ: "Тэмүжин! Аав чамайг гайхамшигт Бөртэ чоно гэдэг. Гайхамшигт Бөртэ чоно минь ээ".

Хэсэг зуур байж байгаад Тэмүжин хүчирхэг дайсантай тулалдахын адил хатуу ширүүн үгээ шидэж гарлаа.

Тэмүжин: "Би бол монгол хүн. Чиний аавын хэлдэг шиг миний биед Бөртэ чонын цус буцалж байна. Монгол хүн бүрийн биед Бөртэ чонын цус урсаж байдаг билээ.

Бөртэ: "Би Хонгарадын охин. Гэвч Тайчуудыг сөнөөхийн төлөө татааруудыг сөнөөхийн төлөө Бөртэ чонын үрсийг хойно хойноос нь төрүүлээрэй гэж аав надад захисан.

Бөртэгийн амнаас гарах үгийг Тэмүжин бурханы номлол болгон сонсов. Түүнийг ер нь нэгэн хүний амнаас тэгэхдээ бас нэг бага залуу охины амнаас гарсан үг байна гэж бодсонгүй.

Тэмүжиний биед халуун цус оргилох шиг зориг оров. Тэгээд Хонгирад аймгийн түрүү Дай Сэцэнээс, эцэг охины хайраа тасалж байгаад өөрт нь хүргэж өгсөн өнөө үзэсгэлэнт хүүхэн рүү нэг алхам ойртон очлоо.

Тэмүжин: "Бөртэ ээ"

Тэмүжин сэтгэлийн гүнээс оргилсон хайр дурлалаар түүний нэрийг санамсаргүй дуудав. Бөртэ: "Тэмүжин"

Түүнд хариулах мэтээр Бөртэ ч нэрийг нь дуудав. Түүний дуудах аяс нь Тэмүжинд хэмжээлшгүй зөөлөн эелдэг санагдав.

## ӨГЛӨӨ

Дай сэцэн, хатны хамт үдэн мордуулахаар цуглажээ. Бөртэгийн үзэсгэлэнг сайхь үлдсэн гурван залуу бишрэн бахдаж харж зогслоо.

Дай Сэцэн, Тэмүжинд хандан

Дай Сэцэн: -Тэмүжин! Монголын хааны хүү чамайг тайчуудад хорлогдлоо гэж сонсоод бид бүгдээр уй гашуу болж байв. Тэгтэл чи амьдаар барахгүй, тэр бэрхийг даван туулаад одоо гайхамшигт эр болон буцаж ирлээ. Би баярлан бахдаад ханахгүй байна.

Тэмүжин: -Би Бөртэгийн өргөөндөө залж аваачихаар ирлээ. Тэмүжиний эрс хэлсэн энэ цөөн үг Дай Сэцэнг бур ч бахдуулж:

Дай Сэцэн: -Би хэзээ ч болзсон болзоог эвдэхгүй. Амь бөхтэй, Монголын хааны хүү чамд би охиноо өгнө гэлээ.



## БОДОЛ

Дай Сэцэнийхээс Бөртийг дагуулан мордоход Тэмүжиний харцанд өөдөөс нь нохой чарга хөлөлсөн Гоо марал, Бөртэ чоно баатар эрсээ дагуулан мөн тэдний адил баяр хөөрөөр бялхан цас манаруулан давхин өнгөрнө. Бөртийг эргэн харахад цэлийсэн ногоон тал харагдана.



## ЭРТНИЙ ЁС

Бурхан Халдун уул, Онон мөрний орчмын үзэсгэлэнт сайхан байгаль дүрслэгдэнэ. Өөрийн тохитой гэрт Тэмүжин Бөртийн хамт хэдэн сарыг жаргалтай, айж ичих аюулгүй өнгөрөөв.

Тэдний гэрийг тойрон бас ч хэдэн гэр, хонь мал нэмэгдээд, үзвэл бяцхан хүрээг үүсгэсэн нь хүний нүдэнд өртөхөөр болжээ.

Боорчи, Хасар, Бэлгүтэй, Зэлмэ дөрөв өсч өндийсөн Хачиун, Тэмүгэ нарын хөвүүдийг дагуулан Тэмүжиний удирдлагын дор өдөр бүр байлдах, харвах сургууль хийж бүгд Өэлүн эх, Бөртэ хоёрын бэлтгэсэн хоолыг зэрэгцэн сууж идэх бөлгөө.



Гэтэл гай зовлон санамсаргүй газраас Тэмүжиний бяцхан отгийг нөмрөн ирэв. Монголын өндөрлөгт аймшигт явдал ирэхийг дохиолсон намар орой цагийн нэгэн өглөө байлаа.

Өглөө үүрээр адуу хураахаар явсан Зэлмэ амьсгаадан давхин ирж

Зэлмэ: - Алсаас олон морьтон цэрэг ирэхийг сонслоо. Түргэн босоцгоо гэж хашгирав.

Хэдэн гэрийнхэн дэрхийн гарч бүгд Тэмүжиний амыг хүлээв.

Тэмүжин:- Энэ тайчууд биз. Бүгд Бурхан халдун уул руу зуга гэж тэр эрс тушаав.

Зугатагчдыг Зэлмэ толгойлон даруй одож, харин Тэмүжин, Хасар, Бэлгүтэй, Боорчи дөрөв хойно нь сахин хадтай толгойд довтлогчдыг тосон үлдэв.

Довтлон ирэгчид нь дөч тавин хүн лав үзэгдэх нь бүрий гэрэлд бүртэлзэнэ. Бяцхан хоцорсон Боорчи эргэн ирж

Боорчи:-Энэ тайчууд биш. Мэргидүүд байна гэж хашгирахтай зэрэгцэн харвасан сум исгэрч, тэд ч байлдан харвалдав. Өэлүн эх бусад хүүхдүүд цөм уулын өөд дугааж явна. Хар хурдаараа яваа үхрээ гуядана.

Зугатагчдаас хоцорсон Хуагчин эмгэн, Бөртэ хоёрын суусан үхэр тэрэгний дугуй мултран унав. Мэргид гүйцэн ирнэ.

Шууд тулгаран байлдах нь огт ашиггүй тул тэд сэм бие далдлан зугатан одов.

Тэмүжин гэрийн зугатсан улсуудыг олж нийлэхэд Бөртэ, Хуагчин хоёр үгүйд галзуурмаар уурлаж, хавийн хад чулууг хэмх балбасан билээ.

Тэмүжин:- Өст мэргид ирж Бөртийг булаав. Би түүнийг даруй буцаан авья гэж бачимдан хашгирахад Өэлүн эх үүнд өөрөө буруутай мэт санан гутарч энэ явдал Есүхэй Өэлүнийг мэргидийн Чилэдүгээс булаасны хариу мөн гэж бодоход агсран догшрох Тэмүжин нь яг тэр Чилэдү мэт харагдсан билээ.

## ТАНГАРАГ

Хүрээндээ ирсний дараа Тэмүжин эх Өэлүн. Хасар Боорчи, Бэлгүтэй, Хачиун, Тэмүгэ нарын хамт гэрийн өмнө тавцан засан Бурхан халдуны зүг хандан бүсээ хүзүүн дээрээ тохож суугаад:

Тэмүжин: -Өндөр их Бурхан халдун өшөөтөн мэргидээс өмгөөлөн хамгаалав. Бөглүү ойт бурхан уул минь бөөсөн чинээ амийг бөөцийлөн аварч бөөрөн чинээ биеийг бүтэн мэнд үлдээлээ. Өндөр дээд Бурхан халдун чамайг өглөө бүр мялааж үүрд чамайг шүтэж байя гэж тангараглан есөнтөө давтан мөргөж айраг, цайны дээж өргөв.

Олноороо тарж явсаны дараа Тэмүжин цас бударсан Бурхан халдуны оройг ширтэн удаан зогсов. Тэр сэтгэлдээ мэргидэд булаагдан одсон Бөртийг хэрхэн буйг төсөөлөх шиг зүрх шимшрүүлэн бодож зогслоо.

Түүний энэ түгшүүрт байдлыг Өэлүн эх л сэтгэлдээ ойлгох тул аргадах, учирлахын алиныг ч хэлж бас ойртон очиж эс зүрхлэн зогслоо.

Чулуун: Тэмүжин, бид ирлээ гэх дуу л сая Тэмүжинийг байрнаас хөдөлгөж эргэн харахад хүргэв.

Түүний өмнө Сорхон шарын хөвүүд болох намхан биет том толгойт Чимбай, дүү хялар нүдэт Чулуун хоёр зогсоно. Тэднийг үзмэгц Тэмүжин их баясан мөрөнд нь хүрч:

Тэмүжин: Та хоёр яаж ирэв

Чулуун: - Мэргид довтолж Бөртийг булаагдсаныг дуулаад бид шууд туслахаар ирлээ. Бид хоёр чадах бүхнээ хичээн зүтгэе гэж Чимбай хоёр биеэ төлөөлж хэллээ.

Тэд духаа нийлүүлсэн нь сэтгэл нэгдэж тохиролцсоны баталгаа билээ.

Чимбай: -Бид зам зуур мэргидийн захын аймгаар орлоо.

Тэмүжин: -Бөртэ яаж буй гэж тэсгэл алдан асуужээ. Сонсогдох төдий шивнэн асуусан энэ үгийг Чимбай арайхийн сонсов. Тэгээд хариу хэлсэнгүйд Тэмүжин арай чангаар, ингэхдээ түүний нүдийг эгц ширтэн дахин зайлах аргагүйгээр:

Тэмүжин: -Бөртэ яаж байна гэж асуулаа. Тэмүжиний үзүүлсэн энэ хатамжит байдалд зоригжсон Чимбай

Чимбай: -Түүнийг Чилгэр бөх гэгч залуу эхнэр болгон авчээ гэж огцом чанга хариулав.

Энэ үгийг ойр байсан бүгд бас Өэлүн эх сонсож сүхээр цохиулсан мэт навсхийн:

Өэлүн: Энэ бол Чилэдүгийн дүү... гэж өөртөө шивнэв

Чимбайн хэлсэн үгийг сонсмогц Тэмүжин эгшин зуур царай хувирч тэр даруй холдон явлаа.



Энэ бол урьд өмнө сонсож үзээгүй гашуудалт бас хорсолт мэдээ байв.


Одоо Бурхан халдуны зүгээс цаст салхи үлээж, хүчин мөхөсдөө илт гашуудсан Тэмүжиний нулимсыг шанаа дагуулан сарниулж байлаа.

Нэг ажвал түүний дэргэд Боорчи, Бэлгутэй, Хасар, Зэлмэ, бас Чимбай, Чулуун нар зэрэгцэн зогсож Тэмүжиний харах зүгт ширтэж байв. Цас тэдний дээрээс бужигнан унаж малгай мөрийг нэвсийтэл дарав.

Тэмүжин: Би Бөртийг булааж авна

**ВАН ТООРИЛ**

Гэрт зөөлөн хөгжмийн аялгуун дор хагас нүцгэн бүжигчин эмс уян налархай бүжиж ван Тоорилыг шаван бүчнэ.



Бүжигчдийн зарим нь тагштай дарсыг барьж ван Тоорилтой зэрэгцэн суусан Сэнгүм, Жамуха, Тэмүжин, Бэлгүтэй, Хасар нарын өмнө эрхлэн бүжнэ.

Тоорил: -Эхнэр булаагдах гэдэг шөнө сар мандахын адил энгүүн зүйл. Нэг муу эмийн төлөө хөвгүүн чи юунд ингэж нус нулимс болж бусдын өмнө өвдөг сөхөрнө. Тийм үү Жамухаа.

Энэ удаа Хасар, Бэлгүтэй хоёр ахын царайг болгоомжлон сэм ажлаа. Тоорил: -Чи яарч байна уу. Тэгвэл манай хэрэйдээс эхнэр ав. Энэ бол Өэлүн хатныг эцэг Есүхэй чинь мэргидээс булаасны хариу. Естой юм ёсоор болж. Чи бүү сандар... Хүчтэй баатар эр болбол хүүхэн эмс хаа мундана. Хэдийг бол хэдийг авна биз гэж дахин хөхөрч Жамухыг харна. Жамуха өнөөх сайхан талбиун инээмсэглэсээр сууна. Тоорил хан гэнэт инээхээ больж:

Тоорил:- Өнчин олон бэлтрэгнүүд минь Хар булган дахны чинь хариуд хагацсан улсыг чинь хамтатгаж өгье. Бүрэн мэргидийг бүрэлгэж Бөртэ хатныг чинь буцааж өгье. Хамаг мэргидийг хамх цохиж хатан Бөртийг чинь хариулж авчирья. Би хэлснээсээ буцдаггүй хүн. Бэлтрэгнүүд минь... гэж инээмсэглэв.

Гэрт хөгжим эгшиглэж бүжигчид бүжиглэсээр байлаа.

## МЭРГЭДЭЭС БӨРТИЙГ БУЛААВ

Олон их гал дүрэлзэж, мэргидийн их хүрээ бүхэлдээ галд автжээ. Тэнд Ван Тоорил, Жамуха, Тэмүжин нар мэргэдийн цэргүүдтэй цавчилдан тулалдаж сэлэм жадны ир харшилдан дайтаж байна.

Тэмүжин: Бөртийг эрж ол. Бөртэ, Бөртэ гэж хашгарна. Тэмүжин цавчилдан тулалдсаар Бөртийн байгаа их гэрийн үүдэнд ирлээ. Гэрээс хүзүүндээ сэлэм тулгуулсан Бөртэ хатан хүүхдээ тэврэн гарч ирлээ. Чилгэр бөх: -Би эрт цагт чиний эцэгт хөнөөгдсөн Чилүдэйн дүү байна. Энэ нялх хүүхдийн судсаар Сэлэнгийн мэргидийн цус урсаж буй учир хүүхдийг би авч, энэ эмийг чамд буцаасугай. Бөртэ дуу тавин гараас нь мултрахыг оролдон тэмүүлж,



Бөртэ: -Тэмүжээн энэ чиний хүү? Би чамд бөртэ чоныг төрүүлсэн? Хүүгийнхээ амийг миний амиар сольж болно.

Чилгэр бөх: -Дуугаа таг? Эс бөгөөс алж орхисугай.

Бөртэ: -Тэмүжээн чи надад итгэгтүн.

Тэмүжин, Бөртийн хүзүүндэх цагаан алчуурыг олж харлаа. Энэ үед Бөртэ Чилгэрийн гараас мултарч гэрт гүйж орлоо.

Чилгэр: -"Аа чи" хэмээн Чилгэр бөх Тэмүжин руу асан дайрав. Энэ сацуу Чилгэр бөх хаа нэгтээгээс суманд харуулж үхэтхийн унав.

## ХУЙВАЛДААН

Уулын оройн тэгш өндөрлөг дээр Тэмүжин өөрийн үнэнч нөхөд болох Хасар, Бэлгүтэй, Боорчи, Зэлмэ, Чулуун, Чимбай болоод Бөртийн хамт зогсож нялх хүүгээ өвөртөлсөн байлаа. Цэргийн цуваанаас ван Тоорил тасарч Тэмүжинг чиглэн ирж түүний өөдөөс өлийн хараад ихээр инээж,

Тоорил: -Тэмүжин чи эхнэрээ олж сэтгэл ханасан шив дээ? гэв. Тэмүжин дуугарсангүй. Тоорил хан Есүхэйн хүү энэ үл ойлгогдох залууг зэвүүн харцаар тэгэхдээ инээмсэглэн харж байв. Юутай ч залуу Тэмүжиний сэтгэл эхнэр олсон төдийхнөөр ханахгүйг тэр ойлгов. Энэ үед холоос Жамуха ирж явлаа.

Тоорил: - Бусдын олзыг хулгайлан идэгч үл бүтэх өлөгчин шонхор... Тэмүжээн хоёул хүч хамсаж Жамухыг идэе.

Тэмүжин: - Би танд дэм болж чадахгүй өчүүхэн бэлтрэг билээ гэв.

Тоорил: Тэмүжин чи байлдаанд анх орж сүлд тугаа өргөлөө. Чамд дайны олзноос хүртээ гэж шийдлээ. Дайны олзноос чи юу авах вэ? гэж асуув.

Тэмүжин: -Би олох юмаа олсон. Миний сэтгэл ханасан гэж тод хэлэв. Тоорил хан их л ажиглан бас гайхах мэт

Тэмүжин рүү харж байх үед Жамуха хүрч ирлээ.

Тоорил: -Жамуха дүү ингээд салж мордоё гэв.

Жамуха: -Өлзийтэй болог гээд хоёр ялагч салав. Ван Тоорил цэрэг рүүгээ давхилаа.

Жамуха Тэмүжин өөд өлийн хараад их л аминчихнаар



Жамуха: - Чи зургуулаа боловч зуун хүн шиг юм. Надтай хавсарч хөгшин Тоорилыг гэндүүлж цохивол ямар вэ? Тэгвэл Хэрэйдийн нутаг биднийх болно шүү дээ гэв.

Тэмүжин: - Ван хан бидэнд эцэг мэт нөмөртэй бус уу? гэж хэлвээс Жамуха инээгээд

Жамуха: - Тэмүжин бид хоёрын бие тусдаа боловч сэтгэл нэг билээ. Цагаан хэрмийг давж ирсэн Алтан улсын их цэрэгтэй Татарын Мэгүжин сүүлт байлдахаар зэхэж байна гэж дууллаа.

Тэмүжин: - Мэгүжин Сүүлт бол эцэг Есүхэйг минь зальхай аргаар хөнөөсөн заналт өстөн билээ. Монголын өнө эртний дайсан болох Алтан улсын их цэрэгтэй Мэгүжин сүүлтийг дайтах үед хавсарч цохъё. Мэгүжингээс эцгийн өшөөг авах сайхан боломж надад тохиож байна.

Жамуха: - Анд минь чиний зөв Мэгүжин үхлээ хүлээх ёстой.

Тэмүжин: - Энэ завшааныг ашиглаж Мэгүжин Сүүлтийг даран сөнөөвөл Алтан улсад ч давхар сануулга болно. Харин чиний тусламж надад хэрэгтэй.

Жамуха: - Дараа нь хэрэйдийн Тоорил ханыг яая гэж бодож байна. Тоорил хан татаарт туслах цэрэг илгээнэ гэж ам гарсныг мартаж болохгүй. Алтан улсын эд агуурсанд ван хан шуналтаж байгаа.

Тэмүжин: - Танайх Тоорил ханыхтай ойр хөрш. Тэгээд ч та хоёрыг эцэг хүү мэт дотно гэдгийг би мэдэх юм чинь чамд хэрхэхийг даатгая.

Жамуха: - Тоорил хаан бол алт мөнгөний төлөө ах дүүгээ хороож чадах хүн шүү дээ.

Анд минь мэдтүгэй гэв. Жамухын цэрэг, Тоорилын цэрэг нэгэн цуваанаас салж хоёр тийш хоёр толгойтой могой мэт салан одохыг Тэмүжин нөхдийн хамт харж байв.

## ЗҮЧИ

Тэмүжинтэй дөрөө харшуулан явсан Бөртэ инээмсэглэх шиг болоод,

Бөртэ: - Хүүдээ нэр өгөөч... гэж аргадаж гуйсан байртай хэлэв.

Тэмүжин: - Би нэр өгөх гэж үү. Бөртэ: - Чиний хүү юм чинь... гэж тулган хэлэв. Тэмүжин сөөнгөтөж хатсан хоолойгоор: Тэмүжин: - "Зочин" гэв

Бөртэ: - "Зочин" гэв үү гэж шивнэв. Тэмүжин нялх хүүгээ өвөртөлсөн чигтээ дахин

Тэмүжин: - "Зочин" гэж хэлэв... Би чамайг боржигон аймгийн зочин гэж санаж явъя...гэв

Бөртэ: -Зочин биш Зүчи болог гэж засан хэллээ. Энэ нэр Тэмүжинд таалагдаж сая инээмсэглээд

Тэмүжин: -За тэгвэл Зүчи болог. Чиний хүссэнээр болог гэвэл удтал тарчлан хүлээсэн мөч нь ирж эр нөхөр Тэмүжин нь түүнийг өршөөн хэлтрүүлсэн нь Бөртийн энхрий ялдам, ядарч тамирдсан нүүр дээгүүр хар аяндаа халуун нулимс урсахад хүргэв.

Бөртэ эмээлийн бүүрэгнээс атгаж дуугүй мэгшинэ.

Бөртийн ялдам харц нулимсаа нэвглэн инээмсэглээд,

Бөртэ: -Монголын Бөртэ чоно минь... гэж аяархнаар

Энэ үгний дараа Тэмүжин Бөртийн хэлсэн Зүчи гэдгийн учрыг бодсон билээ. Энэ бол Зочин гэсэн үг мөн байв. Тийм учраас Зүчи гэсэн нэрийг хүлээн зөвшөөрч Тэмүжиний сэтгэл зүрх нь Бөртийн төрүүлсэн нялх хүүд хэрэг дээрээ өөртэй нь адил хэний хүү болох нь мэдэгдэхгүй байгаатай адил хувь заяа ирснийг морин дэл дээр ойлгов.

Бөртийн хүсэн гуйсныг хүлээн авч, түүний төрүүлсэн хүүд Зүчи гэсэн нэр өгсөн явдал нь бүхнийг Тэмүжин хүлээн зөвшөөрсөн хэрэг байв. Хэрэв зөвшөөрөөгүй бол Зүчи гэсэн нэр өгөхгүй байсан билээ. Өөрийн эхнэр Бөртөөс төрсөн нялх хүүг урт хугацаанд энэ айлын зочин хэмээн үзнэ гэж Тэмүжин бат шийджээ. Нялх Зүчийн царайг Тэмүжин удтал харав. Өөрийн бие,боржигин аймгийн цустай гэдэгт зовнин байсантай адил энэ нялх хүү бас энэ явдалд зовних хувь зохиолтой ажээ.

Би өөрийн бие Бөртэ чоно болох явдалд дулдуйдан, Монголын цусан удамтан болохоо батлах хэрэгтэйн адил Зүчи ч гэсэн Бөртэ чоно байх ёстой, ядаж ийм зоригтой байх ёстой гэж Тэмүжин шивнээд өвөр рүүгээ тонгойж

Тэмүжин: -Би ч Бөртэ чоно болно. Зүчи чи ч бас Бөртэ чоно болоорой гэж Тэмүжин өөрийн том хүү Зүчид хандан анхны үгээ хэлэв.

Тэмүжин: -Хайраа үүнээс илүү илэрхийлэх арга надад алга гэж бас өгүүлэв.

Бөртэ Тэмүжин рүү харав. Царай нь ядрангуй боловч нярайлсан гэмээргүй гэрэлтэж үзэгдэнэ. Тэмүжин түүнийг хайрлан ширтэв.

Тэмүжин /монолог/: -Эхнэр Бөртэ ч, эх Өэлүн ч бүр эмэгтэйчүүд дорой буурай төржээ. Тийм болохоор эд нар зочныг төрүүлдэг юм.





Бөртэ ч, Өэлүн эх ч монголын удам болох Бөртэ чоноо төрүүлдэг боловч бас түүний оронд мэргидийг ч, татаарыг ч, хэрэйдийг ч төрүүлж чаддаг аж.

Миний эхнэр миний дайсны хүүхдийг төрүүлж болох уу. Өөрийн нөхдийн үнэнч шударгад итгэж болно. Харин эмэгтэй хүнд итгэж болох уу. Итгэнэ гэвэл эмэгтэй хүнийг хэзээ ч алдахгүй, үүрд өөрийн болгох ёстой. Бөртийг булаалгахгүйн төлөө би эрэлхэг хүчтэй хүн болох хэрэгтэй гэж боджээ.

Тэмүжин: -Үүнээс хойш би чамайг дэргэдээсээ өчүүхэн ч холдуулахгүй. Чи бас үүрд эрхэм баг журмыг сахь гэлээ.

Энэ бол Бөртийг үүрд өөрийн болгох тухай Тэмүжиний тангараг боловч Бөртэд өвөрлөсөн чин хайраа илэрхийлсэн хэрэг байв.

## ЗАР

Өлгийтэй бяцхан Зүчийг морин дээрээ тэвэрсээр ирэхэд нөхөд нь инээмсэглэн үг дуугүй хүлээв.

Тэмүжин: -За хар. Энэ миний ууган хүү Зүчи... Би Зүчи хүүтэй болсон гэж чанга хэлж хүүгээ өргөхдөө тэр итгэл тегс үзэгдэв.

Нөхөд нь хашгиран: -Тэмүжин, Зүчи хүүтэй боллоо гэж уухайлж нялх Зүчийг бүчин хүрээлж үнэрлэж үнссэн бөгөөд Тэмүжинд талархал хүргэн духаа нийлүүлж ёслов.

Энэ бүгдийг харсан Бөртэ үжин Өэлүн эх хоёр сэтгэл амарч инээмсэглэв. Энэ үед

Тэв Тэнгэр зар түгээн хашгирав.

Тэв Тэнгэр: -Манай хүрээнд нүүдэл ирж байна. Жалайр аймгийн Хачиун, Тохуран нар ирсэн.



Шөнө бас Дархад аймгийн Хадаан, Далдурхан ах дүү тавуул ирэв. Барулас аймгийн Хубилай Худус ах дүү нар ирлээ... гэж уламжлав. Баярлалдан зогсоо залуу эрчүүдийн дундаас Тэв тэнгэр морьтойгоо гарч ирээд Тэмүжинд хандан

Тэв тэнгэр: -Тэнгэр газар тэтгэж Тэмүжин Монголын хаан болно гэж миний төлгөнд буусан тул тэнгэрийн зөнг дуулгахаар ирлээ гэв. Тэмүжин тэр үгийг сонсуут бодолхийлснээ,

Тэмүжин: -Хөхөчү тэнгэр чиний үг үнэн юм бол чамайг монголын их бөөд өргөмжлөө хэмээн нийтэд дуулдахуйц зарлан тунхаглав.

## ӨШӨӨ АВАЛТ

Тал хээр нутаг дээгүүр Алтан улсын их цэрэг явганаар газар дэвслэн улаан өнгөөр урсан ирж явааг Мэгүжин сүүлт харж байв. Уул толгод, хээр тал улаанаар будагдсан мэт гүвэлзэн харагдана. Мэгүжин сүүлтийн нүдний хараа аажмаар эргэж толгойн оройд буй Тэмүжин, ван Тоорил, Жамуха нарын хуяг дуулга бүхий хүчирхэг дүрсийг бас харлаа. Хоёр их хүчит цэргийн дунд Мэгүжин сүүлт хавчуулагдсан байв. Тулалдааны талбарын төв дунд Тэмүжин гарч ирлээ. Тэмүжин сэлмээ өндөрт өргөн

Тэмүжин: -Мэгүжээн эцэг хааныхаа өшөөг авахаар ирлээ. Мэгүжин: -Тэмүжин чи одоохондоо Мэгүжин надад дайсан болж чадахгүй гэж хашгирав.



Биеэ бэлтгэхтун хэмээн тушааж хашгирав.

Тэмүжин: -Чи харь холын Алтан улсын ирт мэсэнд амиа өгснөөс миний илдэн дор сөхөрч эцэг Есүхэйн амийг төлөх ёстой хэмээн баатарлагаар тод өгүүлэв. Тэмүжин: -Таргудай чамайг хар Татаартай сүлбэлдэж Боржигон овогтны голомтыг дэвсэн өшиглөсөн тул эцгийн минь сүнс амрахгүй дагаж явааг санагтун. Амьсгалах хоногийн чинь тоо гүйцсэн шүү хэмээн цэргийн цуваан дунд байгаа Таргудайг чичлэж хилэгнэн өгүүлэв. Цаст уулын оройд эцэг Есүхэй баатрын сүнс тэднийг харан зогсоно.

Энэ сацуу Тэмүжин болон Мэгүжин сүүлт морио давиран хоёр талаас мөргөлдөв. Илднээс нь оч бутран хоёр этгээдийн тулалдааныг дайны талбар ажин түжин чагнацгаана. Энэ мөргөлдөөнийг Алтан улсын цэргийн жанжнууд улайран харж байв. Мэгүжин сүүлтийн эзэнгүй морь хуйлран зулран хоёр талын цэргийн өмнүүр тулалдааны талбар дундуур цулбуураа чирэн давхив. Харин Тэмүжинд бугуйлдуулж газарт унасан Мэгүжин сүүлтийг тэрбээр тоос татуулан чирч давхисаар Алтан улсын цэргийн ноёдын өмнө аваачиж хаяхад эцэг Есүхэйн тайвшран инээж буй сүнсний дүрс

Тэмүжин: - Цус асгаруулан байлдахаар ирт мэсээ хурцалж ирсэн дайснаа ав гэж хэлэв. Тэгээд хятадын жанжнууд руу эрс шийдэмгий хараад

Тэмүжин: -Монголын хаадыг мэхлэн хөнөөсний төлөө ял асуух цаг мөдхөн ирнэ гэж заналтай

өгүүлээд давхин одов.

## БОРЖИГОНЫ ХААН

Мэгүжин сүүлтийг бут цохисон тулалдааны дараа Тэмүжин ван Тоорил, Жамуха гурав толгойн оройд сууж байв. Тэр үед татаарын олзлогдсон хоёр гоо бүсгүйг Тэмүжиний өмнө авчирахад,

Тэмүжин: - Та хоёр хэн бэ? гэхэд тэд зэрэг шахам

Есүй, Есүгэн:- Эгч дүү Есүй, Есүгэн гэдэг. Их Чэрэнгийн охид билээ гэвэл

Тэмүжин: -Миний цацарт аваач хэмээн тушаав.

Тэмүжин элдсэн нэхий дэлгэхэд газрын зураг тод харагдав.



Тоорил: - Энэ чинь... хэмээн дуу алдав. Жамуха: -Монголын газрын зураг уу? Тэмүжин тайвнаар

Тэмүжин: -Дайн тулааны завсраар Хасар Бэлгүтэй хоёрыг Алтайгаас Тангуд хүртэл хэрэн хэсүүчлүүлж судалгааны үндсэн дээр зурж авсан зураг билээ гэж өгүүлэв. Нэхийн дээрхи Монголын газрын зураг дээр зохиогч өгүүлнэ. Мөн зохиогчийн өгүүлэх ярианы цаад дэвсгэр дээр Бөртэ үжин өөрийн хөвгүүд Зүчи, Цагадай, Өгөдэй, Толуй нарын нас ойр хүүхдүүдийг морьтой дагуулан давхиж явна.

Зохиогч:- Мэргид аймаг дарагдсан дуулианаар Тэмүжинийг орхин одсон Боржигон аймгийн иргэд түүнд ирж нийлэв. Өсч нэмэгдэн Есүхэйн үеийнх шиг хүч хөрөнгөтэй болсон Боржигон Монгол аймгаан манлайлж Татаар, Найман, Мэргэд аймгийг сөнөөн дарсны эцэст

Тэмүжин Монгол аймгийн хаан болон өргөмжлөгдөв. Монголын өндөрлөгт түүнтэй өрсөлдөгч нь эцгийн анд их туслагч Хэрэйд аймгийн ван хаан Тоорил, бага насны эвдэршгүй тангарагт Жадаран аймгийн хаан Жамуха хоёр байлаа. Энэ зуур Бөртэ хатан Зүчийн хойно хүү Цагадай Өгөдэй отгон хүү Толуй нарыг төрүүлсэн билээ. Энэ үед Тэмүжин 28 настай боллоо. Энэ бол нийтийн тооллын 1190 он байлаа.

## МОНГОЛЫН ӨНДӨРЛӨГИЙН ЭЗЭН

(төгсгөл хэсэг)

Хар хувцастай, хар морьтой арван цэргүүд тал тал тийш давхилдана. Анх зогсож байсан

Өндөрлөг дээрээ Тэмүжин нөхдийн хамт зогсож байлаа. Чингис хааны их цэргийн цуваа тэдний өмнүүр өнгөрнө.

Киноны аппарат аажмаар тэднийг нэг бүрчлэн гарган дүрсэлнэ.



Тэд нөгөө л зогсож байсан дэг жаягаараа алсыг харан зогсоцгоох ажээ. Далдаас эдгээр баатруудын дүрсэн дээр өгүүлэх ину:

Зохиогч: -Эрч хүчтэй, эрэмгий зоригт Тэмүжинээр толгойлуулсан Боржигон монгол аймаг өдрөөс өдөрт хүчирхэгжиж Монголын өндөрлөгийн нүүдэлчин аймгууд Тэмүжин, Тоорол хан, Жамуха гэсэн гурван удирдагчийн хүчин дор хуваагдан тэд монгол нутгийг ганцаар эзэмшихийн төлөө тэмцэл, тулааныг өрнүүлж эхэллээ.

Энэ тэмцлийн галыг Жамуха эхлэн асааж Тэмүжиний эсрэг тулаанд цэргээ хөдөлгөв. Тэмүжиний цэрэг Жамухын эхний дайралтад ялагдал хүлээсэн ч энэ тэмцэл шинэ шинэ хүчээр өргөжин тэлсээр гурван жил үргэлжилжээ.

Энэ үед Тэмүжин 35 настай, дүү Хасар, Бэлгүтэй 33 настай, Хачиун, Тэмүгэ нар нь 30 насны эр чадалтай эрчүүд болон өсчээ. Тэмүжиний баруун гарын үнэнч нөхөд Боорчи 35 настай, Зэлмэ 38 настай болов. Хэрэйд аймгийн Тоорил хан бол Монголын өндөрлөг дэх Тэмүжиний гол хамтран тэмцэгч хань нөхөр нь хэвээр байлаа.

Өндөрлөг дээр зогсож буй Тэмүжин тэргүүтэй баатруудын зүг 18 настай хүү Зүч морины хурдаар давхин ирлээ.

Боорчи: - Энэ яаран довтолж яваа чинь Зүч үү дээ... гэлээ.

Хар эрчээрээ давхин ирсэн Зүч морин дээрээсээ унаж яваа хүлгийнхээ адил амьсгаадан,

Зүчи: -Хаан эцэг минь, Жадаран аймгийн Жамуха боржигон аймгийн хаан тантай нийлэх гэлээ гэж Хонгирад аймаг руу дайлаар цэрэг хөдөлгөжээ гэж хэлээд морины хурдаар буцаж давхилаа.

## ДАЙ СЭЦЭНИЙ ХҮРЭЭ

Галд автаж шатсан хот хүрээ. Олзлогдсон эрс.

Жамуха хэсэг баатруудын хамт морин дээр сэлмээ хуйлж амжилгүй заналтайяа зогсоно.

Гал өрдсөн том хонин тогоонд Хонгирадын тэргүүн, Бөртэ хатны эцэг Дай Сэцэнийг хатан Цотоны хамт тогоотой ус руу хийлээ.



Дай Сэцэн: -Жамуха чи манайд тараг ууж өссөн бусуу. Эрийн цээнд хүрэв гээд миний ачийг ингэж хариулна уу? Тэр үед тарганд минь цацах нь яав даа.

Жамуха: -Монголд нэг л хаан байх ёстой /цээжээ шаан/ Тэр нь би! Жамуха би байх болно. Тэмүжин, чиний охин Бөртэ ч хонин тогоонд чанагдах өдөр ирнэ гэж хашгиран хэллээ. Дараа нь том тогооны халивыг тавина. Тогооны эргэн тойронд гал дүрэлзэн асна.

Тогооны таган дээр хүдэр чийрэг хоёр цэрэг ташаа тулан зогсжээ. Чанагдаж буй хүмүүс таган дороос түлхэх мэтээр байж ядах нь мэдэгдэж байлаа.

Аппарат панорамдан эргэхэд айж түгшин орилолдон гүйх авгай, хүүхнүүдийн хашгираан, олзлогдсон цэргүүдийн зодуулах ташуурын дуун, аймаг хотлоороо үнсэн товрог болсон хот суурин, олзлогдон туугдаж яваа эрчүүдийн цуваа, мөн содон цагаан баг нүүрэндээ угласан нэгэн бүсгүй зугатан гүйж яваа нь бидэнд харагдах авай.

## ХОРСОЛ

Цэргийн хүрээний цацрын гадаа Тоорил хаан хатуу сархад зооглон борц идэнгээ өөдөөсөө харан суусан Жамухад

Тоорил: -Жамухаа чи өнөөг хүртэл Тэмүжинд хэд хэдэн удаа тусалсан боловч хариуд нь газар нутаг, эд хөрөнгө эс олов гэж дуулсан юм байна. Жамуха: -Тэмүжин анд бол Татаар, Тайчууд, Мэргэд, Ойрад, Найманыг мөхөөж монголын өндөрлөгийг бараг гартаа оруулаад байна.



Ван хаан та бид хоёрын газар нутагт Тэмүжин хөл тавих цаг тулжээ. Тоорил: -Удахгүй морилон ирвэл яана. Жамуха: -Алалдан тулалдана.

Тоорил: -Тэмүжин үнэхээр Монголын хаан болбол түүний нүдний хог болох бус уу? Хэрэв Тэмүжинг мөхөөвөл бид хоёрын хэн нэг нь Монголын хаан болно.

Жамуха: -Тэмүжинг хаан та хэнээс ч илүү мэдэж байгаа дайн тулаан болоход тэнгэрт ойр

байж цог заль болон хүч чадал нь нэмэгддэг юм билээ. Бас одоо цэрэг нь арван түм байтугай хорин түм хүрсэн байх шүү.

Тоорил: -Одоохон дарахгүй бол цэрэг нь зуун түм хүрээд бид хоёрыг ч гэсэн залгина шүү.

Жамуха " "

Тоорил: -Жамухаа. Тэмүжинг мөхөөе гэвэл хөдлөх цаг болжээ. Миний олж мэдсэнээр Тэмүжиний их цэргийн дийлэнхи нь алтайн нуруу давж өөрт нь цөөн хэдхэн цэрэг л үлдээд байгаа. Энэ жил цас ихтэй өвөл болж байгаа тул аян дайнд явсан цэргийг дуудаж ирүүлэхэд хэдэн сарын хугацаа шаардагдана. Цас хайлахаас өмнө амжиж гэнэдүүлэн довтолвол ялах боломж бий. Хамгийн гол нь чи ийм шийдвэр гаргахгүй бол бид Тэмүжиний морины цулбуурыг атган амь зуухаас өөр аргагүйд хүрнэ.

Жамуха: -Би хэдийнээ бэлтгэчихсэн

Тоорил: -Чи сайн үйл хийжээ. Жамухаа Тэмүжинг мөхөөх хэрэгтэй. Би бүх хүчээ дайчлан чамд туслах болно. Чамайг хөдөлж эхэлмэгц, Тэмүжин өөрөө цэргээ удирдана. Түүний ар хударгаар нь би дайрвал Тэмүжин буцах газаргүй болно. Монголд хоёр хаан хэрэггүй, хүү шигээ санах чамайг л тохирно гэж бодож байна даа гэж хэлээд Жамухын нүд рүү ширтэнэ.

## ТЭМҮЖИНИЙ ҮГ

Тэмүжиний цэргүүд хоёр эгнээгээр шилээ харж уртын урт цуваагаар хөвөрч байлаа. Энэ их жагсаалын дэргэдүүр Чингис хаан, Боорчи, Зэлмэ, Зэв, Мухулай, Чулуун,



Тэмүжин: -Эцэг мэт санаж явсан Тоорил ван ховын үгэнд хордож хоёр нүүр гарган хөнөөн халдаж эхлэв. Бид цөөн боловч олноос дутахгүй, муу гэж сэтгэвч сайнаас дордохгүйг ван Тоорилд мэдүүлье.

Тэмүжин: - Анд Жамухад би бас андгайг нь сануулъя. Бид хоёрын хэн нь эрт босож ван эцгийн хулаар айраг уудаг билээ. Одоо Жамуха хэдийхэн хороох аж. Хорон муу сэтгэлээр хаа тэр хүрэх билээ.

Би дээлтэй төрсөн байхад нүцгэн төрсөн Сэнгүм ван эцгээ амьд ахуйд хаан болох гэж эцгийн сэтгэлийг зовоож эвдрэлийн үр цацлаа. Ван хан, Жамуха анд, Сэнгүм анд нарт гэмий нь мэдүүлье гэж хүүрнэн өгүүлэв.

Монголын өндөрлөгийн төлөөх ширүүн тулааны өмнө Тэмүжин өөрийн баатар эрсдээ хандаж байлдааны учрыг ийнхүү тодорхой болголоо.

## ИХ ТУЛААН

Ван Тоорил, Жамуха, Сэнгүм нар руу эзэнгүй морьд бөөнөөрөө давхилдан орж ирэв. Гэвч удалгүй цэргүүд морьдын бөөрнөөс эмээл дээрээ цоройлдон гарч уулгалан дайрав.

Бөөн морьд

Морины нуруун дээр гарч буй хэсэг цэрэг Дараа нь бүгд мориндоо мордсон байна. Жамуха, Ван Тоорил, Сэнгүм нарын удирдсан цэргийн их цуваа тулаанд орлоо.

Тэмүжин хөдөлж эхлэв. Зэв, Хувилай, Зэлмэ, Сүвээдэй нарын дөрвөн төмөр нохой нь Жамухын толгойн цэргийн ангийг довтолж самууруулав.

Зэвийн цэргүүд уул хаданд авиран харваж илт давуу байсан тул Жамуха нэхсэнгүй байжээ.

Жамухын их цэрэг Тэмүжиний нутаг хээр тал руу давшив.

Харин энэ нь Тэмүжиний урьдчилсан занга байв.

Жамухын цэргийн хоёр бөөрнөөс Тэмүжиний цэрэг босон гарч ирэв.

Дараагийн агшинд газрын гүнээс оргилон гарах гал мэт монгол цэргийн гэнэтийн довтолгоон эхэллээ. Тэмүжиний их цэрэг цүүцдэх, ухарч бүслэх, нум болон саран хэлбэрээр бут цохих байдлаар давшина.

Хасар, Боорчи, Бэлгүгэй нарын удирдсан морьт цэргүүд Жамухын их цэргийг хендлөн гулд сүлжин давхиж самууруулав.

Жамуха ихэд хилэгнэв.

Өмнө харагдах толгойн оройд дөрвөн нохойгоо дагуулсан Тэмүжиний бараа үзэгдлээ.

Толгойн оройгоос Тэмүжингийн дөрвөн нохой хилэнгийн давалгаа мэт Жамуха, Тоорил нарын сүр бараат цэргийг бутраан сарниулав.

Тэмүжин, Жамуха хоёр хоромхон агшинд илд зөрүүлсэн боловч цахилгаан цахих шиг оч бутарсаар тэр хоёрын дүрс эгшин зуур эмх замбараагүй байлдаан дунд уусан алга болов.

Тэмүжиний цэргүүд морины нуруун дээр амьд чоно шүдээ ярзайлган суусан мэт харагдана.

Тарж бутарсан Жамухын цэргийн араас үлдэн хөөж явсан ван Тоорил богинохон зуурын тулаанд ядарч цуцсан байдалтайгаар нэгэн өндөрлөг дээр Жамухатай халз таарлаа.



Гэвч Жамуха танигдахгүйгээр нүүрэндээ бүтэн өвчсөн баг өмсчээ. Зогтуссан ван Тоорил:

Тоорил: -Чи хэн гээч вэ? Би Хэрэйдийн хан Тоорил байна гэхэд Жамуха ха ха инээж,

Жамуха: -Муу хөгшин гуйлгачин чиний амьдрах хугацаа, амьсгалах агшин чинь үүгээр дууссаныг мэдтүгэй хэмээгээд Жамуха сэлмээ сугалж түүний толгойг тас цавчиж унагалаа.

Алсаас ван Тоорилын морьт цэргүүд ванд туслахаар яравчлан давхилдана. Жамуха газар унасан цустай толгойг морин дээрээс шүүрч аван ирж буй цэргүүдээс зугатан морины хурдаар давхин одлоо.

## ХУЛАН

Дайн туладдаан шивхэрч буй бололтой Тэмүжин, Хасар, Боорчи тэргүүтэй баатрууд талын чулуун худаг дээр морьтойгоо давхилдан ойртоход ангаж цангаж ядарсан нэгэн бүсгүй нүүрэн дэх цагаан багтайгаа ховоотой уснаас цалгиулан байж залгилах ажээ. Тэнд бас нутгийн ардууд байна. Дайчин эрсийн давхин ирэх бараанаар мөнөөх бүсгүй сандран зугатав. Бүсгүйг нэлээд холдсон хойно Хасар түүний араас морьтойгоо ухасхийн давхиж очих үед тэр бүсгүй гэнэт сэлэм гаргаж тулалдахад бэлтгэнэ.



Бүсгүйн эл шийдмэг байдал Хасарын хор шарыг хөдөлгөв бололтой сэлмийн хурц үзүүрээр хүүхний багийг хага зүсээд түүнийг бүргэд мэт шүүрэн эмээлийн урдуур дүүрлээ. Хасар бүсгүйг дүүрсэн чигтээ давхин ирж Тэмүжиний өмнө мориноос буулгалаа. Бүсгүйн нүүрэндээ зүүсэн баг нэгэнт зүсэгдсэн тул хоёр тийш ангайж завсраар нь хүүхний жавхлант сайхан нүүр царай харагдаж Тэмүжинд гайхалтай ойр дотно санагдах нь тэр.

## БӨРТЭ ЧОНО, ГОО МАРАЛ

Тэмүжиний нүдэнд эрт багаас хоногшин үлдсэн Гуа Марал, Бөртэ чоно тодрон харагдав. Ялангуяа залуу сайхан Хулан зүүдний юм шиг Гуа Маралын дүрд хувиран Тэмүжиний сэтгэл бодлын утсыг уянгалуулан доргиох бөлгөө. Нүүрэндээ цас наан тэрийн унасан есөн настай Тэмүжиний урьд цагийн зураг харагдах ажээ.





## ЖАМУХЫН ЗУГАТАЛТ

Ван Тоорилын толгойг барин Жамуха дагуулуудын хамт морины хурдаар зугатаж явна. Жамуха ван хааны толгойг Тэмүжинд хүргэж өгөхөөр яваа нь энэ байлаа. Хар морьтой, хар хувцастай цэргүүд давхилдана.



## ХУЛАН СҮҮ

Тэмүжиний нэгэн өргөөнд гэрийн голд цовдлон татсан хөхүүр мэт задгай ширэн саванд дүүрэн сүү хийсэн байх агаад түүнийг тойрон шивэгчин бүсгүйчүүд зогсож голд нь чармай нүцгэн Хулан ариун сайхан биеэ угаан шавшиж байлаа. Гэрийн гадна гүү сааж байна. Хувинтай сүүг саальчин бүсгүй авчрахад гэрээс хэн нэгэн тосон авч хувинг буцаана.

Гэрийн зүүн талд ятга бүхий 4-5 бүсгүйчүүд сууж зөөлөн аялгууг ятгын утаснаа амилуулан доргиож байв.



## БӨРТИЙН ЗАХИДАЛ

Яг энэ үед Чингис хааны хойт өргөөнд морин хуурын зөөлөн татлаганд дээл нөмгөлөн суусан Тэмүжин ямарваа юмыг тэсэн хүлээж ядсан мэт бодлогошрон сууна.

Энэ нь түүний анхны харцаар хайрлан дурласан эршүүд шулуун зантай Хулантай өнгөрөөх хайрын түгшүүрт үдэш байлаа.

Тэмүжин өвөр юугаан ухаж нэгэн нандигнасан бичээстэй алчуур гаргаж ирлээ. Энэ алчуур

нь Бөртэ, Тэмүжин хоёрын биендээ хайрын илгээмж болгон өгч байсан бидний таних алчуур байлаа.



Уг алчуур одоо Бөртэ үжиний гараар дурайлган бичсэн монгол бичиг бүхий захидал байлаа.

Тэмүжингийн нүднээ захидлыг бичин илгээсэн Бөртэ үжиний энхрий ялдам дүр амилан харагдана.

Бөртэ: "-Тэмүжин минь ээ! Монголын өндөрлөгийн их хаан минь ээ? Таныг ялгуулсан тугаа өндөрт мандуулж нутагтаа буцаж ирэх үед чинь шинэ өргөөг эхнэр Бөртийн чинь гэрийн хажууд барьчихаад байхыг та олж үзэх болно. Шинэ өргөөнд суух залуу Хулан, миний дутууг гүйцээж эзэн таны ер бусын хүч чадлын эх булаг болох болтугай гэж ерөөе"

Энэхүү захидлыг дуусах үед Бөртэ үжин захидалт алчуурыг хоёр гардах мэт Тэмүжин рүү чиглүүлэн барьж байгаа план. Бөртийн аяга дүүрэн нулимстай нүд.

Тэмүжин захидлыг дөнгөж сая Бөртөөс авсан мэт хоёр гардан авч уншиж дуусаад өөрийн эрхгүй алчуураар нүдээ даран хэсэг тонгойлоо.

Тэмүжин доголон нулимстай зовхио дээшлүүлэн харах ахуйд гоо үзэсгэлэнт Хулан хатан нарийн торгон хувцастай орж ирсэн байлаа.

Хулан явсаар зүүн талын орноо очиж сандайлан цомцойн сууж ирээдүйн нэгдсэн монгол улсын эзнийг харав...

Гэр тэрэг тасралтгүй хяхтнан дуугарч холын аяны газрыг эвхэн хороож аажмаар урагшлан ахина.

Газрын эвхээсийг аажим аажмаар хороох гэсэн мэт гэрийн дэргэд суусан морин хуурч гэр тэрэгай хөдөлгөөнийг эс ажран тоглосоор байх авай.

## ГЭР ТЭРЭГНИЙ ҮДЭШ

Сартай энэ үдэш гэр тэрэгний зөөлөн дайвалзах хөдөлгөөн дунд их хайрын галыг дөнгөж саяхан асааж байсан Тэмүжин, Хулан хоёр гэр тэрэгний хашлагыг налан зогслоо.



Их цэргийн цуваа тасралтгүй урагшилна.

Тэмүжин, Хулан хоёр нөмгөн байх ажээ.

Морин хуур тасралтгүй тоглогдсоор байлаа.

Алсыг харан зогсоо Тэмүжиний ханхар цээжийг Хулан энхрийхэн наллаа.

## ӨРГӨМЖЛӨЛ

Саяхан тоглогдож байсан ганц морин хуур нүсэр олон хуурын чавхдсыг араасаа дагуулан хөглөгдөн тоглогдлоо.

Уулын хормойгоос бэл өөд өгсөн олон зуун морин хуурч их хааныг залах төрийн аялгууг тоглоно.

Өндөрсгөн зассан тавцан дээр Тэвгэнгэр олон дагуул бөөгийн хамт тэнгэр, газарт дуулгах гэсэн мэт хэнгэрэг хүчтэй дэлдэн балбаж нүргэлсэнээ огцом чимээгүй болов.

Аппарат аажмаар эргэлдэн орчныг харуулахад бүгд Тэв тэнгэрийн зүг ширтэж ямарч хөдөлгөөнгүй анхааран харцгаах ажээ. Тэв тэнгэр өндөр хадан дээр зогсоно. Түүнийг тойрон 33 бөө байна.

Энэ чимээг Тэв тэнгэрийн царгиа бадриун хоолой эвдэн хүнгэнэлээ. Тэрбээр гараа дээш өргөн:

Тэв Тэнгэр: -Дээд тэнгэр таалав. Бүгдийн эзэн тэнгэрийн ивээлд багтлаа. Тэмүжин:- Чингис хаан болов хэмээн сүртэй чангаар хашгиран мэдэгдэхэд саяхан хөдөлгөөнгүй байсан тал дүүрэн хүн, амьтан, мал, тэрэг хөсөг бүгд амь орох мэт хөдөлгөөнд орж,

Чингис хаан

Чингис хаан

Чингис хаан гэж уухайлан хашгиралдаж эхэлвэй.

Энэ үед тэлэн татсан том цагаан эсгий дээр их эзэн Тэмүжин Чингисийг зогсоон газраас хөндийлэн өргөсөн олон ард өндөрлөгт байрлах тавцаны зүг түүнийг хүндэтгэлтэй аваачлаа.

Тогтсон цагт Тэмүжин ёслолын газар ирж байраа эзлэв. Тэмүжиний баруун гарт эх Өэлүн,

эхнэр Бөртэг дагалдан Зүчи, Цагадай, Өгөдэй, Толуй нарын дөрвөн хөвүүд зэрэгцэн түүний ард олон хатад зогсоцгоов. Хуланыг л өмнө эгнээнд байрлуулж, Есүгэн, Есүй нарт ар талаар суудал өгөв. Өэлүний хүмүүжүүлсэн харь үндэстний өнчин хүүхэд болох Шигихутаг, Борохул, Хүчү, Хөхөчү нарын багачууд ч тус тус ар талаар зэрэгцэн зогсчээ. Тэмүжиний зүүн гарт Хасар, Бэлгүтэй, Хачиун, Тэмүгэ, Тэмүлүн нарын дүү нар зогсож түүний дэргэд Боорчи, Зэлмэ нарын гол гол сайд түшмэдээс эхлэн Чимбай, Чулуун, Зэв, Мухулай, Сүбэдэй, Хубилай нарын жанжин нар болон Мэнлиг, Сорхон шар нарын ахмадууд байлцав. Тэмүжин Монголын түмэн ард иргэд, дайчин баатар эрсдээ хандан үгээ хэлж эхлэх агшинд Бөртэ чоно Гуа марал хоёр үлгэр домгийн мэт сүр жавхлантай өндөр уулын орой дээр тэднийг харж зогсоно.



Тэмүжин: -Дээд тэнгэрээс заяатай төрсөн Бөртэ чоно,

тэнгис далайг гэтлэн ирсэн Гуа марал хоёрын хоорондоос , "I төрсөн хүү бол Монголын өвөг дээдэс Батцагаан мөн ёс билээ.

Монгол бол Бөртэ чонын үр угсаа мөн. Тэрхүү Бөртэ чоноор сүлд хийморь болгосон монголын эсгий туургат иргэд хорин нэгэн аймгаараа энэ өдөр нэгэн хүч болж цугларчээ. Миний бие одоо олноо сонгогдож хаан ширээнээ суув. Баатар цэргүүд минь Хянган давааг давах хэрэгтэй. Алтайн нурууг давах хэрэгтэй. Тэнгэр уулыг давах хэрэгтэй. Чилияншин уулыг давах хэрэгтэй. Монголын өндөрлөг дэх хүрээ бууцуудыг нэн үзэсгэлэн сайхан болгохын төлөө бид нар ингэх хэрэгтэй. Бидний зүүдэнд ч үл орох баялаг амьдрал, баяр цэнгэл, баясалт хөдөлмөрийг бид өөрийн болгох ёстой. Тануусын шинэ хаан бол түүнийг биелүүлэхийн төлөө алив зарлигийг та бүхэнд буулгаж байх зөвшөөрөл олов. Миний биеийг үнэмшин итгэгтүн. Миний зарлигийг биелүүлэгтүн. Эрэлхэг баатар шинэ монгол улсын Бөртэ чонууд аа энэ улсыг их Монгол улс хэмээн нэрлэе гэж нийтэд хандан үгээ дуусгав.

Нэгэн их хүрээнд бөхчүүд хүчийг үзэн ид хавыг гайхуулан барилдаж начин шонхрын дэвэлтээр дэвэн дэлж наадмыг үзэгчид уухайлан дэмжиж түрлэг өргөх ажээ.

Энэ зуур Бэлгүтэй бөхийн өмсгөлтэй тод томруун харагдах болно. Эдгээр баяр найр наадмыг Чингис хаан өөрийн хөвүүд, Бөртэ, Хулан, Өүлэн, Боорчи, Зэлмэ, Мухулай, Чулуун, Чимбай, Зэв, Хубилай, Сүбэдэй нарыг дагуулан явж сонирхоно.

Үнэхээрийн их Монголын их наадам гэдэг нь гарцаагүй мэдрэгдэж байлаа. Чингис хаан Боорчид хандан:

Чингис: -Чи надтай хамт хүнд хүчир замыг тууллаа. Алтай орчмын түмнийг мэдэж захиртугай гэв.

Чингис хаан: -Зэлмэ минь ээ, чамд олгох байр, зэрэг, тушаалыг аажмаар бодох уу даа гэлээ.

Чингис хаан: -Чулуун, Чимбай нар минь ээ, та нар эцгийнхээ хамт Мэргэдийн Сэлэнгэ орчмын газрыг татвар төлбөргүй эзэмших эрхтэй гэлээ.

Морьтой явах Чингис хаан

Чингис: -Алтан улсыг эзлэх бүх цэргийн жанжин Мухулай минь чи зуун түмэн Бөртэ чонуудаа дагуулж эцэг өвгөдийн захиасыг биелүүлж цагаан хэрмийг дав хэмээн тушааж өгүүлэв. Чингис хааны эл зарлигт улсын заргач Шихихутаг морины явдал дунд муутуу цаасан дээр бийр янтай хэрэглэн худам монгол бичгээр бичих авай.

## ҮДШИЙН ГЭГЭЭ

21 аймгийн хүрээнд гал дүрэлзэн асч галын гэрэлд баярласан овог аймгуудын хүмүүс тус бүрдээ өөр өөрсдийн ая дууг өргөн барьж дуулалдан хөгжилдөнө.

Олон үндэстний бүжгийн цуглуулга мэт санагдана.

Галыг тойрон бүжиглэх олон хүмүүс нь заримдаа өнөө цагийн ёохор хатирахыг сануулах мэт... гар савчин, мөр цохин бүжиглэх эмгэд хөгшид нь баруун монгол зүгийн бүжгийг санагдуулах мэт...



## ЖАМУХЫН ЭЦЭСЛЭЛ

/Тэмүжиний цацрын гадаа/

Наран шингэх үест бамбайгаар тойруулан хүрээлсэн элсэн манхны нэгэн өнцөгт Зэв тэргүүтэй дөрвөн чононд баригдсан Жамухыг чирж авчирлаа. Тэмүжин түүнийг хүлээж байлаа. Жамухын бүх бие шарх олжээ.

Жамуха: -Тэмүжин анд минь би дайнд анх удаа ялагдал хүлээлээ. Гэсэн хэдий ч дайсныхаа агуу сүр хүчийг бодохоор харамсах зүйл алга.



Тэмүжин: -Жамуха анд минь миний одоо оршин тогтнож байгаа нь чам шиг журмын андтай байсных билээ. Чи өнөөдрийн тулаанд ялагдсанаа тэнгэрийн санаа хэмээн бодож, нэрэлхэж зоволгүй миний дэргэд хааны амьдралаар амьдран, удаан жил журмын анд минь хэвээр байгаач.

Жамуха: Үгүй дээ би ч монголын дайчин эр. Амьд үлдэх аваас чамайг мөхөөх өдөр ирнэ гэж хүсэмжлэн, түүндээ ч итгэх болов уу. Чи даруй түргэн миний амьсгалын үндсийг таслах ёстой. Харин журмын андын сэтгэлийг боддог бол намайг цус гаргалгүй хороогтун. Хүүрийг минь өндөр ууланд оршуулаарай гээд Жамуха өврөөсөө гавлын ясаар хийсэн мөнгөн аяга гаргаж ирлээ. Жамуха: -Би ийм хоёр аягатай больё гэсэн юм. Энэ бол Тоорилын гавлын ясаар хийсэн аяга, даанч би чамд ялагдлаа. Тэмүжин: -Зэв Хубилай хоёр оо. Жадарны Жамуха хааныг цус гаргалгүй нөхчөө гэж Чингис хааныг тушаангуут ханцуйнд нь мод шургуулан цовдлон хүлсэн Жамухад ойртсон хоёр баатар нэг зэргээр ямааны зумалсан нойтон арьсыг шууд нүүрэнд нь наав.

Зумалсан арьсны цаанаас Жамухын амьсгал боогдон арьс татвалзан нүүр нь хөдөлж байв.

Тэмүжин:-Хамгаас хүчирхэг бөгөөд эрхэм анд, монголын өндөрлөгийн агуу дайчин минь хагацаа даа... гэж хэлээд Жамухын мөрөн дээр бат суусан шонхрыг авч нисгэлээ.

## ЧИНГИС ХААНЫ АНД

Өргөөндөө сэнтий дээрээ суусан Чингис хааны өмнө Жамухын нүүрний хэв бүхий зумалсан арьсыг авчирч тавихад их хаан түүнийг ширтсэнээ.

Чингис: -Анд минь бид хоёр удаан жил хамт байж болох байсан даа гэж өгүүлэв. Жамухын нүүрний хэв бүхий арьсан дээр ван Тоорилын гавлын ясаар мөнгөлж хийсэн аяга тавиатай байв. Монголын өндөрлөгийн төлөөх гурван хааны хувь төөрөг эцэстээ ийм байжээ. Чингисийг их цацрын тооно өөд харахад тоононы цамхраан дээр суусан шонхор Жамухын нүүрний хэвт арьс, Тоорил хааны гавлыг мөнгөлж хийсэн аягыг харан сууж байв.

Энэ үед Чингис хааны цацарт Зүчи, Хасар, Бэлгүтэй нар орж ирэв.



Чингис: -Зүчи ээ. Чамд их цэрэг өгч явуулья гэж бодох юм. Хэрэйдэд дайтсан шигээ хүчирхэг эр зоригоо харуул...

Зүчи:-Мэдээж надад итгэгтүн надад даалгахтун хаан эцэг минь.

Чингис: -Хөвүүн чи хоёр түмэн цэрэг авч, умар зүгийн зэрлэг аймгийнхны хоромсог саадгийг хурааж авчир.

Элчийг минь тэд зэрлэгээр хороосон билээ.

Зүчи: -Тэд гэмтэй тул сөгдүүлэх ёстой. Хасар, Бэлгүтэй хоёр гайхан бие биерүүгээ харлаа.

Чингис: -Алтан улсыг дайлахын зэрэгцээ ар талдаа байх дайсныг дарангуйлан хураахгүй бол сэтгэл амар дайтаж чадахгүй нь.

Хасар: -Хаанд мэдүүлье. Умар зүгт ойн зэрлэг иргэд өлөн барсын нүдээр отон хүлээж байгаа. Мөн сибирийн ой тайга бол маш хүйтэн тулалдахад санаанд багтамгүй бэрх газар билээ. Дайн тулааны туршлага багатай Зүчи хан хүүд арай хүндцэх байх гэж бодож байна.

Зүчи: -Хасар авга минь. Та санаа бүү зовоxtун. Би хаан эцгийн зарлигийг гялалзтал биелүүлж Бөрт чоно болохоо харуулна гэв.

## ХУЛАН АМАРЖИВ

Их цэргийн цуваан дундах бага гэр өргөө тэрэгний дугуй хяхнан аажмаар урагшилна. Гэр өргөөнд Хулан хатан амаржихаар дуншиж түүний гэрэлт царай дээгүүр хөлс бурзайж тэрэгний дайвалзаанд гэр доторхи юмс үл ялиг бүүвэйлэгдэн хөдлөх авай. Хулан хатны дэргэд Бөртэ үжин болон бусад хатад шивэгчид байх бөлгөө. Хүүхдийн чанга цовоо дуу хадахад их цэргийн цуваа түрүүчийн адил урагшилсаар байлаа.



Энэ үед их өргөөнд Чингис хаан явж байх бөгөөд хүүхдийн цовоо цалгин дуу сонсож суугаа ч юм шиг, дайн тулааны хэцүү бэрхийг төсөөлж байгаа ч юм шиг тэвчээртэй суух ажээ.

## ЦАГААН ХЭРЭМ

Монгол цэргүүд сүрдүүлэх аястай олон гавлын ясыг хэлхэн цагаан хэрэм өөд чулуудна. Мухулай алсын өндөрлөгийг ажин зогсоно.

Монгол цэргүүд дарьтай сум дүүгүүрдэн шидэж гал авалцуулан их Цагаан хэрмийг эзлэх тулаан болж байна.

Морьтой эгнэн зогссон цэргүүд...

Цагаан хэрэм рүү дөхөн очиж сум тавин эргэж давхина.

Хэрмэн хана өөд шат тавин авирах монгол цэргүүд...



## ЁР БИЛГЭ

Чингис хааны их өргөө.

Газар тэнгэрийг холбосон их бөө Тэв тэнгэр, Чингис хааны өмнө бөөлөн байлаа.

Тэрбээр гэнэт салганан чичирч,

Тэв тэнгэр: -Надад ёр үзэгдэв гэлээ. Чингис хаан гайхан харна.

Тэв тэнгэр: -Би мөнх тэнгэрийн зарлигийг уламжлая. Хаан таны суурийг Хасар дүү чинь булаана гэж тэнгэр над хэлэв гэлээ.

Үнэхээрийн ёр билгийн ухааныг гайхамшигтай эзэмшсэн Тэв тэнгэрийн сүлдэт буулганд Хулан, Хасар хоёр морьтой давхиулан яваа нь үзэгдлээ.

Хар морьтой, хар хувцастай арван цэрэг давхилдан өнгөрнө.



Үнэхээр энэ үйл явдал болж өнгөрсөн ер бусын хэсэг үзэгдэл байсныг Хулан, Хасар хоёрын байдал бидэнд илчилнэ.

Яг энэ үед гаднаас алтан гэрэгэт элч орж ирлээ.

Элч: -Гоо ван, жанжин Мухулай Алтан улсын их Цагаан хэрэмний 72 цайз бэхлэлтийг эзэлжээ. Хэдийд нутгийн зүг жолоо эргүүлэхийг таалан болгооно уу? гэж асууж байна гэлээ.

Алтан гэрэгэт элч аюумшигт хариу сонсох гэж байгаа мэт айж балмагдан хариуг удаанаар хүлээв.

Чингис хаан хариу эс хэлэв.

## ШИЙТГЭЛ



Атираат манхан, элсэн цөлийн оройгоор шуурга шуурч хон хэрээ эргэх бөгөөд тийшээ ойртож очиход цовдлогдсон Хасар ухаангүй байна. Хасарын урагдсан хувцас салхинд хийсч дэрвэлзэх агаад зориуд ял шийтгэлд бэлтгэгдсэн модны холтос залтсыг цагаалж Хасарыг үхлүүт хүлжээ. Хасарыг үхлийн цөлд хаясан байв. Өэлүн эх, Бөртэ хатны хамт Хасар дээр хүрч ирлээ. Энэ үед Чингис хаан хар хувцастай, хар морьтой цэргүүдийн хамт давхин ирэв. Өэлүн эх, Хасарыг хүлж цовдолсон модыг ганхуулан түлхэж хөдөлгөх зуур ядрангуй хоолойгоор Чингис хаанд хандан



Өэлүн эх: -Хаан хүү минь ээ... Чи урьд дүү Бэгтэрийгээ хороосон Хасар бол чиний баруун гар болж явсан одоо түүнийг хороох санаатай юу? Чи миний нэг хөхний сүүг хөхөж бардаггүй байхад Хасар хоёр хөхий минь хөхөж хоослоод цээжий минь уужим болгож амирлуулдаг байсныг санаж явахгун... хэмээн их дуугаар хайлан байж хэлэв. Элсэн цөлийн дунд зоосон шон мод ганхсаар байгаад хазайв. Хасар шонтой цуг аажмаар элсэн дээр унахад түүний хүлээсийг Бөртэ хатан хурц хутгаар хэрчлээ.

Чингис: -Хасар дүү эрүү шүүлт амсах нүглийн үүд нээсэн тул тэнгэрийн таалалд үл нийцсэн билээ гэв.

Өэлүн: -Энгийн ард алдаа эндэгдэл гаргаж болно. Харин хаан эзний ухааны мэлмий саруул байх ёстой гэж бахардан өгүүлэв. Хасарыг ухаан орж нүдээ нээхэд хөх тэнгэрийн дэвсгэр дээр ачит Өэлүн эх нь Бөртэ үжиний хамт харагдлаа... Цөлийн дээгүүр салхин исгэрэн шуурч байлаа.

## ИТГЭЛ

Их Цагаан хэрэм дүнхийн харагдана.

Мухулайн хээрийн цацрын өмнө алтан гэрэгэт элч сүр дуулиантай ирэн,

Элч: -Бусад цайз хэрмийг гуйцээн эзлэх хүртэл тэр нутгаа тохинуулан үлд гэж

Чингис хаан зарлигдав.



Мухулай: -Чингис хаанд сөхрөн очиж миний үгийг дамжуулахад их хаан яаж хүлээж авав?

Элч: - Эрхий хуруугаа гозойлгов гэж чангаар хариулав. Мухулай ихэд бах хавгайгаар,

Мухулай: -Харин миний тухай ярихад эрхий хуруугаа гозойлгов уу? Элч :-Бүр өндөр өргөн гозойлгосон гэж хариу хэлэв.

Мухулай:-Тэгэхээр би амь насаа үл хайрлан зүтгэсэн нь яавч дэмий биш байна. Цаашдаа их монгол улсынхаа төлөө хичээн зүтгэх болно гэв.

## ХЭЭР ТАЛ

Хасар хэдэн цэрэг дагуулан яаран давхиж явна. Тэртээ өмнөөс нь туг хиараа намируулсан их цэрэг дөхөж ирлээ.

Хасар: -Энэ чинь... хэмээн цочирдон дуу алдлаа. Их цэргийн түрүүнд явах жанжин давхисаар ойртож ирлээ.

Энэ бол Зүчи байлаа. Хасар мориноосоо үсрэн буугаад унаж тусан гуйв. Зүчи ч мориноосоо буун өмнөөс нь гүйлээ. Хасар Зүчи хоёр үг дуугүй тэврэлдэн авлаа.



## ЭХ ТААЛАЛ ТӨГСӨВ

1210 он гэсэн бичиг хуучин монголоор гарна.

Элч: - Өэлүн эх насан хутаг оллоо... Сүлд тугаа бөхийлгө... Их гашуудал зарлаж байна гэж элч зарц нар хашгиран зарлав. Мөнөөх хар морьтнууд давхилдан замд яваа хүмүүсийг харваж цэвэрлэж эхлэнэ.

Зохиогч: Өэлүн эхийн шарилыг ачсан их тэргийг даган цэрэг, зарц шивэгчид, бусад хүмүүс хөвөрчээ. Оршуулгын цувааны магнайд баг цэрэг давхин замд тааралдсан бүгдийг харван зайлуулж, замыг чөлөөлж явлаа. Санамсаргүй энэ замд тааралдагсад толгойн харуулын суманд өртөн хөсөр унаж морь нь жолоо цулбуураа чирэн талд давхих нь дүрсээр харагдана.



Өэлүн эхийн шарилыг түүний өсгөсөн дөрвөн өнчин хөвүүн, өдгөө 30 эргэм насны залуу сайхан эрс Хүчү, Хөхөчү, Шигихутаг, Борохул дөрөв морин тэргэнд авч явах ажээ.

Шарилын ард Өэлүн эхийн хөвүүд Хасар, Хачиун. Тэмүгэ-отчиган, Тэмүлүн гээд ач үрс хүүхдүүд нь явах ажээ. Ганцхан энд Чингис хаан л үгүй байлаа.

## ХАГАЦАЛ

Голын дэнж дээр Өүлэн эх болор авсан дотор амар амгаланг бэлгэдэх мэт тайван нойрсоно

Болор шилэн авсны дэргэд Чингис хаан очиж эцсийн удаа эхийн царайг харав. Өэлүний царай гал шижир алтны туяагаар шаргалтан гэрэлтэнэ. Эхийг алтаар бүрсэн нь үүрд энэ чигт нь мөнхлөх гэснийх байв.

Чингис хаан нүүр, сахлын дээгүүр том том нулимс бөмбөрүүлэн чимээгүй уйлж

Чингис: -Ээж минь. Таны цусыг биедээ шингээсэн би гав ганцаар нүв нүцгэн хоцорлоо. Би өөрийнхөө хэний цус болохыг асууж эс зүрхэлсээр танаас хагацлаа. Одоо тэр нууцыг мэдэх ганц хүн та ээж минь үгүй болов. Тиймээс миний эргэлзээ тантай хамт үгүй болж, би энэ мөчөөс эхлэн дахин эргэлзэхгүйгээр жинхэнэ Бөртэ чонын удам гэдэгтээ итгэж явах боллоо. Би чөлөөтэй боллоо гэж өөртөө ч юм шиг, болор чулууны цаана хэвтэх эхдээ ч хэлсэн юм шиг шивнэжээ.



Түүнийг эхийн дэргэдээс холдон өндийхөд дөрвөн баатар эрс Өүлэн эхийн шарилыг хүндэтгэлтэйгээ өргөж голын ус руу зөөлхөн алхсаар орлоо.

Тэд явсаар усны гүн рүү орсоор байлаа.

Өргөсөн чигээрээ далд орсон баатрууд эргэж гарч ирсэнгүй.

Их мөрний ус юу ч болоогүй юм шиг намуухан долгион байлаа.

Их мөрний эрэг дээр зогсох Чингис хааны нүднээс нулимс хуран асгаравч түүний хар багаас өлгийдөн өсгөж бүүвэйлсэн Өүлэн эхийн бүүвэйн дуу намуухан эгшиглэсээр байлаа.

## ЦАГААДАЙН ЖӨТӨӨРХӨЛ

Чингисийн их өргөөнд ойр дотны шадар бараа бологсоц болон Бөртэ, Хулан нарын хатад сууна. Анир чимээгүйг эвдэж Бөртэ хатан өгүүлрүүн:

Бөртэ: - Уул мэт бие чинь нурж одвол улс олон монголыг чинь хэн захирах юм бэ? Төрсөн дөрвөн хүүгээс чинь төр барих нь хэн бэ. Хан хөвүүд дүү нар, харц олон ард ба хатад бид бүхэнд хариу айлдах эсэхийг хааны зарлиг мэдтүгэй.

Чингис хаан: -Хатан хүн боловч таны хэлсэн үг зөвөөс зөв. Би өвгөдийн хойноос одохгүй мэт өөрөө олтгойтсон ажээ. Үхэл надаас тойрох мэт үнэхээр түүнийг санасангүй гээд хүүхдүүдээ ээлж дараалан харснаа Зүч рүү хандан



Чингис: -Хөвгүүдийн ах нь Зүч мөн. Юу хэлнэ.чи хэл гэв. Тэдний яриаг Цагаадай таслан,

Цагаадай: -Зүчийг үг хэл гээд Зүчийг юунд томилох гэж байна. Энэ мэргидийн орхидост бид захирагдах гэж үү гэж хилэнтэйгээ хэллээ. Бөртэ хатан энэхүү яриаг зовиуртай ширтэн ажна. Зүч босоод Цагаадайн энгэрээс шүүрэн авч өгүүлрүүн:

Зүчи: - Хаан эцэг намайг гадуурхан үзээгүй байхад чи намайг яагаад ялгаж үзнэ. Чи надаас ямар эрдэм чадлаараа илүү вэ? Чи ганцхан догшин омгоороо илүү биз. Харвалцаад чамд гартвал эрхийгээ огтолж хаясугай. Барилдаад чамд унавал унасан газраас бүү босоё. Хаан эцгийн зарлиг мэдэг гэв. Зүч, Цагаадай хоёр энгэрээсээ барилцаад Зүчийн гараас Боорчи татаж, Цагаадайн гараас Хасар татаж байхад Чингис хаан дуугай сууж байлаа. Боорчи нэлээд ширүүнээр

Боорчи: -Цагаадай чи юунд яарав. Хаан эцэг чинь хөвүүдийн дотроос чамд итгэж байсан билээ. Тос шиг санааг царцуулж, сүү шиг сэтгэлийг ээдүүлэх чалчаа муу үгийг Цагаадай чи хэллээ. Бүлээн элэг нэгтэй Бөртэ хатны хүүхэд биш үү. Халуун элэг нэгтэй хамт төрсөн хүүхэд биш үү. Эгмээс чинь татан эрийн зэрэгт хүргэсэн эрхэм ачийг санацгаа. Хүзүүнээс чинь татаж хүний зэрэгт хүргэсэн хүндэт ачийг бодоцгоо. Бохирыг чинь арилгаж борвийг чинь сунгаж, эрийн зэрэгт хүргэж, эмээлийн дөрөөнд хүргээд энхрий хөвүүд та нарын эрхэм сайныг үзье гэж эх чинь одоо бодож байна. Наран шиг гэгээн ухаант, навч шиг дэлгэр сэтгэлт сайн хатан эхийнхээ санааг бүү гомдоо гэв.

Чингис -Зүчийг тэгж хэлж яаж болно. Хөвүүдийн минь ахмад Зүч биш үү.

Хожим тэгж бүү хэлтүгэй хэмээн зарлиг болгов.

Энэ үгэнд Цагаадай мушилзан өгүүлрүүн.

Цагаадай: -Зүчийн хүч эрдмийг басамжлахгүй. Аавын хөвүүдийн ахмад нь Зүч бид хоёр билээ. Хаан эцэгтээ хавсарч хүчээ өгье. Өгөдэй дүү өршөөлтэй учир түүнийг хаанд өргөмжлөхөд болно гэв.

Чингис Зүчи чи юу хэлэхээ хэлэхтүн гэв.

Зүчи: -Цагаадайн хэлсэн ёсоор бид хоёр хавсарч хүчээ өгье. Өгөдэйг өргөмжилье гэв. Чингис хаан зарлиг болгон:

Чингис: -Зүчи, Цагаадай та хоёр хэлсэн үгэндээ хүрч ардын инээдэм, амьтны тоглоом болохгүй эв найртай яваарай. Өгөдэй юу хэлэхэв хэлэгтүн гэв. Өгөдэй: -Хаан эцэг соёрхож үг хэл гэхэд би юугаа хэлэх вэ. Чадахгүй гэж яаж хэлэхэв. Чадахыг хичээе. Гагцхүү хойч үеийн хөвүүд ач нар минь өвсөнд ороовч үхэр тоож идэхгүй өөхөнд хучивч нохой тоож идэхгүй юм төрөөд хандгайг харваад оготныг онох болуузай хэмээн санаа зовинон байна гэлээ.

Чингис: - Толуй чи юу хэлэх вэ, хэлэгтүн гэв.

Толуй: -Би хаан эцгийн нэрлэсэн ахын уриалах дуунд нь уухай болж, унах моринд нь ташуур болж явья хэмээлээ.

## ЗҮЧИЙН ОМГОРХОЛ

Элч Сартаулаас ирдэг эхлэл хэсгийн үргэлжлэл байна. Чингисийн их цэргүүд рүү Зүчи давхин очно. Чингис хаан Боорчи Зэлмэ, Хасар, Бэлгүтэй, Зэв, Хубилай, Сүбэдэй зэрэг баатруудын хамт байх бөлгөө.



Зүчи: -Эцэг тэнгэр минь та болгоон соёрхоно уу. Би баруун зүгт орших лалын шашныг үндэслэн нэгтгэсэн Сартаулын улс руу таны урьд хэлсэн ёсоор дайлаар мордьё.

Монголын Бөртэ чонууд хадыг өндөр гээд харайхаа болих уу, жалгыг гүн гээд туулахаа болох уу. Хаан эзэн та Зүчи надад хэдэн түмэн цэргийг өгч хад харайлган, жалга туулуулаач...

Чингис хаан Зүчийн нүдийг ширтсэн хэвээр, "Ёстой л монголын Бөртэ чоно доо" гэж аль ч үеэс илүү бодлоо.

Чингис: -Манай боржигон овгийнхон өвөг эцэг ч байг. элэнц өвөг ч байг төрсөн цагаас аваад үхэн үхэтлээ цөм дайсантай байсан юм. Дайсантай байдгаараа сая боржигон овогтон болсон хэрэг. Бөртэ чоно дайсангүй байж болохгүй. Дайсангүй Бөртэ чоно бол даруй Бөртэ чоно биш гэж хэлэв. Энэ уед улсын дээд заргач Шихихутаг эзэн хааны зарлигийг шаравтар муутуу цаасан дээр бичих ажээ.

## ТАХИЛГА

Хар хувцастай, хар морьтнууд сүлжилдэн давхилдана.

Тэв тэнгэр бөө ганцаараа тэнгэр, газрын хүчийг дуудан өндөр уулын овоо тахилгыг тойрон бөөлнө.

Их цэрэг хөдлөхийн өмнө Чингис хаан Бурхан халдун ууланд ялалтаа даатган мөргөв. Чингис хаан их овооны өмнө сөхрөн сууж бүсээ хүзүүндээ зүүж, энгэрийн товчийг тайлан цацал өргөж залбирав.



Чингис: - "Мөнх тэнгэрийн сахиус минь. Эрт урьд Алтан улсад алагдсан өвөг дээдсийн өшөөг нэхэхээр энэ бие их цэрэг дайчлан мордох гэж байна. Хамаг монгол ардын хүсэл зориг энэ билээ. Хаан Амбагай өвгийн хатуу хэлсэн захиа бий билээ. Хан их тэнгэр минь өршөөн соёрх. Хоёр гарт минь тэмцэл ялалтын хүчийг атгуулж хайрла".

## ГАНЦААРДАЛ

Урьд шөнө өөрийн гэрт дөрвөн хөвүүнтэйгээ Бөртэ хатныхаа хамт ярьсан явдал санагдана.

Чингис: -Бөртэ минь.Чиний төрүүлсэн дөрвөн хөвүүн Зүчи, Цагадай, Өгөдэй, Толуй нар чинь маргааш өглөө тус тус их цэргийн жанжин болж, Алтан улс Сартуулд орно. Энэ шөнө Бөртэ ч дөрвөн хүүтэйгээ салах ёс хийж буйн адил би ч бас тэдэнтэйгээ салах ёс хийж байна. Маргааш өглөө бид тав тус тусын цэргийн хамт салан одох болно. Дахин уулзахыг зөвхөн тэнгэр л мэднэ.

Бөртэ: -Хөвгүүдээс салахад би юунд уярах. Би бол Татаар, Тайчуудыг сөнөөх Бөртэ чонын үрсийг чамд төрүүлж өгсөн бус уу. Харин эднийг нялхад чи өөрөө Татаар тайчуудыг сөнөөжээ.



Тэдэнд гавьяа байгуулах өчүүхэн ч юм үлдсэнгүй. Одоо Зүчи, Цагадай, Өгөдэй, Толуй эрийн цээнд хүрэв. Хөвгүүдийн тэсвэр алдагдаж байна. Цагаан хэрмийг давж Алтан улсыг дарах мөн сартуулыг дарах эрх чөлөөг хөвгүүдэд минь олгосон нь болжээ гэлээ.

Чингис: -Би тэгэхийг хүссэн. Гэвч Зүчээс бусад нь их тулаанд бие даан цэрэг удирдаж оролцоогүй тул би хөвүүдийн отгоныг дэргэдээ авч, Цагадай, Өгөдэй хоёрын дэргэд Боорчийг явуулна. Зөв биз. Харин ойн иргэдийг дарж Зүчийн байгуулсан гавьяаг би зарлиг гарган сайшаасан нь өөрийн хөвгүүдийг бусдаас илүүд үзсэн хэрэг биш. Хөвүүд минь та нар надад балчир хэвээрээ байна. Их дайны хөлд омгойтож эндүүзэй хэмээн эх чинь ч бас та нарын төлөө сэтгэлдээ шаналан зовж буй гэвэл бүгд дуугүй болж Чингис хаан өмнөх дөрвөн хөвүүнийхээ царайг ээлжлэн харав.

## ХАР СҮЛДНИЙ СҮР

Чингис хаан Бурхан халдунаа тахиж дуусаад бослоо. Тэр дор хорин түмэн цэрэг нь шивээлэн жагсжээ. Чингис хааныг дохимогц үүлс доргих шиг чимээ гарч их цэрэг уруудан урагшлав.

Чингис хаан Хасар. Боорчи нарын хамт Зүчи хүү дээр давхин ирлээ.

Чингис хаан:-Зүчээ хүн морийг зовоолгүй, хүр гэсэн газарт хүр! Чиний нэг цэргийн амь зуун лал хүний амьтай дүйцнэ. Тосож угтсаны нь өөрт оруулан тэрсэлж ирсний нь чандрыг хийсгэ!

Хөвүүн минь чи миний алтан аргамжийг бөхөлж жолоогоо бат атгаж яв. Хорейзм Бухарын лалыхныг төвшитгөж тохинуулсан цагтаа над руу ир! гэв.

Зүчи /Морин дээрээ тогтож ядан/

Зүчи: Хаан эцгийн зарлигийг дагаж илдний чинь ир болж өштөнийг өрлөж дайтая гэлээ.

Чингис хаан: -Хүмүүн төрөлхтний эсрэг хэн хэрээ мэт гуаглан цөөвөр мэт авирлана, түүний сүнсийг газарт булж, үнсийг тэнгэрт хийсгэ! гэлээ.

Их цэргийн нүүгэлтсэн цуваа уухайлан хөдлөх нь нэн сүртэй агаад газар тэнгэр доргион хадаасан морьдын туурайн тачигнаан дэлхийг хөмрөөх мэт авиа гарган биднээс холдов.

Чингис хаан эдгээр үгийг Зүчид хэлж дууссаны дараа 40 хөгжимчний хөгжимдөх аялгуун дор 40 гоо бүсгүй бүжиглэн үдэх бүжгийг харан түр азнаснаа нум,саадгаа агссан цэргүүд дагуулан алслан холдлоо.

Эдгээр хөгжимчид. бүжигчдийн дуулах аялах. бүжих нь эрт үеийн монголчуудын угтах, үдэх ёслолын нэгэн хэсэг байлаа.

Зах хязгаар нь үл харагдах их цэргийн цуваа тасралтгүй үргэлжилж хэдэн салаа болон задарч зүүн өмнө зүг, баруун зүг рүү хошууран нүүгэлтсээр бараа тасарна.



## ТУЛААН, ЦАГААН ХЭРМИЙН ҮҮЛ

Чингис хаан дайны байдлыг ажиглаж байлаа. Дэргэд нь хуяг дуулгаар биеэ өвч бүрсэн Хулан, мөн хуяг дуулгаар өвч хувцасласан Хөлгөн хүү нар тус тусдаа морьтой зогсоцгооно. Тэртээ алсад, Алтан улсын Шаньси мужийн хойд талын уул нуруудын оройгоор урт цагаан хэрэм үүлэн дундаас сүүмэлзэн харагдана.



## САМАРКАНД

Элсэн толгойн оройд жанжин Зүчи их цэргийн хамт гарч ирээд алс тэртээ зэрэглээн дунд харагдах Самаркандын барааг олж харлаа. Самарканд тодрон наашилна.

Зүчи: /монолог/ -Эцэг тэнгэр минь таны зарлигийг ёсчлон биелүүлэхийн төлөө цусаа огшиж, ясаа цайтал ^ зүтгэх болно. Би монголын Бөртэ чоно болж байж хаан ^ эцэг таныхаа шаналалд гүн шингэхээ мэдэж байна. Одоо

миний замд галзуу догшин барс ч өчүүхэн төдий садаа болох юм гэж үү. Бөртэ чонын замаар явлаа... Самарканд тодорхой дүрслэгдэн харагдах ажээ.



## АЯН ЗАМД

Чингис хааны цэргийн цуваа. Цэргийн цувааны хөдөлгөөн дунд бяцхан хүү Хөлгөнийг тэвэрсэн Хулан хатан явах амой. Нэгэн өвгөн дархан цэрэг эмээлийн бүүргэнд суулгасан дөшин дээр сумын зэв давтаж явах харагдана. Аян замын гэр тэрэг дотор өөрийн бяцхан хүүгийн хамт Хулан хатан Чингис хааныг угтан авлаа.



Чингис хаан гаднаас орж ирэн хүүг энхрийлэн үнсэж өргөснөө,

Чингис: -Бяцхан хүү Хөлгөн минь чи их тулааны аяг даахуу даа...

Хулан: -Их хаантан минь би таны дөрвөн хүүгийн адил монголын нэгэн бөртэ чоныг төрүүлсэн бус уу. Тэдний адил морьдын хөлс үнэртэж өсөг гэж бодсон юм.

Чингис хаан юу ч сонсоогүй мэт хүүг үнэрлэн үнссээр байлаа.

Хулан: -Та юунд хүүг ийм удаан үнсэв. Сайны ёр уу, муугийн ёр уу? гэв.

Дайны талбарт байх гэр тэрэг дотор айж эмээж, асууж сураглалгүйгээр Зэв, Хувилай, Зэлмэ, Сүвээдэй нарын дөрвөн жанжин ирж Чингисийн гараас хөвүүн



Хөлгөнийг эхэд нь үнсүүлэлгүй гар дамжуулан авч гадагш гарахыг завдлаа.

Энэ үед Чингис хаан эрдэнийн чулуун шигтгээтэй алтадсан өөрийн сэлмийг баатруудын гар дээр унтаж буй хүүгийнхээ дээр тавилаа. Гэнэтийн энэ учралд айж балмагдсан Хулан хатан,

Хулан: -Хүүгий минь яах гэж байгаа юм бэ?Хөлгөөн..., Хөлгөөн ...гэж хашгиран үүд рүү тэмүүллээ.

Чингис хаан: -Дээд тэнгэрийн тааллаар амьдраг. Хөлгөн үнэхээр бөртэ чонын удам мөн юм бол хатуу ширүүн хувь заяаг даван туулж эх болсон монголын хөрс шорооны төлөө амьдрах ёстой. Хэзээ нэгэн цагт монголын хаан болох хөвүүд цөм дээд тэнгэрээс заяасан зочин болой. Одоо бид нэгэн цогцос болж монгол морины туурайгаар газар дэлхийг тамгална гэж өгүүлэв. Саяхан дуу тавин хашгирсандаа гэмшсэн мэт Хулан хатан чив чимээгүй болж дотогшоо эхэр татсанаа,

Хулан:-Миний хүү Хөлгөн их хааны суудлын төлөөх цуст ерсөлдөөнд хожмоо ах дүүстэйгээ тэмцэлдэнэ гэж та бодоо юу? Одоо би таны дайны чинь хатан болж явья. Би эцэг нэгт ах дүүсийг цусан өшөө зангидахад хүргэмгүй байна гэж хэлээд хөлд нь сөхөрлөө.

## ХАСАР ТЭНГЭРТ ХАЛИВ

Их Эзэн Чингисийн цэрэг дайн байлдааны аян замд явж байх нэгэн өдөр, газар тэнгэр нийлсэн их талын хаяанаас нэгэн морьтон цэрэг шархадсан Хасартай хамт давхилдан ирлээ.

Чингис хаан холын бараанаас түүнийг танин, цуваанаас тасарч Хасар руу дөхөн очив. Түүний цээж нум суманд нэвт харвагдсан байлаа. Чингис морин дээрээсээ Хасарт тулж очин

амьсгалах тоолонд нь цээж нь хяхтнан цус бургих түүний биеэс сумыг суга татлаа. Хасар цээжээ хяхтнуулан сүүлийн үг хэлэв.

Хасар: -Би Уша бэхлэлтийг хиар цохин авав. "Их эзэн минь" гэсэн үг байлаа. Ийнхүү эх дэлхийн тоосыг газраас тэнгэрт хадаан уухайлан явсан монголын нэгэн Бөртэ чоно морин дээрээ амьсгал хураалаа.

Чингис хаан морин дээрээсээ огцом эргэж Хөхөчү тэнгэр бөөгийн зүг харснаа,



Чингис: -Чи монголын их хааны орыг залгамжлагч нь Хасар гэж миний онгодод буулаа хэмээн тэр нэгэн цагт өгүүлсэн биш билүү. Түүнийг их хаадын журмаар сүнс нь зөвхөн салхитай уулзаж байхаар болгоож хээр талд өөрийн дураар онголон тавьсугай. Одоо амьд ахуйд нь хэлж байсан бүхий л сайн үгсийг сүнс нь холдоогүй байгаа үед нь хэнгэргээ дэлдэн үдэж явуул хэмээв.

Хөхөчү тэнгэр бөө:

Ээ мөнх хөх тэнгэр минь ээ

Захгүй тэнгэр чиний мэдэлд

Үе үеийн Бөртэ чоноудад эргэн бууж байхаар ижилгүй төрсөн

Хасарыг илгээв ээ. Монголын Бөртэ чоно чи хүлгийн нуруунд төрөөд

Хүлгийн нуруун дээрээ хальжээ. Чи үүрд ингээд явтугай.

Хасар хав хүчтэй тул хатгалдан зайлагсдыг

Харвах сумны хүчээр хамж авчирдаг байлаа.

Огшиж дутаагсдыг онох сумын хүчээр

Оруулан авчирдаг байлаа хэмээн өөрийн онгод сүр хүчийг дуудан бөөлж эхлэх нь үнэхээрийн сүртэй агаад эзэн Чингисийн сэтгэлд хэлэх үг бүр нь зүрхэнд нь шивэн орж буй мэт байлаа.

Хөхөчүгийн ард тэнгэрийн увдисаар бүтсэн мэт газар газрын олон бөө уул овоо, тал хээр, цаатны урц, элсний нүүдэл дунд бөөлж хэнгэрэг юугаан балбаж газрын ханхүү Хасарыг тэнгэрт тушааж байх амой.

Энэ үед мориндоо бөхлөгдөж эмээл дээрээ бат бэх суусан Хасар олон биднийг орхин оройгүй тэнгэрийн зүг давхин одлоо.

Эртний уламжлал ёсоор мориндоо дахин мордохгүйн ёр билгэдлийг гүйцээж Хасарын эмээлийн зүүн талын хас тэмдэгтэй ган дөрөөг Чингис хаан тас татахад морь үргэн аниргүй алс зүг давхин одов.

Гэнэт Чингис хаан Хөхөчүгийн амьсгаадан бөөлөх үгийг тасдаж,

Чингис: -Чи үнэхээр ид шидийн хүчээр тэнгэрт харвасан олон оддын адил сүнсийг газарт буулгаж чаддаг юм бол Хавт Хасарыг ээжийн минь сүнстэй уулзуулж санаа сэтгэлийг нь амраа гэж зарлиг буулгалаа.

Уг зарлиг ёсоор биелэх мэт сүүмэлзэн буй зэрэглээн дундаас Өэлүн ээж морьтойгоо зөөлөн давхин гарч ирсэнээ хүү Хасараа дагуулан замхран одлоо. Чингисийн нүдэнд үнэхээрийн ингэж харагдав бололтой чихарч хяхатнасан дуугаар, Чингис: - Хөхөчү бөө чи тийм хүч чадалтай бол хүү Зүчийг надад хаана байгааг хэлээд аль. Тэр юунд нүүр буруулах мэт чимээ алдрав гэж өгүүлэв. Хөхөчү ихэд ядарсан хоолойгоор.

Хөхөчү: -Миний нас өндөр болж тэнгэр над руу ирэхээс жийрхдэг боллоо.

Зүч миний сэтгэлд баригдаж нүдэнд харагдахгүй байгааг минь өршөө гэлээ.

Чингис: -Одоо би тэнгэртэй өөрөө харьцана гэж өндөр дуугаар хэлэв.

Чингис хаан, Хулан хоёр морьтойгоо бусдаас холдон давхиуллаа.

Хулан: -Их хаантаан! Ингэхэд та юуны учир хавт Хасарыг нэгэн цагт шийтгэсэн билээ гэв.

Чингис үг дуугарсангүй боловч түүний нүд дүүрэн нулимстай нь бидэнд мэдрэгдэж байлаа.

Хулан: -Хавт Хасар гэж амандаа шивнээд,

Хаантанд гурван зуун татвар эм багадаагүй биздээ хэмээн тайвшруулж аргадсан аястай хэлээд давхилдан одлоо.

## ХӨЛГӨН

Хөхөчү Тэнгэр өвдөг сөхрөөд тэнгэрт хандан рашаан цацаж Хөлгөнийг рашаанаар угаана. Тал нутагт намрын хүйтэн салхи сэвэлзэн үлээж байлаа. Хад чулуун дундаас халуун рашааны уур савсан Хөхөчү тэнгэрийн залбирал, Хөлгөн хүүг нямбайлан угаахаар ээлжлэн гарна.



Уур цан савсан манан үүсчээ. Салхины аясаар цас холилдон бударна. Хаа нэгтээгээс хонхны дуу ойртон ирэв. Хатуу ширүүн өвөлд бэлтгэж нүүдэллэн явах малчид ба хонин сүрэг үзэгдлээ. Хөлгөнийг нойрсуулаад Хөхөчү бөөг холдон одох зуур хүүхэд орилж

Хүүхэд: -Аав аа, ээж ээ... энд хүүхэд байна хэмээн цуурай хадаав.

## АЛТАН УЛСЫН БЭЛЭГ

Их цагаан хэрэм рүү ээлж дараалан харвах морьт цэргүүд...

Тэнгэрт зайгүй шившсэн исгэрэх сум...

Монгол цэргүүдийн Цагаан хэрэм өөд авирч эзэлж байгаа байдал. Баатрын хувцас өмссөн Хулан хатан Чингис хааны хамт их цэргүүдтэй харан зогсоно. Их Цагаан хэрэмний нүсэр том хаалга алгуурхан нээгдэж. 500 гоо бүсгүйчүүд Чингис хаан, Боорчи, Зэлмэ болон тэднийг дагалдах монгол цэргийн өмнө хүндэтгэл үзүүлэн намсхийн сөхөрнө. Алтан улсын жанжин Чинсан Пусин дагалдан явагч, бараа бологсдынхоо хамт тэдэнд дөхөн ирлээ.

Чинсан Пусин: -Манай Алтан улсын хаан, танай Монголтой найрамдлын гэрээ тогтоож Чингис хаан танд бэлэг хүргүүлэв.



Энэ бол Алтан улсын хаан Чун Хэн охин Чи гоо гүнж. Төгөлдөр үзэсгэлэнт гүнжийг дагуулж Чингис хаан таны өлмийд алт эрдэнэс, 500 хөвүүн, 500 гоо үзэсгэлэнт охид, 3000 агт морьдыг бэлэг болгон өргөж байна.

Чингис хаан, Чинсан Пусины дагуулан ирсэн Алтан улсын хааны охиныг ихэд шохоорхон харснаа хэрмийн цаадах бэлгийн агт морьд, бэлгийн цувааны зүг хараа чилээлээ.

## ИХ ЦАГААН ХЭРЭМ ДЭЭР

Их Цагаан хэрэм дээр Чингис хаан, Боорчи, Зэлмэ нар бахархалтайяа зогсоно.

Чингис хаан Цагаан хэрмийн хойгуур урдуур нь өнгөрч байгаа үзүүр хязгааргүй цэрэг ангийнхаа урт цувааг хараад хажуудаа бараа болж зогссон Зэвд,

Чингис: -Чинийхээ ачаар Цавчаал боомтыг амархан өнгөрч байна гэв. Зэв жанжин нүдэндээ гэрэл цацруулан,

Зэв: -Зэв би Цавчаал боомтыг үүнээс хойш хэд дахин байлдан авахгүй бол болохгүй нээ гэж хэлээд инээв.

Боорчи: - Алтан улс хэмээх энэ аварга том мангасыг өнө үүрд өөрийн мэдэлдээ оруулчихлаа гэхэд итгэж өгөхгүй байна гэлээ.



Цэргүүдтэй давхилдан явсан Хулан хатны цээжин тус газар нэгэн тэнэмэл сум онон тэрбээр үхэтхийн унав.

## ЧИНГИС ХААН, ЧИНСАН ПУСИН ХОЁР

Чинсан Пусин: Танай их цэрэг өвгөд дээдсийн минь босгосон бат цагаан хэрмийг хялбар сэтлэжээ гэхэд

Чингис хаан: -Үгүй ээ, та нар энэ их цагаан хэрмийг бариагүй, Бидний дээд өвөг Хүннүчүүд бариулсан юм биш үү гэвээс Пусин эвгүүрхэн булзааруулж

Чинсан Пусин: -Би жанжин хүн, манай цэрэг өвч бөх хуяг зэвсэг сайтай атал, танай цөөхөн цэрэгт хялбар дийлдсэнийг эс ухаарна гэв. Чингис: -Манай морь шулуу мэт хурдан, цэрэг нь ирвэс мэт шалмаг, жанжид нь бүргэд мэт нүдтэй гээд Зэв рүү харлаа.

Зэв:-Танай цэрэг төмөрт дарагдаад түүртэх бус уу? Танай жад миний өдөн хуягийг нэвтэлж чадсангүй гэж сайрхан хөхрөв.



## ЕЛЮЙ ЦУЦАЙ

Чингис хаан хэрмийг ихэд сонирхож байгаа бололтой хэрэм дээгүүр цаашиллаа, Чингис хаан эргэн харж,

Чингис: -Миний монгол хүчирхэг улс болсон гэж би бат итгэнэ. Гэтэл зарим улс огт байлдахгүй мөртлөө биднээс дутахгүй амьдран суух нь юу вэ? гэж бодол болон асуув.

Елюй Цуцай энэ тулгасан асуултыг ойлгож бас чин сэтгэлээр хариулахаас айсангүй.

Елюй Цуцай: -Хаан та Алтан улсыг хүчирхэг гартаа атгасан. Алтан улс хэдийгээр дайны хөлд

сүйрсэн ч өнө эртний соёлтой улс хэвээрээ билээ. Соёл боловсролыг өндөр байлгахыг эрхэмлэх нь аливаа улсын зорилго байх ёстой юм. Эс тэгвэл хүйтэн төмөр шиг хөхөрч хоцрох болно.

Соёлыг эрхэмлэх үү, цэргийг эрхэмлэх үү гэдэг нь их хаан бүрийн өмнө тулгардаг зорилго. Алтан улсын иргэдэд энэрэлт бодлого явуулж тэднийг өөрсдөө сайн сэтгэлээр татвараа өргөдөг болгох хэрэгтэй гэвэл Чингис хаан илт дургүйцээгүй ч



Елюй Цуцай: -Цэрэг гэгч зөвхөн дайснаа дарахад л хэрэг болно. Өөр иргэн улсыг эзлэн захирч сууя гэвэл тэднээс 9 илүү соёл боловсролтой байх хэрэгтэй. Ер нь монгол хүн ^ малаа дагавал мал л болно. Өндөр соёл боловсрол хэзээ ч ялдаг. Тийм болохоор та хожим хойно Алтан улсын эзэмшилд ч орж болно гэж хэлээд хариу хүсэх мэт Чингис / рүү харлаа.

## ХУЛАН, МУХУЛАЙ ТЭНГЭРТ ОДОВ

Холоос шархдаж зовсон Хулан морин дээр дүүрүүлэн ирж яваа мэдээг Чингис хаанд уламжиллаа. Чингис хаан Хуланд дөхөн очиж түүний дээрээс тонгойн харав. Энэ үед тэр хоёрыг үлдээн цэргүүд холдон явлаа. Хулан тасалданги дуугаар:

Хулан: -Гималайн нурууны цаад талд бас эзлэгдээгүй том улс буй. Тэр нь халуун орон. Том зааны оршдог газар. Буддагийн шашин үүссэн тэр гүрний эрэгтэйчүүд нь толгойгоо цагаан даавуугаар ороож эмэгтэйчүүд нь нүүрээ цагаан бөсөөр бүрхэж явдаг. Тэр орныг хаан яагаад өөрийн мэдэлд авья гэж бодохгүй байгаа нь надад тун хачин санагдаж байна.

Чингис: -Хулан би чиний сэтгэлийг ойлгож байна. Хулан чи Гимлайн нурууны чанад дахь улсад дурлаж байгаа биш харин тэнд явагдах ширүүн тулаанд дурлаж байгаа гэв.

Хулан: -Юу ч болсон би зовиур зүдүүрийн дунд яваа хаан тантай хамт байхыг хүсэж байна. Харь улсын дайны талбарт хаан тантайгаа хамт амьдрах юмсан. Гэвч намайг Хавт Хасар, Өэлүн эх дуудлаа. Би тэдний араас явах нь гэлээ.

Хулан: -Хаан минь ээ, Одоо танд бол хүчрэхгүй хэрэг гэж үгүй болов. Монгол цэрэг энэ дэлхийгээр чөлөөтэй тойрон давхиж явна. Би таныг олон хатадаас чинь харамлан байж дайны хатан болсон. Би их эзэн хаан таны их үйлсийн төлөө Хөлгөн хүүгээ хүртэл хаясан билээ. Одоо би өөрийн амиа газар хөсөр хаяхаас юунаас айх билээ гээд амьсгал тасалдаж гүнзгий амьсгаа аван чимээгүй болно.

Чингис хаан хүүхэд шиг Хуланг өөр рүүгээ тэврэн ойртуулж,

-Хулаан...Чи намайг битгий орхи. Би бүхнийг чиний хүссэн ёсоор хийе Энэтхэгт орох үед чи надтай хамт байл даа хэмээн цурхиран тэвэрлээ. Энэ үед алтан гэрэгэт Чингисийн элч Алтан улсаас ирсэнээ мэдэгдэн бөхийж,

Элч: -Их хаантан... манай цэргийн ерөнхий жанжин Мухулай нас нөгчив гэж бөхийн газар мөргөлөө. Чингис хаан шүдээ зуун шивнэж,

Чингис: -Боорчи, Зэлмэ хоёрыг дууд... гээд хэсэг чимээгүй болсноо

-Тэр дөнгөж 54 -тэй байв. Юунд ийм эрт түүнийг минь надаас авч одов. Миний баруун гар хугарсан мэт болов. Алтан улсад Мухулай үгүй бол би Сартаул орныг сэтгэл амар дагуулж яаж чадна. Миний зүрх шимширч байна. Боорчи чи яана... Энэ үед дэргэд нь хүрч ирсэн Боорчи:

Боорчи: -Тэр миний дүү мэт байв. Яаж мартаж билээ. Тэмүжээн удахгүй бид бүгд түүний араас одох биш үү.

Чингис -Бүү чалч Боорчи чи ... Би чамайг үхэхийг чинь цаазална. Чи үхэж болохгүй.

Боорчи: -Үхлийг цаазаар хорьж үл болно.

Чингис улам бахардаж цочирдсон дуугаар,

Чингис: -Тийм байх ёсгүй чи бүү үх. Би ч бүү үхье хэмээн хашгирлаа. Хээрийн тулалдаанд амь эрсэдсэн Чингисийн баатар Мухулайн биеэс сүнс болон хувирч эгшин зуур холдон одох чонын дүрс Бөртэ чонын домгийг санагдуулна.

Тэр их баатар хүн Чингис хаан түр зуурын хугацаанд дараалан аянганд ниргүүлсэн мэт бөхийн зогссоноо "Хулан" гэж амандаа шивнэв. Хулан эцсийн амьсгал татав.

Чингис: -Хулаан... Хулаан... цаана чинь Мухулай намайг орхилоо, чи намайг бас орхих нь уу? гэж Чингис чичирхийлэн хашгирав. Хаан Хуланг өвөр дээрээ тэврэн Хулангийн гоо үзэсгэлэнт царайг ширтэн хацар дээр нь нулимс унагав. Чингис хаан хүүхний өнө эртнээс хайрласан эвэрт цагаан багийг авч, үүрд зүрхэндээ



нандигнан шигтгэсэн Хулангийн царайг ширтэн харж, дөнгөж бүлээхнээрээ байгаа уруулыг нь тэсэлгүй озлоо. Эл үнсэлт түүнийг юунд дуудсан дуудлага байсныг хэн ч үл мэднэ. Хаан Хуланд өгсөн гал халуун хайраа хөргөлгүй уруулыг үнсэн Хасарын сэлмэнд хуваагдсан цагаан багийг Хулан хатны нүүрэнд эвээр нь эвлүүлэн тавьж буцаан өмсгөлөө.

**ДАРХНЫ ГАЗАР**

Утаа тортог уур цан цохисон нэг газар есөн хүдэр чийрэг эрс цээж нүцгэн тойрон суухын сацуу нэг бөө дунд нь сүнс дуудах мэт цамнан бөөлнө. Нүүр нүдгүй шивээстэй хижээл эр жижиг зэсэн цар тавганд цогшсон хусны нүүрсэн дээрхи улайссан олон шивээсний зүүнүүдээс нэгийг авч чийрэг эрийн биен дээр аваачиж шивнэ.

## ХУЛАНГИЙН ОРШУУЛГА

Цас бударсан их уулын оройгоос Хулан хатанг суугаа шахуу байдлаар дамнуурга дээр тавьж явах найман чилгэр сайхан эрс уг дамнуургыг мөрөвчилжээ.

Чингисийн хар багын найз Боорчи хэдий бээр насан өндөр болж байгаа боловч найман цэрэг эрсийн урд алхаа нийлүүлэн түрүүлэн явна. Тэд их өндөрлөгийн орой дээр гаран зогслоо.

Боорчийн нүдэнд тэртээ дор хүглийн хеглөрөх ногоон тал, ус мөрөн харагдаж, адуу мал талбиун бэлчих нь харцнаа тусна. Гэвч өндөр уулын оройд цасан шамарга хуйлруулан босгож есөн эрсийн өмссөн нимгэн хувцсыг салхинаа дэрвүүлэн хийсгэнэ.

Тэд хоорондоо юу ч ярихгүй байх амой.

Гэвч Боорчийн нүднээ чийрэг найман эрс анх удаа хийж буй нэгэн үйлдлийг хэзээний сурмагаар үйлдэх нь нэн гайхалтай. Найман эрс уулын оройн чанх голд Хулан хатныг наран мандах зүг рүү харуулан тавилаа.



Тэгснээ эдгээр найман эрс Боорчийн нүднээ мөн л дөрвөн зүг, найман зовхисийг бэлгэдэн Хулан хатны суудлыг тойрон тал тал тийш харан сууцгаалаа. Цас будран орсоор байв.

Эдгээр чийрэг эрс өөрсдийн биеийг үл хөдөлгөн их эзэн Чингисийн баатарлаг дайчин хатан Хулангийн мөнхийн харуул болж цаст уулын оройд үлдэнэ. Уулын орой өөд цас маажин гарч ирсэн Боорчи гутлын бэхэлгээ төмрүүдийг уулын уруу гулсуулан шидлээ. Лавширсан цасанд дарагдах эрчүүдийг харж зогссон Боорчи цаа бугын годоор хийсэн жижиг цаныг мөрнөөс авч хөлдөө углан уулын уруу гулган одлоо.

Зөвхөн уулын оройд салхи татуулан хуйсагнан орох нэлийсэн цасан хөмрөг оргил дээр сууж үлдсэн хүмүүсийн дээрээс тасралтгүй будран орсоор байлаа.

Хуланг сахин хамгаалсан эрс цасан дотор зоолттой үлдэв.

Уулын уруу өөрийн хэр чадлын хэрээр унаж тусан чадмаг гулгасаар бууж ирсэн Боорчи нялх ногоон дээгүүр цас мөс шидлэн хол хол алхсаар морьтойгоо зогсож буй Чингис хааны өмнө



хүйтэн салхи татуулсаар сөхрөн уналаа.

Чингис хаан тэр үед хоёр гараа алдлан савж арагш гэдийн тэнгэр бурхнаас гуйх мэт "Хулаан" гэж амаа томоос том ангайлган зөвхөн өөрөө өөртөө хашгирлаа. Түүний энэ дууг өөр хэн ч сонссонгүй. Цасанд дарагдсан есөн овоо...

Энэ үед нүдний аяганд ганц дусал нулимс мэлтрэн бөнжийж хаашаа нэвтрэн урсахаа тогтоож ядах мэт цийлэгнэн байлаа.

## ИХ ЦЭРГИЙН БУУДАЛ

Хар морьтой, хар хувцастай цэргүүд тал тал тийш сүлжин давхилдана.

Зохиогч: "Чингис хаан Алтан улсын хааныг дагаар оруулж, их эд зүйлс авч Хашин /Тангуд/ улсын хаан Бурханыг элсүүлж олон тэмээг авав. Чингис хаан Сыр, Эрчис мөрөн гэтлэн Химлайн уулсыг гэтлэн Инди мөрөн хүрч, морины жолоог эргүүлээд Саарь хээрт буув" хэмээн зарлав. Чингис хааны өргөө гэр тэрэг зогсож Чингис хаан морь сэлгэн унаж жагсаж яваа цэргүүдийн зүг дөхөн очлоо. Талбай дүүрэн жагссан цэргүүдийн дунд ганцаар явж орлоо. Чингис хааныг дөхөж очиход захирагчдын дохио зарлалаар цэргүүд дараа дараагаар жагсаалаа эмхлэв.

Их эзэн Чингис хааны зарлигаар дэлхийн элгийг цөмчөн гишгэсэн монгол цэрэг нутгийн зүг жолоо эргүүлэн залжээ.

Чингис хаан он удаан цагийн аян дайнд монгол төрхөө гээж лал үндэстний малгай, алт мөнгөн эрхи, зүүлтүүдийг олноор нь давхарлан зүүсэн өөрийн цэргүүдийг харна. Тэдний дунд цагаан царайтай цэрэг ч байв, пад хар царайтай негр цэрэг ч байлаа.

Чингис -Одоо та нар бие биенээ харцгаа. Хэн монголын Бөртэ чонууд гэж хэлэх юм бэ? гэж зэвүүцэнгүй хэлэхэд цэргүүдийн зарим нь үнэхээр өмссөн хувцаснаасаа сэжиглэн газар шидлэн хаяж байв.

Чингис хаан Боорчийг дуудан:

Чингис: - Цэрэгт элсэх болон дархан, мужаан гээд гарын уртай хүмүүсийг ялга.

Харин залуу эмсийг цэргүүдэд хувааж өг гэв.

Боорчи: -Тэмүжин Цэргүүдэд эмс хуваан өгч үл болно. Энэ бол цэргийг самууруулах муу хор биш үү.

Чингис: -Боорчи чи юу ярина. Харин олзлогдсон эмсийг цэргүүдэд хувааж өгөх ёстой. Чингэж монгол цусыг ойрад, тангуд, сартаул хэн байна бүх эмсэд тараан цацах хэрэгтэй. Монголын Бөртэ чонын цусыг тээсэн хүүхэд олон олноор төрөг. Боорчи чи юунд ийм сайхан үйлд татгалзана вэ? Чи ч эмсэд дуртай биш үү гэж Чингис хаан Боорчийг мохоож инээв.

Их эзэн Чингис хаанд туйлын тоогүй мэдээ ирэв. Тэрбээр гартаа өөрийн үнэнч шударга

баатар Зэвийн өмсөж асан чонын багийг гартаа нэг атгаж, нэг зүрх рүүгээ ойртуулан олон цэргийн дундуур хараа талбин нүд цуцаана.

Чингис хаан жагсаалын хоорондуур явж

Чингис: -Зэв яав...? Миний хүзүүг шархдуулсан эрт

урьдын залуу минь, Зэв минь... Сум минь ... хэмээн амандаа үглэн явав.

Чингис хаан өмнөөс нь угтан ирэх цувааг хүлээн зогслоо.

Энэ сая үзвэл олон зуун нялх унага, бас орос царайтай охид хөвүүд, хэдэн зуун тэмээг унуулан туусан бүлэг цэрэг ажээ. Тэр сонин туувар Чингис хааны дэргэд ирлээ. Туугсад давхин ирж Чингис хааны дэргэд бууж.

Элч: Бид Зүч хааны дэргэдээс Чингис хаан танд энэ бэлгийг хүргэж ирлээ.

ЧИНГИС хаан: -Зүч хаа байна. Тэр тушаал дагаж цэргээ хурааж юунд наашаа ирсэнгүй вэ? гэхэд Элч: -Зүч жанжин...



Чингис хаан: -Элчээс зайдуухан зогсоо арав орчим насны хүү дээр хараа тогтоолоо. Их эзэн хааны хараа мэлмийд өртсөндөө баярлаж омогшсон бяцхан хүү урагш гарч ирэн

Бат: -Их эзэн хаан, өвөө минь би эцэг Зүчийн бэлгийг хүргэж ирэв. Чингис: -Чи хэн бэ? хэмээн асуулаа.

Бат: -Би хаан таны ач хүү Бат байна. Аав Зүчи маань бие барж намайг тань руу бэлгийн хамт илгээв гэв.

Чингис хаан анх удаа Батаас Зүчийн бага насыг олж харсан мэт амандаа ийнхүү өгүүллээ.

Чингис: -Хөвүүн чамайг эс мэдэн чиний эсрэг дүү нарыг тань цэрэглэн хөдөлгөснийг минь өршөө. Энэ олон зуун нялх унага, харь цусны олон зуун хүүхэд... Ийм сонин бэлгийг чи л явуулж чадна... Бөртэ минь өршөө гээд Бөртийн алчуурыг гаргаж ирээд удтал дуугүй суув. Зүчи чи бол үнэхээрийн нэртэйгээ ижил зочин мөн байж. Дээд тэнгэрээс боржигон аймагт суулгасан зочин мөн байж. Зүч чи Одоо тэнгэртээ буцжээ... гэж Чингис хаан сахал руугаа нулимс урсган шившин суулаа. Тэгснээ сая л ач хүү Батыг анзаарав бололтой түүн рүү эргэн харж

Чингис: -Чи ямар хүн больё гэж боддог вэ? хэмээн асуулаа. Хүү огтхон ч түгдрэлгүй,

Бат: -Би тань шиг дэлхийн хаан болох хүсэлтэй. Би Бат хаан болно гэж зөөлнөөр шивэгнэн хэлж өвгөний нулимстай нүд рүү ширтэн харлаа.

Чингис хаан үл мэдэг мушилзан,

Чингис: Эцгийн халааг залгамжилж монгол морины туурай хүрээгүй өрнийн их улс гүрнийг эзлэн ав, Бат хаан минь! Христосийн Есүс ч, Лалын Мухамед ч, Бурхны Будда ч талын монголын бөө ч бидэн шиг мөнх тэнгэрийг шүтдэг. Гэвч тэд тэнгэрээс хол оршдог юм хэмээн загнах тушаах хоёрын хооронд хэлээд хүүг элгэндээ тэвэрлээ.

## ХААНЫ ЗАРЛИГ

Чингис хаан дараа өдөр хан хөвүүн Зүчийг нас барсныг нийтэлсэн зарлиг гаргав. Энэ зарлигийг өртөөлөн тарааж хар морьтой, хар хувцастай цэргүүд ийш тийш давхилдана.



Зохиогч: -"Хан хөвүүн Зүч Хивчакийн тал нутгийн нэгэн өнцөгт нас нөхчив. Тэр газар бол монголын өвөг дээдэс бөгөөд дээд тэнгэрийн зарлигаар төрсөн Бөртэ чоно, Гуа маралын эрт урьд цагт гэтлэн ирсэн тэнгисийн хөвөө мөн. Түүний нэрийг Каспийн тэнгис гэнэ. Хан хөвүүн Зүч монголын ноёд цэрэг нарын үлгэр дууриал болж байлаа. Түүний эзэлсэн хотын хэрэм ер, хот хоёр зуу, Сартаулын дайн, Арал, Каспи, Хар тэнгисийн хойт талд Хибчак вант улсыг байгуулан түүний анхны хаан болжээ. Зүчийн үр ач нар өнө мөнхөд Хибчак вант улсыг захирах болтугай. Түүнийг дагалдан явсан ноёд цэргүүд тэндэх тал нутагт нутаглаж хааныхаа бүтээсэн их улсыг хамгаалах болтугай" хэмээжээ.

## ЧИНГИС ХААН, БАТ ХҮҮ ХОЁР

Чингис хаан Зүчийн хүү ирээдүйн их хаан Батыг тэвэрсэн чигээрээ хараа сунган харахад тэртээ холоос денгөж саяхан болж өнгөрсөн гунигт мэдээг хуваалцъя гэсэн шиг их хатан Бөртэ залуугийн эрч хүчийг санагдуулан морины хурдаар давхин айсуй ажээ. Чингис хаан хүүг харамлах мэт улам элгэндээ нааж.

Чингис: -Бат хаан минь би чамд ганцхан зүйл аминчлан шивнэе. Миний монгол дэлхийн магнай дээр оршдогтоо тэнгэрт ойрхон байдаг юм. Чи ганц нартай дэлхийд мөнх тэнгэрийн аугаа хүчин дор хүмүүн төрөлхтөн нэгдэж амар амгалан амьдрах ёстойг мэдүүл. Үүнийг чи үеийн үед санаж,



үрээс үрд дамжуулан хэлж монголын Бөртэ чонуудын бодол санааны үзүүрт хүргэсүгэй. Одоо бол хоёр хаан ярьж байна шүү Бат хаан минь гэж өхөөрдөн инээмсэглэснээ "Хэзээ нэгэн цагт хүү Зүчий минь амьдралын хугацаа дууссантай адил минийх ч бас эцэс болно. Бөртэ чонын удмыг дахин төртөл миний онгоныг нуухгун. Хэн ч бүү мэдэг. Хэзээ ч бүү олог.

Алд бие минь алжааваас алжаатугай

Ахуй төр минь бүү алдраг... гээд уужирсан мэт амьсгаа аван Бөртийн зүг инээвхийлэн харлаа. Холоос хурдтай давхин айсуй Бөртэ үжин хатны дэл шанхаа намируулан ирэх морь нь марал бугын эврийг толгой юундаа залсан домогт гоо марал лугаа Чингисийн нүдэнд харагдаж байлаа. Бөртийг энхрийлэн харж хүлцэл уучлалтыг хүсэн хүүхэд мэт инээвхийлсэн энэ царай киноны туршид бидэнд огт үзэгдэж байгаагүй, харин хожим хойно бидний зүрх сэтгэлд үүрд хоногшин үлдэх гэгээн дүр байх болтугай.

## ТӨГСГӨЛ

Чингис хаан далайн эрэг дээр морьтойгоо зогсоно.

Их эзэн хааны нүднээ Гуа марал Бөртэ чоно хоёр өрлөг баатруудаа дагуулан далайн усыг туучин ирж яваа нь үзэгдэнэ.

Чингис хаан эргэн далай тийш харцаа илгээх аваас хөлөг онгоцон дээр Бөртэ чоно, Гуа Марал болоод тэдний баатар эрс, олон арван бөө нарын хамт хөвөн хүрч ирээд эзэн хааныг суулган одох мэт...

Чингис хаан далайн хөлөг дээр удам гарал нэгтнийхээ дунд орж Чингис хааны биеэс сүнслэг бие нь салан одох мэт эргэлдэн хөвнө. Чингис хааны нүд дүүрэн нулимстай царай.



1227 он гэсэн бичиг гарна.

Дэлхийд өөрийн сүр сүлдийг тунхаглан зарлаж дайтсан Чингис хааны цэргүүдийн эзэлсэн газар нутагтай дэлхийн бөмбөрцгийн зураг...

Үүний давхар фонон дээр олон мянган морьд хөлөглөн дайтан давших цэргүүдийн довтолгоо...

Гол, гол улс орнуудын онцлог дүрс бүхий хотууд гарна.

Дундад Азийн улс гүрнүүд, Орос гүрэн, Москва зэрэг Европын орнуудын онцлог тэмдэгт хот суурин морьдын хөлд дайрагдан өнгөрөх мэт харагдана.

Олон мянган морьдын туурайн тачигнаан, цэргүүдийн уухайлах дуун дундаас "Хөлгөөн, Хөлгөөн..." мөн хариуд нь "Бат хаан, Бат хаан.." гэж хашгирах эрэмгий тод дуу сонсдох авай.

(Киноны уран бүтээлчдийн нэрс гарна.)

## ЗӨН БИЛГИЙН РОМАНЫ ТУХАЙ ШҮҮМЖ СУДЛАЛ

### ЧИНГИС ХААН ДАХИН АМЬДАРСААР

Энэ онд Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойг тэмдэглэх нь зөвхөн Монгол туургатны төдийгүй дэлхий дахины сонорыг дэлдсэн томоохон үйл явдал болж байна. Чингисийн амьдралын түүхийг зөвхөн монголчууд төдийгүй дэлхий дахин сонирхдог нь бидний нүдэнд илхэн байдаг.

Тухайлбал, Оросын зохиолч роман туурвиж, Хятадын уран бүтээлчид томоохон хэмжээний кино бүтээсэн нь үүний нэг тод илрэл юм. Гэтэл эрдэмтэн, зохиолч Ц.Дамдинсүрэн, Ш.Гоодамба, Д.Цэрэнсодном нарын зэрэг хүмүүс "Нууц товчоо"-г орчин үеийн монгол хэлнээ хөрвүүлж, энэ сэдвээр эрдмийн зэрэг хамгаалсныг эс тооцвол дорвитой уран бүтээл бараг гарсангүй. Манай нэрт зохиолч С.Эрдэнэ, Д.Маам, Д.Батбаяр нар Чингисийн тухай "Мөнх тэнгэрийн хүчин дор" кино зохиол туурвиж, зохиолч С.Жаргалсайхан роман бичсэн боловч үзэгч, уншигчдын сэтгэлд төдийлөн хүрсэнгүй. Бид ийм л байдалтай Их ойг угтах гэж байна. Харин их ойн сураг дуулианаар зарим нэг бүтээл гарч эхэллээ.

Юун түрүүнд зохиолч Дамдины Жамъянгийн "Чингис хааны мэнгэ" хэмээх зөн билгийн роман саяхан хэвлэгдэж гарлаа.

Энэхүү романд Эзэн Чингисийн эхээс мэндэлсэн үеэс идэр залуу нас, хаан суудалд заларсан үеийг дүрслэн үзүүлсэн байна. Түүхэн дурсгалт бичгээс үүдэн зохиол бичнэ гэдэг хэцүү ажил байх. Гэхдээ зохиолч Жамъян зориглож эл том сэдвийг хөндсөн нь сайн хэрэг. Юмаар юм хийнэ гэдгийг уран дархны ажилтай зүйрлэдэг билээ. "Монголын нууц товчоо" хэмээх алдарт түүхэн бичээсийг уран сайхны хэлбэрт оруулан роман туурвина гэдэг амаргүй ажил болох нь мэдээж.

Зохиолч уг романыг нэн сонирхолтой үйл явдлаар эхлүүлжээ. "Нууц товчоо" -нд өгүүлдэг хамгийн гол үйл явдал нь Есүхэй баатар гурван мэргэдийн нэгэн баатар болох Чилээдүйн хатан Өүлэнг хүч түрэмгийлэн өөрийн өврийн хүн болгосноос үүдэн Мэргэд, Боржигон хоёр аймгийн дунд олон жилийн турш тасрахгүй өш хонзон, дайн дажин үргэлжилсэн ажээ. Энэ бүхэн нь гурван Мэргэдийнхнийг Орхон, Сэлэнгийн сав газарт нутагладаг байсан тэр үеэс Чингис хаан их цэргийнхээ хүчээр Мэргэдийг хиар цохисон тухай өгүүлж байна.

Мэргэдүүд ийнхүү сүйрсэн тул Увас мэргэдийн язгууртан Дайр-Үсүн нэгдүгээрт, өөрийнхөө амийг аврах, хоёрдугаарт, үхлээс үлдсэн цөөн ард олноо аврах нэгэн санааг өвөрлөн арван зургаахан настай Хулан охиноороо дэнчин тавьсан хэсгийг ДЖамъян чадварлаг дүрслэн үзүүлжээ.

Тухайлбал, Их хааны насан хэвийх цаг арай болоогүй ч цэл залуу хатан Хуландаа сэтгэл алдран аавыг нь асрамжиндаа авч үлдээхдээ ийн өгүүллүүн:

- Би чамаас гурван гэм тулгаж ял асуух байсан. Тэнгэр үүнийг гэрчилнэ. Гурван мэргэд хуйвалдаж Өүлэн эхийн булаагдсаны өшөөг нэхэн Бөртэ хатанг булаасан нэгэн гэм буй. Тэмүжиний хатанг булаасны дараа тэнэг аймхай Чилгэрт асруулж, Хуагчинг ятгаж Бөртээг өөртөө авах гэсэн нэгэн гэм буй. Бөртэ хатан дээр алтаар бороо оруулах гэхэд Дайр-Үсүн чиний өмнө сөгдөөгүй билээ. Намайг алгандаа нөж атгаж төрснийг сонсоод аймшигтайгаар хашгирч "Есүхэй баатрын хөвгүүний баруун гарыг тасдаж хая" хэмээн хэн хэллээ. Энэ бол Дайр-Үсүний хүнд гэм билээ.

Намайг багад хорхой идсэн баавгайгаар гишгүүлэх санааг гурван мэргэд сэдсэнийг тэнгэр гэрчилнэ хэмээн мэргэдүүдээс өш хонзонгоо авч дуусаад хамаг монголын эзэн сууж дэлхийг дайлаар мордох замаа эхэлсэн байна. Энэхүү эхний хэсэгт хамаг монголын тархай бутархай олон овог аймгууд нутаг ус, мал хөрөнгө, эмс охидоо булаалдан тэмцэлдэж байсан тэр эмгэнэлт явдал дуусгавар болж, Их Эзэнт Гүрэн нэгэн хааны гарт атгагдсанаар бүх монголын ард түмэн амар тайван амьдрах болсныг уран сайхнаар дүрслэн харуулжээ.

"Чингис хааны мэнгэ" хэмээх эл романы гуравдугаар бүлэг нь Есүхэй баатар Мэргэдийн хаан Чилэдүгээс Өүлэн хатныг хүч түрэмгийлэн булаан авсан тухай өгүүлнэ. Есүхэй баатар залуу зандан насандаа ийнхүү Өүлэн хатнаа өөрийн болгож аваад эцэг өвөгдийнхөө өш хонзонг татааруудаас авч Тэмүжин нэртэй баатрыг нь егүүтгэж энэ завсраа надад хүү төрвөл Тэмүжин нэр хайрлаарай хэмээн дурдсан байдаг. Өүлэн хатан баруун гартаа нөж атгасан хүүгээ төрүүлээд нэлээд хэдэн жилийг үдсэн бололтой.

Есүхэй баатрын зөн совин татсан юм болов уу, нэгэн өдөр Тэмүжинг дагуулан Хонхирадын толгойлогч Дай Сэцэнийд морилоод хайртай хөвүүнээ Бөртэ Үжинд нас бие гүйцсэн хойно ураг төрөл болгохоор сүй тавин буцжээ.

Буцах замдаа Есүхэй баатар татааруудад хорлогдон ордон газраа арай ядан очсон ажээ. Ийнхүү Есүхэй баатрыг амь тавьснаас хойш хуучин хонзонтой татаар болон мэргэд тэргүүтэй дайснууд нь халдан довтолж Бөртэ Үжинг булаан авч Тэмүжин ой шугуйд нуугдан амиа аварчээ.

Энэ бүхний дараа Өүлэн хатан ядуу зүдүүгийн амтыг амсан хэдэн хүүхдээ тэжээхийн тулд уул, голоо даган жимс ногоо, загас жараахайгаар хооллон амьдарч зовлон гачаал амталсан түүхийг Д.Жамъян маш чадамгай дүрслэн үзүүлсэн нь энэ романы том ололт юм.

Энэ хүнд үед Тэмүжин элдэв зүйл сэдэж, эцгийнхээ анд найз нараас тусламж гуйн Монгол аймаг угсаатнаа нэгтгэх ажил үйлсийг эхэлсэн ажээ. Бас энэ завсар Боржигин, Тайчууд нарын ерсөлдөөн болж, Есүхэй баатрын хатан Өүлэн, Сочихэл нарын үр сад хаан ширээний төлөө тэмцэлдэж буй нэгэн хэсэг бий. Эл бүхнээс үүдэн түүхэн эх сурвалж бичиг, түүхэн сэдэвтэй роман хоёрыг харьцуулан үзэх гэсэн нь миний гол зорилго биш байлаа. Гэхдээ түүх бол түүхээрээ үлддэгийг зохиолч Д.Жамъян бага зэрэг хэтрүүлсэн бололтой.

Д.Жамъян "Монголын нууц товчоо"-ноос үүдэн түүхэн сэдэвтэй роман бичихдээ зөн билиг гэдэг тал руу нь дөвийлгөсөн талтай санагдана. Яагаад вэ гэвэл, Тэмүжин тайчуудад баригдах үеэс ширэнгэн ойд гарч зугатсанаас бус могойн сүрэг аварлаа гэсэн зүйл байхгүй. Гэтэл Д.Жамъян "жаран зургаан могой Тэмүжиний амийг аварлаа" хэмээн айлдсан байдаг. Энэ мэт

зөн билэгдлийн дүрслэл зүйрлэлийг олон газар хэрэглэжээ. Зөн билэгдлийн шинжтэй дүрслэл, зүйрлэлүүд нь уг зохиолын амин сүнсийг амьдралаас холдуулсан шинжтэй. Тэртэй тэргүй түүхэн баримтад түшиглэсэн хойно дүр, дүрслэлийг амьдралд улам ойртуулах нь уг зохиолын үнэ цэнийг улам дээш өргөх байх. "Монголын нууц товчоо"-нд ардын аман зохиолын хэтрүүлгийг хэрэглэсэн нь мэр сэр тохиолддог. Тухайлбал, Тэмүжин найман шарга морио хулгайд алдаад мөрдөн мөшгөх замдаа Наху баяны хүү Боорчтой тааралдан хамтарч морьдоо аваад гурван өдөр, гурван шөнө давхилаа гэж бий. Мөн тэр үхэр их тэргээр Тэмүжиний хойноос зүтгэн явж төөрөн хэлэх нь:

Тэнгэр газар эелдэж (зөвлөж)

Тэмүжин улсын эзэн болтугай гэж

Тээж хүргэж явна гэж хөөрнө (МНТ.65-ртал) хэмээн мал адгуусыг хүнчлэн бичсэн нь бий.

Түүхэн баримттай романы тухай өгүүлж байгаад гэнэт "Монголын нууц товчоо"-ноос эш татах болов гэсэн асуулт гарах байх. Яагаад гэвэл "Монголын нууц товчоо"-нд ч, Жамъянгийн романд ч нэг адил зөн совин билэгдлийн дүрслэл, зүйрлэл байх юм.

Бас нэг жишээ авъя. Энэхүү "Монголын нууц товчоо" болон "Чингис хаан мэнгэ" роман нь зөн билэгдлээр дүүрэн. Тухайлбал, Чингис хааны зайран ийн өгүүллрүүн:

- Чамд аз тохиов. Үзэсгэлэнт бүсгүй алтан хэвлийтэй, рашаан устай ажээ. Тэр хүүхнээс хаан хөвүүн төрнө. Тэнгэрийн таалал ийм байна. Бүсгүйн рашаанаа (шээсээ) юүлсэн газарт барын чих хэмээх цэцэг дэлбээлж байхыг би нүдээрээ үзэв. Онгон шүтээн тэнгэр эцэгтээ талархав хэмээн Чингис хааны мэргэн түргэн бөө зайрангийн үгнээс тодорхой харагдана. Өүлэн хатныг ийнхүү лус савдаг, тэнгэр бурхантай зүйрлэжээ. Бас нэгэн зүйл Баатар Есүхэйн бахим гарт бат атгагдаж явсан шонхор шувууны дүрс юмсан.

Боржигон овогтон шонхорыг зүрхэндээ сийлсэн юм. Шонхор шувуу тэдний амьд сүлд билээ хэмээн Чингис хааны шүтээнээ болгож байсан гурван зүйлийн тухай зохиолч дэлгэрэнгүй дүрсэлснийг уншсан хүн л мэдэх буй заа.

Энэхүү түүхэн сэдэвтэй романы агуулгыг нэгэн шүүмжийн жижиг өгүүлэлд багтаана гэж байхгүй. Гэхдээ уг романд дурдсан, бас хэлж яримаар ганц нэг баримтыг дурдалгүй өнгөрч болохгүй байх.

"Монголын нууц товчоо" хэмээх түүхэн бичээс буюу түүхэн тэмдэглэлээс үүдэн туурвисан зохиолч Д.Жамъянгийн "Чингис хааны мэнгэ" романы хэл найруулга, зохиомжоос өө сэв эрэхэд хэцүү юм. Бас түүхэн баримтыг уран сайхнаар найруулан зохиомжлохдоо алдсан зүйл бараг байхгүй байх гэж хэлмээр байна. Дутагдал, доголдол хайсан хүнд бол Зүчийг Чингис хааны ууган хүү мөн гэх тал руу нэлээд чармайсан байна. Энэ нь Чингис хааны үр хүүхэд зөвхөн Их хааных байх ёстой, хатадууд нь ч цэвэр ариун байх ёстой гэдэг санаанд тулгуурлан ийм санаа, дүрслэл бичсэн нь бий.

Тэмүжин Бөртэ хатнаа мэргэдүүдэд булаалгаад нэгэн жилийн дараа мэргэдийг дахин дайлж



Бөртэ хатнаа олзноос авран, асарч хамгаалах нэрээр хатныг нь эдэлж байсан Чилэдүйн дүү Чилгэр бөхийг цавчин хөнөөхөд Бөртэг асрамжлагч Хуагчин эм мэгшин уйлж,

- Чилгэр бөх буруугүй гэв.

- Түүнийг яагаад өмөөрнө вэ гэж Тэмүжин асуув.

- Бертийг хүмүүст захиж үлдээгээд намайг авч оргосон билээ. Тэр их аймхай хүн. Чамд цавчуулжээ. Чилгэр бөх хагсарсан эм намайг тоож байсан юм. Одоо би Бөртээгөө очиж асрах минь гэсэн Хуагчины өчиг Тэмүжиний цээжийг цээлсүүлэв гэж бий. Бөртэ хатан ийнхүү Их өргөөнд очих замдаа анхны хүүгээ төрүүлж, Тэмүжин түүнд "Зүчи" хэмээн нэр хайрлажээ. Хөвүүнээ амлуул хэмээн Хуагчинг өгүүлэхэд Бөртэ цээжээ эгшээн уртаар шүүрс алдаж хээр төрсөн хөвүүн хэлтгий заяатай бус уу. Тэмүжин түүнийг гийчин гэсэн нь салаа утгатай үг байна. Зүчи бол Тэмүжиний гэрт гийчин болж очно. Харин надад бол гийчин бус үр минь билээ гэсэн байдаг.

Энэ бүхнээс үзэхэд Тэмүжин ухаалаг, тайван учраас ууган хүүгээ ад шоо үзэлгүй хүний зэрэгт хүргэж, Есүй хатны зөвлөснөөр Чингисийг залгамжлах хөвүүний нэрийг тодруулах мөчид "Хөвүүдийн ах Зүчи мөн. Юу хэлнэ. Чи хэл" гэв.

Зүчийг үг хэлэхийн урьд Цагаадай өгүүлрүүн: "Зүчийг үг хэл гээд Зүчийг юунд томилох гэж байна. Энэ мэргэдийн орхидост бид захирагдах гэж үү" гэсэнд Зүчи, Цагаадай нар заамдалцан авч хүчийг үзэхэд Боорчи, Мухулай нар салгахад Чингис хаан дуугүй сууж байв хэмээсэн нь Эзэн хааны ихээхэн хүлээцтэйг өгүүлжээ. Ийнхүү Зүчийн саналаар Өгэдэй үе залгамжлах болсон хэсгийг "Монголын нууц товчоо"-ны арваннэгдүгээр бүлгээс ишлэл авав.

Д.Жамъян романдаа монголын нэгэн овог, аймаг болох боржигонуудын амьдрал ахуйгаас үүдэн бүх монголын туургатныг нэгтгэсэн Чингис хааны үүх түүхийг бодит баримтаас гажилгүй дүрслэн үзүүлсэн байна. Зохиолын эхэнд Мэргэдүүд буун өгч Дайр-Үсүн охин Хулангаараа сүй тавьсан бол романы төгсгөлд Чингис хаан Хуланг дагуулан ирж ээждээ бараалхуулжээ.

Хуланг хараад эх нь нялхаараа амьтан байна гэжээ. Бас Өүлэн эх хааны мэдэл хязгаартай бус уу хэмээн Чингис хааныг зэмлэсэн ч юм шиг өгүүлжээ. Энэ нь Өүлэн эх Чингис хааныг насан туршид нь сургамжилж байсны баримт юм. Ямар ч ухаантан байлаа үр хүүхэд нь аав, ээжийнхээ үгийг дагадаг хүмүүний ёс буй.

Д.Жамъян романыхаа төгсгелийн бүлгийг "Миний хөвүүн нөж атгаж төрсөн бус уу. Миний хөвүүн алгандаа нүдтэй бус уу" хэмээн зохиолын гол санаагаа Өүлэн эхийн үгээр төгсгөж байна.

Үүнд эргэлзмээр зүйл бий боловч бидний амьдарч байгаа энэ үед Дундговь аймгийн бага сургуулийн охин алгандаа ойр тойрныхоо бүх юмыг хардаг байгаад хожим нь их эмч болсон, бас Хэнтий аймгийн нэг жаалхүү бас л алгандаа элдэв зүйл хардаг байсныг хэлмэгдүүлсэн.

Энэ бүхнээс үзэхэд одоогоос 800 гаруй жилийн тэртээ дэлхийн ард түмнийг дэнжигнүүлж

байсан Их Эзэн Чингист иймэрхүү увидас, зөн билэг байгаагүй гэх арга алга. "Чингис хааны мэнгэ" роман уншигч олны талархлыг хүлээнэ гэдэгт гүнээ найдна.

МЗЭ-ийн шагналт, утга зохиолын мэргэжлийн шццмжлэгч Барын Цэдэв

## "МЯНГАН ОНЫ УЧИР ШАЛТГААНЫГ БИЙР, БЭХСЭЭС АСУУЖ"

(Нууц товчооны өгөөгүй хариуг Чингис хааны мэнгэ романаас олсон нь)

Агуу их Чингис хааныхаа явдал суудлын нарийн учрыг өлгийдөн авсан газар шороо нь сайн мэдэхээс бус, үр ач бид нар тун өчүүхэн мэдмуй. Басхүү тэр их хүний агуу их амьдрал, тэмцлийн түүхийг дэлхийн соёлт их, бага орнууд болох Франц, Ром, Манжийн эзэнт гүрэн монголчуудаас нь илүү сайн мэддэгийг номын сангуудад нь дараастай хэвтэх үй түмэн номууд гэрчилдэг гэх. Бидэнд гагцхүү "Монголын нууц товчоо" л үлдсэн. Түүнийг өдгөөгийн нүүдэлчдэд хүргэн авчирсан нь Цэндийн Дамдинсүрэн гуайн мартагдашгүй их оюуны буян.

Энэ бүхнийг сануулан хэлэхийн учир нь гэвэл, нэгэн тэнэмэл франц эр өнгөрсөн зууны эхээр халимагуудаас сонссон үлгэр түүхээс сэдэвлээд "Хөх Монголын хөх судар" гээч уран сайхны лут романыг туурвичихсан байхад, эс бөгөөс Ванчинбалын Инжиннааш хэмээх цахар бичигтэн Манж руу довтолсон Английн түрэмгийллийг эсэргүүцсэн сэтгэлдээ өдөөгдөн "Хөх судар" гэдэг түүхэн бүтээл туурвичихсан байхад, тэр ч бүү хэл Дундад Азийн чантуу зохиолч В.Ян гэгч Сталины даалгавраар (тэрээр Чингис, Бат хаанд хайртайдаа биш, харин тэдний зан төрхөөс өөрийнхтэйгөө адилтгах зүйл хайлгасан хэрэг гэдэг нь ойлгомжтой) манай их хаадын тухай гурван том цувралыг бүтээчихсэн байхад мөнөөхөн төрөлх эх орон нь юу ч үгүй суусаар (өчүүхэн бичээч би бээр энд 1990-ээд оноос хойш уг сэдвээр бүтээгдсэн киноны болон тайзны урлагийг дурдаагүйг уншигч авгай эрхбиш ойлгох буй заа) өдийг хүрчээ.

Харин аз таарч саяны нэг өдөр миний зам дээр "Чингис хааны мэнгэ" хэмээх ном дайралдав. Хавтсыг нь сөхөөд үзвээс Урианханы хөх чоно овогт Дамдины Жамъяны "зөн билгийн" хэмээх тодотголтой роман аж. "Уулаа, суулаа, дууллаа" гэдэг шиг "уншлаа, үзлээ, ойлголоо". Одоо харин энэ номын талаар дуугарахаас аргагүй санагдаад үг хэлмээр бодмоглов.

... "Жүд модны мянган навч газар бүтээхэд мод нүцгэрч арван үе мултарч өнгөрөөд Бутанцар мунхаг хэмээх хөвүүн Бөртэ чонын удмаас үлджээ... Бөртэ чонын дээд язгуур үргэлжилсээр Чингис хааны үед газар, тэнгэрт суу нь тархаж мөнх тэнгэр тэтгэснийг мэдтүгэй. Монголын тал нутагт хавар болж Сэлэнгийн шар тохой нэлдээ ногоорон өвсний үндэс хөөсөн цагаар Чингис хааны морьдын туурайд газрын нойтон хөрс хэгз гишгэгдэв.

Мэргидийн цус тэнгэрт үсрэв. Орхон Сэлэнгийн уужуу бэлчир малын сэг зэм хүний хүүрээр дүүрч, шатсан гэр майхны үнс чандруу хийсч, хаа нэгтээгээс үхдэлийн үнэрт соронздуулсан тас, ёл, хонхэрээ, сар мэтийн махчин шувууд тэнгэр харлуулан цугларчээ..." роман ингэж эхэлнэ.

"Хөрст дэлхий хөрвөж

Хөвчин улс хямралдаж

Хөнжилдөө унтах завгүй

Хөнөөлдөн тэмцэж явав" хэмээн "МНТ"-нд гардаг тэрхүү аюумшигт дүр зургийн дэлгэрэнгүй зураглал, өнгөт фото нь энэ буюу. Хүчтэй дүрслэл, зоригтой тэмүүллийн содон үнэр эндээс ханхална. Хамгийн өштөн дайсан мэргэдийн цусыг тэнгэрт үсэргэж их тэмцлээ эхэлсэн оргилуун зүрхэт, цөс ихт дайчин эрийн дүрийг чухамхүү романтизмын онолоор бол ингэж л эхлүүлэхээс өөр яах. Хорин нэгэн бүлгээс бүрдэх (хорин нэгийн тоог зүгээр ч нэг аваагүй, мөн л зөн Совингийн утгыг агуулсан бололтой нь романы төгсгөлийн бүлгээс харагдана) чухам утгаараа Монголын анхны (тэр дундаа Чингис хааны тухай) зөн совингийн энэхүү романы хэллэгийг ёстой л Чингис хааны тэр эринтэй нь сүлэлдүүлэн түрхэрсэн амьсгалаар бичсэнийг нь өөр олон жишээгээр дурдаж болох бөгөөд цөөн хэдийг нь уншигчдын "хорхойг гозгонуулахад" зориулан иш татаж болох юм.

..."Үхдэлүүдийн дийлэнх нь мэргидийнх аж. Гавлын ухархайн нүхээр мөлхөө ургамал сүвлэж зангилагдана. Мөлхөө ургамал дараагийн гавалд мөн зангилагдаж нэгэн өдөр үхсэн мэргидийн яс овоорох гэнэ..." "Дайр-Үсүний нүдэнд үерийн ус шиг их цэргийн цуваа харагдана. Сэлэнгэ мөрний урсгалыг зогсоох хүчин бий юу? Усны урсгалын хүчит чимээн Чингисийн их цэргийн морин төвөргөөнийг дэмжин шуугих ажээ". "Эрт бэлбэсэрсэн эмсийн уй гашуу тэнгэр эзлэн гунигийн дуу үлдээж, нулимс нь Онон мөрний цутгалан лугаа адил асгарчээ". "Есүхэй баатрын өвөрт байсан овгийн сүлд амилж, түүний гар, мөр, магнай дээр цагаан шонхор шувуу дэрвэлзэн сууж байна. Цагаан шонхор шувууны аманд жүд модны навчис, ялгуун модны холтос зуулттай байна. Толин нуурын ус тогтуухан мяралзаж, нэг л мэдэхэд Бөртэ чоно баатар түмэн дагуулынхаа хамт зогсож байв". Тэнгэрийн тэмдэг болох шагайн чинээ нөжийг хамаг Монголоор тараан цац!"...

Эр, эмийн ёсны талаарх монгол сэтгэлгээ, дорнын lib философи хоёр энд тухайн үедээ байлдах дайтах ч арга эвээ олоогүй байсан өрнө, дорно ард түмнүүдийн зан заншилтай сөргөлдөх мэт. Бод л доо та, өөрийн гутгаар хөвгүүнтэй нас чацуутан, өөрт нь царай зүсээ харуулахын тулд зорин ирэхдээ "зэрлэг" цэргүүдийнх нь эрх мэдэлд хэд ч хоносныг бүү мэд Хулан бүсгүйг Чингис хаан ердөө л бүслэхийг нь хүртэл нүцгэлүүлж, онгон гэдгийг нь хоёр , - > хөхөөр нь танин мэдцэг нь их хааны агуу оршихуйн их ^ ухаан бус уу. Гадаадын судлаачдын андуурснаар "Чингис хаан Хулан гэгээ л мөнөөхөн анх хөтөлж авчирсан толгодын дунд "дараад унасан"-ыхаа хойно л тэр тухай мэдсэн гэх

нь холгүй маргалдсан байдаг. Гэтэл 20-хон мянган үгийн нөөцтэй манай өнөөдрийн телевизийн орчуулагч нар маань "онгон" гэдэг үгтэй адил бас хөвгүүдэд зориулсан "зандан" гэдэг үгийг мэдэхгүйн харгайгаар "40 настай онгон эр" хэмээн "хөрвүүлсэн" нэртэй киногтелевизээр "туушиндаж" байгаа нь үндэснийхээ хэл соёл, зан заншлаас хичнээн их хоцорсныг гэрчилнэ. Харин Жамъянгийн роман шал өөр, жаал жуулхан "зүлгүүрдчихвэл" бараг л төгс төгөлдөр шахуу ажээ.

Хулан охиныг анх хараад хүлэг Боорч нь "Надад менгөн загас шиг санагдав" хэмээн Чингис хаанд өчиж буй нь тэнгэр язгуурт их хүнд заяагдсан лусын гүнж лүгээ адилтгах зөн совингийн далд утганд дулдуйдсан монгол зохиолчийн сэтгэлгээ биш гэж үү? Зохиолч бас Хулан хатны гоо үзэсгэлэнг шагшрахдаа "эрвээхэй мэт хөнгөн явдалтай, дүүрэн гишгэдэлтэй, сэргэг цочимхой атлаа ажигч гярхай харцтай, гурвалжин нүүр, гурвалжин хамар, гурвалжин чих, гурвалжин том нүд"-тэй хэмээн дүрсэлсэн нь Галидасын "Үүлэн зардас"-ын ягшийн

дүрийг Ринчин гуайн орчуулгаар уншиж буй мэт тийм гэхийн аргагүй ид шидийн мэдрэмжийг төрүүлээд, нээрээ л сайхан бүсгүйн нүүр царай тиймэрхүү нэг гурвалжин байдаг даа хэмээн шивнэх тансаг аялгууг зүрхэнд уяна. Эс бөгөөс, бас л мөнөөхөн зөн совингээч нь юмуу, бүү мэд. Энэ ч бас юу ч биш. Өүлэнг анх харсан Есүхэйн сэтгэлийн зургийг сонсоё. "Есүхэй баатрын харц Өүлэн Үжинг олзлон түүний бие дээгүүр хэсүүчлэн тэнүүчилж, өлөн араатны шуналыг агуулна. Өүлэн бэлхүүс нарийн, хөх том, егзег хондлой бөөрөнхий болоод гуниг тогтоогүй цайвар царайтай, тогтуун дулаан харц, тэргүүтэн яруу зохицолтой тул Есүхэй хэт тэмүүлэлдээ автаж улангасан ээрч билээ" гэсэн байхад, харин тэнгэр лүгээ харьцсан Цагаанбух зайран Есүхэйд "Чамд аз тохиов. Үзэсгэлэнт бүсгүй алтан хэвлийтэй, рашаан устай юм байна. Тэр хүүхнээс хаан хөвгүүн төрнө. Рашаанаа юүлсэн газарт нь барын чих цэцэг дэлбээлж байхыг би нүдээрээ үзэв. Онгон шүтээн тэнгэр эцэгтээ талархав хэмээн өчиглөнө. Тэр цэцэг нь чухам ямар цэцэг байдгийг өдгөөгийн бидэн үл мэдсү. Харин зохиолч Жамъянгийн дүрсэлснээр бол үзүүртээ барын чих мэт бор толботой, дэлбээтэй шар бөрлөн цэцэг байдаг юмсанж. Чухамхүү Өүлэн шиг бумбын хэвлийтэй бүсгүйн рашаан усаар тийм л цэцэг умдаалж дэлбээгээ нээдэг юмсанж. Өүлэн бүсгүй болбаас ялагдашгүй баатрыг төрүүлнэ гэж зайран бөө хэлснийг Чилэдү баатар ч өмнө нь бас хэлж байсан бөгөөд энэ нь Өүлэн эхийн заяа төгөлдөр алдрыг улам ч тодруулжээ. Яг л диваажингийн тухай үлгэр домог мэт сэтгэгдлийг төрүүлж, үзэг барьсан хүний цагаан атаархлыг өөрийн эрхгүй буцалгам, ёстой л "зөн совингийн" романы бичлэг гээч энэ буюу.

Энэ романд эр хүний үүргийг Төгсжин удганы үгээр "Эхнэр хүүхэд тэжээхээс гадна цэрэгт явж, аян дайны хөлд үрэгдэх", харин эмэгтэйн заяаг "хүүхэд төрүүлэх" хэмээн тодорхойлсон бол Чилэдү баатар эмийн заяаг "эрийн өвөр хэсэх" гэж тодруулсан ч Есүхэйн анд нарын өөдөөс эвшээсэн нумаа буулгаж, цээжээ гиншүүлж буй өгүүлэмж бас бий. Үхэх-төрөх, хайрлах-үзэн ядахуйн мөн чанарыг бүрнээ таньсан дорнын сэтгэлгээг гайхалтай сайхан сүлжилдүүлсэн иймэрхүү өгүүлбэр, догол мөрүүд "Чингис хааны мэнгэ"-ний дурын хуудсыг эргүүлэх төдий таарах агаад тэр бүхнийг ишлэл болгон аваад тайлбар, дүгнэлт бичсүгэй хэмээвээс анхны агч романаас нь зузаан ч болж мэдэх тул өчүүхэн тэвчсү.

Сая дурдаад өнгөрснөөр, Чилэдү баатар эмийн заяаг ut> "эрийн өвөр хэсэх" гэдэгтэй аргагүйн эрхэнд эвлэрч, ЭВШЭЭСЭН нумаа буулгасан байхад Дамдины Жамъян яагаад өөрийнхөө шинэ романыг Өүлэн бүсгүйн хэлсэн үгсээр түрээ барин "Зөн совингийн" гэсэн тодотголтой өргөн барьж буйг таамагласнаа уншигч авгай нартай хуваалцах хэсэг рүүгээ одоо харин орсү. Өүлэн бүсгүйг хадамд мордох үес Ольхон аймгийн удган сүйхээчлэн "Чи мэргидэд үл очно. , "> Чи өөр эртэй учирна. Хэрэв замдаа баригдвал үйл лайгаа ^ дагаарай. Галын сорил үүнийг шивнэв" гэсэн юмсанж. Жамъянгийн тайлбараар шүү дээ. Түүнд сүжиглэсэн Өүлэн эх Есүхэйн андуудыг дайран ирэхэд хувь заяа

нь тийм аж гэдгийг ойлгон Чилэдү баатарт "Эдэнд хэн хэрэгтэйг Чилэдү чи мэдэж буй. Хайран амиа бүү сүйтгэ! Гэр бүрт хацар гоо охид буй" гэж буй нь уг зохиолыг "зөн совингийн" зэрэглэлд аваачих нэгэн ухагдахуун ажгуу. Ер нь ч МНТ өөрөө зөн совингийн олон тодотголтой байдгийг эргэн ухаарч болно. Тэнгэрээс шагалзах шар гэрлийн үес тооноор орж ирдэг "тэр амьтан", алган дээрээ нар, сар мандуулан Дай сэцэний зүүдэнд орж ирсэн цагаан шонхор шувуу, мөрөн дээрээ бүсээ тавиад тэнгэрт хандаж буй Чингисийн залбирал - энэ бүхэн "цаанаа л нэг юм хэлээд байдаг"-ийг санагалзахын ялдар, энэ мэт тоо томшгүй

олон зүйлд "Монголын нууц товчоо" ямар ч хариу өгөөгүйг гайхах нь зөв мэт. Тиймээс ч "Нууц" хэмээн тодотгосон байж болох талтай.

Харин Д.Жамъян бээр өөрийнхөө "Чингис хааны мэнгэ"-ээр хариултгүй үлдсэн түүхийн нууцад хариу эрсэн мэт санагдвай. Тухайлбал, Зүч хэний хүү вэ? Цагаадай дүүгийнх нь хэлснээр, мэргидийн орхидос нээрээ мөн гэж үү? Үгүй гэдгийг Жамъян зохиолч зөн совингоороо батлахыг оролджээ. Тийн зориглохын учир нь зурхай судлал, хүн судлал, алганы хээ судлалыг бараг л мэргэжлийн хүний зиндаанд хүртэл "оролддог"-той нь ч холбоотой байж болох. Тэгэхээр Зүч хэний хүү вэ? Тэнгэр язгуурт Чингис хаанд ууган нуган үр нь өөрөөс нь заяагаагүй байж таарах уу? Жамъянгийн зохиомжилсноор бол мэргидэд олзлогдож, Чилэдү баатрын дүү Чилгэр бөхийн гэрт хүргэгдсэн Бөртэ үжинг хамгаалахын эрхээр Хуагчин эмгэн унтах ороо Бөртэтэй шөнө бүхэн сольж унтаад Чилгэрт хөөрхий биеэ тушаадаг байв гэнэ. Ганц ч удааг үл алгасав гэнэ. Зохиол биш бол нээрээ тийм байгаасай гэж итгэмээр. Гэхдээ яагаад үгүй гэж? Эзэн Чингисийн минь их хүү өөрийнх нь л байсан байгаасай хэмээн залбирдаггүйсэн бил үү, бид чинь? Бөртэ үжин өөрийгөө хумсын төдий ч буруутгахгүй бардам байдаг нь "Нууц товчоо"-ноос илт болохоор итгэхээс аргагүй.

Тэгвэл Мэнлигийг яагаад Мэнлиг эцэг гэдэг юм бэ? "Нууц товчоо"-ноос бидний дутуу ойлгосноор болон орчин үеийн гадаад, дотоодын "сексопатологч-дын" судалснаар бол Чингисийн хойт эцэг. Харин Жамъянгийнхаар бол Есүхэйн гэрээслэлээр бага хатан Сочихэлтэй нь нөхцсөн сайн санаат албат. Сочихэл эх Бөртэтэй хамт мэргидэд олзлогдож очоод тэнд өөрийн саналаар үлдсэн нь ч нэгийг цаанаа өгүүлнэ. Түүнчлэн гурван мэргид яагаад боржигинтой өстэй болсон бэ? Ойлгомжтой. Чилэдү баатар Өүжинг булаалгахдаа бараг улих шахам "Боржигинууд мэргидийн зуултанд оров. Нэг нартай өдөр эргэж уулзанаа, гайгүй" хэмээн хэлсэн гэж Жамъян бээр таамаглажээ. Тэр л ёсоор болдог л доо.

Энэ мэтчилэн Тэмүүжиний "галын бөө нар"-ын тухай хийгээд гавлын ухархайнуудыг сүвлэдэг мод ямар учиртай, Хуагчин эмгэн гэж хэн бэ, Сочихэл эх, Тэмүүжин хоёрын харилцаа ямар байв, Жамуха Чингистэй харгалдах болсонд Бөртэ ямар "буруутай" вэ, Тоорил хааныг хэн хатгав, хэрвээ Тоорил хаан Чингист бууж ирсэн бол Чингис түүнийг яах байсан бэ гэх мэтчилэнгийн "Монголын нууц товчоо"-ны хариу өгөөгүй олон асуултад хариу олдох нь магад. Романыг яагаад "Чингис хааны мэнгэ" гэж нэрлэсэн юм бэ? "Нууц товчоо"-нд гардгаар бол Тэмүүжин эхийн хэвлийнээс гарахдаа баруун гартаа нөж атгаж мэндэлжээ. Мөн л "Зөн совингийн" хэмээх тодотгол өгч болох талтай "МНТ"-д энэ явдлыг алган дээрээ нар, сар тавьсан цагаан шонхортой зүйрлэж, тэнгэрийн хөвгүүн ирлээ гэж бэлэгшээдэг. Харин "стандартын бус" зохиолч, "загвар сэтгэлгээнээс салсан судлаач" Жамъянгийнхаар бол тэрбээр алгандаа мэнгэтэй байж. Тэр нь явдал суудлаа зохицуулдаг МЭЛМИЙ нь байж. Түүнийг зөвхөн эхийн сүү зөөллөнө. Тэр мэнгэ нь ямар учиртай юм байв, Чингис хаан яагаад нохойноос аймтгай, саранд дурламтгай, могой зүүдлэмтгий байв гэх мэтчилэнгийн учир жанцанг энэхүү романыг ердөө л ганцхан удаа уншаад, унтахынхаа өмнө гурвантаа эргэцүүлчихвэл ойлгогдоно. "Мянган оны учир шалтгааныг бийр, бэхсээс асуудаг"-ийн зорилго энэ юмсанж.

"Цус хэдий улаан ч цагаан сүүгээр бүрэлддэг". "Яс ургаж үлддэг бол цус урсаж алга болдог", "Эхээсээ өөр хүнд алганыхаа хээг бүү харуул", "Цочимхой хүний ой ухаан сэргэг" гэх мэтийн

ардын цэцлэлүүд шиг, эс бөгөөс яг л Бавуугийн Лхагвасүрэнгийн бүтээлүүдэд гардаг агуу их цэцэрхэл, зүйрлэлийн туйл мэт мөрүүдийг энэ номноос олж уншсан хүн ямар их баярлахыг би эс мэдсү. Ардын хэллэгийг уран зохиолын гүйлгээнд оруулчихсан юм биш үү, цаадах чинь?!

Зөн совингийн зохиолыг "стандарт бусаар сэтгэдэг хүн" бичдэг юм. Тийм хүний зохиол бүтээлийнх нь баатрууд зорьсондоо ямагт хүрдэг юм. Тийм хүнийг төгс төгөлдөр хүн гэнэ. Төгс төгөлдөр дүрүүд гардаг уран зохиолын урсгалыг романтизм гэдэг байсан юм гэнэ лээ. Одоо даанч үзэгдэхээ больчихож. Виктор Гюго, Достоевский хоёр дахин төрөхөө өнгөрч. Романтизм бол хамт олонч үзлийн реализм ч биш, хуулбарлагчдын натурализм ч биш. Капитализмын философийг үндэслэгч Айн Рэнд "Капитализмыг өмөөрөх нь" номондоо тэгж бичсэн байна лээ. Өнөөгийн дэлхий дахины хамгийн танил романтизм бол Жеймс Бондтой кинонууд л даа. Тийм агуу урсгал яруу найрагт ч тохирдоггүй юм. Харамсалтай нь гэвэл, Чингис хаан шиг төгс төгөлдөр хүний дүрийг эдүгээ цагт зөвхөн "зөн совингийн" урсгалд л оруулж бичихгүй бол хүн төрөлхтөн итгэхээ болчихож. Гэхдээ "Зөн совингийн" ном бол түүх биш, судалгаа ч биш, ердөө л стандартын бус эргэцүүлэл. Урьд нь зөвхөн яруу найрагт л хааяа цухалздаг байсан "Зөн совингийн" ийм зохиолыг манайд анхлан бичсэн хүн бол талийгаач Гүр. Нямдорж минь байсан гэчихвэл Жамъян ах өршөөг! Номын буян ч бас оршиг!

МЗЭ-ийн шагналт яруу найрагч, сэтгүүлч Ж.НЭРГҮЙ

# Table of Contents

[Нэгдүгээр бөлөг](#)

["Хөх өвсний эгшиглэн" найман боть зохиолыг танилцуулж байна.](#)

[Хоёрдугаар бөлөг](#)

[Гуравдугаар бөлөг](#)

[Дөрөвдүгээр бөлөг](#)

[Тавдугаар бөлөг](#)

[Зургадугаар бөлөг](#)

[Долоодугаар бөлөг](#)

[Наймдугаар бөлөг](#)

[Есдүгээр бөлөг](#)

[Аравдугаар бөлөг](#)

[Арванэгдүгээр бөлөг](#)

[Арванхоёрдугаар бөлөг](#)

[Арвангуравдугаар бөлөг](#)

[Арвандөрөвдүгээр бөлөг](#)

[Арвантавдугаар бөлөг](#)

[Арванзургаадугаар бөлөг](#)

[Арвандолоодугаар бөлөг](#)

[Арваннаймдугаар бөлөг](#)

[Арванесдүгээр бөлөг](#)

[Хорьдугаар бөлөг](#)

[Хориннэгдүгээр бөлөг](#)

[ГЭГЭЭН ЧИНГИС ХААН](#)

[ЗӨН БИЛГИЙН РОМАНЫ ТУХАЙ ШҮҮМЖ СУДЛАЛ](#)

[ЧИНГИС ХААН ДАХИН АМЬДАРСААР](#)

["МЯНГАН ОНЫ УЧИР ШАЛТГААНЫГ БИЙР, БЭХСЭЭС АСУУЖ"](#)